



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

Улсын Их Хурлын
Асуулгын цаг

УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ

№62

УЛААНБААТАР
2026



УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулган
/2025.9.15 - 2025.12.31/

№ 62

Улаанбаатар хот
2026 он

ГАРЧИГ

Хуудас

1.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиас:- Улсын Их Хурлын асуулгын цаг	3-4
2.	Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-т Монгол Улсын Ерөнхий сайдаас асуулт асуусан Улсын Их Хурлын гишүүдийн нэрс	5
3.	Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 9 дүгээр сарын 26-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-ийн товч тэмдэглэл	7
4.	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-т Улсын Их Хурлын гишүүдийн Монгол Улсын Ерөнхий сайдаас асуусан асуултууд	8-16
5.	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-ийн тэмдэглэл	17-50
6.	Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 31-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-ийн товч тэмдэглэл	51
7.	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-т Улсын Их Хурлын гишүүдийн Монгол Улсын Ерөнхий сайдаас асуусан асуултууд	52-57
8.	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-ийн тэмдэглэл	58-102
9.	Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 28-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-ийн товч тэмдэглэл	103
10.	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-т Улсын Их Хурлын гишүүдийн Монгол Улсын Ерөнхий сайдаас асуусан асуултууд	104-111
11.	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-ийн тэмдэглэл	112-145
12.	Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 26-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-ийн товч тэмдэглэл	146
13.	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-т Улсын Их Хурлын гишүүдийн Монгол Улсын Ерөнхий сайдаас асуусан асуултууд	147-151
14.	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдааны “Улсын Их Хурлын асуулгын цаг”-ийн тэмдэглэл	152-176

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛИАС:

2025 оны 7 сарын 09 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

9 дүгээр зүйл.Хуралдаанд асуулт асуух, үг хэлэх журам

9.9.Хуралдаан даргалагч урьдчилан мэдэгдэж, дараалалд орсон гишүүдийн нэрсийн дагуу асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх ба асуулт асуух, үг хэлэх гишүүдийн нэрс ирцэд бүртгэгдсэн дарааллаар эрэмбэлэгдэнэ. Хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөхийн өмнө энэ зүйлд заасан журмыг баримтлахыг сануулна.

112 дугаар зүйл.Улсын Их Хурлын асуулгын цаг

112.1.Ээлжит чуулганы хугацаанд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаан гишүүдээс Ерөнхий сайдад хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад асуудлаар асуулт тавих Улсын Их Хурлын асуулгын цаг байна.

112.2.Гишүүд Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурлын даргад бичгээр хүргүүлэх бөгөөд ирүүлсэн асуултыг нэгтгэн Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдад ажлын 2 өдрийн дотор хүргүүлж, асуултыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулна.

112.3.Улсын Их Хурлын асуулга, түүнд өгөх Ерөнхий сайдын хариултыг Байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэхгүй.

112.4.Улсын Их Хурлын асуулгын цагт Ерөнхий сайд өөрөө биечлэн хариулт өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох Засгийн газрын гишүүн нэмэлт хариулт өгч болно.

112.5.Улсын Их Хурлын асуулгын нийт хугацаа 2 цагаас хэтрэхгүй. Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах хугацаа цөөнхийн бүлэгт 75 минутаас, олонхын бүлэгт 15 минутаас, цөөнхийн гишүүдэд 30 минутаас хэтрэхгүй байна.

112.6.Цөөнхийн бүлэгт оногдсон хугацааны хоёрны нэг хүртэлх хугацааг тухайн бүлгийн дарга, эсхүл бүлгээс томилогдсон гишүүний цуварсан асуултаар эхлүүлж мэтгэлцүүлнэ. Үлдсэн хугацаанд цөөнхийн бүлгийн бусад гишүүн асуулт асууж, хариулт авна.

112.7.Энэ хуулийн 112.6-д заасан бүлгийн цуварсан асуултын тоог 9-өөс хэтрүүлэхгүй байна

112.8.Ерөнхий сайдаас асуулт асуух, үг хэлэх хугацаа 2 минутаас хэтрэхгүй байх бөгөөд 1 удаа 1 минутаас хэтрэхгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, үг хэлж болно. Хариулт өгөх хугацаа 2 минутаас хэтрэхгүй байх бөгөөд нэмэлт тайлбар өгөх хугацаа 1 удаа 1 минутаас хэтрэхгүй байна.

112.9.Асуулт, хариултыг тусгайлан бэлтгэсэн индрээс асууж, хариулна.

112.10.Цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд Улсын Их Хуралд мэдээлэл хийх шаардлагатай гэж үзвэл энэ зүйлд зааснаас өөр цаг, өдөрт хийж болно. Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан гишүүн асуулт асуух, үг хэлэхэд энэ хуулийн 9.17-д заасныг баримтална.

---oOo---

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
“УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-Т МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДААС АСУУЛТ АСУУСАН
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН НЭРС**

Улсын Их Хурлын асуулгын цаг				
Огноо	2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр	2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр	2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр	2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр
Нэг. Монгол Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн гишүүд				
1	О.Цогтгэрэл	О.Цогтгэрэл	Б.Жаргалан	О.Цогтгэрэл
2	Ж.Баярмаа	О.Алтангэрэл	Ц.Баатархүү	Ж.Баясгалан
3	Б.Жаргалан	Ж.Баясгалан	Д.Батбаяр	Б.Жаргалан
4	Ц.Мөнхтуяа	Д.Жаргалсайхан	Ж.Баярмаа	Ч.Лодойсамбуу
5	Ц.Туваан	Ц. Мөнхтуяа	Дав.Цогтбаатар	Л.Мөнхбаясгалан
6	Х.Тэмүүжин	Г.Хосбаяр	С.Цэнгүүн	Д.Цогтбаатар
7	Ө.Шижир	Д.Энхтуяа	Ө.Шижир	С.Цэнгүүн
8	С.Эрдэнэболд	С.Эрдэнэболд	С.Эрдэнэболд	С.Эрдэнэболд
9	О.Эрдэнэбүрэн			
Хоёр. Монгол Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн гишүүд				
1	Х.Баасанжаргал	О.Батнайрамдал	М.Ганхулэг	Д.Ганмаа
2	О.Батнайрамдал	Б.Уянга	С.Зулпхар	-
3	Г.Лувсанжамц	Д.Энхтүвшин	Г.Лувсанжамц	-
4	М.Мандхай	С.Эрдэнэбат	О.Саранчулуун	-
5	Д.Энхтүвшин	-	-	-
Гурав. Цөөнхийн гишүүд				
ХҮН намын зөвлөл				
1	П.Ганзориг	Б.Найдалаа	П.Ганзориг	Л.Энхнасан
2	-	Г.Уянгахишиг	Б.Мөнхсоёл	-
3	-	Б.Мөнхсоёл	Л.Энхнасан	-

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 4 УДААГИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-Т УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН АСУУЛТАД МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Г.ЗАНДАНШАТАР ХАРИУЛЖ, МЭТГЭЛЦЭЭНД ОРОЛЦОВ.



НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ

1.1. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-ИЙН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 103 гишүүн хүрэлцэн ирж, 81.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 07 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Тусгайлан бэлтгэсэн индрээс Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар нар цуварсан асуулт, хариултаар мэтгэлцэв.

Мөн тусгайлан бэлтгэсэн индрээс Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө бичгээр ирүүлсэн гишүүд болох Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, О.Шижир, Х.Тэмүүжин, Ц.Туваан, Б.Жаргалан, Ц.Мөнхтуяа, Ж.Баярмаа, Улсын Их Хурал дахь олонхын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Ч.Анар, Д.Энхтүвшин, Х.Баасанжаргал, Л.Лувсанжамц, Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг нарын тавьсан асуултад тусгайлан бэлтгэсэн индрээс Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын асуулгын цаг 15 цаг 51 минутад дуусав.

---oOo---

1.2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ 2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДРИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-Т УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДААС АСУУСАН АСУУЛТУУД

№	Улсын Их Хурлын гишүүн	Асуулт
УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ		
1	О.Цогтгэрэл	Төсөв ба эдийн засгийн шинэчлэл: Эдийн засгийг удирдах хэрэгсэл болохын хувьд 2026 оны төсвийн төсөлд шинээр ямар бодлого, шийдэл туссан бэ?
2	Х.Тэмүүжин	2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан "4.2.1.14.Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргана." гэж заасан. Энэ бодлогын хэрэгжилтийн талаар танилцуулна уу?
3	Б.Жаргалан	2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр УИХ дахь Ардчилсан намын бүлгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн бодлогын шаардлагад, "Хувийн хэвшилд ногдох татварын дарамтыг 20 хувиас доошгүй хувиар бууруулах" тухай асуудлыг дэвшүүлсэн. 2026 оны улсын нэгдсэн төсвийн төсөлд татварын дарамтыг бодитоор бууруулах чиглэлээр ямар бодлого, арга хэмжээ төлөвлөсөн бэ?
4	О.Эрдэнэбүрэн	Монгол Улсын төсөвт урсгал зардлын эзлэх хувь 75-80 хувийн хооронд хэлбэлзэж ирлээ. Энэхүү урсгал зардлыг бууруулж, үйлдвэрлэл, дэд бүтэц зэрэг хөгжлийн ач холбогдолтой хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлэх ямар бодлого байна вэ? Түүнчлэн хөрөнгө оруулалтууд олон жил үргэлжилж, өртөг нь эрс нэмэгддэг, үр өгөөж буурдаг байдлыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай байна. Иймд цаашид зөвлөх үйлчилгээ нэвтрүүлэх зэргээр төсвийн хөрөнгө оруулалтын төслийн менежментийг сайжруулах бодлого Засгийн газарт байна уу?
5	Ц.Туваан	1.Хөдөө аж ахуйн салбарын хүүгийн татаас дээр тодорхой мөнгө төсөвлөсөн. Энэ жил тариаланч, ногоочид ургац их алдсан. Тэд зээлийн эргэн төлөлтийн асуудалд орсон. Зээлийг хойшлуулах, хүүгийн тодорхой хэсгийг төсөвт суулгаж болох уу? 2.Ахмадуудын тэтгэврийг хуулийн дагуу 10% нэмж болох уу? 3.Алдагдалгүй төсөв баталж болох уу?
6	Ө.Шижир	1.Монголбанкны алт худалдан авалт, иргэд аж ахуйн нэгжийн алт тушаалт болон хууль бус экспортыг хязгаарлах талаар: Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь

	<p>баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно." гэж заасан.</p> <p>Түүнчлэн 2010 онд Монгол Улсын Их Хурлаар батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2 дугаар хэсэгт Эдийн засгийн аюулгүй байдал гэсэн бүлгийг тусгасан. Үүний 3.2.1 дэх заалтад Эдийн засгийг олон тулгуурт бүтцээр хөгжүүлэх, 3.2.1.3-т "Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулна", 3.2.3 дах заалтад Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдал, 3.2.3.3-т "Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгана. Цаашид нөөцийг нэмэгдүүлэх, удирдлагыг боловсронгуй болгох урт хугацааны арга хэмжээг хэрэгжүүлнэ", 3.2.4 дэх заалтад Эрчим хүч, эрдэс баялгийн салбарын бодлого, 3.2.4.1-т "Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын баталгааг хангахыг чухалчилж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох, байгаль орчныг доройтуулахаас сэргийлнэ. Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна." гэж тус тус заасан байдаг.</p> <p>Манай Улс Алт-1, Алт-2000, Алт-2 хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байсан ба одоо Алт-3 хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Гэвч хяналтгүй тогтолцоо, төрийн бодлого шийдвэрийн хангалтгүй биелэлтээс хамаарч алт тушаалт жилдээ 24 тонн хүртэл өсөлт, 2 тонн хүртэл уналтыг үзүүлж дэлхийн аль ч улсад байхгүй хэлбэлзлийг бий болгоод байна.</p> <p>Зөвхөн Монголбанкны 2010 оноос хойш буюу сүүлийн 15 жилийн алт худалдан авалтын тайланг харвал 2009 онд батлагдсан Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн үйлчлэлтэй хамааралтайгаар 2010 онд 2.1 тонн хүртэл буурсан. Мөн 2019 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хөнгөлөлттэй буюу 2.5 хувьтай байх хугацаа бүхий хуулийн үйлчлэл дууссанаар 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр таван хувь, алтны зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч 0-5 хувийг нэмж, нийт 5-10 хувиар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулах болсонтой холбоотойгоор 15.2 тонн хүртэл буурсан. Гэвч Ковид 19 цар тахлын үеийн хорио цээр, хязгаарлалттай холбоотойгоор худалдан авалт буцаад 23.6 тонн хүртэл өссөн боловч түүнээс хойш тогтмол уналттай байна.</p>
--	---

	<p>Дэлхийн зах зээл дээрх алтны ханш түүхэн дээд цэгтээ хүрсэн энэ цаг үед алт тушаалтыг нэмэгдүүлэх, хууль бусаар хилээр нэвтрүүлэхийг таслан зогсоох, Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд туссан бодлогыг хэрэгжүүлэх, олборлогч, үйлдвэрлэгчдэд эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлж өгөх чиглэлд ямар арга хэмжээ авч байна вэ?</p> <p>2.Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд хувийн хэвшилтэй өрсөлддөг байдалд ямар бодлого баримталж үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа талаар:</p> <p>Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3 дахь хэсэгт Дотоод аюулгүй байдлын бодлогыг тусгасан ба үүний 3.3.2 дахь заалтад "Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх", 3.3.2.5-д "Төрөөс стратегийн ач холбогдолтой эдийн засгийн салбар дахь зайлшгүй үйл ажиллагаанаас бусад бизнест оролцохыг хязгаарлаж, аж ахуйн шинжтэй чиг үүргүүдийг иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх бодлого баримтална", гэж тодорхой заасан байдаг.</p> <p>Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт 3.3-т "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ", Зорилт 5.2-т "Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна", 5.2.2-т "Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой хуваарилах санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий нэгжийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцэд бий болгоно", 5.2.19-т "Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.", 5.2.22-т "Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг нэгтгэн хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, хяналттай тогтолцоонд шилжүүлнэ." гэж тусгасан боловч бодит нөхцөл байдалд биеллээ олохгүй хувийн хэвшлийн үйл ажиллагааг улам хавчих бодлогын шийдвэрүүд гарсаар байна. Тухайлбал, одоогоор Монгол Улсад ашигтай ажилласан 65, алдагдалтай ажилласан 54 нийт 119 төрийн оролцоотой аж ахуйн нэгжүүд байна. Гэвч ашигтай ажилласан аж ахуйн нэгжийн нийт ашгийн 67.4%-ийг "Эрдэнэс Тавантолгой" ХК, 15.3%-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нар бүрдүүлж байна.</p> <p>Эдгээр 119 аж ахуйн нэгжийн дийлэнх нь дээр дурдсан бодлогын чиглэлд зөрүүтэйгээр ажилладаг ба стратегийн ач холбогдолтой эдийн засгийн салбарын зайлшгүй төр эрхлэх шинжтэй үйл ажиллагаа эрхэлдэггүй болно. Харамсалтай цөөн жишээ дурдвал хоол, хүнсний дэлгүүр, талх нарийн боовны үйлдвэр, ажилчдын хувцас угаалгын үйлчилгээ, сувилал, амралтын үйлчилгээ, агуулах зэрэг үйлчилгээ, бизнесийн салбарт төр үйл ажиллагаагаа явуулж байна.</p>
--	---

	<p>Үүний эсрэг чиглэсэн аливаа арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа эсэх? Мөн бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн ажиллах төлөвлөгөөний талаар мэдээлэл өгнө үү.</p> <p>3.Төр олгосон зөвшөөрлөө хамгаалах, хувийн хэвшлийн үйл ажиллагааг тасалдалгүй, төрийн хүнд сурталгүй явуулах чиглэлд ямар бодлого, ажил хэрэгжүүлж байгаа талаар:</p> <p>Монгол Улсын Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлд хуулийн үйлчлэлийн хүрээнд баримтлах үндсэн зарчмуудыг тусгасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашиг, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах; - хууль дээдлэх; - ил тод, шударга байх; - бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх; - хуульд зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардахгүй байх; <p>Түүнчлэн 6 дахь хэсэгт "Хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын тогтоосон хувь, хэмжээнд багтаан эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгоно" гэж заасны дагуу тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгжид олгодог.</p> <p>Аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа тусгай зөвшөөрлийн дагуу Монгол Улсын хууль, тогтоомжийг мөрдлөг болгох ажиллах үүргийг мөн хүлээдэг. Түүнчлэн "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Зорилт 4.1-д "Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно.", 4.1.18-д "Эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах замаар бизнес эрхлэгчид шинээр хөрөнгө оруулалтын эх үүсвэр бий болгох таатай орчныг бүрдүүлнэ. Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн бодлого хэрэгжүүлнэ.", 4.2.11-д "Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ.", 4.2.12-т "Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө.", 4.2.14-т "Уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн дараах цогцолборуудыг барьж, байгуулна. Үүнд:</p> <p>Уул уурхайн ордууд:</p> <ul style="list-style-type: none"> - Таван толгойн нүүрсний орд; - Оюутолгойн далд уурхай; - Дорноговийн цахиурын орд; - Цагаан суваргын орд; - Хармагтайн орд; - Литийн орд; - Газрын ховор элементийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлнэ.
--	--

		<p>Хүнд үйлдвэр:</p> <ul style="list-style-type: none"> - Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр; - Нефть-хими, кокс-хими, металлургийн үйлдвэр; - Нүүрс угаах үйлдвэр; - Нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн парк; - Ган төмөрлөгийн үйлдвэр; - Жонш баяжуулах үйлдвэр; - Алт цэвэршүүлэх үйлдвэрийг тус тус барьж байгуулна. <p>Эдгээр төслүүдийг нарийн тодорхой тусгасан боловч хууль, журмын дагуу авсан тусгай зөвшөөрөл, лицензийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжийг иргэд, хэсэг бүлэг зохион байгуулалттай этгээдийн зүгээс ялангуяа уул уурхайн салбарт хаагдуулж боомилдог нь ил байдаг. Энэ асуудлыг тал талд нь шийдвэрлэх хөгжлийн бодлогын зорилт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, хувийн хэвшил, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг дэмжих чиглэлд хэрэгжүүлж буй арга хэмжээ, төлөвлөгөөний талаар мэдээллийг Монгол Улсын Их Хурлын чуулганд танилцуулж, албан бичгээр хариу Монгол Улсын Ерөнхий сайдаас хүсэж байгаа тул уламжилж өгөхийг танаас хүсье.</p>
7	Ц.Мөнхтуяа	<p>Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдаж, хэрэгжиж эхлээд 2 жил гаруйн нүүр үзэж байна. Энэ хуульд Боловсролын салбарын багш, ажилтны нийгмийн баталгааны заалтуудыг хэдийгээр их сайн гэж хэлэхгүй ч тодорхой түвшинд сайжруулах заалтууд орсон. Жишээ нь, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт "Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ." гэж заасан байдаг. Гэтэл энэ хугацаанд дээрх заалтын дагуу тийм тооны багш, ажилтанд ийм дэмжлэг үзүүлээ гэдэг юм сонсоогүй.</p> <p>Орон сууцны дэмжлэг гэдэг бол багш нарын нийгмийн баталгааны маш чухал хэсэг. Харамсалтай нь бага цалинтайгаасаа болоод ипотекийн зээлд хамрагдаж чаддаггүй. Тэгэхээр энэ заалтын дагуу ямар арга хэмжээ авч, хэдэн багш, ажилтанд орон сууцны дэмжлэг үзүүлсэн бэ?</p> <p>Цаашид энэ чиглэлээр ямар хөтөлбөр, арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?</p>
8	Ж.Баярмаа	<p>1.Засгийн газраас өргөн мэдүүлэхээр бэлтгэж, олон нийтээс санал авч байгаа татварын хуулиудын шинэчлэл иргэд, аж ахуйн нэгжийн татварын дарамтыг огт бууруулахааргүй байна. Энэ талаар олон иргэдээс санал хүсэлт ирсээр байна. Татварын шинэчлэлийг төрийн оролцоо, төрийн бүтэц, орон тоог эрс бууруулах шинэчлэлтэй хамтад нь цогц байдлаар хийх шаардлагатай байна. Та энэ шинэчлэлийг хийж иргэд, аж ахуйн нэгжийн бизнесийн эрх чөлөөг бүрэн нээх талаар хэрхэн төлөвлөж байгаа талаар хариулт өгнө үү?</p> <p>2.Орон нутагт цалингаас бусад зардлын эрхийг 7 сараас хойш, сумдын хөрөнгө оруулалтын зарцуулах эрхийг 3 сараас хойш нээгээгүй байна. Үүнийг хэзээ нээж, хэвийн болгох талаар хариулт өгнө үү?</p>

9	С.Эрдэнэболд	<p>Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд улсын төсөв нийцэж байгаа эсэх талаар аудитын газар дүгнэлт гаргах хуультай. Энэ хууль сүүлийн жилүүдэд хэрэгжсэнгүй. Шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус байсаар байна. Өмнө жилээс энэ асуудлыг хэлсээр байгаа ч хэрэгжихгүй байна. Энийг хэрхэн хэрэгжүүлэх вэ?</p> <p>Хэзээ шалгуур үзүүлэлттэй болох вэ?</p> <p>Хэзээ төсөвтөө ҮАБҮБ-д нийцүүлж эрэмбэ тогтоодог болох вэ?</p>
УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ МАН-ЫН БҮЛЭГ		
10	Д.Энхтүвшин	<p>1.Түгжрэлийг хэмжиж байгаа гол үзүүлэлт, түүний өнгөрсөн жилүүдийн түвшин, 2025, 2026, 2027, 2028 онд хүргэх зорилтот түвшин, зорилтот түвшинд хүргэх арга хэмжээ, хөрөнгө оруулалтууд болон тэдгээр арга хэмжээ, хөрөнгө оруулалт тус бүр түгжрэлийн үзүүлэлтийг хэд хэдэн онд, хэдэн нэгжээр бууруулах вэ?</p> <p>2.Агаарын бохирдлыг хэмжиж байгаа гол үзүүлэлт, түүний өнгөрсөн жилүүдийн түвшин, 2025, 2026, 2027, 2028 онд хүргэх зорилтот түвшин, зорилтот түвшинд хүргэх арга хэмжээ, хөрөнгө оруулалтууд болон тэдгээр арга хэмжээ, хөрөнгө оруулалт тус бүр агаарын бохирдлын үзүүлэлтийг хэд хэдэн онд, хэдэн нэгжээр бууруулах вэ?</p>
11	Ч.Анар	<p>Монгол Улсын Засгийн газраас шинжлэх ухаан, технологи, инновацын салбарыг хөгжүүлэх чиглэлээр ямар бодлого, стратегийг хэрэгжүүлж, эдийн засгийг энэ салбарын дэмжлэгтэйгээр төрөлжүүлэх ямар төлөвлөгөөний талаар болон 2026 оны улсын төсөвт тус салбарт хэдий хэмжээний хөрөнгө оруулалт (ДНБ-ий хэдэн хувь) тусгагдаж, ямар чиглэлд зарцуулахаар төлөвлөсөн, цаашид энэхүү хөрөнгө оруулалтын дүн, ДНБ-д эзлэх хувийг шат дараатайгаар нэмэгдүүлэх ямар зорилт, төлөвлөгөөтэй байгаа талаар?</p>
12	Х.Баасанжаргал	<p>Сүүлийн үед гараад байгаа харамсалтай үйл явдлуудын ихэнх нь гэр бүлийн хүмүүжил, ёс суртахуун, сэтгэл зүйн хямралтай холбоотой байгааг бид харж байна. Үүнтэй холбоотой Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл одоо ямар процесстэй явж байгаа вэ? энэ хууль аль 1999 онд батлагдаж, 8 удаа л нэмэлт, өөрчлөлт орсон. Гэтэл аливаа хууль тогтоомжийн тухайн цаг үедээ ач цаг үеийн холбогдолтой үзэж байсан зохицуулалт цаг хугацаа өнгөрөх тусам ач холбогдол буурдаг. Гэр бүлийн суурь эрх, харилцааг зохицуулдаг хуулийг шинэчлэн батлах нь нэн чухал байна.</p> <p>Мөн ЗГҮАХ-ийн 2.1.1.4-т "Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ." гэсэн арга хэмжээний хэрэгжилт ямар шатандаа явж байгааг тодруулмаар байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээг анхан шатны нэгж дээр үзүүлж байгаа албан хаагчдыг цомхотголд оруулаагүй гэж найдаж байна. Оруулсан уу? Энэ талаар тоон мэдээлэл өгөөч.</p>

13	О.Батнайрамдал	<p>Оюутолгой стратегийн бүлэг ордын хил заагт орших ОНТРЭ компанийн эзэмшил "Жавхлант", "Шивээ толгой" ашиглалтын лиценз дээр хөрөнгө оруулалтын шинэ гарааг энэ ондоо багтааж хийх үү?</p> <p>Яг энэ цаг мөчид Рио Тинто компани Оюутолгой руу энэхүү 2 лицензийг шилжүүлэх үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа асуудлыг Та анхаарч авч үзэж байна уу?</p> <p>Энэ хоёр лиценз Монгол Улсын Засгийн газартай гэрээ хийхгүйгээр шууд шилжвэл ямар арга хэмжээ авах вэ?</p> <p>Мөн Оюутолгойн хөрөнгө оруулагч талтай 2011 онд байгуулсан Дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээний 11.3(4)-д зааснаар долоон жил тутамд санхүүжилтийн хүүгийн зохистой хувийг хянан үзэх хугацаа 2025 оны сүүлээр дуусаж байгаатай холбогдуулан, энэхүү эрхээ хэрэгжүүлэн, зээлийн хүүг зохистой түвшинд бууруулах уу?</p> <p>Оюутолгой төсөл дээр Монгол Улсын Засгийн газар 11.1 хувийн хүүтэй, ОНТРЭ компани 6.7 хувийн хүүтэй Рио Тинто/ОТ-гоос зээл авч байна. Энэ ялгаатай зээлийн хүүг гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлж, ОНТРЭ-тэй ижил байдлаар олон улсын жишигт нийцүүлэн хугацаанд нь амжиж бууруулж чадах уу?</p>
14	Г.Лувсанжамц	<p>Монгол Улсын Их Хурлын 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний Хавсралт №2-ын 3.10.1.5-д Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор ногоон зээлийн дэмжлэг үзүүлэхэд 300 тэрбум төгрөг төлөвлөж баталсан. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан 57 дугаар тогтоолоор ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, холбогдох эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр Засгийн газарт 17 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Мөн 2025 оны 7 дугаар сарын 25-ны өдөр Ерөнхий сайдад хандаж агаарын бохирдлыг бууруулах төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл ирүүлэх тухай асуулт хүргүүлсэн. Энэхүү асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтоос ирүүлсэн хариу албан бичигт ногоон зээл олгох эх үүсвэрийг шийдвэрлэнэ гэж ирүүлсэн.</p> <p>Гэтэл БОАЖЯамнаас ирүүлсэн мэдээллээр 2026 онд ногоон зээлийн хүүгийн татааст 2 тэрбум төгрөг төсөвлөгдсөн байна. Ногоон зээлийн хүүгийн татаасыг нэмэгдүүлэх байдлаар айл өрхийн дулаалгын ажлыг орон даяар зохион байгуулж агаарын бохирдлыг бууруулах нь хамгийн үр дүнтэй бөгөөд урт хугацааны тогтвортой шийдэл гэдгийг өмнө ажлын хэсгийн дүгнэлтээрээ бүх гишүүдэд хүргүүлсэн. Үүнтэй холбоотой дараах хоёр асуулт асууя.</p>

		<p>1.Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн тогтоолоор "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо"-ны даргаар Ерөнхий сайд томилогдсон байна. Энэхүү хорооны 2026 оны хийж хэрэгжүүлэх ажлуудын талаар, 2026 оны төсөвт хийж хэрэгжүүлэх ажлууд нь яаж туссан байгаа вэ?</p> <p>2.2026 онд Засгийн газар, нийслэл, дүүрэгт ямар төсөл арга хэмжээг төлөвлөж, эдгээр нь хоорондоо хэрхэн уялдаатай ажиллаж, ирэх онд агаарын бохирдол хэдэн хувиар буурахаар тооцоолж байна вэ?</p>
15	М.Мандхай	<p>1.Бэлчээрийн болон тариалангийн газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, хөрсний үржил, шимийн доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх, малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах, эрүүл өвчингүй бүс нутаг бий болгох, малын үржил, ашиг шимийг дээшлүүлэх, генетик нөөцийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнгийн талаар бүс нутаг тус бүрээр дэлгэрэнгүй танилцуулах;</p> <p>2.Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор импортын хүнс, нийтийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээ болон дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалтын чиглэлээр нийслэл болон орон нутагт авч хэрэгжүүлсэн, цаашид 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бодлогын талаар танилцуулах;</p>
ХҮН НАМЫН ЗӨВЛӨЛ		
16	П.Ганзориг	<p>1.Монгол Улсын ДНБ сүүлийн 20 жилд 10 дахин, улсын төсвийн хөрөнгө оруулалт сүүлийн 10 жилд 8 дахин нэмэгдсэн өнөөдөр уул уурхай, нүүрснээс хамааралтай байсаар байна. Төсвийн хөрөнгө оруулалт үр ашиггүй, элс рүү хийсэн ус мэт болж байгаагийн нотолгоо юм. Иймээс, улсын төсвийн төсөлд туссан, өргөн барьсан байгаа тоо, дүнг биш баригдах засаг захиргаа, төрийн албаны бүтэц зохион байгуулалт, шинэчлэл реформтой холбоотой тодорхой асуулт асууя.</p> <p>Төсөв үр ашигтай, оновчтой байхын тулд мөнгөн тоо дүнг биш агуулга, бүтэц, схемийг шинэчлэн зохион байгуулах, орчин үетэй хөл нийлүүлэн шинэчлэх нь зайлшгүй байна. Тухайлбал, сүүлийн 100 жил бараг өөрчлөгдөөгүй, цаг үе, нийгмийн шаардлага хөгжлөөс хоцроод байгаа засаг захиргааны нэгжийн шинэчлэлийг хэзээ хэрхэн хийх вэ?</p> <p>21-р зууны орчин цагийн Монгол Улсын сум, сумын төв ямар бүтэц зохион байгуулалттай байх, түүндээ зохицсон дэд бүтэц, төрийн алба, эрүүл мэнд, боловсрол, соёлын үйлчилгээ нь ямар байх бүтэц загвараа шинэчлэх шаардлагатай байна. Та Ерөнхий сайдын хувьд үүн дээр ямар бодлого барьж, яг ямар өөрчлөлт шинэчлэлийг хийх вэ?</p>

	<p>2.Эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, аж ахуй нэгжүүд, баялаг бүтээгчдийг дэмжинэ, халамжаас хөдөлмөр рүү шилжинэ гэж олон жил ярилаа. Гэтэл ажлын байр нэмэгдүүлэх, цалин, орлогоор нь дамжуулж дэмжих бодитой бодлого дутагдсаар байна. Тухайлбал, Татварын шинэчлэл дээр зөвхөн НӨАТ-ын хуулийн хөнгөлөлтөөр хязгаарлахгүйгээр ХХОАТ, ААНОАТ болон ажил олгогчийн төлж буй нийгмийн даатгалын хувь хэмжээг бууруулах замаар хөдөлмөрийг дэмжих, ажлын байр, цалин, орлогыг нэмэгдүүлэх татварын хуулийн өөрчлөлтүүд хийх үү? Үүн дээр та ямар бодлого баримтлах вэ?</p> <p>3.Төрийн албаны шинэтгэлийг хийхийн тулд өнөөдрийн Төрийн албаны тухай хуулийг задлах шаардлагатай гэж үзэж байна. Төрийн захиргаа, үйлчилгээ, тусгай, улс төрийн албан хаагчдыг нэг хуулиар зохицуулсаар аливаа шинэтгэлийг гацаах гол хүчин зүйл болжээ. Цалин хөлсний шинэчлэл, үр ашигтай, бүтээмжтэй цомхон бүтэц, цалин хөлсний шинэчлэл хэрэгжүүлэх гэвэл энэ хуульдаа баригдчихдаг. Төрийн албаны зөвлөл гэж төрийн байгууллагуудын дотоод ажилд хэт хутгалдаж байна. Тиймээс Төрийн албаны тухай хуулийг дээрх ангилал тус бүрээр нь бие даасан хууль болгож, Төрийн албаны зөвлөл үйл ажиллагааг төрийн захиргааны албаар хязгаарлах шаардлагатай гэж үзэж байна.</p> <p>Мөн бүсчлэн хөгжих шаардлага тулгарч буй өнөөгийн нөхцөлд орон нутгийн төрийн албан хаагчдыг орон нутгийн онцлогт нь тохируулан шалгаруулж авдаг байх нь зүйтэй. Тиймээс эрхэм Ерөнхий сайд та, төрийн албаны тогтолцооны шинэчлэлийг хийх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлийг хийх үү?</p>
--	--

--oOo--

1.3.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ 2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДРИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-ИЙН ТЭМДЭГЛЭЛ



Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан эхэлж байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдаас урьдчилан хүргүүлсэн асуултын дагуу асуулт асууж, хариулт авах Улсын Их Хурлын асуулгын цаг эхэлж байна. Өнгөрсөн хаврын чуулганаар Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 10 гишүүн санаачлан 2025 оны 6 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлж, 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх зохицуулалтыг Улсын Их Хурлын асуулгын цаг болгон өөрчилсөн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлд ээлжит чуулганы хугацаанд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайдад гишүүдээс хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад асуудлаар асуулт тавих Улсын Их Хурлын асуулгын цаг байна гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 9 дүгээр сарын Улсын Их Хурлын асуулгын цаг өнөөдөр албан ёсоор эхэлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.5-д Улсын Их Хурлын асуулгын цагийн нийт хугацаа 2 цагаас хэтрэхгүй Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах хугацаа цөөнхийн бүлэг 75 минутаас, олонхын бүлэг 15 минутаас, цөөнхийн гишүүдэд 30 минутаас хэтрэхгүй байна гэж заасны дагуу Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн 75 минутын 37.5 минутад цөөнхийн бүлгийн дарга урьдчилан ирүүлсэн асуултаа асууж мэтгэлцэнэ. Асуултын тоо 9-өөс хэтрэхгүй байна. Үлдэх 37.5 минутад асуулт ирүүлсэн цөөнхийн бүлгийн бусад гишүүд асуулт асууж, хариулт авна гэж заасан. Олонхын бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд 15 минутад багтаан асуултаа асууж, хариулт авна. Цөөнхийн асуулт ирүүлсэн гишүүд 30 минутад багтаан асуултаа асууж, хариулт авна. Ерөнхий сайдаас асуулт асуух, үг хэлэх хугацаа 2 минутаас хэтрэхгүй байх бөгөөд нэг удаа нэг минутаас хэтрэхгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, үг хэлж болно. Хариулт өгөх хугацаа 2 минутаас хэтрэхгүй

байх бөгөөд нэмэлт тайлбар өгөх хугацаа нэг удаа нэг минутаас хэтрэхгүй байна гэж хуульд заасан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9.9-д заасны дагуу асуулт ирүүлсэн гишүүдийн нэрс ирцэд бүртгэгдсэн дарааллаар эрэмбэлэгдэж байгаа тул гишүүд дарааллын дагуу асуултаа асууна. Нэр ирчихсэн байгаа тул эрэмбэд орно. Ингээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.9-д асуулт, хариултыг тусгайлан бэлтгэсэн индрээс асууж, хариулна гэж заасан. Ингээд Улсын Их Хурлын Тамгын газраас 1, 2 дугаар индрийг бэлдсэн байна. Засгийн газрын гишүүд Ерөнхий сайдын хариулт дээр нэмж хариулт өгч болно. Хариулт өгөхдөө тусгайлан бэлдсэн индрээс буюу 3, 4 дүгээр индрээс хариулт өгнө. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар нарыг тусгайлан бэлтгэсэн индэрт урьж байна. 1, 2 дугаар индэр дээр 37.5 минутаар микрофон шууд нээгдэнэ.

Асуулт асууж байгаа, хариулт өгч байгаа Улсын Их Хурлын гишүүд болон Засгийн газрын гишүүд минутаа барих ёстой. Одоо 37.5 минутад бүлгийн дарга асууна. Ингэхдээ хуульд заасны дагуу 2 минутаас хэтрэхгүй асууна, 2 минутаас хэтрэхгүй хариулна. Асуулт тус бүрийг 2 минутаар хязгаарлагдана.

Улсын Их Хурлын асуулгын цаг албан ёсоор анх удаагаа эхэлж байна. Мэтгэлцэгч талуудад амжилт хүсье. Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар болон Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл дарга нарын микрофоныг нээе.

О.Цогтгэрэл: Гишүүддээ өдрийн мэндийг хүргэе. Улсын Их Хурлын хуралдааны шинэ дэгээр Ерөнхий сайдын мэдээллийн цагийг Улсын Их Хурлын асуулгын цаг болгож өөрчилсөн. Агуулгын хувьд том өөрчлөлт гэж үзэж байгаа. Энэ удаа анхны хэлэлцүүлэг, анхны мэтгэлцээний асуулт, хариулт явах гэж байна. Ерөнхий сайдаа, таны анхны төсөв Улсын Их Хурлаар хэлэлцэж байна. Мөн өдрүүдэд танай Засгийн газрын анхны 100 хоногийн ажлын тайлан тавигдах гэж байна. Тэгэхээр зөвхөн уламжлалт нэг удаагийн төсөв биш, Монгол Улсын эдийн засгийг бүтцийнх нь хувьд яаж харж байгаа вэ? Алсын хараатай илүү холбоотой болов уу? гэж бодож байна. Тийм учраас зөвхөн төсөв гэдэг ярианаас гадна эдийн засаг талаас нь бид нэг жижигхэн зүйл бэлдсэн юм.

Энэ бол 100 их наядын Монгол Улсын эдийн засаг. Үүний 35 хувь нь одоо бидний хэлэлцэж байгаа Монгол Улсын төсөв, 30 хувийг нь төрийн өмчит компани эзэлж байгаа. Дахиад нэмээд 25 хувийг нь төрийн зохицуулалт буюу тусгай зөвшөөрлөөр ажилладаг бизнес эрхлэгч байна. Ингээд бараг сав дүүрч байгаа буюу төртэй холбоотой бизнес эрхлэгчид эдийн засгийн бүтцэд байгаа жижигхэн үрлүүд ба үндсэндээ иргэдийн бизнест ногдож байгаа хэсэг гэж үзэж болох юм. Тэгээд эдийн засаг эргэхээр юу болох вэ? Энэ 3 том бөмбөлөг Монголын эдийн засгийг, ард иргэдийг, бизнесийг тээрэмдэж байгаа. Одоогийн нөхцөл байдлаар ийм л орчин нөхцөлд эдийн засаг ажиллаж байна.

Төсөв өөрөө эдийн засгийг удирдах арга хэрэгсэл юм. Тэгэхлээр та зөвхөн төсвийн хүрээнд болон төсвийн бусад эдийн засгийн арга хэрэгслийнх нь хувьд энэ үүсээд байгаа нөхцөл байдлыг та юу гэж харж байна вэ? Сүүлийн жилүүдэд энэ 3 том бөмбөлөг тойрч тээрэмдээд бусдыгаа улам буталдаг тогтолцоонд эрчимтэйгээр явж байгаа. Энэ 3 нийлээд Монгол Улсын нийт эдийн засгийн 90 хувийг эзэлж байгаа. Зохицуулалттай төрийн өмч буюу 30 гаруй их наядын төсвөөс дутуугүй төрийн өмч Улсын Их Хурлын танхимаас тусдаа шийдвэр гардаг асуудал яригдаж байгаа. Тэгэхлээр та эхлээд эдийн засгийн бүтцийнх нь хувьд, эдийн засгийг удирдах арга хэрэгсэл болохынх нь хувьд энэ удаагийн төсвийнхөө онцлогийг тайлбарлаж өгөөч. Үүнд ямар өөрчлөлт гарч байгаа вэ?

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, өнөөдөр Монголын парламентын түүхэнд анх удаа мэтгэлцээн өрнүүлж байгаад баяртай байна. Бид парламентын шинэчлэл, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг анх санаачилж, хэрэгжүүлж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа парламент бол мэтгэлцээний танхим байх ёстой гэсэн зарчимд анх суурилсан. Өнөөдөр бодитой мэтгэлцэх бололцоо олдож байгаа, тэгэхдээ анхны туршилтын туулай болж байгаад нэг талаас баяртай, нөгөө талаас сонирхолтой байна.

Та чухал асуулт асуулаа. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд манай эдийн засгийн бүтэц үндсэндээ төрийн оролцоо хэт давамгайлсан, ТӨК-уудын эдийн засаг дахь оролцоо төдийгүй төсөвт гүйцэтгэх үүрэг нэлээн нэмэгдсэн бодит байдалтай байна.

Үүний улмаас шалтгаалаад Монгол Улсын эдийн засгийн экспортын 95 хувь нь уул уурхайгаас хамааралтай, тодруулбал хоёр бүтээгдэхүүн буюу нүүрс, зэсээс 80 хувийн хамааралтай байгаа. Гадаад худалдааны 70 хувь нь нэг улсаас хамааралтай ийм бүтцийн гажигтай болсон. Ийм учраас эдийн засгийн бодлогын хүрээнд 2025 оны 10 сарын 31-ний өдөр бидний өргөн барихаар төлөвлөж байгаа нийгэм, эдийн засгийг ирэх 5 жилд хөгжүүлэх үндсэн чиглэлд шинэ итгэл, эрс шинэтгэл гэсэн эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хийх зорилтуудыг тодорхой тусгасан.

Харамсалтай нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд цаглавар өөрчлөгдсөн учраас 9 дүгээр сарын 01-ний өдөр төсвийг нь өргөн барьдаг, дараа нь 10 дугаар сарын 30-ны өдөр нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ өргөн барьдаг зөрүүтэй, гажигтай тогтолцоо бий болчихоод байна. Тийм учраас таны асуулт уг нь тэр үед хэлэлцэгдэх асуудал, эхэлж энийгээ хэлэлцчихээд дараа нь төсвийн бодлоготойгоо тодотгон уялдах ёстой. Энэ цаглаварын зөрүүгээ Улсын Их Хурал засах хэрэгтэй.

2 дугаарт энэ жилийн төсвийг боловсруулахдаа бид иргэдийн оролцоотой, иргэдийн хяналттай, иргэдийн үнэлгээтэй байх зарчмыг суулгасан. Ингэснээр зөвхөн төр хуваарилдаг, түүнийгээ төрд зарцуулдаг биш, иргэдийн оролцоотойгоор төсвийн төслийг боловсруулдаг болгох шаардлагатай. Энэ удаагийн төсвийг боловсруулахад нийт 240 мянган иргэн саналаа өгсөн, түүнийг нь эрэмбэлж тусгасан. Одоо иргэдийн хяналттай хэлэлцдэг.../минут дуусав./

Г.Занданшатар: Таны асуусан асуултын хүрээнд хариулахад энэ цаглавар, бодлогоо өөрчлөх хэрэгтэй байна. Энэ төсвөөр эдийн засгийг бид танасан. Н.Алтанхуяг Ерөнхий сайд байсан хүн маш чухал пост, видео оруулсан байна. Тэр нь Засгийн газар төсөв барихдаа анх удаа зарлагын хязгааргүй өсөлтийг хязгаарлалаа, хэмнэлээр ийм төсөв оруулж ирсэнд баярлалаа гэж байсан. Өөрөөр хэлбэл уул уурхайн хамааралтай, баялгийн хараалтай гэдэг шиг урсгал зардлын өсөлтийг хяналтгүй тавьж байсныг бид хязгаарласан. Энэ хэмжээгээр төрийн оролцоог багасгасан. Бид төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшилд илүү боломж олгох зорилготойгоор эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, хувийн хэвшилд суурилсан өсөлтийг дэмжих чиглэлд татварын шинэчлэлийг 2026 оноос эхлэн үе шаттай хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсний зэрэгцээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хувиар хуулийг хялбаршуулан, хувийн хэвшлийн оролцоо.../минут дуусав/

О.Цогтгэрэл: Хувийн хэвшлийн орон зайг нэмсэн гэж байна. Энэ төсвийг харвал эдийн засаг дахь оролцоо 32 хувь болж буурсан тоо байгаа юм. Гэтэл энэ 32 хувьд багтахгүй төсвийн гадуур асар их зардал өмнө нь ч явж ирсэн, одоо ч байгаа. Монголбанк дээр жишээ нь төсвийн шинжтэй хэрэгжүүлчихсэн 7 их наядын өр Монголбанк дээр байгаа. Уг нь энэ өр төсөв дээр нэмэгдээд өөр тоо байгаа. Өнөөдөр бид өөрөө өөрсдийгөө хуурсан тоон дээр, төсөв дээр ажиллаж байгаа. Төсөв багасаад 32 болчихсон гэдэг. Жишээ нь төсөв дээр харахад төрийн өмчит ААН-ийг олон нийтийнх болгоно гэж байгаа. Гэтэл өнгөрсөн хугацаанд Төрийн банкиг олон нийтийнх болгосон, 5-хан хувийг нь хувьчилсан, тэгээд 95 хувь нь төрдөө хэвээр нь үлдсэн. 5 хувийн хувьчлалын үр дүнд 700 төгрөгөөр нэгж хувьцааны "IPO" гаргаж байсан Төрийн банк өнөөдөр 300 төгрөг болгосон байх жишээтэй. Ийм гоё лоозон, хэлбэрийн доор бид өнгөрсөн хугацаанд ажиллалаа.

Тэгэхээр бид чин сэтгэлээсээ төрийн оролцоог бууруулах гэж байгаа бол энэ тоонуудыг үнэн болгох, хувьчлал гэж байгаа бол 5 хувийг нь биш, 50 хувийг нь ядаж хувьчилж байж эрүүл эдийн засаг руу орно. Одоо дахиад 2026 онд МИАТ-ын 10 хувийг хувьчилна гэж байгаа. Тэгвэл ийм засаглалтай компанийн 10 хувийг хувьчлаад 90 хувь нь МИАТ-т байх нь бид зүгээр өөрөө өөрийгөө хуурсан бодлогын шинэчлэлийг л олон нийтэд танилцуулж байгаа.

Г.Занданшатар: Өнөөдөр төсвийн хэлэлцүүлэг явж байгаа гэж ойлгож байгаа. Эдийн засгийн чиглэлийг Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 10 дугаар сарын 31-ний өдөр өргөн барьж энэ талаар хэлэлцэнэ.

2 дугаарт өнөөдөр манай Засгийн газрын 100 дахь хоног тохиож байна. Энэ 100 хоногт мэдээж бүх асуудлыг өргөс авсан юм шиг засаад, энэ 30 жил бий болчихсон эдийн засгийн бүтцийг нэг өдөр бүгдийг нь хувьчлаад өөрчилнө гэж байхгүй. Харин ч энэ 100 хоногт уруудаж байсан эдийн засгийн сэргэлтийг бий болгож, эдийн засгийн өсөлт 5.7 хувьд хүрлээ. 1 дүгээр улирлын байдлаар 4.7 тэрбум ам.доллар байсан валютын нөөц 5.7 тэрбум ам.доллар болж өслөө. Бид 6 сард 570 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан төсвийг одоо 52 тэрбум

төгрөгийн ашигтай болгож чадлаа. Экспортын үнийг нэмэгдүүллээ, экспортын нүүрсний үнэ гээд байгаа нүүрсний хулгайн асуудлыг бид таслан зогсоож нүүрсний борлуулалтыг 13-аас 17 хувь хүртэл нэмэгдүүллээ.

Бид энэ том бүтцийн урт хугацааны өөрчлөлтийг хийх биш, өнөөдөр унаж байгаа, живэх гэж байсан эдийн засгаа яаж зогсоогоод сааруулаад, дээш нь босгох вэ гэдэг ийм үнэнтэй, хямралтай нүүр тулсан 100 хоногийг ардаа үдэж байна. Энэ 100 хоногийн хугацаанд бид өдөр, шөнөгүй борви бохис хийхгүй ажилласны үр дүнд эдийн засагт сэргэлт бий болгож чадлаа. Энэ бол 100 хоногийн бодит ажлын үр дүн. Бид юу хийснээ бүгдийг нь тоочих гээгүй, тоо худлаа хэлдэггүй учраас эдийн засгийн бодит үр дүнгээр нь тооцож байна. Хэрвээ төсвийн тодотгол хийж та бүхэн маань дэмжиж батлаагүй бол валютын ханш 4 мянгад, инфляц, үнийн өсөлт 15 хувьд хүрч болзошгүй эрсдэлтэй, төсвийн орлого 3.3 их наядаар тасрах бодит эрсдэлтэйд тулгарсан байсан. Бид төсвийн зарлагыг 2.2 их наядаар танасан төсвийн тодотголыг хийснээр төрийн оролцоог хумьсан, үр ашиггүй зардлуудыг танасан, төрийн албан хаагчид төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэн.

Энэ бүхний үр дүнд өнөөдрийн эдийн засгийн сэргэлтүүд бий болж байгаа. Энэ бол Улсын Их Хурал, Засгийн газрын хамтын ажиллагааны үр дүн гэж үзэж байна. Энэ чиглэлээр О.Цогтгэрэл гишүүн эдийн засагч хүний хувьд... /минут дуусав/

О.Цогтгэрэл: Ард иргэдээс асуулт, санал гарахаар эдийн засгийн асуудлаас гадна иргэдийн дунд бухимдал бий болгож буй авлигын асуудлыг төсөв гэлтгүй бид холбож ярих шаардлагатай болно. Тэгэхээр том биетийн сүүдэр том л байдаг. Авлига гэдэг өөрөө юу вэ гэдэг асуултад энгийнээр хариулах ёстой байх. Авлига гэдэг том төрийн сүүдэр. Том төрийн сүүдэр том авлига л байна гэж үзэж байгаа. Сүүлийн үед хэвлэл мэдээллээр гарч байгаа мэдээллийг харахад нэг нам завсаргүй олон жил засаглаад өнгөрсөн 10 жилийн хугацаанд социализм бий болгохоор яаж томордог вэ? Үүний цаана авлига тэр хэмжээгээр нэмэгдэнэ. Энэ том төрийн цаана том авлига, том хулгай л байгаа шүү дээ. Сүүлийн өдрүүдэд яригдаж байгаа үйл явц нь зүй тогтлын л асуудал гэж бодож байна.

Тэгэхээр та хууль сахиулах байгууллагыг хариуцаж байгаа хүний хувьд цаашид бид авлигатай яаж тэмцэх ёстой вэ? Хэчнээн мянган шүүгч, прокурор, цагдаа магадгүй хэдэн арван шорон бариад энэ авлигын ард гарах уу? Одоо та ямар бодлогын шийдлүүдийг танилцуулж байгаа вэ? Бид дахин, дахин нэг хэлбэрийн зүйлийг тал талдаа яримааргүй л байна.

Г.Занданшатар: Авлигатай тэмцэнэ гэдэг бол зөвхөн уриа лоозон биш. Тийм учраас Монгол Улсын Засгийн газар байгуулагдсан өдрөө авлигатай тэмцэх, авлигын индексийг бууруулах цогц хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж ажлын хэсэг байгуулж ажиллаж байна. Төрийн нарийн бичгийн дарга нарыг оролцуулсан авлигатай тэмцэх чиглэлээр ажлын хэсэг ажиллаж байна. Жишээлбэл, 1-д дээр, дооргүй авлигад идэгдчихээд, ард түмний итгэлийг унагааж байгаа

асуудлыг шалгаж нэг тийш нь болгох хэрэгтэй. Авлигын сүүдэр өнөөдрийн эдийн засгийн хамгийн том хорлогч хүчин зүйл учраас тууштай тэмцэх хэрэгтэй. 2-т авлигын нөхцөлийг бий болгож байгаа дунд, доод шатын хүнд суртлыг арилгах, тодорхой хэлбэл цахимжуулах, хиймэл оюун ухааны шийдвэр гаргах төслүүдийг хэрэгжүүлж байна. “Эрдэнэтийн шахаа” гэж ярьдаг байсан Эрдэнэт үйлдвэр дээр худалдан авах ажиллагааг хиймэл оюун ухаанаар зохион байгуулдаг шинэ систем нэвтрүүлж байна. Үүнийг төрийн өмчийн бүх компанид нэвтрүүлж, хиймэл оюун ухааны оролцоотой, хяналттай худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг болно.

Цаашилбал мөрдөн шалгах аливаа үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтын тогтолцоог хиймэл оюун ухаанаар хийхийг зорьж байна. Технологийн дэвшлийн “ICT” форумыг өнөөдөр нээж зохион байгуулж байна. Долоо хоногийн “tech week” дээр та бүхэн оролцоод, энэ талаар тодруулж болно. Гэхдээ эцсийн дүнд Улсын Их Хурал өөрөөсөө, төр дээрээсээ цэвэр ариун, ёс суртахуунаа дээдэлдэг, зарчимтай байж авлигатай тэмцэж чадна. Энэ бол зөвхөн Засгийн газрын ажил биш бүх нийтийн үйлс байх ёстой. Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааны үр дүнд, хууль сахиулах байгууллагуудаа дэмжиж, хараат бус байдлыг нь хангаж байж энэ авлигаас сална. Энэ чиглэлд сөрөг хүчин хамгийн том хяналт тавьж ажиллах ёстой парламентын механизм юм.

О.Цогтгэрэл: Тэгэхээр хяналтыг ихэсгэж байж авлигатай тэмцэнэ гэдэгтэй би санал нийлдэггүй. Хэчнээн мянган цагдаа, прокурор, шорон бариад авлигатай тэмцэхгүй байх, бууруулж чадахгүй байх. Энэ том биетийг багасгаж байж авлигын сүүдрийг бууруулах ёстой, үндэс шалтгаантай нь тэмцэх ёстой байх гэдгийг хэлье.

Дараагийн асуулт нь яг одоо төсөв хэлэлцэхтэй зэрэгцээд гадаа олон нийт, багш нар жагсаж байна. Энэ хаалган дээр ахмадууд өлсөнө гэж байна. Тэгэхээр үүний цаана нөгөө худалдан авах чадвар, үнийн өсөлт гэдэг зүйл яах аргагүй амьдрал дээр тулдаг. Судалгаагаар ч хамгийн өндөр гардаг зүйл байх. Засгийн газар үнийн өсөлт бидэнд хамаагүй, мөнгөний ханш бидэнд хамаагүй, Монголбанкны асуудал гээд түлхчихдэг. Одоо хэдэн их наядын төсөв хэлэлцэж байгаа. Гэтэл амьдрал дээр иргэдэд GDP хэдэн хувь эзэлж байгаа нь хамаагүй байх. Харин бодит худалдан авах чадвар яаж байна, бидний цалин хүрч байна уу, тэтгэвэр, тэтгэмж маань яаж байна гэдэг хамгийн чухал асуудал байх.

Тэгэхээр дээр дурдсан асуудлыг Монголбанкны асуудал гэж Засгийн газар түлхчхээд, өөрөө төсвөө, төрөө асар том болгоод, нөгөө бизнес эрхлэгчдэд орон зайг нь олгохгүй, ажлын байр бий болгохгүй, хөрөнгө оруулалт орж ирэхгүй, иргэдийн худалдан авах чадвараас гадна мөнгөний ханш 10, 20 хувиар унаж байгаа оронд хэн, ямар хөрөнгө оруулалтаа гадна, дотноос хийх вэ? 10, 20 хувиар унаж байгаа инфляцтай газар бодлогын хүү хэд байх вэ? Энийг дагаад зээлийн хүү хэд байх вэ? Ийм зээлийн хүүгээр хэн нь хөрөнгө оруулалт оруулах вэ? Үүний цаана нөгөө үнийн өсөлт байхаас өөр аргагүй. Бид тэтгэврийг 1.5-15.0 сая болгосон ч ийм өндөр инфляцтай үед ямар ч үр ашиггүй бодлого болно. Тэгэхлээр Засгийн газар өөрт хамаагүй гэж түлхдэг энэ үнийн өсөлтийн эсрэг ямар бодлого барьж байгаа вэ?

Г.Занданшатар: О.Цогтгэрэл даргаа, олон асуулт байгаа учраас эрэмбэлбэл 1 дүгээрт, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулахын тулд бид төрийн өмчийн компаниудын үр ашгийг сайжруулах цогц төлөвлөгөө боловсруулаад Засгийн газрын хуралдаанаар 2 удаа хэлэлцээд, Улсын Их Хуралд өргөн барихаар ажиллаж байна. Энэ хүрээнд төрийн өмчийн компаниудын зардал чирэгдэл, үр ашиггүй зардлыг бууруулж байна. Үр ашиггүй төрийн өмчийн компаниудыг нэгтгэж байна. Жишээлбэл баруун бүсийн эрчим хүчний дулаанаас эхлээд 9 компанийг нэгтгэж, татан буулгах ажлууд зохион байгуулж байна. Дээр нь хувийн хэвшилд шилжүүлэх, хувийн хэвشلээр гүйцэтгүүлэх ажлууд, хувьчлалын хэсэгчилсэн болон бүтнээр нь IPO гаргаж, олон нийтийн хувьцаат компани болох зэрэг цогц ажил хэрэгжиж байгаа. Төсөвтэй шууд хамааралгүйгээр төрийн өмчийн үр ашгийг сайжруулах үндсэн чиглэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлнэ. Энэ үед илүү дэлгэрэнгүй ярих бололцоо олдох байх.

2 дугаарт, мэдээж төрийн оролцоо багасаж байж тэр хэмжээгээр авлига, шударга ёсны индекс сайжирна. Төрийн өмчийн компаниудын үр ашгийг дээшлүүлэх, хяналт шалгалтыг сайжруулах, авлигатай тэмцэх ажил зайлшгүй тэргүүн эгнээнд явах ёстой. Улсын Их Хурлаас баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр бодитой хэрэгжих ёстой.

3 дугаарт нь, төсөв татвараар бүрдэж байгаа ч нэг талаас татварыг бууруул гээд, нөгөө талаас цалин, тэтгэвэр, тэтгэмжээ нэмэгдүүл гээд байдаг. Ийм 2 асуудлын дунд төсвийн баланс, тэнцвэрийг олоход нэг талаас хувийн хэвشلээ дэмжих, нөгөө талаас цалин, тэтгэвэр, тэтгэмжээ нэмэгдүүлэх асуудал тулгарч байгаа. Ганцхан нүүрс, зэсээс хамааралтай шахуу болчихсон төсвийн орлого нь ийм хайчин дунд байна. Олон улсын нөхцөл байдал, геополитик, тарифын дайнаас шалтгаалаад нүүрсний үнэ 2 дахин унаад байна. Яг ийм нөхцөл байдалд энэ бүх реформыг нэгэн зэрэг хийх ямар ч бололцоогүй. Та эдийн засагч хүний хувьд үүнийг сайн мэдэж байгаа. Нэг талдаа татварыг бууруулахад төсвийн орлого буурна, нөгөө талдаа тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлсийг яаж... /минут дуусав/

О.Цогтгэрэл: Би үргэлжлүүлээд асууя. Саяын үнийн өсөлт инфляц бодит байдал дээр нийгмийн ядуу хэсгийг улам ядууруулдаг, нөгөө дундаж давхаргаа улам хавчдаг ийм л хөшүүрэг, ийм л хамгийн харамсалтай үр нөлөөтэй тогтолцоо юм. Тийм учраас өнгөрсөн хугацаанд үнийн өсөлтийн явцыг харахад ядуурал нэг ч хувиар буурсангүй, 3 хүний 1 нь ядуу гээд л бид бүгдээрээ ярьдаг боллоо. Дундаж давхаргын доод хэсэгт дахиад 3 хүний 1 нь бага зэрэг хөл сэгсрэлтэд тээрэм нь ажиллаж 3 хүний 1 нь буюу нийт 3 хүний 2 нь ядуурлын шугамд орчихлоо.

Засгийн газрын бодлогын бичиг баримтуудад дундаж давхарга гэдэг ойлголт, үг, хэмжүүрийг өнгөрсөн хугацаанд олж хараагүй. Тэгэхээр 1 дүгээрт, дундаж давхаргыг Засгийн газар хэрхэн, яаж томьёолж, тооцож төсөв болон бодлоготой байхыг зорих ёстой шүү дээ. Ер нь нэг юмыг сайхан болгоно гэж биш, тодорхой тоо, хэмжүүртэй, алсын хараатай ямар ажлыг та нар хийж байгаа вэ?

2 дугаарт нь одоо таны өргөн барьж байгаа төсөв болон эдийн засгийн бодлого дээр хөдөлмөрлөсөн хүн сайхан амьдардаг талаар бодлогын ямар өөрчлөлт энэ төсөвт тусгасан бэ? Хөдөлмөрлөсөн нь сайхан амьдардаг тогтолцоо, хөшүүрэг, механизм, урам зориг энэ төсөвт шингэсэн үү? Та энэ талаар мэдээлэл өгөх үү?

Г.Занданшатар: Энэ төсөв бол эдийн засгийн мөчлөгийг сөрсөн төсөв. Гадаад нөхцөл байдал, дотоод улс төрийн нөхцөл байдал энэ бүхнээс шалтгаалаад төсвийн орлого бодитойгоор буурчихсан. Гэхдээ энэ төсөвт бид, жишээлбэл, дундаж давхаргаа бодлогын хүрээнд НӨАТ-ын буцаан олголтыг 2 хувиас 5 хувь болгож нэмэгдүүлэх замаар нийт НӨАТ төлөгчдийн 75-80 хувьд нь өгөөжтэй байх шинэ хэлбэрийг оруулж ирж байгаа. Жишээлбэл 4 ам бүлтэй айл жилдээ ойролцоогоор 2 сая 500 мянган төгрөгийг буцааж авна гэсэн үг. Нийт иргэдийн 80 хувь нь сард 1 сая хүртэл төгрөгийн худалдан авалт хийж байхад 20 хувь нь илүү чинээлэг хэсэг байж болно. Тийм учраас дундаж давхарга гэж орлого багатай хэсгээ дэмжсэн бодлогыг бид төсөвт оруулж ирсэн.

Таны хэлдгээр төсөв төвлөрүүлээд, төр хуваарилах биш, иргэдэд өөрсдөд нь нийт дүнгээр 560 тэрбум төгрөгийн орлогыг эргэж үлдээж байгаа. Энэ үржүүлэгчийн эффектээр далд эдийн засгийг ил болох, татварын суурь реформыг хийх, хэрэгжүүлэх суурь болох юм. НӨАТ бол зөвхөн төсөв бүрдүүлэгч биш, бүртгэлийн үүрэг рольтой. Ийм учраас далд эдийн засгийг ил болгоод, илүү татварын бааз суурийг шударга, нээлттэй болгох ба энэ суурин дээр татварын цогц реформыг хэрэгжүүлж, нийт татвар төлөгчдөд учирч байгаа татварын ачааллыг 3-4 их наяд төгрөгөөр бууруулж, тэр хэмжээгээр төрийн оролцоо багасах, хувийн хэвшлээ дэмжих бодлогын эх суурийг энэ төсөвтэй хамт оруулж ирж байгаа юм.

Ийм учраас татварын реформыг бүгдийг нь оруулж ирээгүй. Эхлээд НӨАТ-ын хуулийг хамт өргөн бариулж, НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлэх замаар үндсэндээ 1, 2 сая татварын байцаагчтай болж байна гэсэн үг. Тэд И-баримтаа нэхэнэ гэсэн үг. Үүнтэй холбоотойгоор дижитал шилжилтийн хүрээнд энэ долоо хоногоос И-баримтыг нэвтрүүлж байна. Цаасаа цуглуулдаг биш И-баримтаар.../минут дуусав/

О.Цогтгэрэл: Саяын асуултыг би дахиад л тодруулмаар байна. Жишээ нь тэр дундаж давхаргатай холбоотой ямар хэмжүүр, зорилгыг манай Засгийн газар тавьж байгаа вэ? Энэ танхимын мэдээлэл гэхээсээ илүүтэйгээр олон нийтэд, бизнесүүдэд, зориулагдах бөгөөд бизнесүүд бодлогоо өөрөө тодорхойлохоос эхлээд олон зүйл дээр анхааруулсан шинжтэй байх гэж бодож байна. Тэгэхээр дундаж давхарга гэдэг хүн амын хэдэн хувиа хаашаа, юунд зориулж, энэ нь ямар эдийн засгийн орлого, чадавхтай хүмүүсийн төлөө бид зориод байгаа вэ гэдэг магадгүй бидний ярьж байгаа энэ бүх зүйлийн огтлолцол дээр очих ёстой байх гэж бодож байгааг дахин хэлье.

Өнгөрсөн хугацаанд уул уурхайн бүтээгдэхүүн өндөр өсөлттэй явж ирсэн үед тооцож үзэхэд 10 төгрөг тутмын 3-ыг нь бид халамжид зарцуулчихсан байна. Гэсэн хэдий ч ядуурал 1 хувиар ч буураагүй. Тэгэхээр энэ бүгдийн цаана бидний

чиглэсэн зорилго, дундаж давхаргатай холбоотой ойлголт байна уу? гэж дахин танаас тодруулах гэсэн юм. Үүн дээр тодорхой мэдээлэл өгөөч?

Г.Занданшатар: Ер нь нийгмийн дундаж давхаргыг бий болгох бол нэг удаагийн төсвөөр юм уу, нэг удаагийн эдийн засгийн бодлогоор хэрэгжүүлэх асуудал биш. Энэ орлогын ялгаа, Жини коэффициентоор тодорхойлогдоно. Манай улс дахь орлогын ялгаа бол уул уурхайн эдийн засаг, баялгийн тэгш, шударга бус хуваарилалтаас шалтгаалаад, дээр нь авлигаас шалтгаалаад гүнзгийрчихсэн. Уул уурхайн эдийн засгийн өндөр өсөлттэй байх үед тэр орлого нийгмийн цөөн хэсэгт төвлөрдөг. Уул уурхай бол “capital incentive” буюу хөрөнгө их шаарддаг, тэгэхдээ “liber incentive” биш, хөдөлмөр бага шаарддаг салбар.

Гэтэл хөдөө аж ахуй, аялал жуулчлал, дижитал гэсэн 3 салбарыг хөгжүүлэх асуудлыг 2025 оны 10 сарын 31-ний өдөр өргөн барих нийгэм, эдийн засгийн чиглэлд тодорхой, бодитой тусгаж ирнэ.

Энэ татварын реформ дээр дундаж давхаргаа дэмжих хөнгөлөлтийн бодлогын хүрээнд жишээ болгоод зөвхөн НӨАТ-ын талаар хэллээ. 3-4 их наядын татварын хөнгөлөлт нь дундаж давхаргаа дэмжих хөнгөлөлтийн бодлого болно. 800 мянга хүртэлх татварыг хөнгөлж чөлөөлнө. 1 хувийн татварын бодлогоор жижиг, дунд бизнес эрхлэгчдээ дэмжинэ. Та бүхэн цогц өөрчлөлтүүдийг www.parliament.mn дээр тавьсан татварын реформ дээрээс харж болно. Энэ бол татварын реформ төсөвтэй уялдаж байгаа хэсэг нь юм.

Хөдөө аж ахуйг цогцоор нь дэмжих эдийн засгийн чөлөөт худалдааны хэлэлцээрийн дагуу 184 сая хүнтэй 2.4 триллион их наяд ам.долларын зах зээл рүү бид хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, энэ чиглэлийн жижиг, дунд бизнесээр эдийн засгаа солонгоруулах боломжийг бүрдүүлэх, энэ бүгд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, жижиг, дунд бизнесээ дэмжих, дундаж давхаргыг бий болгох ийм цогц бодлого юм. Энэ нь 300 мянган малчид, оёдлын салбар, “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн гээд цогц бодлогын хүрээнд хэрэгжих тул 2 минутын дотор дундаж давхаргыг, эсвэл 100 хоногийн дотор Монголын эдийн засгийг бүтцээр нь бүрэн өөрчлөх боломжгүй. Үүнийг бид 2025 оны 10 сарын 31-ний өдөр орж ирэх нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 5 чиглэл дээр О.Цогтгэрэл даргыг хамтран ажиллахыг уриалж байна.

О.Цогтгэрэл: Төсөвтэй холбоотой ганц, хоёр асуулт асууя. Монгол Улсын нэгдсэн төсвийг ярьж байгаа. Нэгдсэн төсвийн нэг том бүрдэл хэсэг нь орон нутгийн төсөв. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд төсвийг харж байхад орон нутгийн төсөв гээд баахан татаасны тухай л яригддаг. Тэгэхээр төсөв гэдэг орлого, зарлагын тэнцлээс гадна эдийн засгийн арга механизм, хөшүүрэг, энэ нь ашиглагдаж байх ёстой гэдэг үүднээс өнөөдрийн Улсын Их Хурлын асуулгын цагийг эдийн засгийн арга механизм талаас нь нэршил өгсөн. Аймгуудын асуудал өмнөх төсвүүд дээр байдаггүй. Харин одоо энэ төсөвт аймгууд бие дааж төсвөө санхүүжүүлдэг болох, төвөөс бага татаас авахаар тийшээ урамшуулдаг, дэмждэг ямар тогтолцоо Монгол Улсын төсөвт байна вэ?

Өнгөрсөн хугацаанд төсөвт аймгуудын асуудал байхгүй явж ирэхээр орон нутагт ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалт орохыг тухайн орон нутгийн удирдлагууд дэмждэггүй. Тэгээд нэг улс төр хийсэн хэдэн хүн, дээрээс төвөөс татаас авдаг. Энэ 21 аймгаас өнгөрсөн жил 4 аймаг л татаасгүй, бусад нь татаастай л байсан. Тэгээд бүгдээрээ татаас авдаг мөртөө нэг улс төрийн уриа лоозон хэлсэн хэдэн хүн байдаг. Илүү орлого олохоор яадаг юм бэ? Тэгэхээр та энэ төсвийн шинэчлэлийн хүрээнд эдийн засгийг удирдах арга хэрэгсэл, төвлөрлийг сааруулах нэг том бодлогын арга хэрэгсэл болохынх нь хувьд орон нутгийг яаж урамшуулж, магадгүй шахаж, шаардаж Засаг дарга нарыг төсвөө бүрдүүлээгүйг нь яаж юм, бүрдүүлснийг нь яаж урамшуулж байх юм бэ? гэдэг дээр мэдээлэл өгөөч?

Г.Занданшатар: Манай эдийн засагт тулгарч байгаа нэг асуудал Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1-д байдаг шиг санаж байна. Аймаг, сум бол нийгэм, эдийн засгийн цогцолбор байх ёстой. Ер нь “corporate body” буюу корпоративны байгууллага байх ёстой гэсэн санааг нийгэм, эдийн засгийн цогцолбор гээд арай зөрүүтэй орчуулчихсан гэж Чимэд гуай хэлж байсан байдаг. Тэгээд энэ нь бие даасан, корпорацийн шинж чанартай, татвартай, орлоготой, өөрөө өөрийнхөө асуудлыг шийддэг эдийн засгийн нэгж байх ёстой. Харамсалтай нь эрх мэдлийг нь ч олгодоггүй, төсөвт бүгдийг нь татан төвлөрүүлчихдэг учраас аймаг, сум бүгд төсвөөс хараат болсон. Сумууд өмнө нь авч явж, өөрөө өөрийнхөө хөрөнгө оруулалтыг шийддэг байсан юм байна лээ.

Тийм учраас дунд, урт хугацааны зорилт байх болно. Энэ хүрээнд эхний ээлжид АМНАТ-ын 10 хувийг орон нутагт нь үлдээдэг болсон. Цаашдаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 20 хувийг үлдээх, үл хөдлөх хөрөнгийн татвар, малын хөлийн татварын орлогуудыг сумын “Орон нутгийн хөгжлийн сан”-д үлдээдэг хуулийн зохицуулалтыг хийсэн. Цаашид орон нутаг өөрөө орлого олдог, төсвийн эрх мэдлийг хуваарилах зарчмаар бие даасан, улсын төсөв хараад суудаг биш, орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх боломжийг өгөх засаг захиргааны нэгжийн шинэчлэлийг хамтдаа хийж, хэрэгжүүлэх ёстой. Тэгэхгүйгээр өнөөдөр уул уурхайгаас хамааралтай эдийн засгаас болоод зарлагаа хэт тэлчихсэн хүндрэлтэй нөхцөл байдалд орон нутгууд байна. Өнөөгийн ийм нөхцөлд орон нутгийг биеэ даах ёстой гээд шууд орхих боломж хязгаарлагдмал тул цаашид татвар, эдийн засгийн боломжийг өгөх хэрэгтэй. Жишээлбэл би Улсын Их Хурлын дарга байхдаа, Улаанбаатар хотын хөгжлийн тухай хуулийг баталж, Улаанбаатар хотод бонд гаргах, “corporate” буюу корпорацийн шинж чанартай үйл ажиллагаа явуулах боломжууд.../минут дуусав/

О.Цогтгэрэл: Төсвийн хуультай хамт өргөн баригддаг нэг томоохон хууль бол Ирээдүй өв сан, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, түүнтэй холбоотой харилцаанууд байдаг. Тэгэхлээр өнгөрсөн хугацаанд өмнөх Засгийн газрын үед Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг өргөн барьж батлуулсан нь дэвшилттэй хэрэг. Тэгэхдээ үндсэндээ “нүглийн нүдийг гурилаар хуурна” гэдэг зүйл болсон. Олон улсын жишиг, агуулга уг хуульд ерөөсөө байхгүй. Олон улсын менежментийг хийх засаглалын тухай агуулга, ойлголт байхгүй. Харин өмнө хэлснээр олсон орлогынхоо 30 хувийг хэрхэн, яаж халамж болгож тараах

вэ гэдэг бодлогын механизмыг гоё “Баялгийн сан” гэдэг сүүдэр доор хийчихсэн. Хуримтлалын сан гэж нэрлэнгүүтээ тэрийгээ Халамжийн сайдын багцад өгчихсөн. Иймд Баялгийн сан гэж юу байх вэ? 3 дэд сантай, нэгдээд ямар ч удирдлага, менежмент байхгүй.

Тэгэхээр энэ Баялгийн сан гэдэг зүйлийг зүй зохистой болгох чиглэлд яг үндсэндээ Монгол Улсын Засгийн газраас бодлогын өөрчлөлт хүлээгдэж байна гэж боддог. Өнгөрсөн хугацаанд Ардчилсан намын бүлгээс 2022 онд байна уу, Баялгийн сангийн тухай хуулийн нэг ажлын хэсэг байгуулаад яг саяын зарчмын өөрчлөлт, зарчмын зүйлүүд дээр бид санал нэгдэхгүй, нэгтгэж хэлэлцүүлэх боломжгүй юм байна гэж үзсэн. Энэ нь нэг хэлбэрийн, хайран юмыг яйран болгож байна гэдэг үүднээс нэгтгэж хэлэлцүүлээгүй. Тэгэхээр төсөв болон төсвийн дараа Баялгийн сангийн менежментийг үр дүнтэй болгох талаар ямар бодлого, төлөвлөгөөтэй байгаа вэ? Энийг олон улсын жишигт нь оруулах юм уу, оруулахгүй юм уу? Гоё сайхан нэг шүхэр доор элдэв янзын халамжийн сан, улс төрийн арга хэрэгсэл, сонгуулийн өмнө мөнгө тараах арга хэрэгсэл болгож цаашид энэ Баялгийн сан гэсэн нэрээр ашиглаж явах юм уу?

Г.Занданшатар: Энэ маш чухал асуулт, санал байна. Та өөрөө энд тодорхой хэмжээгээр хариулчихлаа. 2015 онд Үндэсний баялгийн санааг анх Ирээдүйн өв сан хэлбэрээр оруулж ирсэн, Норвегийн Баялгийн сангийн тухай хуулийг үндсэндээ хуулчихсан. Норвег улс баялгаараа бүх асуудлаа ажилгүйдэл, ядуурал, орон сууцжуулалт бүгдийг нь шийдчихсэн. Ганцхан далайгаа яаж цэвэрлэх вэ гэдэг асуудал ярьдаг ийм хөгжингүй улсын жишээг манайх аваад ирэхээр баялгийн өгөөжөө зөвхөн ирээдүйдээ үлдээнэ гэхчихсэн. Ийм учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд Үндэсний баялгийн үзэл санааг томъёолж оруулахдаа одоо ба ирээдүй үед гэж би онцолсон байгаа. Одоо энэ хүүхдүүд сургуульгүй байхад, ажилгүйдэл, ядуурал, гэр хороололд амьдарч байхад бид үүн дээр илүү анхаарч байж ирээдүйгээ сайн сайхнаар бүтээнэ.

Ийм учраас одоогийн бидний Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн цаашдын менежмент, үйл ажиллагааг жишээлбэл Ирээдүй өв сангийн тухай хуулиар гадаадад Ирээдүй өв сангийн мөнгийг байршуулна гэж заасны дагуу 3-хан хувийн хүүтэй байршуулаад байна. Энэ хуулиа засах хэрэгтэй байна. Үүнийг дотооддоо Орон сууцжуулалтын банкны эх үүсвэр болгож ашиглавал доод тал нь 6 хувиар өсөх төдийгүй нийгмийн асуудлыг, хөрсний бохирдлыг, агаарын бохирдлыг шийдэх бодитой гарц шийдэл болно. 80 мянган айлыг орон сууцжуулах хөтөлбөрийг, Орон сууцжуулалтын хөтөлбөрийг бид хэрэгжүүлж чадна. Агаарын бохирдлыг бид түлшээр, зуухаар шийдэхгүй, зөвхөн орон сууцжуулж байж шийднэ. Ирээдүй өв сан маань, харин одоо үедээ бодитой шийдэл болсон Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан орон сууцжуулалт, Хуримтлалын санг бодитой болгох орчин үеийн хувилбарыг боловсруулаад, Монгол Улсын Засгийн газраас Үндэсний орон сууцжуулалтын хөтөлбөр, Орон сууцжуулалтын банкны үзэл санааг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдэж ажиллаж байна. Манай Э.Бат-Амгалан сайд 80 мянган айлын орон сууц.../минут дуусав/

О.Цогтгэрэл: Хуралдаан зохион байгуулах газраас сүүлийн асуулт асуугаарай, цаг болсон гэж надад хэлж байна. Ер нь олон асуулт байна. Би нэг асуултыг асуучихъя.

Бид татвар ярихаар татварын хувь ярьдаг, манай НӨАТ өндөр биш 10 хувьтай, 2-ыг нь буцаахаар 8 хувьтай байгаа нь өндөр биш гээд ярьдаг. Гэтэл татвар нийлэхээр эдийн засаг дахь татварын ачаалал гэдэг юу болж байна вэ? Буцаан төлөх утгагүйгээр суутгаж авч байгааг бүгдийг нь татвар гээд үзвэл албан татвар, хураамж, шимтгэл гээд олон зүйл нийлээд татварын ачаалалд орно. Тэр байтугай манай Монгол Улс өөрөө бизнес эрхлэхэд газар зүйн татвартай орон. Далайгаас алслагдмал, төмөр зам, дэд бүтэц маань хэдэн километр цагийн хурдтай ямар билээ. Дахиад дээр нь нэмээд жилийн 10 хувийн, бараг давхар оронтой тоонд орчихсон шахуу инфляцтай. Энэ бүгд далд бус татварууд. Энэ бүгд нийлэхээр татварын ачаалал болоод Монгол Улс асар өндөр татварын ачаалалтай орон. Гэхдээ бид яг хэлэхээр НӨАТ ч, хүн амын орлогын албан татвар ч их биш гээд жижиглээд татварын тухай ярьчихдаг. Тэгэхлээр яг өнөөдөр нийт татварын ачааллын талаар та нэг мэдээлэл өгөөч?

Миний бодлоор Монгол Улс газар зүйн татварыг, инфляцыг нэмбэл бид асар өндөр татварын ачаалалтай улс болно. Тэр тусмаа даатгал гэж хэлдэг, нийгмийн даатгалын хувьд хүн өөрөө төлсөн мөнгөндөө сэтгэл хангалуун бус байгаа учраас миний хуримтлал биш, надаас төр булааж авч байгаа юм гэж иргэд үүнийг татвар гэж ойлгоод байна. Тэгэхлээр тухайн нэг татвар гэхээс урьдаар, энэ бүгдийг нийлүүлэхээр татварын ачааллыг та ер нь яаж бууруулна гэж харж байгаа юм бэ?.

Г.Занданшатар: Манай хувийн хэвшлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа хувь 72.5 хувь байдаг, дундаж давхаргыг 51.2 хувь гэж хамгийн сүүлийн статистикаар тооцсон. Ядуурлыг бас буурсан гэж тооцоод, Улсын Их Хурлын харьяа Үндэсний статистикийн хорооноос гарсан байсныг та бүхэн үзэж танилцаж болно. Гэхдээ татварын бодлогыг би түрүүн Танд хэлсэн. Татварын реформыг татварын бааз суурь, бүртгэлээ ил тод, сууриа сайжруулж байж тэр суурин дээр татварын реформыг хийхээр зориод хэлэлцүүлж байна. Энэ талаар Улсын Их Хурлын гишүүд ажиллах нээлттэй гэж хэлсэн.

Энэ тооцооллоор би түрүүн Танд хэлсэн нийт татварын дарамт, ачааллыг 3-4 их наядаар бууруулах зорилготой татварын реформыг хэрэгжүүлж байна. Энэ хэмжээгээр татварын бааз сууриа тэлэх ёстой, татварын тэгш, шударга систем бий болох ёстой. Төлдөг нь хохирдог, төлдөггүй нь хождог системийг өөрчлөх ёстой. Аль ч дэлгүүр хоршоо, зах дээр очоод худалдан авалт хийхэд НӨАТ-тай юу, НӨАТ-гүй гэж асууж байна. Илт хууль зөрчөөд НӨАТ-гүй авбал 5 хувиар хямдруулна гэж байна. Байшин барихад сууриа засаж байж дээшээ зөв барих ёстой байдагтай адил эхлээд энэ системийн суурийг засах хэрэгтэй. Ийм учраас өнөөдөр НӨАТ-ын асуудал төсөвтэй орж ирж байгаа. Эдийн засгийн бодлогын асуудлын хүрээнд Нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл дээр эдийн засгийн бүтцийг өөрчлөх цогц төлөвлөгөө, бодлоготой орж ирнэ. Энэ чиглэлээр эрчим хүч, боловсрол, эрүүл мэнд цогц хөтөлбөрөөр энэ төсөвт тусгалаа олсон

байгаа. Мэдээж дэлхий дээр татваргүй улс гэж байхгүй, татваргүй төр гэж байхгүй. Дэлхийн бүх хувийн хэвшил татвараа бууруулаач гэж байгаа. Харин татварын бааз сууриа өргөтгөж, тэгш, шударга систем бий болгож байж энэ орлогоо ч алдахгүй, ачааллаа ч бууруулах жигд нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Тэгэхгүй бол нөгөө талдаа цалин, тэтгэвэр, тэтгэмжээ нэмэх хэрэгтэй байдаг, бууруул гээд байдаг, хувь хэмжээг л бууруулах талаар яриад байдаг биш, бааз сууриа өргөжүүлж байж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Бүлгийн даргын 37.5 минутын хугацаа дууслаа. Дараачийн шат буюу цөөнхийн бүлгээс асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна. Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй байна. Гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асуух болно. Эхлээд С.Эрдэнэболд гишүүн, дараа нь Ө.Шижир гишүүн. Гишүүдийг индэрт ойртохыг хүсэж байна. 2 дугаар индрийн микрофоныг өгье. 2 минутад багтаж асуултаа асууна, шаардлагатай бол 1 минутын нэмэлт асууна.

С.Эрдэнэболд: Эрхэм Монгол Улсын Ерөнхий сайдаа, асуулт асуухаасаа өмнө Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.1-ийг уншмаар байна. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ гэж байгаа. Энэ бол оюун санааны нийгэм, эдийн засаг, улс төр гээд өргөн хүрээтэй сэдэв. Тэгээд энэ дотор эдийн засгийн аюулгүй байдал бол асар чухал. Шууд утгаараа төсөвтэй холбогдож байгаа. Улс орон хэдий хэмжээний төсөв бүрдүүлээд, түүнийг нь яаж зарцуулж байгаа, тэр нь үнэхээр хөгжил дэвшлийг авчирч чадаж байна уу, үгүй юу гэдэг асуултын тухай бид ярьж байгаа. Тэгэхээр энэ төсөв өөрөө асар том гажуудал, шударга бус зүйл, өрсөлдөөний тэгш бус байдлыг бий болгож байгаа. Үүнийг сая Ардчилсан намын дарга, бүлгийн дарга дурдаж байна.

Гол асуудал нь өнгөрсөн жил Засгийн газар байгуулагдахдаа 578 зүйл, заалттай мөрийн хөтөлбөрийг “Хурдтай хөгжихийн төлөөх зориг” гэж мөрийн хөтөлбөрийг баталсан. Үүнийг 11 хэмжих нэгжээр 4 жилийн хугацаанд хэмжинэ. Хүний хөгжлийн индексийг 2 оронтой руу оруулна, авлигын индексийг ингэж бууруулна, өрсөлдөх чадварын индексийг ингэж сайжруулна гэдэг 11 хэмжих нэгжтэй зүйл тавьчихсан. Гэтэл төсөв нь зөвхөн тоо яриад байгаа болохоос биш, энэ хөгжлийг авчрахын төлөө нөгөө 11 хэмжих нэгжийнхээ шалгуур үзүүлэлтийг хангах дээрээ асар том алдаатай болчихсон. Тэгэнгүүт одоо яаж байна гэвэл төсвийг эрэмбэлэх боломжгүй болчихсон. Уг нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд төсөв нийцэж байгаа эсэхийг аудит хянах ёстой байтал хэмжих тэр хэмжүүр нь 15 жил тодорхойгүй байсан. Тэгэхээр хэмжих үзүүлэлт нь тодорхойгүй болохоор төсвийг хянаж болдоггүй, төсвийг тодорхойлж эрэмбэлж болохгүй нөхцөл байдал үүсчихсэн. Тийм учраас маш яаралтай энэ эрэмбийг тогтоохгүй бол хүчтэй улс төрчдийн лоббигоор тал тал тийшээ төсөв татагдаад, Монгол Улсын хөгжил өрөөл татанхай болчихоод байгаа юм. Энэ дээр таны байр суурь юу байна вэ?

Г.Занданшатар: Ширчингийн Сүхбаатарын Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Маш чухал асуудал хөндлөө. Энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуулт байна. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу тухайн үеийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар энэ асуудлыг зохицуулах заалт орж ирсэн санаж байна. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг нэг улсын хамаарлын жишээгээр тайлбарлахад, манай экспорт уул уурхайгаас 95 хувийн хамааралтай, гадаад худалдаа 70 хувийн хамааралтай, өр дотоодын нийт бүтээгдэхүүний 158 хувь буюу харанга дэлдсэн хэмжээнд, эрчим хүч 20 хувийн импортын хамааралтай, түлш шатахуун 100 хувийн хамааралтай, эдийн засгийн хамаарал, аюулгүй байдлын индексээр дэлхийн түвшинд хамгийн өндөр орнуудын нэгд харьяалагдаж байгаа.

Ийм учраас Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц “Хэмжиж чадвал хянаж чадна, хянаж чадвал сайжруулж чадна” гэж хэлж байсан. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын эдийн засгийн аюулгүй байдлын хүрээнд нэг улсын хөрөнгө оруулалт 60 хувиас дээш байж болохгүй гэсэн тоон үзүүлэлт бүхий хэмжүүр байдаг. Үүнийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлох шаардлагатай. Харин хэмжих шалгуур үзүүлэлтийг Үндэсний аудитын газар сайжруулах шаардлагатай. Энэ нь Улсын Их Хурал хянах, хэмжих үзүүлэлт болох ёстой. Энэ талаар холбогдох байгууллагуудтай тухайлбал, Улсын Их Хуралтай Засгийн газар хамтран ажиллахад элэн. Энэ үзүүлэлтүүдийг бид төсөв өргөн барихдаа тодорхой хэмжээгээр харгалзан үзэж, тусгасан байгаа.

Д.Амарбаясгалан: С.Эрдэнэболд гишүүнд нэг минут нэмж өгье.

С.Эрдэнэболд: Одоо байгаа хуулийн гарц нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр хэмжих нэгж буюу шалгуур үзүүлэлтийг тодорхойлох ёстой байгаа юм. Тэгэхдээ бас нэг хувилбар нь Улсын Их Хурлаас хэмжих нэгжийг гаргаж болно. Ноднингийн 11 сард Улсын Их Хурал хүн төвтэй байх 5 шалгуур гаргачихсан. Тэр үзүүлэлт дотор ч үүнийг оруулж болно. Бие даасан, шалгуур үзүүлэлтийг гаргах зайлшгүй шаардлагатай байна. Нэг асуулт асуусан, хариултад хариулсан болохоос илүүтэйгээр яг одоо энэ дээр шийдэл хэрэгтэй байна. Тэгэхгүй бол төсөв өөрөө эрэмбэгүй, тэгээд нэг Ерөнхий сайд ч юм уу, нэг Сангийн сайд орж ирээд л асуудалд ингээд ямар ч өөрчлөлтийн зүйл байхгүй байгаад байна. Энэ эрэмбийг яаралтай тогтоогооч гэсэн хүсэлтийг л тавьж байна. Болж өгвөл энэ төсвийн 2, 3 дугаар хэлэлцүүлэг гээд сүүлийн хэлэлцүүлэгт орохоос өмнө энэ шалгуур үзүүлэлтээ Улсын Их Хурал тодорхой болгоод явахад та манлайлаач. Ингэж чадвал бид олон хэрүүлийг тасална, олон шуналыг тасална, шударга бусын олон кейсүүдийг байхгүй болгоно. Ингээд зөв зам руу.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайдад хариултын нэг минут өгье.

Г.Занданшатар: Тэгэхдээ энэ шалгуур үзүүлэлтүүд огт байхгүй биш юм шүү. Жишээлбэл төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувиас дээш байж болохгүй, өр 50 хувиас дээш болохгүй. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зааж байгаа шалгуур үзүүлэлтүүд дандаа эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой. Хөрөнгө оруулалтын зардлын 60 хувийг дэд бүтэц,

боловсрол, эрүүл мэнд, хүний хөгжилтэй холбоотой чиглүүлнэ гээд тодорхой заачихсан. Тийм учраас бодлого, түүний хэмжүүр үзүүлэлт тодорхой түвшинд байгаа, цаашид сайжруулах ёстой. Тантай санал нэг байна. Үүнийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон гишүүд та өөрөө санаачлаад үүн дээр ажиллах нь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Хүний эрхийн хороо, холбогдох хороод санаачлан ажиллах нь нээлттэй гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя. Дараа нь Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асууна.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Г.Занданшатар дарга та 2016 оноос хойш Монгол Улсад байгаа хамгийн олон удаа, бүх том албан тушаалыг хашсан. Гадаад харилцааны сайд, Улсын Их Хурлын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, одоо Ерөнхий сайд. Тийм учраас та аливаа асуултад хаанаас, яаж ярихаа хамгийн түрүүнд, хамгийн сайн мэдэж байгаа энэ танхимд байгаа хүмүүсийн нэг гэж би бодож байна. Таны Засгийн газар эдийн засаг дахь төрийн оролцоог яг яаж бодитойгоор бууруулах вэ? Өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүний 74 хувийг төр үйлдвэрлэж байна. Хэдий болтол бид лоозогносон шинжтэй, хувийн хэвшлийнхээ үйл ажиллагааг боомилсон, амьсгаа авах орон зайг нь бий болгож өгдөггүй ийм орон, ийм эдийн засагтай байх вэ?

Бид хуульдаа чөлөөт эдийн засагтай, чөлөөт ардчилсан нийгэмтэй гэж тунхаглаж, хуульчилсан байгаа. Гэтэл өнөөдөр төр нь арай л бууз хийж, хуушуур хайрч, ууц чанахгүй байна. Үүнээс бусад бүх салбарын бизнест оролцож байна. Амралтын газар ажиллуулж байна, хоол, хүнсний үйлчилгээ буюу “catering” хийж байна. Тийм болохоор 2026 онд, мөн цаашлаад таны тэргүүлсэн Засгийн газар эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулахын тулд хамгийн эхлээд төрийн болон орон нутгийн өмчит компаниудаас 2026 онд хэдийг нь хувьчлах вэ? Үүний эсрэг Засгийн газар нь арга хэмжээ авч ажиллаж байгаа бодлогын баримт бичиг байгаа юу? Бид эдийн засаг дахь төрийн оролцоог багасгаж байж чөлөөт эдийн засгийг ярина, эдийн засаг дахь төрийн оролцоог багасгаж байж ардчилсан нийгмийг ярина, бизнесийн эрүүл харилцааг ярина. Тийм болохоор төр нь үйлчилгээний салбарт хийж байгаа бизнесүүдийг хэзээ болих вэ гэдэг маш ерөнхий асуулт байна? Ер нь төр өөрөө хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг хэзээнээс, яг яаж биелүүлэх юм бэ? Яаж ажиллуулах юм бэ? гэдэг ийм 2 асуулт байна?

Г.Занданшатар: 1 дүгээрт Монгол Улсын Засгийн газраас Баялаг бүтээгчдийг дэмжих багц хуулийг өргөн барихаар төлөвлөж байна. Үүнд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль зэрэг хуулиуд дээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа. Энэ хүрээнд хувийн хэвшил болон Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтарч ажиллаж байгаа.

2 дугаарт нь төрийн өмчийн компаниудын хувьчлал, үр ашгийг сайжруулах цогц хөтөлбөрийг хэрэгжүүлж, Засгийн газар ажлаа авснаас хойш 7 сард ажлын хэсэг байгуулаад, Засгийн газрын хуралдаанаар 2 удаа хэлэлцсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтоор ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Энэ ажлын хэсэгт төрийн өмчийн компаниудын үр ашгийг сайжруулах, тухайлбал, “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр онцгой дэглэм тогтоож, менежментийн баг томилуулж ажиллуулснаар үр ашиг 3 дахин сайжирсан, борлуулалт нь 1.6 дахин нэмэгдсэн зэрэг тодорхой зэрэг өөрчлөлттэй олон тоо баримт дурдаж болно.

Ирэх жил 2026 онд 9 компанийг хувьчилна, нийт 26 компанийн “IPO” хувьцаа гаргах, жишээлбэл Төрийн банкны 20 хувийг гаргах гэж санаж байна. МИАТ-ийн 20 хувиас 49 хувийг “IPO” гаргах, стратегийн хөрөнгө оруулагчид хувьчлах замаар үр ашгийг нь нэмэгдүүлэх, өмч хувьчлал, үр ашгийг сайжруулах цогц хөтөлбөр боловсруулж байгаа. Энэ талаар төсөвт суусан тоо нь төрийн өмчийн компаниудын төсөвт төвлөрүүлэх орлого 540 тэрбум төгрөг, үүний үр ашиг нь төсөвт суудаггүй. 540 тэрбум төгрөг бол татварын орлогыг нэмэгдүүлэх тооцоо нь. Тийм учраас энэ асуудлыг тухайн үед нь Улсын Их Хурал Засгийн газраас өргөн барихад илүү дэлгэрэнгүй хэлэлцэх бололцоотой. Дахин.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ө.Шижир гишүүнд нэг минут нэмж өгье.

Ө.Шижир: Та миний үндсэн нэг асуултад хариулсангүй. Төр хэзээнээс хувийн хэвшилтэй өрсөлддөг энэ байдлаасаа болих вэ? Одоо нийт 119 төрийн өмчит аж ахуйн нэгж компани байгаа. Үүн дээр орон нутгийн өмчит компаниудыг огт дурдаагүй. Гэтэл өнөөдөр орон нутгийн өмчид байгаа 400 орчим компани, яг төрийн өмчид байгаа 100 орчим компаниудаас хувийн хэвшлийн хийж болж байгаа амралтын газар, үйлчилгээний бизнес, хоолны хүргэлтийн үйлчилгээ, хүнсний дэлгүүр зэрэг салбарт хэзээнээс өрсөлдөхөө болих вэ? Яг өнөөдрөөс үү, эсвэл тодорхой хугацааны дараа юу? Та миний энэ асуултад тодорхой хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайдад нэг минут нэмж өгье.

Г.Занданшатар: Ер нь 60 хоногийн өмнөөс эхэлчихсэн гэж бодож байна. Яагаад гэвэл 60 хоногийн өмнөөс бид одоогоор 9 компаниудыг нэгтгэсэн, өөрчилсөн, өөрчлөн зохион байгуулсан. Нийт 109 компани байгаагаас 70 хүртэл бууруулах бодлогыг боловсруулаад энэ хүрээнд хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх бодлогууд хэрэгжээд явж байгаа. Улсын Их Хурлаар энэ 109-ийг 70 болгох бодлого өргөн барьж хэлэлцэгдэнэ. Тэр үед дэлгэрэнгүй хэлэлцэх бололцоотой. Төсөвтэй шууд холбоогүй учраас тухайн үед илүү тодорхой хариулъя гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууя.

Х.Тэмүүжин: 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1.14-д нэг бодлогын чиглэл байгаа. Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн

шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатад гаргана гэсэн зорилт байна. Тэгээд энэ зорилтын хүрээнд 3 ажил бичигдсэн. Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог 2016 онд татан буулгаснаас хойш бид яг дахиад 15 жилээр ухраад, одоо гэр бүлийн хүчирхийлэл ч байна уу, ямар нэгэн хүчирхийлэлд өртөж хохирогч болсон иргэд энэ хамгаалалтгүй байдлаасаа болоод ажлын байран дээрээ олон хутгалуулж үхдэг тэр тохиолдлууд дахиад давтаад л гараад эхэллээ. Иргэд амь насаараа яг энэ бодлогын цоорхой дотор эрсдэлээ үүрч явж байгаа. Тэгэхлээр энэ гэрч, хохирогчийг хамгаалах байгууллагыг буцаан сэргээх бодлогыг хэзээнээс хэрэгжүүлэх вэ?

Яг үүнтэй холбоотойгоор хохирол барагдуулах үйл ажиллагаатай холбоотой хэсэг байгаа юм. Соёлт хүн төрөлхтөн хохирол, манайх шиг хохирол барагдуулах сан гэж байгуулахаасаа илүүтэйгээр хохирол барагдуулах үйл ажиллагааны процессын хуультай байгаа. Хүч хэрэглэсэн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн хохирогчийн хохирлыг төр энэ сангаас урьдчилж төлөөд, тэгээд иргэн хохирсон дээрээ хохироод шүүхийн шийдвэр хүлээгээд зовдог биш, харин төр хохирсон иргэний хохирлыг урьдчилж төлчхөөд, нөгөө буруутай этгээдүүдээс сангаа хохиролгүй болгохын төлөө араас нь хөөцөлддөг ийм иргэнээ хөнгөвчилсөн, иргэндээ ээлтэй тогтолцоо бий болгочоод байгаа юм. Бид энэ тогтолцоог бий болгохгүй бол гудамжинд зодуулсан иргэн эрүүл мэндийн хохирлоо шүүхийг дуусан дуустал дээр нь зардал гаргаж хүлээдэг. Өөрсдөө эрүүл мэндээрээ хохироод, өөрсдөө халааснаасаа мөнгө гаргадаг ийм нэг гажиг тогтолцоо бий болчхоод байна. Тэгээд сүүлийн өдрүүдэд маш олон гэмт хэргүүд эрх бүхий өндөр хариуцлагатай албан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Гэрч, хохирогчийн хамгаалалт нь өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар цагдаагийн байгууллагын бүтцэд хамаарагдаж байгаа. Цаашдаа энийг илүү хариуцлагатай, бие даасан, хараат бус, үр нөлөөтэй бүтэцтэй болох шаардлагатай байгаа. Энэ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам эрх зүйн шинэчлэл хийж ажиллахаар төлөвлөж байгаа. Энэ талаар илүү тодорхой мэдээллийг манай Хууль зүй, дотоод хэргийн сайд Лхагвын Мөнхбаатар өгнө.

Д.Амарбаясгалан: 3 дугаар индэр дээр Л.Мөнхбаатар сайд хариулт өгье.

Л.Мөнхбаатар: Х.Тэмүүжин гишүүний асуултад, нэмэлт мэдээлэл өгье. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Үүн дээр гэрч, хохирогчийг хамгаалахаас гадна хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, мөн тодорхой этгээдийг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, мөн энэ харилцаанд оролцож байгаа бусад этгээдүүдийг хамгаалах асуудлуудыг нэгтгэсэн, ялтан болон ялтныг эрэн сурвалжлах, оргосон ялтныг эрэн сурвалжлах, яллагдагчаар татагдсан этгээдийг

эрэн сурвалжлахтай холбоотой харилцааг өргөн хүрээнд зохицуулсан хуулийн төслийг боловсруулаад байна.

Түүнээс гадна тусгай субъектийн буюу хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцогчдоос үйлдсэн тусгай субъектүүдийн үйлдсэн эрүүдэн шүүхтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийг мөрдөх албыг оруулсан ийм бүтэцтэйгээр зохион байгуулахаар төлөвлөж байгаа.

Д.Амарбаясгалан: Х.Тэмүүжин гишүүнд дахиж нэг минут нэмж өгье.

Х.Тэмүүжин: Бид Засгийн газрын үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хүлээгээд байвал нэлээн их хугацаа авах гээд байна. Хэрвээ Засгийн газар идэвхтэй, хурдтай ажиллахгүй бол Улсын Их Хурал энэ хуулиудыг санаачлах хэрэгцээ байна. Анх Улсын Их Хурлын чуулган эхлэхэд л эрүү шүүлттэй холбоотой зовлон гарсан. Өнөөдөр болж байгаа үйл явдлаас хараад энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг үйлдэгдсэн байж болзошгүй гэмт хэргийн тухай маш олон үгнүүдийг хариуцлагатай албан тушаалтнуудын амнаас гараад байна. Нэг ийм үг байдаг гудамжинд иргэд иргэнийхээ эсрэг хийдэг хэргийг шийдүүлэхийн төлөө байгуулсан төр иргэнийхээ эсрэг гэмт хэрэг хийгээд эхэлбэл тэнд хууль, ардчилал огт байхгүй болно гэж үг байдаг. Тийм учраас төрийн өөрийнх нь хийдэг хэргийг хянан шалгадаг, нэн даруй шийдвэрлэх тогтолцоог бий болгохгүй бол төр өөрөө иргэний эрх чөлөөний эсрэг мангас болж хувирдаг шүү. Энэ чиглэлээр дорвитойхон хурдтай ажиллахгүй бол ардчилал, хуулийн засаглал, энэ улсын Үндсэн хуулийн дэг журам өөрөө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд 1 дүгээр индрийн микрофон.

Г.Занданшатар: Энэ маш чухал асуудал. Ер нь гэрчийн аюулгүй байдал сул, гэрч, хохирогчид гэмт хэргийг илчлэхээс айдаг, зугтдаг байдал, гэрчийн хамгаалалт сулаас шалтгаалаад байна гэж мөрдөх байгууллагууд үзэж байгаа. Тийм учраас ер нь жилдээ 20-30 мянган эдийн хохирол гардаг, үүний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, биелэлтийн ажиллагаа хангалтгүй. Үүнтэй холбоотойгоор иргэд хохирдог, улмаар иргэдийн төрд итгэх итгэл сулардаг. Ийм учраас гэрч, хохирогчийг хамгаалах асуудал системийн хувьд зайлшгүй яаралтай хийх шаардлагатай процесс. Энэ чиглэлээр Улсын Их Хурлын гишүүд, та жишээлбэл манай туршлагатай хуульчийн хувьд манай Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтраад илүү шуурхай ажиллахыг аль, аль талаасаа шахаад ажиллахыг уриалж байна. Энэ зөв зүйтэй асуудал байна.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя. 2 дугаар индрийн микрофон өгье.

Ц.Туваан: Сайн байцгаана уу? Бид 2026 оныхоо төсвийг батлахаар оруулж ирсэн. Ойролцоогоор 32,9 их наяд төгрөгийн төсөв 1,4 их наяд төгрөгийн алдагдалтай орж ирж байна. 1 жилийн өмнө бид яг энэ танхимд яриад, алдагдалгүй төсөв гэж сайхан юм байдаг, алдагдалгүй батлах ёстой, Монгол Улсын Ерөнхийлөгч алдагдалгүй батлах талаар яриад баталж байсан. Тэгтэл

энэ жилийн төсөв алдагдалтай ороод ирж байна. Бид саяхан хэдхэн сарын өмнө төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг баталж байсан. Энэ дээр бас алдагдалгүй гээд л батлаад явж байсан. Тэгээд яагаад өнөөдөр 1,4 их наяд төгрөгийн алдагдалтайгаар төсвийг оруулж ирэв? Энэ төсвийг алдагдалгүй баталж болох уу гэдэг асуулт эхний асуулт?

Хоёрдугаарт, ахмадуудын тэтгэврийн асуудлыг бид өнгөрсөн парламентын үед инфляцын түвшинтэй уялдуулан дараа жилийн төсөв хэлэлцэх үед нэмүүлж өгнө гээд хуульчилж өгсөн. Энэ жилийн ахмадуудын тэтгэвэр 6 хувиар нэмэгдэхээр төсөв дээр орж ирсэн байна. Хамгийн сүүлийн 8 сарын байдлаар 8.8 хувийн инфляцтай гээд Үндэсний статистикийн хорооноос оруулаад ирчихсэн. Гадаа гудамжинд ахмадууд тэтгэвэр нэмэгдүүлж өгөөч гэдэг байдлыг маш их ярьж байна. Тэгэхээр ахмадуудын тэтгэврийг энэ улсын төсөв дээр 10 хувиар нэмэгдүүлсэн байдлаар баталж болох уу?

Гуравдугаар асуулт нь Монгол орон даяар гангийн нөхцөл байдалтай зуслаа. Газар тариалангийн гол бүс нутгуудаар 60 хэдэн хоног ганц ч бороо дуслаагүй Төв аймгийн Жаргалант сум байна. Яг энэ гангийн улмаас тариаланч, ногоочид асар их ургац алдаж, хохирол амслаа. Тэгэхээр энэ төсөв дээр хүүгийн татаас хэлбэрээр нэлээн олон тэрбум төгрөгийг тавьсан байгаа. Тэгэхээр энэ татаасан дотроо газар тариалангийн салбарын зээл.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: 1 дүгээрт, нэг зүйлийг тодруулах хэрэгтэй. Төсвийн дефицит гэж ярьдаг, энэ бол “loss” буюу алдагдал гэсэн үг биш, харин дутагдал юм. Энэ бол тайлан тэнцэл биш, төлөвлөгөө. Тийм учраас олон улсад энэ төлөвлөгөөний гажилт 3 хувь байж болно гэж үзэж, төсвийн алдагдлын хэмжээг 3 хувь дотор байж болно гэсэн стандартыг мөрддөг. Тэгэхээр дефицит гэдэг үг бол “loss” буюу алдагдал гэсэн үг биш бөгөөд дутагдаж байгаа орлого гэсэн үг юм.

2 дугаарт энэ жил 1,3 их наядаар төсөв дутагдахаар тооцсон. Энэ 2 шалтгаантай. Эхнийх нь Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, газрын тосны үйлдвэр гэх мэт “bankable” буюу эргээд өөрөө өөрийгөө нөхөх зээл бол уг нь олон улсын стандартаар төсөвт суудаггүй. Энэ зардлууд суухаар төсөв алдагдалтай болж харагдаад байгаа юм.

3 дугаарт нь, ноднин жил төсвийг алдагдалгүй батлах шалтгаан нь та хэд биш, Засгийн газар тухайн үед хэт өөдрөгөөр төсөөлөөд, тэрний дараагаар Трамп сонгогдоод, тарифын дайн эхлээд, нөхцөл байдал ч өөр болоод, төсвийн орлого буурах нь тодорхой болчихсон учраас хэт өөдрөгөөр төсөөлсөн бол өнөөдөр бид валютын ханшаа 4000 руу алдчихсан байх байсан. Яагаад гэвэл тухайн үеийн 2,4 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв баталсан бол 3,3 их наядаар сох дутаад, бараг 6 их наяд төгрөгийн төсвийн алдагдал үүсвэл ийм хэмжээний өр дарамтад ороод, энэ бол жинхэнэ алдагдал болох байсан. Дутагдал биш. Үүнээс сэргийлэхийн тулд төсвийг алдагдалгүй батлах шаардлага тавьсан юм. Дэлхий дээр төсвийг алдагдалгүй баталдаг жишээнүүдэд алдагдал гэдэг утга нь ийм учраас өөр юм.

Ер нь Төсвийн хуульдаа өөрчлөлт оруулж, “bankable” буюу банкаар дамжаад эргүүлээд төлөгдөх зээлүүдийг жишээлбэл газрын тосны үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС-ын үйлдвэр нь төсөвт зардал болоод суухаар алдагдалтай харагдуулаад байгаа хүчин зүйл шүү. Тийм учраас энэ бүхнийг тооцсон гэдгийг онцолж хэлмээр байна. Иймд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй болгохын тулд төсвийн төслийн нэгдсэн төсвийн нийт зардлын хэмжээг 1.4 их наядаар бууруулах шаардлагатай болно. Тэгвэл.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ц.Туваан гишүүнд нэг минут нэмж өгье.

Ц.Туваан: 2 дахь асуултдаа хариулт авна. Дээрээс нь иргэд сонгогчид асуугаад байна. Алдагдалгүй гээд уянгалаад сайхан ярьж байсан зүйл яагаад одоо алдагдалтай болохоор болов гэдэг дээр эргэлзээ байгаа. Энийг л би асууж байгаа юм.

Гуравдугаарх нь, хөдөө аж ахуйн салбар, ялангуяа газар тариалангийн салбар, тариаланч, ногоочид гангийн эрсдэл үүрсэн. Энэ төсөв дээр хүүгийн татаас нэлээн тавигдчихсан байгаа. Энэ салбарын хүмүүс маш их зээл авч байж энэ жилийнхээ тариалалтыг хийсэн, одоо багахан хураалтаа хийж байгаа. Тэгэхээр энэ зээлийн хугацааг хойшлуулах, энэ зээлд төлөгдөх хүүг 2026 оны төсөвт татаас байдлаар хөнгөлөлт оруулж ирж болох уу? гэдэг асуулт.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Г.Занданшатар: “Хүнсний хувьсгал”, “Атрын 4 дүгээр аян”-ы хүрээнд олгосон зээлүүдийн хүүгийн дэмжлэгт 124,3 тэрбум төгрөгийг төсөвт суулгаж ирүүлсэн байгаа. 2026 онд төсвийн хүрээнд энийг шийдвэрлэх бололцоотой. Харин энэ хөтөлбөрүүдийн хүрээнд олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах саналыг судалж үзээд, шийдвэр гаргахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд даалгасан, ажиллаж байна. Бид газар тариалангийн атрын газруудад ажиллаж байхад ган гачиг, ган зудын давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөллийн улмаас ургац алдсан, эргэн төлөх боломжгүй болсон аж ахуйн нэгжүүддээ хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд тодорхой хэмжээний хойшлуулалт хийх боломжтой гэж үзэж байгаа. Энэ чиглэлээр яам ажиллаж байгаа. Энийг бол яам нь шийдвэрлэнэ.

Тэр ахмадуудын тэтгэврийн асуудал энэ жил 387 тэрбум төгрөг тусгасан. Үүнийг илүү нэмэгдүүлэхэд төсвийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя. 2 дугаар индрийн микрофон өгье.

Б.Жаргалан: Өнгөрсөн 30 жилийн бодлогын гажуудлыг 100 хоногт засах боломжгүй гэж та сая хэллээ. Тэгвэл манай Ардчилсан намын гишүүдийн яриад байгаа нийгэм, улс төр, эдийн засгийн энэ бүх гажуудлыг бий болгосон 30 жилийн дийлэнх цаг хугацаанд таны сонгогдсон Монгол Ардын Нам

засагласан. Тэр дундаа та Монгол Ардын Намаас 2004 оноос хойш улс төрийн өндөр дээд албан тушаал хашиж ажилласан байна. Тэгэхээр 100 хоног уул нь хангалттай л гэж бид хараад байгаа. Тэгэхдээ эрт, орой хэзээ нэгэн цагт шинэтгэл хийх шинэ итгэл төрж байгаад баяртай байна.

2026 онд иргэд, аж ахуйн нэгжүүд нийт 29,7 их наяд төгрөгийн татвар төлөхөөр төсөвлөжээ. 2020 оноос хойш ердөө 6 жилийн дотор иргэдийн төлж байгаа татвар 3 дахин нэмэгдсэн байна. Монгол Ардын Нам удаа дараалан татвар, хураамж, нийгмийн даатгалын шимтгэл, газрын төлбөр гэх мэт байж болох бүх татваруудыг нэмсэн. Татваргүй төр гэж байхгүй гэж та сая хэллээ. Гэхдээ татвар хурааж байгаа төр иргэддээ татварынх нь мөнгөөр нь нийгмийн үйлчилгээнүүдийг хүргэдэг. Сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, эмнэлэг бүх зүйл нь байдаг, дэд бүтцийн хөгжил нь ямар байдаг билээ? Гэтэл өнөөдөр Монгол Улсад татварын ачаалал энэ дэд бүтцийн хөгжлөөрөө, төрийн үйлчилгээний чанараараа илүүрхэж байгаа Европын улс орнуудтай дүйцэхүйц хэмжээнд очжээ.

Өнөөдөр Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлж байгаа татварын дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцах харьцаа 29 хувь байна. Дэлхийн дундаж 16, 17 хувь байгаа. Тэгэхээр манай татварын ачаалал Европын улс орнуудтай адилхан болчихоод байдаг. Гэтэл иргэд төрийн үйлчилгээг ерөөсөө хүртэж чадахгүй байгаад байна. Иргэдийн төлж байгаа татварын мөнгө амьжиргаанд нь хүрэхгүй, харин төрд шургасан авлигын сүлжээг санхүүжүүлээд байгаа учраас энэ урсгал зардлаа тана.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Түрүүн Ө.Шижир гишүүн ч асуусан. Олон жил ажиллалаа гээд байгаа. Тэгэхдээ би ажилласан газар болгондоо өөрчлөлт, шинэчлэлт хийж байсан. Жишээлбэл, би Гадаад харилцааны сайд байхдаа гадаад бодлогын үзэл баримтлалыг шинэчилж, гуравдагч хөршийн бодлогыг анх удаа цаасан дээр бодитоор томьёолсон, улс орноор нэрээр нь заасан. Гадаад харилцааг эдийн засаглуулах хөтөлбөр, бодлогуудыг тусгасан. Би “Атрын аян” зэрэг ажлуудын хөрс суурийг нь тавьж хэрэгжүүлж байсан. Хамгийн сүүлийн тод жишээ гэхэд бидний санаачилсан зөвлөлдөх ардчиллаар хэрэгжүүлсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд өнөөдрийн Үндэсний баялгийн сан, төсвийн тогтвортой байдлын мэтгэлцээний зарчим, тухайн үед 108 гээд байсан дутуугаа гүйцээж 126 гишүүн болгох өөрчлөлтийг 2023 онд хийснээр өнөөдрийн энэ танхимд мэтгэлцээн бодитой өрнөж, ардчилал шинэ шатад гарч байгаа.

Энэ бүхэн өөр өөрийнхөө байгаа газарт хийдэг ажил болохоос биш, эдийн засгийг 100 хоног дотор сэргээчихдэг ид шидтэн би бол биш. Юмыг нураахад 4 жил битгий хэл 4 хоног ч хангалттай юм байна. 4000 гаруй ААН хувьчлагдсаны үр ашиг нь өнөөдөр хаачсан бэ? гээд асуувал 1991 онд Монгол Улсын экспортын 80 хувь нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн байсан. Өнөөдөр 5 хувь хүрэхгүй болчихсон байна. Ийм учраас бид үр дүнгүй шинэчлэл хөгжлийн үр дүн нь ямар вэ гэдгийг өөрчилж засах гэж байна. Байшинг барихад 4-өөс олон жил хэрэгтэй болно. Харин нураахад нэг хоног ч хэрэгтэй байж болно.

Мэдээж улс төрийн асуулт тавих нь зүй ёсны хэрэг. Гэхдээ бид өнөөдөр урагшаа эрүүлээр харж, эрс шинэтгэлийг хамтдаа хийж байж улс орон хөгжинө. Улс орон хөгжихийн тулд парламентын шинэчлэлийг бид эхлүүлсэн, хийсэн. Зөвлөлдөх ардчиллын механизмыг суулгасан, хуулийг нь баталсан. Энэ бүхний үр дүнд өнөөдрийн парламентын ардчилал бэхэжсэн, сайжирсан олон асуудлууд бий. Харин бид энэ хуулиа хэрэгжүүлээгүй удааширсан нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүнд нэг минут нэмж өгье.

Б.Жаргалан: Өнөөдөр Монгол Улсад 2 компанийн нэг нь татварын байгууллагад хуримтлагдсан татварын өртэй байна. 2020 онд нийт ААН-ийн татварын өр 260 тэрбум төгрөг байсан бол 2024 оны эцэст татварын өр 3,5 их наяд төгрөг болж 13 дахин нэмэгджээ. Тэгэхээр өрөндөө баригдаж байгаа компаниудаа дэмжихийн тулд та Ерөнхий сайдын хувиар юу хийх вэ? НӨАТ-ын буцаан олголтын 370 тэрбум төгрөг гэх халамжийн маягтай бодлогыг татварын шинэчлэл гэж тайлбарлаад байгааг ойлгохгүй байна. Яг бодитоор татварын дарамтад учраад байгаа, татварын байгууллагад хуримтлагдсан өртэй байгаа компаниудаа та яах гэж байгаа вэ? Энэ улсад цаашдаа хувийн хэвшил гэж байхгүй боллоо. Тийм учраас Ардчилсан нам татвараа бууруул гэж удаа дараалан шаардаад байгаа. Энэ асуултад та хариулж өгнө үү?

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулъя, 1 дүгээр индэр.

Г.Занданшатар: Татварын шинэчлэлийн үр дүнд иргэд, аж ахуйн нэгжүүдэд тулгарч байгаа татварын дарамт, ачааллыг 3-4 их наяд төгрөгөөр бууруулна. Эхлээд дарамтаа бууруулахын тулд тэгш шударга татварын тогтолцоог бий болгож, бааз сууриа өргөжүүлэх шаардлагатай. Тэр хэмжээгээр тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлс, эмч, багш нарынхаа цалин, хөрөнгө оруулалтыг бид шийдвэрлэх ёстой. Тийм учраас бааз сууриа өргөжүүлж байж хэрэгжүүлэхийн тулд НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлж, 2027 оноос 100 хувь болгох хүрээнд үндсэндээ 2 сая татварын байцаагчтай болж байж, бүртгэлээ ил тод болгох хэрэгтэй байна. Ингээд бүртгэл ил тод болоод ирэхээр дараагийн татварын дарамтаа бууруулах, бааз сууриа тэгш, шударга татварын тогтолцоог бүрдүүлэх үндэс суурь бүрдэнэ. Хэрвээ би алдаагүй бол 3,5 их наяд төгрөгийн дийлэнх нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр байдаг гэж санаж байна. Сангийн сайд тодруулж нэмээд хариулна. АМНАТ-ын төлбөрийг бодох тооцох аргачлалтайгаа холбоотой асуудлууд бий. Тийм учраас тэр чиглэлд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 3 дугаар индрээс Б.Жавхлан сайд нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Таны ярьж байгаа нийт дүн зөв дүн байна. Гэхдээ энэ хуримтлагдсан олон жилийн өр биш байгаа юм. Татварын хугацаат тайлан үүсээд, өр төлбөрүүд үүсээд дараагийн хугацаат тайландаа төлөгдөөд явдаг ийм дүнгүүд байгаа. Энэ нэмэгдэж байгаа нь өөрөө эдийн засаг тэлж байна. Татвар төлөлтийн суурь тэлж байгаатай холбоотой асуудал юм. Тэрнээс биш аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадвартай шууд холбоотой асуудал биш шүү. Тодорхой хэмжээний нөлөө байгаа.

Д.Амарбаясгалан: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхтуяа: Юуны өмнө та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 7 сарын 02-ны өдөр өргөн барьсан. Энэ намрын чуулганаар өргөн хэлэлцэнэ гэж итгэж найдаж байгаа. Тэгээд 126 эрхэм гишүүд, Ерөнхий сайд та багш нарын нийгмийн асуудалтай холбоотой Боловсролын ерөнхий хуулийг дэмжиж өгөөрэй гэж юуны өмнө хүсье.

2026 он Засгийн газраас “Боловсролыг дэмжих жил” гэж тунхаглан зарласан хэдий ч харамсалтай нь боловсрол, боловсролын салбарын багш, ажилтнуудад ямар ч ээлгүй төсөв хэлэлцэж байгаад харамсалтай байна. Ер нь боловсролын салбарын 2026 оны төсвөөс бараг 1 их наяд төгрөгийн алдагдалтай баталж байгааг Ерөнхий сайд маань мэдэж байгаа байх гэж бодож байна. Тэгээд миний хамгийн гол чухал асуух гэж байгаа асуулт бол Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 сарын 07-ны өдөр батлагдаж, хэрэгжиж эхлээд 2 жил өнгөрлөө. Энэ хуульд боловсролын салбарын багш, ажилтны нийгмийн баталгааны заалтуудыг оруулсан нь төдийлөн сайн биш боловч тодорхой заалтууд орсон. Жишээ нь Боловсролын ерөнхий хуулийн 13.4-д багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ гэж заасан байдаг. Гэтэл энэ хугацаанд би лав энэ заалтын дагуу хэрэгжсэн юм сонссонгүй.

Орон сууцны дэмжлэг гэдэг багш нарын нийгмийн баталгааны хамгийн чухал хэсэг. Харамсалтай нь бага цалинтайгаасаа болоод багш нар ипотекийн зээлд хамрагдаж чаддаггүй. Энэ тал дээр танай Засгийн газраас багш, ажилтанд орон сууцны дэмжлэгийг яаж үзүүлэх вэ?

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулья.

Г.Занданшатар: Маш чухал асуулт байна. Би түрүүн тайлбарласан. Орон сууцжуулалтын үндэсний хөтөлбөрийн хүрээнд багш, эмч нар, төрийн албан хаагчид, бага, дунд орлоготой иргэдийг хямд өртөгтэй орон сууцаар “affordable housing” буюу бага өртөгтэй орон сууцаар хангах цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Багш, ажилтны орон сууцны судалгааг 2025 онд хийсэн. Судалгаагаар 34,100 ерөнхий боловсролын сургуулийн багш, 10,157 цэцэрлэгийн багш нарын 94 орчим хувь нь орон сууцны нөхцөлөө сайжруулах шаардлагатай гэж хариулсан байдаг нь багш нарын хувьд орон сууцны асуудал тэргүүн чухал юм гэдгийг харуулж байгаа. Ийм учраас орон сууцжуулалтын үндэсний хөтөлбөрийн хүрээнд Боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан бид багш нарын орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Одоо бас орон сууцны олгосон зээлүүд дээр тодорхой хэмжээний хүүгийн хөнгөлөлттэй зээлд шилжүүлэх арилжааны зээлийг, мөн Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулж илүү үр өгөөжтэй хэлбэрээр багш нар, ер нь хүний хөгжлийг дэмжих орон сууцжуулалтын бодлогыг хэрэгжүүлэх, Улаанбаатарыг орон сууцжуулах,

хөдөө орон нутгийн багш нарыг орон сууцжуулах цогц хөтөлбөрийг орон сууцын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлнэ. Боловсролыг дэмжих асуудал нэгхэн жилийн асуудал биш гэж бодож байна. Эхний ээлжид 3 жилийн үндсэн чиглэлийг баталж, зорилтот түвшинд цалинг нэмэгдүүлэх. Нэг өдрийн дотор эдийн засаг хүндрээд, төсвөө хязгаарлаад, бүх юмаа танаж байхад мэдээж өнөөдөр цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх ямар ч боломжгүй шүү дээ.

Татвараа бууруул гэж сая асууж байна. Нөгөө талд нь цалингаа нэмэгдүүл гэж байна. Энэ 2 ямар ч баланслах боломжгүй. Бид 100 хоногийн хугацаанд цаг хугацааны хайчинд байлаа. 9 дүгээр сарын 01-ний өдөр төсөв өргөн барьдаг болчихсон. 2 дугаарт, нүүрсний үнэ уначихсан, инфляц өсчихсөн, бид төсвийн хайчинд байлаа. 3 дугаарт, улс төрийн нөхцөл байдлын хувьд ч гэсэн бид өнөөдөр урагшаа харж илүү эв нэгдэлтэйгээр урагшлах.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ц.Мөнхтуяа гишүүнд нэмж нэг минут өгье.

Ц.Мөнхтуяа: Монгол Ардын Нам маань сүүлийн 8 жилд төр засаг барьсан. Та нар өнөөдөр 100 хоног гэж хэлэхээсээ ичих хэрэгтэй. 8 жил төр барьчаад өнөөдөр ард түмнийхээ төлөө юу ч хийгээгүй байж өнөөдөр гэнэтхэн сая 100 хоног төр барьсан юм шиг ингэж ярьж болохгүй. Би хатуухан л хэлнэ. Тэгээд дандаа ирээдүй цаг дээр тэгнэ, ингэнэ гээд ярьдаг. Хэзээ ч тэглээ, ингэлээ, тэгсэн, ингэсэн гэж ерөөсөө би ярьж байхыг сонсоогүй. Тийм учраас хэдэн багш байранд оруулсан бэ, хэдэн багшийг одоо оруулах вэ?

Гэтэл өнөөдөр тэгнэ, ингэнэ гэж бид хэчнээн жил явах юм бэ? Одоо бид ард түмнээсээ ичих хэрэгтэй. Ингээд л нэг тулга тойрсон юм ярьсаар байтал ард түмний амьдрал сайжрахгүй байна. Сүүлийн 8 жил эрх барьсан Монгол Ардын намын та бол Улсын Их Хурлын гишүүн, даргаар олон жил ажилласан хүн шүү дээ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байсан ийм хүн байж өнөөдөр 100 хоног яриад сууж байхаасаа та нар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 дүгээр индрийн микрофон өгье.

Г.Занданшатар: Өнгөрсөн 5 жилийн хугацаанд 105 багш, 2025 онд 9 багш орон сууцад орсон байгаа. Түрээслээд өмчлөх орон сууцны хөнгөлөлттэй нөхцөлийн хүрээнд яригдаж байгаа нийт 12 мянган орон сууцны талаар П.Наранбаяр сайд тодорхой хариулна.

Д.Амарбаясгалан: Хугацаа дуусах гээд байна. Жудагийн Баярмаа гишүүн хугацаандаа багтаж асуултаа асууна. Нэмэлт хариултыг П.Наранбаяр сайд өгөх боломжгүй болж байна.

Ж.Баярмаа: Монгол Улсын түүхэнд анх удаагаа ийм чухал мэтгэлцээн гэх нь хаашаа юм, гэхдээ ямартай ч урьдчилан бэлдсэн бус сэдвээр асуулт, хариулт явж байна. Өмнө нь бол Ерөнхий сайд танхимд орж ирээд мэдээлэл хийхчээд гардаг байсан бол одоо тодорхой хэмжээнд асуултуудыг нь авч байгаад хариулж байгаа шинэ дэг эхэлж байгаад баяртай байна.

Тэгээд арга байхгүй хүн болгон татвартай холбоотой асуулт асууж байна. Энэ нь өөрөө юуг илэрхийлж байна гэвэл иргэд, ААН дээр төдий чинээ дарамт их байна л гэсэн үг. Тэгэхээр би хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуулт асууя. Павел Дуров гээд телеграммын үүсгэн байгуулагч саяхан 7 сард байр, хоол, хувцаснаасаа цаашаа илүү гарахгүй цалинтай хүн бол боолын хөдөлмөр эрхэлж байгаатай агаар нэг шүү гэж хэлсэн байна. Тэгэхээр та энэ тал дээр юу гэж хэлэх вэ? Манай иргэдийн дийлэнх олонх нь хэдэн төгрөгийн дундаж цалинтай байгаад, энэ 3 хэрэгцээнээсээ илүү гарч чадаж байгаа юу? Хэрвээ чадахгүй байгаа бол манай иргэд боолын хөдөлмөр, тэрэндээ тохирсон хөлс авч байгаа гэж үзэх юм биш үү?

Тэгэхээр 100 мянган иргэд гарын үсэг зурчихсан хуулийн төсөлд Улсын Их Хурлын гишүүдээс 33 хүн гарын үсэг зурчихсан байгаа. Тэгэхээр та энийг дэмжих үү?

Хоёрдугаарт, ААН-ийн албан татвар дахиад л ярья. Манай Засгийн газрын үед 4, 10-ын шатлалтай татварын тогтолцоо байсан, энийг хэрэгжүүлэх бодол байгаа юу? Одоо та бүгдийн хэрэгжүүлж байгаа бодлого компаниудыг улам жижиглэх чиглэлд явж байна. Тэгэхээр уг нь компани.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Асуулт, хариултын хугацаа дууслаа. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд асуулт асууж, хариулах хугацааг 37 минут 30 секунд гээд заасан тул хариулт өгөх хугацаа дуусчихлаа. Ж.Баярмаа гишүүний асуултад жич хариулт өгье гэж Ерөнхий сайд хэллээ.

Одоо Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авахаар байна. 15 минутад багтаж асуулт асууна. Нийт 6 гишүүний нэр ирсэн байна. Цаг хугацааны хувьд бараг амжихгүй шахуу л болох нь. Гишүүд маш товч, тодорхой асуултаудаа асуух нь зүйтэй болов уу гэж бодож байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя, 2 дугаар индэр.

О.Батнайрамдал: Ерөнхий сайдад өдрийн мэнд хүргэе. Маш тодорхой асуулт, шийдэл асуумаар байна. “Оюу толгой” бүлэг стратегийн ордын хил заагт албан ёсоор оршиж байгаа “ОНТРЭ” компанийн эзэмшилд байгаа “Жавхлант”, “Шивээ толгой” гэсэн 2 үндсэн лиценз дээр “Оюу толгой” дээр 2009 онд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан шиг бид гэрээ байгуулах уу? Энийг бид энэ цаг хугацаандаа хийж чадах уу?

Яагаад гэвэл нэг зүйлийг хэлье. Яг энэ цаг мөчид “Рио Тинто” компани энэ 2 компанийн лицензийг шилжүүлэхээр үйл ажиллагаа явуулж байгаа. Шүүхэд хүртэл өгсөн байгаа, шүүхийн ажиллагаа хүртэл явж байгаа. Тэгэхээр энийг бид шийдэж чадах уу, Үндсэн хуулиа хэрэгжүүлж чадах уу? Бид Монгол Улсын хууль тогтоомжоо хэрэгжүүлж, ард түмний хүлээж байгаа эрх ашгийг 1 дүгээрт тавьж байгаад “ОНТРЭ” шинэ хөрөнгө оруулалтын гэрээ хийж чадах уу?

2 дугаарт, 2011 онд дахин тодотгосон нэмэлт, өөрчлөлт оруулсан хувь нийлүүлэгчдийн гэрээ гэж байгаа. Энэ гэрээгээр Монгол Улсад 12 тэрбум ам.доллар болсон хувь нийлүүлэгчдийн зээл 11 хувь хүү төлж байгаа. Энийг бид дахин авч хэлэлцэх гэрээний эрх нь байгаа. Энэ эрх нь дуусахад бидэнд 100 хүрэхгүй хоног л үлдсэн байна. Тэгэхээр энэ гэрээний эрхээ хэрэгжүүлж, гэрээний хугацаанд нь бид хүүгээ бууруулж чадах уу, хүүгээ зах зээлийн зарчимд нийлүүлэн зохистой бууруулж чадах уу л гэж асуух гээд байгаа юм. Тэгэхээр энэ 2 зүйлийг бид хуулийн хугацаанд нь, гэрээгээр олгосон эрхийн хугацаанд нь Ерөнхий сайд аа, бид хийж чадах уу, хийж амжих уу? “Рио Тинто” лицензээ шилжүүлэх гээд ажиллаж байгаа. Хэрвээ энэ 2 лиценз өнөөдөр шилжвэл Улсын Их Хурлын бүрэн эрхийг давж, Засгийн газартай гэрээ хэлэлцээр хийхгүйгээр шилжих гээд байгаа юм. Хэрвээ ингэж шилжвэл хэн хариуцлага хүлээх юм бэ? Энэ дээр ард түмэнд бид ямар хариулт өгөх юм бэ? Тэгэхээр энэ асуудлуудыг эхлээд асууя.

Д.Амарбаясгалан: 1 дүгээр индэр, Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: О.Батнайрамдал гишүүн ер нь өөрөө асуугаад, өөрөө хариулчихлаа. Та өөрөө ажлын хэсгийг ахалж байгаа хүн шүү дээ, Засгийн газар оролцож болохгүй гээд ажлын хэсгийг ахлаад явж байгаа хүн. Манай өрөөнд та уулзсан, би Танд байр сууриа маш тодорхой илэрхийлсэн. Миний байр суурийг та хамгийн сайн мэдэж байгаа. Бид Үндсэн хуулиа хэрэгжүүлэх ёстой. Энэ өндөр байгаа хүүгийн зардлыг яаж бууруулах уу? Би яаж ч ажиллаж байсан хүүгийн зардлаас энэ өр үүсээд байна. 34 хувь эзэмшиж байгаа нэртэй боловч ногдол ашиг авахгүй. Яагаад гэвэл хүүгийн зардал, менежментийн төлбөрөөр үүнийг хийгээд байна. “Labor” нэмэх нь 6.5 хувийн хүү аваад байна. Бас нийтэд ярьж болох, болохгүй асуудал байна. Мэтгэлцээн хэдий чухал боловч хэлэлцээрийн яриа, стратегийн хувьд гар хугаравч ханцуй дотроо гэж гуравдагч этгээддээ задлаад байхгүй. Өнөөдөр Арбитрын шүүх хурал явж байгаа. Бид давуу байдалтай явж байгааг та маш сайн мэдэж байгаа.

Энэ бүхэн маань бидний яриа хэлэлцээрийн стратегид их нөлөөлөх учраас би Улсын Их Хуралд ажиллаж байхдаа Улсын Их Хурлын 103 дугаар тогтоолоор энэ үүргүүдийг тодорхой өгөөд, Дубайн гэрээнээс эхлээд тодорхой чиглэлүүдийг гаргаад ажиллаж байгаа. Тийм учраас дэд ажлын хэсгийн хүрээнд болон ажлын хэсгийн хүрээнд явагдаж байгаа энэ асуудлуудыг бид онцгой анхаарч ажиллах хэрэгтэй. Энэ чиглэлээр манай Сангийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Сангийн сайд тодорхой мэдээлэл өгнө.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд 3 дугаар индрээс нэмэлт хариулт өгье.

Б.Жавхлан: О.Батнайрамдал гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Сая Ерөнхий сайд их тодорхой хэллээ. Бид удахгүй хэлэлцээрт орно. Тийм учраас тактикаа хараад бид ярьж болох юм байна, ярьж болохгүй зүйлүүд байна. Ярьж болох 3 зүйлийг хэлье. Одоо хэмжих нэгжээр бид “SOFR” дээр нэмэх нь 6.5 хувийн хүүг 2018 оноос хойш төлж байгаа. Энэ хооронд бид 6 тэрбум төгрөгийн үндсэн өр дээр 5 тэрбум төгрөгийн хүү бодогдоод 11 тэрбум

болчихсон байгаа. Өнөөдөр манай Засгийн газрын үнэлгээ “SOFR” дээр нэмэх нь 2,3 байгаа. Өнөөдрийн манай эрсдэлийн үнэлгээнээс 3 дахин илүү үнэтэй хүү төлөөд байгаа. Энийг буулгана. Бид буулгах гол түлхүүрээ бол атгачихсан байгаа. 2018 онтой харьцуулбал бид зээлжих зэрэглэлээ 2012 оны жилийн өмнө авч байсан хамгийн өндөр цэг дээрээ өнгөрсөн жил аваачиж чадсан. Энэ жил үүнийгээ бид хадгалж чадлаа. Тэгэхээр бид хамгийн том зэвсгээ атгачихсан байгаа. Тийм учраас хүүгээ буулгах боломж бол өнөөдөр сайн бүрдсэн гэж харж байгаа. 2 дугаар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тодруулга нэг минут.

О.Батнайрамдал: Ерөнхий сайдаа Улсын Их Хурал дээр Хянан шалгах түр хороо байгуулсан байгаа. Хянан шалгах түр хороо хэлэлцээрт орох субъект биш. Монгол Улсын Засгийн газар гүйцэтгэх засаглалын хувьд хэлэлцээрт орох субъект байгаа. Тэгэхээр Хянан шалгах түр хороо бол энэ 16 жилийн туршид юу болж өнгөрсөн юм, ямар эс үйлдэхүй гарсан юм, яаж хойшилсон юм энэ асуудлыг бид ард түмэнд нээлттэй сонсголоор тайлагнах үүрэгтэй юм. Энэ хуулийг та өөрөө баталсан хүн сайн мэдэж байгаа. Тэгэхээр Ерөнхий сайдаа, энийг би яагаад онцлоод байна вэ гэвэл яг үнэнийг хэлэхэд өнөөдөр 3.5 сая иргэний хүлээлт байгаа юм. Өнөөдөр бид гэрээгээр олгосон эрхээ хэрэгжүүлэхгүй 100 хоногийг өнгөрөөвөл дахиад тэр гэрээг өөрчилж чадахгүй шүү дээ. Тэр гэрээг өөрчилж чадахгүй өнгөрөөчихвөл “Рио Тинто” уучлаарай хугацаа дууссан байна гэж хэлэх эрхтэй болох гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн шийдлийг бид заавал гаргах ёстой гэдгийг л олон нийт, ард түмэн, 3.5 сая иргэн харж байгаа. Тэгэхээр энэ дээр та амлалтаа өгөөч гэж чин сэтгэлээсээ хүсмээр байна.

Д.Амарбаясгалан: 1 дүгээр индрийн микрофон өгье.

Г.Занданшатар: “Оюу толгойн” асуудлаар бид 3 ажлын хэсэг байгуулж ажиллаж байгаа. Хүүгийн зохистой түвшнийг хадгалах асуудлаар Сангийн сайд, ОНТРЭ-тэй холбоотой, лицензтэй холбоотой асуудлуудаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд хариулсан байгаа. Ер нь бид Монгол Улсын эрх ашгийн үүднээс ажиллах ёстой шүү, энэ асуудал бол хоорондоо улс төрийн ашиг хонжоо болж ярих ёсгүй. Монгол Улсын 3.5 сая хүний эрх ашгийн асуудал. Энийг бид нарийн ойлгож, Улсын Их Хурал, Засгийн газар хамтарч ажиллах ёстой гэдгийг би хатуу анхааруулж хэлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар хариулах цаг дууссан тул Чинбаатарын Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Оройн мэнд Ерөнхий сайдаа. Таныг би Монгол Улсын шинжлэх ухаан, технологи, инновац, боловсролын салбарт нэлээн томоохон ач холбогдол өгдөг гэж ойлгож байгаа. Тэгэхээр асуулт тавих бүлгийн гишүүддээ боломж олгох үүднээс маш богино асуулт асууя. 1990 онд дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувийг шинжлэх ухаан, технологид ирээдүйд 3 хувьд хүрнэ гэж заасан. 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Үндэсний баялгийн сангийн нэгээс доошгүй хувь, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд

шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, тэргүүлэх чиглэлийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь гээд маш олон зүйл, заалт, уриа лоозонтой. Таны оруулж ирсэн 2026 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнд 0.5 хувьд хүргэнэ гэсэн. Гэхдээ бодит байдал дээр 2013 оноос дотоодын нийт бүтээгдэхүүний 0.14, 0.11, 0.09, одоо бүүр 0.07 хувь болчихоод байна. Тэгэхээр бид шинжлэх ухаан, технологио хөгжүүлэхгүйгээр яаж эдийн засгаа солонгоруулж, бие даасан улс болж хөгжих вэ?

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Ч.Анар гишүүн маш чухал асуудал хөндлөө. Өнөөдөр ICT Форум, tech week үргэлжилж байгаа. Энэ чиглэлээр Ч.Анар гишүүн Хиймэл оюун ухааны үндэсний стратеги боловсруулах ажлыг санаачлаад Засгийн газрын хуралдаанаар энэ долоо хоногт хэлэлцсэн. 2026 оны бодлогод шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувьд хүргэж, мэдлэгт суурилсан эдийн засгийг бэхжүүлэх, 21 дүгээр зууны эдийн засаг бол мэдлэгийн эдийн засаг юм. “Expand Ent” хөгжлийн загвар бол инновац, хөрөнгө оруулалт, гарааны бизнес, технологийн дэвшлийг дэмжихэд чиглэгдэх ёстой, их сургуулиудын лабораториудыг төрөлжүүлэн хөгжүүлэх ёстой гээд тодорхой асуудлууд хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд туссан.

Энэ хүрээнд 2026 оны төсөвт тусгасан хөрөнгө оруулалт бол Шинжлэх ухааны хүрээлэнгийн цогцолбор 154 тэрбум төгрөгийн хөрөнгөөр эхлүүлсэн, 2026 оны үлдэгдэл 40.5 тэрбум төгрөгийг бүрэн санхүүжүүлж, ашиглалтад оруулна. Лабораторийн тоног төхөөрөмж 32.3 тэрбум төгрөг, цахим шилжилтийн хатуу дэд бүтэц 52.2 тэрбум төгрөг, нээлттэй өгөгдөл, төрийн бүтээмж, хүнсний аюулгүй байдал, 112 яаралтай дуудлагын систем 32 тэрбум төгрөг, алслагдсан 151 багийн үүрэн телефоны дэд бүтэц 14.4 тэрбум төгрөг, БНХАУ-ын зээлийн хөрөнгө 16.2 тэрбум төгрөгөөр харилцаа холбооны хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл, Дэлхийн банкны ухаалаг засаг 2 төсөлд 13.5 тэрбум төгрөгийн эх үүсвэр, төрийн 100 үйлчилгээг цахимжуулж дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлууд суусан байна.

Энэ хүрээнд хүлээгдэж байгаа үр дүндээ шинжлэх ухаан, инновацын зохистой санхүүжилт, тогтвортой орчныг бүрдүүлэх, лаборатори, дата төв, Хиймэл оюун ухааны үндэсний стратегийг баталж, хэрэгжүүлэх, хиймэл оюун ухаан, дижитал нээлттэй өгөгдөлд суурилсан ухаалаг бодлого, шийдвэр гаргалтыг нэвтрүүлэх зэрэг бодитой асуудлуудыг суулга.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чинбаатарын Анар гишүүнд нэг минут нэмж өгье.

Ч.Анар: Таны хэлсэн шинжлэх ухаан, технологийн төсөв гэдэг бол аудитын газрын дүгнэлтийн дагуу байдаг. Үүн дотор Шинжлэх ухааны академийн зардлыг нэмээд, нэмээд дотоодын нийт бүтээгдэхүүний 0.18 болж байгаа. Бусад нь заавал байх ёстой урсгал зардлууд. Тэгэхээр энэ олон хөтөлбөрт заасан байгаа хувьдаа дотоодын нийт бүтээгдэхүүнд нийцүүлж төсвөө оруулж ирээсэй гэж хүсье. Амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Маш тодорхой хүсэлт тавьчихъя. Ер нь агаарын бохирдол, түгжрэл гэсэн 2 асуудал байгаа. Гэхдээ энэ 2 асуудлаа хуулиар яг онож тодорхойлж чадахгүй байгаа. Тэгэхээр би ирэх долоо хоногоос ч юм уу, ирэх сараас ч юм уу хот дээр байх нь уу, Засаг дээр байх нь уу энэ 2 үзүүлэлтийг хэмждэг үзүүлэлтийг жишээлбэл, “VCR” ч юм уу, яг ямар үзүүлэлтээр агаарын бохирдлыг хэмжих юм, ямар үзүүлэлтээр түгжрэлийг хэмжих юм гэдгийг тодорхой болгоод, өдөр бүр энэ үзүүлэлтүүдээ хэмжиж гаргаад олон нийтэд мэдээлдэг байгаач гэсэн хүсэлт байна. Тэгэхгүй бол агаарын бохирдлыг бууруулах, түгжрэлийг бууруулах хөрөнгө оруулалт шийдсэн ч яг ямар үзүүлэлтийг бууруулах гээд байгаа юм, ямар нэгжээр бууруулах гээд байгаа юм гэдэг нь тодорхойгүй байна. Тэгэхээр хөрөнгө оруулалтын хувьд ч гэсэн эрэмбэ тогтооход их зөв юм болов уу. Тийм учраас Танд нэг хүсэлт байна. Энэ үзүүлэлтүүдийг өдөр болгон зарладаг, хэмждэг, гаргадаг болооч. Тэгвэл иргэд мэдээлэлтэй, удирдлагуудыг нь ч гэсэн, ажлын гүйцэтгэлийг нь дүгнэхэд ч гэсэн амар болно. Тэгээд бид ч гэсэн энэ асуудлаа яаж бууруулж байгааг ч гэсэн харах боломжтой болно гэдэг хүсэлт байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Энэ удаагийн Засгийн газрын хүүхэд, гэр бүлийн бодлого дээр гаргах ямар ахиц дэвшил, ямар өөрчлөлтийг харж байгаа вэ гэдэг дээр маш тодорхой хариулаад өгөөч?

2 дугаарт, Хүүхэд хамгааллын үйлчилгээний анхан шатын нэгж дээр ямар нэгэн цомхотгол, ямар нэгэн эдийн засгийн хэмнэлт бүхий төсөв өргөн баригдсан уу? Тийм төсөв өргөн баригдаагүй байх гэж найдаж байна. Хүүхдийн эрхийн конвенцоор хүүхэд онцгой халамж, тусламж авах эрхтэй хүн байгаа. Тийм учраас энэ удаагийн Засгийн газар хүүхдийн асуудал дээр ямар бодлогын ахиц дэвшил, ямар өөрчлөлт гаргах вэ?

Д.Амарбаясгалан: 1 дүгээр индэр, Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Ер нь хүүхдийн хөгжлийн асуудал бол аливаа төрийн цөм анхааралд байх ёстой. Энэ чиглэлээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Гэр бүлийн хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж байгаа. Энэ талаар манай Т.Аубакир сайд дэлгэрүүлж хариулна.

Нэн ялангуяа хүчирхийлэл, хүүхдүүд эндэж байгаа, гэмтэж байгаа гэмт хэрэг маш их байна. Энэ бол төр засгийн ч алдаа байна, эцэг, эхчүүдийн ч анхаарал сонор сэрэмж, хамгийн эмгэнэлтэй явдал бол сая болсон үйл явдлууд. Засгийн газрын өмнөөс бид онцгой анхаарч холбогдох газруудад чиглэл өгч байгаа. Энэ чиглэлээр манай Хүүхэд, гэр бүлийн газар онцгой анхаарч ажиллах ёстой. Хүний хөгжлийн шинэтгэл бол хүүхдэд онцгой анхаарах ёстой. Тэгээд энэ талаар манай Т.Аубакир сайд хариулна.

Д.Амарбаясгалан: Т.Аубакир сайд байхгүй байна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Товчхон шууд асууя. Өвөл айсуй, утаа айсуй. Агаарын бохирдол энэ өвөл хэдий хэр хэмжээгээр буурах вэ? Улсын Их Хурлын 48 дугаар тогтоол, 57 дугаар тогтоолын арга хэмжээний хүрээнд Засгийн газарт 17 чиглэл өгөхийг хүссэн. Энэ хүрээнд С.Бямбацогт сайдаас ногоон зээлийн хүүгийн татаасыг нэмэгдүүлэх боломжтой гэсэн хариу бичгээр авсан. Гэтэл Байгаль орчны яамнаас ирэх жил 2 тэрбум төгрөгийн л ногоон зээлийн хүүгийн татаас олгоно гэж байгаа юм. Тэгэхлээр цаашид агаарын бохирдлыг бууруулахад ямар ажил төлөвлөж байгаа гэдгийг бичгээр авъя.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд, 1 дүгээр индэр.

Г.Занданшатар: Г.Лувсанжамц гишүүн маш зөв тодорхойлсон. Юу вэ гэвэл хэмжиж чадвал хянаж чадна, хянаж чадвал хэрэгжүүлж чадна. Тийм учраас агаарын чанарыг хэмжих ёстой. Энэ хүрээнд Байгаль орчны яам сая Сингапур, Швейцарт карбон кредит хийх эрх зүйн шийдвэрүүдийг гаргаад, одоо бид борлуулахаар энэ 2 улстай ажиллаж байна. Ингэвэл 66 мянган янданг карбон кредит хийх бололцоотой. Энэ чиглэлээр манай холбогдох газрууд ажиллаж байгаа. Карбон кредит бол манай Орон сууцжуулалтын банкны нэг чиглэл, нэг яндан буулгах, түүнийг нарны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн гишүүд асуулт асууж, хариулт авах хугацаа дууссан. Улсын Их Хурал дахь цөөнхийн асуулт ирүүлсэн гишүүн асуулт асууж, хариулт авна. Нийт хугацаа 30 минут байгаа. Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууна.

П.Ганзориг: Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт ХҮН намын сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс дараах гол зорилтуудыг оруулж баталсан. Үүнд эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, эдийн засаг дахь төрийн оролцоогүйгээр хязгаарлаж, эдийн засгийг илүү либералчлах, боловсролын салбарын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, тэр тусмаа багш, ажилтнуудын үнэлэмж, нийгмийн баталгааг сайжруулах, эрчим хүчний хараат байдлаас гарч, дотооддоо эрчим хүчийг бүрэн хангаж, цаашлаад ногоон эрчим хүчийг экспортлох, мөн эдгээр гол зорилтуудыг Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт оруулсан. Үүнтэй холбогдуулан Ерөнхий сайдаас дараах 3 асуултыг асууя.

1 дүгээрт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шинэчлэлтэй холбогдуулан асууя. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн сүүлийн 20 жилд 10 дахин, улсын төсвийн хөрөнгө оруулалт 10 жилд 8 дахин нэмэгдсэн ч өнөөдөр Монгол Улсын эдийн засаг уул уурхай, нүүрснээс хамааралтай хэвээр байгаа. Энэ бол нэг талдаа төсвийн хөрөнгө оруулалт оновчгүй, үр ашиггүй явж ирсний нэг нотолгоо. Иймээс төсвийн төсөлд тусгагдаж орж ирдэг тоон дүнд биш, цаад агуулгад нь анхаарах буюу засаг захиргаа, төрийн бүтэц, зохион байгуулалтын схемийг шинэчлэн зохион байгуулах, орчин үеийн

хөгжилтэйгөө хөл нийлүүлэн шинэчлэх, реформ хийх зайлшгүй шаардлагатай байна. Тэгэхээр 21 дүгээр зууны орчин үеийн Монгол Улсын сум, сумын төв ямар бүтэц, зохион байгуулалттай байх, түүнд зохицсон ямар дэд бүтэц, төрийн алба, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээтэй байх вэ? Энэ нь яг ямар зохион байгуулалттай байх уу?

Д.Амарбаясгалан: Микрофон нээе. 2 минут, Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: П.Ганзориг гишүүний асуултад хариулъя. Ер нь манай эдийн засгийн бүтцийн тогтолцоонд эдийн засаг газар зүйтэйгээ уялдаад мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг анхан шатны боловсруулалт хийдэг, боловсруулдаг. Өөрөөр хэлбэл бүх сумын төвүүд нийгэм, эдийн засгийн цогцолбор байсан юм байна. Энэ нь корпорацын шинж чанартай нэгдэл гэдэг байгууллага бүх барилгууд болон сумыг өөрөө барьсан. Энэ анхдугаар 5 жилийн төлөвлөгөөнөөс эхлээд, тэр 5 жилийн төлөвлөгөөтэй явж байх социализмын үед сум өөрөө өөрийгөө санхүүжүүлж явдаг илүү зах зээлийн систем байсан байгаа юм.

Гэтэл одоо болохоор бүгдийг нь дээрээс нь хуваарилдаг системтэй болчихсон. Биеэ даасан нэгж биш, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумын дэд бүтцийн асуудлыг шийддэг, мэдээж зам, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудал бол асар их хөрөнгө шаардана. Монгол Улс дэлхийд хүн амын суурьшлаараа хамгийн сийрэг улс. Дэлхийд газар нутгийн хэмжээгээр 17-д, хүн амын тоогоор 3.5 сая хүнтэй ийм улс. Ийм учраас засаг захиргааны бүтцийн онцлогийн хувьд ийм таруу байршсан хүн амын нягтаршил багатай 21 аймаг, 330 сумын дэд бүтцийг замаар хөрөнгө оруулалтаар хангахад нэлээн урт хугацаа шаардана. Мянганы замаас авхуулаад зохих өөрчлөлт гарч байж энэ аялал жуулчлал дагаж хөгжих ёстой, цогц бодлого болгож хөгжих ёстой.

Тэгэхээр 1 хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагаа тооцож үзвэл суманд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын үр өгөөжийг том суурин газрууд, эдийн засаг, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн эдийн засгийн бүтэцтэйгээ уялдуулах ёстой. Ийм учраас бүсчилсэн хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлж, бүсийн төвүүдээ хөгжүүлэх, хамгийн гол нь хот, тосгоны эрх зүйн байдлыг бий болгож бүх аймгууд, хот, сумын төвүүд, тосгон болж хөгжих ёстой. Ингэж байж иргэдийн амьдрах орчин сайжирч, Улаанбаатарын төвлөрөлт саарна. Ийм учраас хөгжиж байгаа орнуудын хувьд төсвийн хөрөнгө оруулалт дотоодын нийт бүтээгдэхүүний 4-8 хувь байдаг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: П.Ганзориг гишүүн дараачийн асуултаа асууя.

П.Ганзориг: Би саяын эхний асуулттай холбоотой маш тодорхой тодруулаад лавлаад асуумаар байна. Сүүлийн 100 жил бараг өөрчлөгдөөгүй энэ тогтолцоог буюу цаг үе, нийгмийн шаардлага, хөгжлөөс хоцроод байгаа энэ засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэрийн нэгжийн шинэчлэлийг хэзээ, хэрхэн, яаж хийх вэ? Та энэ дээр ямар байр суурьтай байгаа юм бэ?

Д.Амарбаясгалан: 1 дүгээр индрээс Ерөнхий сайд хариулт өгье,.

Г.Занданшатар: Ер нь 1 дүгээр асуудал бол Үндсэн хуулийн 58.1-д заасны дагуу сум, аймгууд эдийн засгийн хувьд өөрөө бие даан хөгжих, өөрөө өөрийнхөө хөрөнгө оруулалтыг шийддэг байх нийгэм, эдийн засгийн цогцолбор буюу корпорац байх шинж чанарыг нь эрх зүйн хувьд нээж өгч, төсвийн бие даасан байдал, татвар, нийгэм, эдийн засгийн бололцоог 1 дүгээрт хангах хэрэгтэй. Энийгээ шийдэж чадахгүй бол зах зээлийн зарчим горимоороо корпорацууд дампуурдаг шиг зах зээлийн зарчмаараа энэ асуудал шийдэгдээд явах ёстой. Түүнээс төрөөс татан буулгаад, нэгтгээд, тэр нь үр ашиггүй болох нь өнгөрсөн 20, 30 жилийн үр дүнгээр батлагдсан. Магадгүй тэнд том уул уурхай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, мах, сүүний боловсруулах үйлдвэрүүд хөгжих зах зээлийн боломж нь эдийн засгийн бодлого, төлөвлөлттэйгөө л нэгдэж уялдаж байж үүнийг залруулахгүй бол, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог нь сайжруулахгүй бол эдийн засгийн хувьд нэгж байх, төсвөө өөрөө авч явах нэгж байх агуулгыг нь төсөв, санхүү.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: П.Ганзориг гишүүн дараачийн асуултаа асууя.

П.Ганзориг: ААН, ард иргэдийн татварын дарамт, ачаалалтай холбогдуулан маш тодорхой асуулт асууя. Ер нь эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ, ААН-үүд, баялаг бүтээгчдээ дэмжинэ гээд олон жил ярьж байгаа. Тэр тусмаа халамжаас хөдөлмөрт шилжинэ гэж олон жил ярьж байгаа. Гэсэн хэдий ч бид бодит байдал дээр харвал сүүлийн 4 жил ААН, ард иргэдийн улсад төлөх татварын өр 200 гаруй тэрбум төгрөгөөс 3.7 их наяд төгрөг болж бараг 10 гаруй дахин нэмэгдсэн байна. Дээр нь сүүлийн 3 жилд буюу 2021 онд 2000 данс хааж байгаад татвараа хураадаг байсан бол 2024 оны эцсээр 21,000 данс хаасан байна. Тэгэхээр ийм байдлаар төсвийн орлого бүрдүүлдэг. Дансаа ингэж олноор хааж байна гэдэг бол хувийн хэвшлүүд татвараа төлж чадахгүй маш их дарамтад байгаа гэдгийг илтгэж байна гэсэн үг. Тэгэхээр татварын ачаа дарамтыг бууруулах, ялангуяа ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс, аж ахуйн нэгжүүдээ дэмжих ямар бодлого баримтлах вэ?

2026 оны улсын төсөв дээр зөвхөн НӨАТ-ын хууль орж ирсэн. НӨАТ дээр 4 орчим их наяд төгрөгийн хөнгөлөлт үзүүлж төсөв дээр тусгасан. Тэгэхээр яг үүн дээр ажил хөдөлмөр эрхэлж байгаа буюу хувь хүний орлогын албан татвар, ААН-ийн орлогын албан татварын хувь хэмжээн дээр шатлалтай байдлаар хөнгөлөх боломж байгаагүй юу? Улсын Их Хурлаас гарсан Татварын багц хуулийг шинэчлэх ажлын хэсэг яг энэ НӨАТ, ХХОАТ, ААНОАТ дээр тодорхой шат дараатай хөнгөлөлт үзүүлэхээр саналууд гаргаад, Сангийн яамтай хамтраад хуулийн төслөө бэлэн болгоод d.parliament дээр тавьчихсан байгаа. Үүний улсын төсөвт үзүүлэх нэг жилийн ачаалал нь 3,4 орчим их наяд төгрөг гэж гарч ирсэн. Ганцхан НӨАТ дээр үзүүлэхгүйгээр ажил хөдөлмөр эрхэлж байгаа чиглэлд чиглүүлэх боломж байгаа юу? Ер нь энэ дээр та ямар байр суурьтай байгаа вэ?

Д.Амарбаясгалан: 1 дүгээр индэр Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Татварын багц хуулийн шинэчлэлийн үр дүнд нийт 3-4 их наяд орчим төгрөгийн татварын ачааллыг бууруулна гэж Татварын хуулийн

зорилго оршиж байгаа. Энэ татварын хуулийн төслийг Хууль тогтоомжийн хуулийн 38.4-т заасны дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан болон албан ёсны цахим хуудсан дээр судалгаа, тооцооллынх нь хамт байршуулаад санал авч байгаа. Энэ дээр иргэд, ААН эрхлэгчид, Улсын Их Хурлын гишүүн та ч гэсэн уншиж судлаад саналаа өгч болно. Гол зорилго шийдэл нь бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулж, дундаж давхаргаа дэмжих, татварын шаталсан тогтолцоог боловсронгуй болгох, татварын шударга, зайлшгүй төлөх чадавх үйл ажиллагааг бэхжүүлэх, татварын өр хураах, хөрөнгө битүүмжлэх үйл ажиллагааг эрсдэлийн түвшнээс хамаарч уян хатан зохицуулах, хариуцлагатай татвар төлөгчдөө дэмждэг байх. Татвар төлөгчдөө дэмжиж, урамшуулж, зөвлөгөө өгдөг байх. Татварын байгууллага дарамтлаад л данс хаагаад байдаг биш, илүү зөвлөгөө өгч дэмждэг тогтолцоонд шилжүүлэх өөрчлөлтүүд хийж байгаа.

Одоогийн татвар төлүүлдэг гол арга нь данс хаах явдал. Одоо бид данс хаахгүйгээр уян хатан зохицуулаач гэж шаардлага тавьж байгаа боловч улирал болгоны эцэст татварын төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд энэ үзэгдлүүд гарсаар байна. Сая зарим аймагт санаатай юм шиг үйлдэл гарч байгаад бид хариуцлага тооцохыг Сангийн яаманд үүрэг болгосон байгаа. Тийм учраас татварын багц хуулийн реформ бол 11 дүгээр сард Улсын Их Хуралд өргөн баригдана. Энэ НӨАТ бол эхний 1 дүгээр шат нь. Үүний үр дүнд татварын бааз сууриа нэмэгдүүлэх, өргөжүүлэх, үндсэн бааз сууриа тэлж, татварын зайлшгүй шударга төлөгчдөг байх зарчмыг бий болгож байж татварын цогц реформ бодитой хэрэгжинэ гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: П.Ганзориг гишүүний микрофоныг өгье.

П.Ганзориг: 3 дахь асуултаа. Төрийн албаны шинэчлэлтэй холбоотой асууя. Төрийн албаны шинэчлэл хийхийн тулд өнөөдрийн Төрийн албаны тухай хуулийг задлах шаардлагатай гэж ХҮН намын зөвлөлөөс үзэж байгаа. Төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, төрийн тусгай, улс төрийн албан хаагчдыг нэг хуулиар зохицуулснаар энэ шинэчлэл хийхэд гол гацаа хүчин зүйл болоод байгаа. Одоо төрийн албанд 220 гаруй мянган хүн ажиллаж байна. Энэ нь төсөв дээр том урсгал зардал, том ачаалал болдог. Тэгэхээр цалин хөлсний шинэчлэл хийж, үр ашигтай, бүтээмжтэй, цомхон бүтэцтэй болгохоор энэ хуулиараа баригдчихдаг. Үүн дээр нэмээд Төрийн албан зөвлөл гэж байгууллага байгаа. Энэ бол төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд хэт хутгалдаж байгаа. Тиймээс Төрийн албаны тухай хуулиар Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг яг төрийн захиргааны албаар хязгаарлах шаардлагатай харагдаж байгаа. Энэ дээр та ямар байр суурьтай байгаа вэ?

Мөн бүсчилсэн хөгжлийг дэмжих шаардлагатай гээд 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон. Гэтэл өнөөдөр орон нутгийн нөхцөлд төрийн албан хаагчдыг орон нутгийн онцлогт тохируулан шалгаруулж авах гэвэл хуульдаа баригддаг. Энэ хэрэгцээ шаардлагадаа нийцэж чадахгүй асуудлууд тулгарч байна. Тэгэхээр Ерөнхий сайд та төрийн албаны тогтолцооны шинэчлэлийг хийх зорилгоор энэ хуульд шинэчлэл хийх үү, хэзээ, яаж хийх вэ?

Г.Занданшатар: Маш чухал асуулт байна. Энэ бид шинэ итгэл, эрс шинэтгэл гэдэг 5 жилийн үндсэн чиглэл боловсруулж, ажиллаж байгаа. Энэ хүрээнд хийгдэж байгаа 5 үндсэн нийт 10 цогц реформын 1 дүгээрт засаглалын реформ байгаа. Засаглалын реформ дотроо төрийн албаны шинэчлэл реформ багтдаг. Төрийн албаны шинэчлэл реформын хүрээнд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ажлын үнэлгээ, ажлыг үнэлэх журмын тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль зэрэг 5 хуульд өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна. Энэ дотроо төрийн албан хаагчид ард түмэндээ үйлчилдэг, ард иргэдийн зовлон зүдүүрийг нэвтэрхий мэдээд зогсохгүй, өөрийн биед ургуулж бодох гэсэн төрийн хүний түшвэл зохих 9 шинжээс авхуулаад хараат бус, бие даасан байдал, цалин урамшууллын системийг нь цогцоор шийддэг цогц шинэчлэлийг аттестатчилалтай уялдуулж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа. Төрийн албан хаагчид ч гэсэн өөрсдөө энийг хүсэж байгаа. Чадалтай, чансаатай төрийн албан хаагчдаа дэмждэг бодлого явах ёстой.

Дэлхий нийтийн зарчим бол улс төрөөс хараат байлгахын тулд Төрийн албаны зөвлөл Улсын Их Хурлын харьяа байгууллага болж тусдаа ажилладаг зарчимтай, мөрдлөгтэй. Энэ хүрээнд хэвээр ажиллах байх. Гагцхүү төрийн албан хаагчийн ажлын үнэлгээ хэт субъектив шинж чанартай байгааг илүү бодит, чанарын үзүүлэлт дээр тулгуурласан жинхэнэ ард иргэддээ үйлчилдэг зарчмыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ чиглэлээр Х.Тэмүүлэн гишүүн нарын санаачилсан хуулиуд бий. Нийт төр, улс төрийн албан тушаалтанд мерит зарчмыг гол үндэслэл болгоё гээд цогц реформын хүрээнд төрийн албаны шинэтгэлийн багц хуулиуд Улсын Их Хуралд өргөн баригдана. Төрийн албаны шинэчлэлийн ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтоор ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: П.Ганзориг гишүүн урьдчилан ирүүлсэн 3 асуултаа асуугаад дуусчихлаа. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Ерөнхий сайдаас асуух асуултыг долоо хоногийн өмнө бичгээр ирүүлэх дэгтэй. Ингээд Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүн асуулт асууж, хариулт авч дууслаа. Улсын Их Хурлын асуулгын цаг дууслаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулган өндөрлөснийг мэдэгдье.

--оОо--

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ

2.1. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 10 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-ИЙН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 78 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Тусгайлан бэлтгэсэн индрээс Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар нар цуварсан асуулт, хариултаар мэтгэлцэв.

Мөн тусгайлан бэлтгэсэн индрээс Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө бичгээр ирүүлсэн гишүүд болох Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Ц.Мөнхтуяа, Д.Энхтуяа, Ж.Баясгалан, О.Алтангэрэл, Г.Хосбаяр, Д.Жаргалсайхан, Улсын Их Хурал дахь олонхын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, С.Эрдэнэбат, Б.Уянга, Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Г.Уянгахишиг, Б.Найдалаа нарын тавьсан асуултад тусгайлан бэлтгэсэн индрээс Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 16 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

2.2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ 2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-Т УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДААС АСУУСАН АСУУЛТУУД

№	Улсын Их Хурлын гишүүн	Асуулт
УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ		
1	О.Цогтгэрэл	Дундаж давхарга, айл өрхийн амьжиргаа: Хавчигдсан дундаж давхаргаа хэрхэн аврах вэ?
2	О.Алтангэрэл	Дундаж давхаргад очих ёстой баялаг хулгайлагдаж байгаа юу?
3	Ж.Баясгалан	<p>1.Хавчигдсан дундаж давхаргаа хэрхэн аврах вэ гэж бид ярьж байна. Тэгвэл хаягдсан доод давхаргаа ядуурлаас хэрхэн гаргах талаар Засгийн газраас ямар бодлого баримталж байгаа вэ?</p> <p>2.Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан өнөөдрийн байдлаар хэчнээн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангаж, зуучилж, ажилтай, орлоготой болгосон бэ? Ажилд авахгүй байгаа талаар гомдол гаргасан хөгжлийн бэрхшээлтэй хэдэн иргэний асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэсэн бэ?</p> <p>3.Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрах асрамжийн газрыг хэзээ байгуулах вэ?</p>
4	Д.Жаргалсайхан	Авлига, хулгайтай яаж тэмцэх вэ?
5	Ц.Мөнхтуяа	<p>Дэлхийн аль ч улс оронд чинээлэг дундаж давхаргын гол төлөөлөл нь багш, эмч нар байдаг. Боловсролын салбарын багш, ажилтнууд ядуурлын ангалд унасныг хэн хүнгүй мэдэж байгаа. Тиймдээ ч өнөөдөр багш нар ажил хаялт, жагсаал цуглаандаа тулчихсан, боловсролын салбар зогсонги байдалд орлоо.</p> <p>1.Өнөөдрийн түвшинд улсын дундаж нэрлэсэн цалин хэдэн төгрөг байгаа вэ?</p> <p>2.Шинээр төгсөөд багшийн ажилд орсон багшийн үндсэн цалин дундаж цалингаас хэдэн хувиар бага байна вэ?</p> <p>3.Хэзээ, хэрхэн багшийн үндсэн цалинг улсын дундаж цалингаас дээгүүр тогтоох вэ?</p>
6	Г.Хосбаяр	<p>1.Мөнгөний ханшны уналт дундаж давхаргын орлогыг үнэгүйдүүлж байна. Үүнийг яаж анхаарах вэ?</p> <p>2.Жижиг дунд аж ахуй нэгжид орлого нь буурч байна. Гэтэл нөгөө талд төр, хувийн хэвшилд цалин орлого нэмэгдүүлэх ямар боломж гаргах вэ?</p> <p>3.Хувийн хэвшил ажлын байраа хадгалж үлдэхэд ямар дэмжлэг үзүүлэх вэ?</p>

7	Д.Энхтуяа	<p>Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар Монгол Улсын 2026 оны жилийн төсвийн төслийг хэлэлцэж байгаа энэ чухал цаг үед ахмад настны тэтгэвэр, багш эмч нарын цалинг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж, нийгмийн зүгээс хүлээлт үүсээд байна.</p> <p>Өндөр хүлээлт бүхий энэ асуудлыг шийдвэрлэх төсвийн эх үүсвэрийг тодорхойлохын тулд Монгол Улсын Засгийн газар, УИХ боломжит хувилбаруудыг авч үзэж, тэвчиж болох зардлуудад таналт хийх чиглэлээр ажиллаж байна. Төсвийн тухай хууль тогтоомж, төсвийн цаглаврын дагуу төлөвлөсөн төсвийн зардлуудаас цаг үеийн тулгамдсан шаардлагыг биелүүлэх зорилгоор, нухацтай судалгаа тооцоололд үндэслэлгүй шууд хасалт, таналт хийх нь төдийлөн оновчтой биш арга зам юм гэж үзэж байна.</p> <p>Харин төсвийн бүрдүүлэлтэд анхаарч, төсөв бүрдүүлэлтийн бааз суурийг нэмэгдүүлэх талаар цаашид илүү анхаарах шаардлагатай байна. 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлалыг даган мөрдөж, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд стратегийн ордуудаас улс оронд хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлж, баялгийн сангаар дамжуулан нийгэмд тулгамдаж байгаа олон асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлэх боломжтой юм.</p> <p>Стратегийн ач холбогдолтой Оюу толгойн ордод Монгол Улсын Засгийн газар гадаадын хөрөнгө оруулагчтай хамтран хэрэгжүүлж байгаа уул уурхайн төслийн хувьд Монгол Улсын хүчин төгөлдөр хуулийг нэг мөр мөрдөж ажиллах шаардлагатай юм.</p> <p>Энэ асуудлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд танаас дараах асуултын хариултыг авахаар хандаж байна.</p> <p>1.Оюу толгой ХХК-ийн үйл ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг хангуулж, Оюу толгойгоос экспортолж буй зэсийн баяжмал дахь эдийн засгийн үр ашигтай үндсэн болон дагалдах эрдсүүдийг бүрэн, гүйцэд тодорхойлж, тэдгээр эрдсүүдийн хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан хэмжээгээр тооцож авах боломжийн талаар Ерөнхий сайд Та ямар байр суурьтай байна вэ?</p>
8	С.Эрдэнэболд	<p>1.Орлогын өсөлт ба амьжиргааны дарамт: Сүүлийн гурван жилийн турш хэрэглээний үнийн өсөлт дундаж орлоготой өрхийн бодит орлогыг бууруулах гол хүчин зүйл болж байна. Таны толгойлсон Засгийн газар бага, дундаж орлоготой өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх, инфляцын дарамтаас хамгаалах талаар ямар бодлого баримтлан ямар арга хэмжээ хэрэгжүүлж байна вэ?</p>

		<p>2.Хавчигдсан дундаж давхаргын нийгмийн баталгааны бодлого: Дундаж орлоготой, татвар төлөгч өрхүүд нийгмийн халамжид хамрагддаггүй хэр нь ипотекийн зээл, боловсрол, эрүүл мэнд, орон сууцны зардлын дарамтад давхар орж байна. Засгийн газар дундаж давхаргыг хамгаалах зорилгоор орон сууц, боловсрол, нийгмийн халамж, эрүүл мэнд, татварын хөнгөлөлт, дэмжлэгийн шинэ бодлого боловсруулж байгаа юу? Хэрэв байгаа бол ямар хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?</p>
УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ МАН-ЫН БҮЛЭГ		
9	О.Батнайрамдал	<p>1.Таны захирамжаар байгуулагдсан Оюу толгойтой холбоотой ажлын хэсгүүдийг С.Бямбацогт, Б.Жавхлан, С.Дамдинням сайд нар ахлан ажиллаж байгаа талаар мэдээлэл авсан. Эдгээр ажлын хэсгүүд дээр ОНТРЭ-гийн асуудлаар хийгдсэн бодитой ажил байгаа юу? Ямар ахиц дэвшил гарсан бэ?</p> <p>2.2009 онд байгуулсан Оюутолгойн Хөрөнгө оруулалтын гэрээ, 2011 онд дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээнүүдийг өөрчлөхгүйгээр Монгол Улс цаашид ашиг авч чадах уу? Энэ талаар тооцоо, судалгаа байгаа юу?</p> <p>3."Оюу Толгой" ХХК-ийн одоогийн байдлаар хуримтлагдсан өр хэд байгаа вэ? Үүнээс Хувь нийлүүлэгчдийн зээл хэдэн хувийг бүрдүүлж байгаа вэ? Энэхүү өр төлбөрийг хэрхэн, ямар арга замаар төлөх төлөвлөгөөтэй байгаа вэ?</p>
10	Б.Уянга	<p>Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим орчинд хүний хувийн болон ажил хэргийн нэр хүндэд халдах, гүтгэх, худал мэдээлэл тараах, доромжлох зэргээр дур зоргоороо авирлах нь ямар нэгэн шүүлтүүргүй бөгөөд түгээмэл асуудал болоод байна.</p> <p>Үүнтэй холбогдуулж Монгол Улсын Үндсэн хуульд заасан холбогдох зохицуулалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, түүний үнэлгээ хэдэн хувьтай байгаа вэ? Энэ талаар асууж, уг хууль болон холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг уламжилж байна.</p> <p>Монгол Улсын иргэн үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхтэй боловч бусдыг гүтгэж худал ташаа мэдээлэл олон нийт, цахим орчинд түгээх зэргээр Үндсэн хуулиар тогтоогдсон, холбогдох хуулиар хамгаалагдсан халдашгүй байх эрхийг зөрчих нь хариуцлага ногдуулах үндэслэл болдог.</p> <p>Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт "Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. нэр төрийг нь доромжилж болохгүй. ...", мөн зүйлийн 14-т "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл</p>

	<p>уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно", мөн Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ", Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Нийтийн мэдээллийн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, мэдээлэл нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх зарчмыг баримтална" гэж тус тус заасан байна.</p> <p>Дээрх хуулиудад заасны дагуу шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг хангах, хууль дээдлэх, халдашгүй, чөлөөтэй байх, бусдын нэр төрийг доромжилж болохгүй, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно", хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, мэдээлэл нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх, мөн хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ" гэж тогтоосон зохицуулалт хангагдахгүй байх, хүний эрх зөрчигдөх, сэтгэл санааны хямралд өртөх тохиолдлууд гарсаар байна.</p> <p>Иймд Монгол Улсын Үндсэн хуулийг сахин биелүүлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Эрүүгийн хууль болон холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж, хүний эрхийг хамгаалах, сэтгэл санааны хохирлыг барагдуулах, хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохицуулалтыг хуульчлах шаардлагатай гэж үзэж байна.</p> <p>Энэ асуудлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд танаас дараах асуултын хариултыг авахаар хандаж байна.</p> <p>1.Монгол Улсын Үндсэн хуулийг сахин биелүүлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, хүний халдашгүй байх эрхийг хамгаалах хариуцлагын тогтолцоог чангатгах талаар?</p>
--	---

11	Д.Энхтүвшин	<p>1.Стратегийн ач холбогдол бүхий ордуудын өгөөжийг шударгаар хуваарилах, Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх бодлогын хэрэгжилтийн талаар?</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгүүдэд заасан стратегийн ач холбогдол бүхий ордуудыг ашиглаж буй аж ахуйн нэгжүүдийн хэд дээр нь төр хуульд заасан хувь хэмжээгээ эзэмшиж байна. Одоо хэдэн аж ахуйн нэгжүүдтэй "төрийн эзэмших хувь хэмжээг тогтоох" хэлэлцээ хийгдэхээр төлөвлөж, аль шатандаа яваа болон хэзээ бүрэн дуусахаар байна.</p> <p>2.Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд Биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг, 2 дугаар хавсралтаар "Төрийн өмчит банкны хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг тус тус баталсан байна.</p> <p>Дээрх тогтоолоор батлагдсан төрийн өмчит 25 хуулийн этгээд болон төрийн өмчит банкныг нээлттэй хувьцаат компани болгох ажил явагдаж байна уу? Яагаад үр дүн гарахгүй байна.</p> <p>Бусад төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, нэгтгэх нийлүүлэх, нээлттэй компани болгохтой холбоотой судалгаа шинжилгээний ажил хийгдэж байна уу?</p>
12	С.Эрдэнэбат	<p>1.Орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдалд Эрүүл ахуйн тухай хуульд заасан төсвийн зарлагын 0.5 хувийг зарцуулахгүй байгаа шалтгаан юу вэ?</p> <p>2.Ирэх 3 жилд цалин хөлс, орлогыг хэдэн хувиар нэмэх вэ?</p> <p>3.Ахмадуудын тэтгэвэр, хөнгөлөлттэй зээлийн асуудалд ямар арга хэмжээ авах вэ?</p>
ХҮН НАМЫН ЗӨВЛӨЛ		
13	Б.Найдалаа	<p>1.Үе үеийн Засгийн газар төсөв боловсруулахдаа төсөл, үйл ажиллагааныхаа эрэмбэ, ач холбогдлыг оновчтой тодорхойлдоггүй, гал унтраах маягаар хуваарилж ирсэн. Энэ бодлогын алдаа, менежментээ хэзээ шинэчлэх вэ? Ялангуяа яг одоо хөндөгдөөд буй эмч, багш нарын цалинг нэмэх талаар цаашид яг ямар бодлогын өөрчлөлт гаргаж, ямар шийдэл гаргаж ажиллах вэ?</p> <p>2.Эмч нарын цалин нэмэхтэй холбогдуулаад Эрүүл мэндийн даатгалын сангийн (ЭМДС) асуудлыг асуумаар байна. Өнөөдөр эмнэлгүүдийн санхүүжилт, өр авлага гээд салбарын бүхий л гол зангилаа асуудал энэ сантай холбоотой байна. ЭМДС-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах стратегийн худалдан авалтын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж,</p>

		<p>хууль эрхзүйн орчныг сайжруулах нэн шаардлагатай байгаа. Энэ санг шинэчлэхгүйгээр эмч, эмнэлгийн ажилчдын цалинг нэмэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах ямар ч боломжгүй. ЭМДС-ийн менежментийг хэзээ, хэрхэн шинэчилж, сайжруулах вэ? Засгийн газрын бодлого, төлөвлөгөөнд тусгасан гээд байгаа боловч тодорхой мэдээлэл алга. Нийгмийн даатгалын сан ч мөн адил. Бүх сан нь дампуурлын үүр уурхай болоод хувирчихсан.</p> <p>3.Утааны улирал эхэллээ. Агаарын бохирдлын үзүүлэлтийг бууруулах чиглэлээр Засгийн газар ямар бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа вэ? Энэ онд эсвэл ирэх онд яг тэдэн нэгжээр бууруулна гэсэн зорилт, бодлого төлөвлөгөө, тэдгээрийг хэмжих үнэлэх шалгуур үзүүлэлт бий юу? Төр засаг нь утаагаа тодорхой хувиар буурууллаа гээд ярих ёстой байтал эсрэгээрээ угаартаж нас барсан иргэдийн тоо нь жил ирэх тусам нэмэгдээд байдаг байж болохгүй.</p>
14	Г.Уянгахишиг	<p>“Нүүрсний хулгай”-тай холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” зэрэг Төрийн өмчит компаниудыг нээлттэй болгох, санхүүгийн удирдлагыг хяналттай болгох тал дээр ямар арга хэмжээ авч ажиллах вэ? Цаашид хувийн хөрөнгө оруулалттай төслүүд дээр төрийн өмчийн оролцоог нэмэгдүүлэх асуудал яригдаж байна. Төр алтан хувьцаа эзэмших, тусгай АМНАТ тооцох зэрэг хувилбаруудыг хэрхэн ашиглах төлөвлөгөөтэй байна вэ?</p>
15	Б.Мөнхсоёл	<p>1.Таны хувьд намын тал гишүүдээсээ шахуу дэмжлэггүй болж байгаа гэж харагдаж байна. Улс төрийн ийм ээдрээтэй үед та Улсын Их Хуралтай хэрхэн хамтарч ажиллахаар төлөвлөж байна вэ? Ямар бэрхшээл учрах бол?</p> <p>2.Эрүүл мэндийн тогтолцооны санхүүжилтийн асуудал хүнд байгааг өнөөдөр хүн бүр ярьж байна. Энэ асуудлыг бодитой шийдэх ямар төлөвлөгөө танай Засгийн газарт байна вэ?</p> <p>3.Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг батлуулах чиглэлээр та ямар ахиц гаргах амлалт өгч чадах вэ?</p>

-oOo-

2.3. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ 2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-ИЙН ТЭМДЭГЛЭЛ



Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Ерөнхий сайдад урьдчилан хүргүүлсэн асуултын дагуу асуулт асууж, хариулт авах “Улсын Их Хурлын асуулгын цаг” эхэллээ.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл болон Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар нарыг тусгайлан бэлтгэсэн индэрт урьж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл Монгол Улсын Ерөнхий сайдад урьдчилан хүргүүлсэн

асуултыг тавьж мэтгэлцэнэ.

Бүлгийн цуварсан асуултын тоо 9-өөс хэтрүүлэхгүй, асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй байна.

Асуултаа асууж мэтгэлцье.

О.Цогтгэрэл: Та бүхний өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын асуулгын цаг хоёр дахь удаагаа эхлэх гэж байна.

Энэ удаа бид “Дундаж давхаргын тухай” Монгол Улсын дундаж давхарга яагаад сүүлийн жилүүдэд хавчигдаад байна вэ? Энэ төрийн бодлогын алдаа хаана гараад байна вэ? гэдэг сэдвийн хүрээнд явуулахыг хүссэн.

Ер нь төрийн бодлого улс орны хөгжил дэвшилд чиглэх бөгөөд энэ нь ядуу иргэдээ дундаж давхаргад, дундаж давхаргад байгаа иргэдээ чинээлэг хэсэгт оруулахад чиглэх ёстой гэж боддог.

Сүүлийн жилүүдэд нөхцөл байдал юу болж байна вэ? Би хоёрхон зураг харуулъя. Уг нь зөв жишгээр улс орны хүн амын бүтэц, орлогын бүтцээр харахад ядуурлын түвшинд байгаа иргэд нь тодорхой хэмжээнд, дундаж давхарга нь түүнээс илүү их, түүний дээр чинээлэг, баян хэсэгтэй байдаг ёстой юм байна. Энэ жишигт төрийн бодлого чиглэх ёстой юм байна.

Гэтэл өнөөдөр Монгол Улсын хүн ам зүйн бүтэц, эдийн засгийн бүтэц нэг хавчигдсан лонх шиг, элсэн цаг шиг болоод байгаа. Доод суурь буюу хүн амын гуравны нэг нь ядуурлын байдалтай. Дахиад гуравны нэг нь дундаж давхаргын

доод хэсэг буюу ядууралд маш ойрхон түвшинд байна. Энэ улаан хэсэг нийлээд Монгол Улсын хүн амын гуравны хоёр болно. Ийм байдлаар дундаж давхарга хавчигдаад байгаад байгаа юм.

Тэгэхээр эндээс асуух асуулт байна. Нөхцөл байдал яагаад ийм болов? Өнгөрсөн 30 жилд, ялангуяа өнгөрсөн 9, 10 жилд яагаад бодлогын алдаа гаргаад дундаж давхаргыг тэлэх бодлогыг хавчаад байна вэ? Өнгөрсөн 9 жил эрх барьж байгаа Монгол Ардын нам яагаад дундаж давхаргыг хавчих бодлогыг бараг санаатай гэмээр явуулаад байна вэ? Энэ дээр тодорхой байр сууриа илэрхийлнэ үү.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дэд дарга, гишүүдийн өнөөдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Өнөөдөр дундаж давхаргын талаар их чухал асуудал хөндөж байна.

Дундаж давхарга бол дийлэнх монгол зон олон байх ёстой. Харамсалтай нь өмч хувьчлалаас эхлээд манай эдийн засгийн бодлогын тэнцвэр алдагдсан, эдийн засгийн бүтэц алдагдсан, ажиллах хүчин, үйлдвэрлэх хүчин алдагдсанаас шалтгаалсан.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын эдийн засгийн бүтэц үндсэндээ уул уурхайгаас хэт хамааралтай, аж үйлдвэржилт багатай болсон. Дундаж давхарга бол ажилчин анги. Ялангуяа хамгийн чухал нь эмч, багш нар.

Тэгтэл 1992 онд өмч хувьчлалын дараа 480 мянган хүн ажлын байргүй болж тухайн үеийн 4800 үйлдвэр, аж ахуйн газруудыг хувьчилж, дампууралд шилжиж, ажилгүй болсноос хойш манай улс хөнгөн үйлдвэр, хөдөө аж ахуйн эдийн засгаас уул уурхайд суурилсан эдийн засагтай улс болж ажлын байр шингээдэг дундаж давхаргын хамгийн гол ажлыг тэтгэдэг үйлдвэрлэлийн салбар унаснаас шалтгаалсан. Энэ нь манай гадаад худалдааны бодлого, дэлхийн худалдааны байгууллагад элссэн бодлого, импорт, татварын бодлого, мөнгө, зээлийн бодлогын цогц шийдлүүд өнгөрсөн 30 жил буруу томъёолол, зохицуулалтгүйгээр явснаас болж Монгол Улсын дундаж давхарга үндсэндээ багассан.

Албан ёсны статистик тооцоогоор 48 хувийн дундаж давхаргатай гэж байгаа. 2022 оны статистикаар нийт иргэдийн 27 хувь буюу бараг гуравны нэг нь ядууралтай байна гэж тооцоо гарсан. 2024 оны байдлаар ядуурал буурч гарч байгаа гэж сонссон. Тэгэхдээ энэ тоон үзүүлэлт хэр бодитой вэ гэдэг нь ядуурлыг 485 мянган төгрөгөөс доош орлоготой иргэнийг ядуу гэж тооцож байгаа. Тэгэхээр энэ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмэлт 1 минут өгье.

Г.Занданшатар: Дундаж давхарга их эмзэг байна. Хүн амын 60 орчим хувь нь дундаж давхаргад хамаарч байгаа гэсэн дүгнэлттэй боловч хамгийн

ноцтой нь Дэлхийн банкны тооцооллоор инфляц 10.3 хувь болж 1 хувиар нэмэгдэхэд 350 мянган иргэн инфляц, зээлийн дарамтаас үүдэн ядууралд шилжинэ гэсэн эрсдэлтэй байгаа нь гол сорилт юм.

Ийм учраас бид өнөөдөр эдийн засгийн бүтцээ өөрчлөх 5 жилийн үндсэн чиглэлийг Улсын Их Хуралд өргөн барьж байгаа.

2026-2030 онд хөгжүүлэх эдийн засгийн бодлогоор “Шинэ итгэл, эрс шинэтгэл” гэж

- ▶ эдийн засгийн бүтцээ өөрчилж;
- ▶ ажлын байрыг нэмэгдүүлж;
- ▶ дундаж давхаргаа өргөжүүлж;

- хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн, халамжаас хөдөлмөрт шилжсэн татварын реформ,
- зээлийн реформ,
- аж үйлдвэржилтийн реформ,
- эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, дижитал шилжилт гэсэн дундаж давхаргаа өргөжүүлэх цогц реформын бодлогыг бид Улсын Их Хуралд өргөн барьж байна.

О.Цогтгэрэл: Та тэгээд дундаж давхаргыг дэмжих бодлого өнгөрсөн 30 жилд, сүүлийн 10 жилд байсангүй гэж байна. Яагаад бодлого ийм байдалд хүрэв? Монгол Улсын төрийн бодлогын шийдвэрүүдэд дундаж давхаргыг тодорхойлсон, түүнд чиглэсэн, тэр тусмаа танай намын мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр зэрэг ямарваа нэгэн баримт бичиг байхгүй. Ямар ч зорилго, зорилт байхгүй. Энэ үзүүлэлтийг тэд байгааг тэд болгоно, бодлогын арга хэрэгслүүд ингэж чиглэнэ гэсэн ямарваа нэг бодлого хэрэгсэл байхгүй ийм л байдалтай байна. Одоо буруутан нь хаана байна вэ?

Тэгээд би ганц хоёрхон тоо хэлье. Өнгөрсөн 20 жилд уул уурхай болон байгалийн баялгаас монголчууд 100 тэрбум ам.долларын орлого олсон байна.

Энэ мөнгө, эдийн засгийн өсөлт гэж байгаа мөнгө хаачив? Яагаад иргэдэд хамааралгүй, хүртээмжгүй бодлогын арга хэрэгслийг өнгөрсөн хугацаанд зохиож явав?

Монгол Улсын сүүлийн 5 жилийн төсвийг нийлүүлбэл 100 их наядын төсөв зарцуулсан. Өнгөрсөн 1 жилийнх нь 35, 36 их наяд руу явсан.

5 жилээр 100 их наядын төсөв зарцуулсан. Энэ төсвийн зарцуулалт 100 тэрбум ам.долларын байгалийн баялгийн орлого саяын дундаж давхаргыг нэг хувиар ч нэмэгдүүлээгүй.

Танай Монгол Ардын намын 2016 оны мөрийн хөтөлбөрт ядуурлыг бид 2016-2020 онд хоёр дахин бууруулна гэж дээр байсан. Тэр ядуурал хоёр дахин буурч байгаа нь дундаж давхаргад шилжих ёстой байсан.

Гэтэл сүүлийн 10 жилд саяын 100 тэрбум ам.доллар, 100 их наяд төгрөг эцэст нь төрийг, төрийн өмчит компанийг данхайлгаж, нүүрсний хулгайдаа идэгдсэн, оффшор, байгалийн баялаг нь гадагшаа гардаг, дундаж давхарга нь хавчигдсан ийм улс орон болсон. Тэгэхээр бодлогын хүртээмжгүй өсөлтийг яаж засах ёстой юм бэ?

Г.Занданшатар: Энэ цөөхөн минутад яагаад арагшаа яриад байгаа юм бэ? Тоочих юм бол маш олон асуудал хөндөх учраас амжихгүй.

Уул уурхайн эдийн засгийн хувьд уул уурхай бол капитал их шаарддаг, ажлын байр бага шаарддаг салбар. Хөдөө аж ахуй бол ажлын байр илүү бий болгодог, хөрөнгө оруулалт харьцангуй бага шаардаж байгаа салбар.

Гэтэл энэ бүх харьцаа өөрчлөгдсөн. Уул уурхайн салбарын ид өсөлтийн үед манайх баян айлын эрх хүүхэд шиг үрэлгэн зарцуулснаас өнөөдрийн энэ данхайсан төсөв, төсвийн алдагдал, инфляц, өр ханшийн алдагдал бий болоод байна.

Нүүрсний үнэ

- ▶ 2024 онд эхэлж байх үед 325 ам.доллар байсан.
- ▶ Ноднин жил 150 ам.доллар байсан.
- ▶ Одоо 70 ам.доллар болоод хоёр дахин, гурав дахин уналаа.

Ийм их эрсдэлтэй үед 3, 4 сар ажиллаж байгаа манай Засгийн газар энэ 30 жилийн алдааг, 3 жилийн алдааг бүгдийг нь нэг өдөр “өргөс авсан” юм шиг засаж чадахгүй. Гэхдээ бид өнөөдөр өргөн барьж байгаа 5 жилийн үндсэн чиглэлийн төсөлд дундаж давхаргыг баталгаатай хангах системтэй реформыг тусгасан.

Энэ эрс шинэчлэлийн реформын гол зорилт нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажил хөдөлмөр эрхэлж байгаа бүх хүмүүсээ дэмжих, зохистой хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг сайжруулснаар дундаж давхаргын эзлэх хувийн жинг 20 хувиар нэмэгдүүлнэ.

2026 онд дундаж давхаргын эзлэх хувийг тооцож, цаашид 20 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан. Цалин хөлс, нийгмийн даатгалын уялдаа холбоог сайжруулах бодлого хэрэгжүүлж багш, эмч нарынхаа цалинг бодитой нэмэгдүүлье.

Өнгөрсөн 3 жилд төсвийн орлого таны хэлснээр ийм их 100 тэрбум ам.доллар орж, зарцуулж байхад багш, эмч нарынхаа цалинг нэмэгдүүлээгүй юм билээ. Өнөөдөр гэнэт 3 жилийн дараа эдийн засгийн өсөлтийн үед ганцхан жилийн дотор 30 хувь, 40 хувиар, 50 хувиар нэмэгдүүл гэж шаардаж байгаа.

Орон сууцны хүртээмж, амьдралын чанарыг нэмэгдүүлэх зорилгоор орон сууцжуулалтын банк байгуулж хүртээмжтэй орон сууц, иргэддээ

хүртээмжтэй эдийн засгийг бий болгоод байна. Уул уурхайн эдийн засаг нь цөөнхөд хүртээмжтэй, ард түмэндээ өгөөжгүй эдийн засаг байна. Яагаад гэвэл тэнд хулгай байна. Ийм учраас баялгийн хулгайтай тэмцэж байж энэ уул уурхайн өгөөж... /минут дуусав/

О.Цогтгэрэл: Тийм. Тэр дундаж давхарга тэлэхгүй байгаа, улам ядуураад байгаагийн үндсэн шалтгаануудын нэг нь энэ үнийн өсөлт байгаа.

Эдийн засгийг нэмж байна, цалин нэмж байна гэдэг. Үүнээс илүү өнгөрсөн хугацаанд үнийн өсөлт цаана л яваад байгаа.

Сүүлийн 4, 5 жилд дунджаар үнийн өсөлт 70 гаруй хувьтай. Тооцооллын аргачлалаар бол үүнээс ч их байх боломжтой. Тэгэхээр нөгөө талд нь үнийн өсөлт байна. Үнийн өсөлт юунаас үүсэлтэй вэ гэвэл төрийн зардлаас л үүсэж байгаа. Бизнесүүдэд мөнгө очихгүй байгаа. Бизнесүүдэд эрх чөлөө байхгүй. Тэнд төрийн зохицуулалт их. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн зарцуулалт их байгаа учраас жижиг, дунд үйлдвэрлэлүүд нь босож чаддаггүй.

Уг нь эдийн засагт байгаа нийт ажлын байрны хувьд тодорхой тоог хэлбэл 64 хувийг жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар бий болгодог юм байна. Гэтэл тэр салбараа хавчсаар байгаад салбар нь ядуурлын ангид ороод тэнд байсан дундаж давхарга гэх нийгмийн бүлэг байхгүй болж хувирч байгаа. Нөгөө ажлын байр бий болгож байгаа жижиг, дунд үйлдвэрлэл хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа.

Үүний цаана дахиад үнийн өсөлт. Үнийн өсөлт гэвэл Засгийн газар. Гэтэл энэ үнийн өсөлт Засгийн газарт хамаагүй, Монголбанкны асуудал гээд түлхдэг. Үнийн өсөлтийг өдөөгч нь Засгийн газар өөрөө, үүний цаана төрийн зардал, төсвийн зардал, төрийн өмчит компаниуд байгаа.

Тэгээд одоо ажил ярихаар танай Засгийн газар Бид 4 сар болж байгаа гэдэг. Яг үнэндээ энэний, тэрний Засгийн газар биш. 2024 оны Монгол Ардын намын олонх болсон Засгийн газрын мөрийн хөтөлбөр хэрэгжиж байгаа гэж бид бүгд үзэж, ард түмэн та нараас тэр зүйлийг хүлээж байгаа байх. Танай намыг сонгосон хөтөлбөр үүний цаана явж байгаа.

Тэгэхээр Засгийн газраас үнийн өсөлтийг өдөөчхөөд, бий болгочоод өөр бусдад, Монголбанк руу түлхээд амьдралын чанар, дундаж давхаргыг хавчиж байгаа, үнийн өсөлтөөр бодит орлогыг хавчиж байгаа энэ бодлогоосоо яаж татгалзах вэ?

Г.Занданшатар: Хэрвээ би андуураагүй бол өнгөрсөн нэг жил хамтарсан Засгийн газар ажиллаж байсан.

Манай Засгийн газар

→ Хэрвээ би андуураагүй бол ажил аваад 4 сар болж байна.

- Хэрвээ би андуураагүй бол сүүлийн 8 жилд Монголын төр 3.5 дахин данхайсны өнгөрсөн нэг жилд хоёр дахин нь данхайсан.
- Хэрвээ би андуураагүй бол, хэрвээ статистик худлаа хэлээгүй бол дээд гурилын үнэ 3494 төгрөг болж, 2023 онтой харьцуулахад нэгхэн жилийн дотор 30 хувиар өссөн.
- Энэ бүх үнийн өсөлт, инфляц бодит байдал дээр
 - Иргэдийн орлогыг бууруулж байна.
 - Уул уурхайгаас олсон орлого цөөнхийг данхайлгаж байна.
 - Нийгмийн орлогын зөрүүг бий болгож байна.
 - Орлогын ялгаа буюу Жини коэффициент нэмэгдэж байна.
 - Энэ хоёр орон тоотой инфляцад сүүлийн нэг жил явж ирсний үр дүнд дундаж өрхийн бодит орлогыг бууруулж байна.
 - Төр баяжиж, иргэн ядуурч байгаагийн тод жишээ нь энэ өнгөрсөн жилд.

Ийм учраас бид төсвийг 2.2 их наядаар танаж тодотгол хийсний үр дүнд өнөөдөр инфляц буурч, 15 хувьд хүрэх байсан тооцооллыг бид барьж чадсан.

Ам.долларын ханш 4000 төгрөгт хүрч, иргэдийн амьжиргаа ядуурах байсныг тогтоосон. Бүх юмаа импортолдог улс болсон учраас импортоос бүх үнэ хамаардаг болсон. Улмаар импортын үнэ валютын ханшаасаа 4 мянгад хүрэх байсныг бид сэргийлж чадсан.

Ганцхан бодит жишээ гэхэд өчигдөр “Standard & Poor’s” агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэл эдийн засгийн нэр хүндийг 2В ангилал болгож 13 жилийн түүхэнд сайжрууллаа.

Энэ инфляц, валютын ханшаа бариад, өр, төсвийн алдагдлыг бууруулж байгаа бүхэн өнөөдрийн манай Засгийн газрын бодит жишээ. Тийм учраас бидний энэ хулгайтай хийж байгаа тэмцэл, авлигатай хийж байгаа тэмцэл нь зөвхөн инфляцыг бууруулж байгаа биш, төсвийн алдагдлыг ч нэмэгдүүлж байгаа юм биш. Ерөнхий утгаараа таны хэлээд байгаа дундаж... /минут дуусав/

О.Цогтгэрэл: Асуултын эхэнд нэг тодруулга хэлэхэд өнгөрсөн нэг жилийн хугацаанд хамтарсан Засгийн газар ажилласан гэдэг.

Гэтэл яг үнэндээ Монгол Улсын Үндсэн хуульд олонх болсон нам Засгийн газраа байгуулна гэж байгаа болохоос биш олонх нь цөөнхтэйгөө нийлээд хамтарсан Засгийн газар байгуулах тухай ойлголт байхгүй.

Тэгэхээр өнгөрсөн нэг жилийн хамтарсан Засгийн газар гэж байгаа ойлголт бол Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газарт Ардчилсан намын 8 сайд хөдөлмөрийн гэрээгээр орж ажилласан ойлголт гэж бид үздэг. Яг хамтарсан Засгийн газар гэдэг хууль эрх зүйн ойлголт байхгүй. Байхдаа хүрвэл аль нэг нам олонх болоогүй “Эвслийн Засгийн газар” гэдэг ойлголт байдаг гэдгийг бас хэлье.

Яг өнөөдөр гудамжинд эмч, багш нар гарсан байна. Бусад улс орны жишгээр эмч, багш нар гэдэг хүмүүс нийгмийнхээ, эдийн засгийнхаа дундаж давхаргад тооцогддог юм байна.

Гэтэл манайд дундаж давхаргыг тооцож байгаа аргачлал байхгүй. Яг хэдээс хэдэн төгрөгийн орлоготой айл өрхийг бид дундаж давхаргадаа тооцох юм бэ гэдэг талаар төрийн бодлогод суусан зүйл байхгүй. Бүр нөгөө “хэмжиж чадахгүй бол удирдаж чадахгүй” гэдгээр бид өнөөдөр хэмжих ч үгүй байгаа. Янз бүрийн аргачлалаар хэмжлээ гээд бодоход нөгөө багш, эмч нар маань бүгдээрээ гудамжинд гараад суусан, ядуурлын байдалд орсон. Багш, эмч нараа, эрүүл мэнд, боловсролын салбараа бид дунджаас доош түвшинд түлхэж оруулчихаад сайн сайхан зүйл ярихад үнэхээр хэцүү байна.

Нөгөө талдаа багш, эмч нарын цалинг дахиад шууд нэмнэ гэхээсээ урьдаар заавал гарц, гүйцэтгэл, бүтээмжийн тухай асуудлыг онцгойлон ярихаас өөр аргагүй.

Тэгэхээр цалин хөлс нэмэх бодлогоо та нэг тодорхойлж хэлж өгөөч.

Г.Занданшатар: Баярлалаа. Ер нь өнгөрсөн 3 жилд багш нарын цалинг 3.5 сая төгрөг болгож жил бүр 10 хувиар нэмэгдүүлж байгаад 30 хувьд хүрнэ гэсэн гурван талт хэлэлцээр байгуулсан юм билээ. Тэрийгээ өнгөрсөн 2 жил хэрэгжүүлээгүй юм байна. Өнөөдөр хуримтлагдсаныг тооцоод 30 хувиар нэм гээд шаардаад байж байгаа.

Хэрвээ би бас андуураагүй бол эдийн засгийн асуудал хариуцсан Тэргүүн Шадар сайдаар Лу.Гантөмөр гээд танай намын дарга ажиллаж байсан. Тэр хүнээс өнгөрсөн жил алт, зэс, нүүрсний үнэ өндөр байхад, төсөв тэлж данхайж байхад энэ асуултуудыг асууж шийдэж байсан бол нэг жилийн өмнө эмч, багш нарынхаа цалинг нэмж өгөх байжээ.

Өнөөдөр бид хуруу хумсаа хуйхалж байгаад багш, эмч нарынхаа цалинг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж байна. Өнөөдөр хүртэл яриа хэлэлцээ хийгээд үндсэндээ зарчмын тохиролцоонууд дээр хүрч харилцан ойлголцож байна.

Жил бүр 10 хувиар нэмэгдэж байгаад 3 жилийн хугацаанд 30 хувь нэмэгдүүлнэ гэснийг өнгөрсөн 2 жилд алт, зэс, нүүрсний үнэ өндөр байхад ганц ч төгрөгөөр нэмэгдүүлэхгүй байж байгаад өнөөдөр бүгдийг нэм гээд шаардаж байна.

Мэдээж боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд Л.Энх-Амгалан сайд бүтээмжийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн цалингийн тогтолцоонд шилжүүлэх тогтолцооны шинэчлэл хийж байж энэ өөрчлөлтийг хийж чадсан.

Одоо бид цалингийн цогц реформ хийж бүтээмж, гүйцэтгэл дээр тулгуурласан оновчтой цалингийн системийг бий болгох замаар бага цалин буюу 1,484 мянган төгрөгийн цалин авч байгаа ачаалал ихтэй нийслэлийн багш нарын цалинг нэмэгдүүлэх шийдэлд хүрч байгаа.

Нийслэлийн багш нар бусад багш нараасаа бараг хоёр дахин ачаалалтай ажиллаж байгаа. Үүнийгээ шийднэ. Энэ бол мэдээж хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэхийн тулд бүтээмж, гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцооны реформ хийхээр 5 жилийн төлөвлөгөөндөө тусгаад 3 жилийн хугацаанд зорилтот түвшинд хүрэхээр төлөвлөж байна.

Одоо 2026 оноос эхлэн бид багш, эмч нарын доод цалингийн суурийг нь 50 хүртэл хувь нэмэгдүүлэх. Ингэж байж... /минут дуусав/

О.Цогтгэрэл: Цалин, тэтгэврийн нэмэгдлийг мэдээж харгалзаж үзэлгүй яах вэ. Тэгэхдээ үүний цаана бүтээмжийг, өсөлтийг, бүтцийн өөрчлөлтийг, олон зүйлүүдийг бас давхар авч явах ёстой шүү гэдгийг дэмжиж хэлж байгаа шүү.

Дараагийн нэг асуулт нь эдийн засгийн бүх үзүүлэлтийн нийгмийн үр нөлөө их гарч байна. Энэ дундаж давхаргыг дэмждэггүй, ажил хөдөлмөр хийж байгаа хүнээ дэмждэггүй 10 жилийн бодлогын үр дүнгээр Монгол Улсад ажил хөдөлмөр хийдэг, арай жаахан сэхээтэнлэг хэсэг тэр чигээрээ дайжаад Монгол Улсаас гараад явж байна. Одоо бараг албан бус тоогоор 300-аад мянган иргэн гадаад улсад байна.

Судалгааны санал асуулгад оролцсон иргэдийн 60 гаруй хувь нь хэрвээ би чаддаг сан бол, хэрвээ би асуудлаа шийдэж чадвал гадагшаа гармаар байна гэсэн. Үндсэндээ оюуны дайжилд гэдгийг Та бүхэн бүгдээрээ “BRAND DRAIN” гээд ярьж байгаа. Тэгэхээр энэ улс орноос яг ажил хөдөлмөр хийдэг хүмүүс нь дайжих нөхцөл байдал байна. Тэр тусмаа бид өнгөрсөн хугацаанд ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүсээ, багш, эмч нараа бодлогоор дэмждэггүй. Ажил хийгээд, цалин аваад ядуураад байдаг тогтолцоог бид өнгөрсөн хугацаанд бий болголоо.

Одоо оюуны дайжилд энэ чигээрээ үргэлжлэх юм бол бараг “оюуны хоосрол” гэдэг зүйл рүү бид бараг нэг алхаад ороход бэлэн боллоо.

Тэгэхээр ажил хөдөлмөр эрхэлж байгаа залуучууд, иргэдэд энэ төрийн бодлого, төсвийн бодлого, төрийн өмчит компанитай холбоотой олон асуудал дээр бидний яриад, тунхаглаад байгаа бодлогууд дээр ганц хоёр удаа ахиц гарах уу? Ажил хийж байгаа хүмүүсээ, ялангуяа залуучуудыг яаж урамшуулах юм бэ?

Г.Занданшатар: Хөдөлмөрлөсөн хэр нь ядуурдаг энэ байдал манай улсын эдийн засгийн хамгийн эмзэг байдал бөгөөд тантай 100 хувь санал нэг байна. Үүнийг л засахын төлөө бид энэ 5 жилийн эдийн засгийн бүтцийн эрс шинэчлэл хийе, бүтээмжийн шинэчлэл хийе, халамжаас хөдөлмөрт шилжье гэж байгаа.

Эдийн засгийн бүтэц маань зөвхөн уул уурхайгаас хамааралтай биш, илүү нэмүү өртөг шингээсэн аж үйлдвэржилт, дижитал шилжилт, инновац, технологи шингэсэн шинэ эдийн засгийн салбаруудаа дэмжье, аялал жуулчлал,

хөдөө аж ахуйгаа инновац шингээж шинэчилье, хөгжүүлье гэсэн цогц шинэчлэлийн бодлогыг бид Улсын Их Хуралд өргөн барьж байгаа.

Зөвхөн багш, эмч биш, энэ “BRAND DRAIN” буюу “оюуны гадагшлах урсгал” Монгол Улсын хамгийн том эмгэнэл болоод байна гэхэд хилсдэхгүй. Яагаад гэвэл энэ баялгийн хулгайгаас, улсад шударгаар хөдөлмөрлөсөн нь, хөдөлмөрлөж байгаа нь тэр хэмжээндээ цалин авч орон сууцтай болж сайхан амьдардаг биш, уул уурхайг дагасан хэсэг нь л хөрөнгөждөг, баяждаг. Тэрний цаана авлига, хээл хахууль нуугдаад байгаа учраас энэ шинэчлэлийг хийж байж энэ реформ бодитой хэрэгжинэ.

Ийм учраас “цалингийн шинэчлэл”, “бүтээмжийн шинэчлэл” хийнэ. Бүтээмжийн шинэчлэлийн хүрээнд бүтцийн өөрчлөлтийг хийх хэрэгтэй. Зөвхөн боловсролын салбарт гэхэд багш нараасаа олон ажилтан, ажиллагсад ажиллаж байгаа.

Ер нь бүх салбарт (боловсрол, бизнесийн салбар гэх мэт) бүтээмжид шингэсэн биш, хөдөлмөрлөсөн, ажиллаж байгаа нь илүү үр дүнтэй байдаг биш байгаа тул цогц эрс шинэчлэл хийе гэж бид 5 жилийн үндсэн чиглэлийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа.

Уг нь төсвийнхөө өмнө өргөн баригдах хуультай байсан. Даанч Улсын Их Хурал цаглаврын өөрчлөлтийг хийсэн учраас 9 дүгээр сарын 01-ний өдөр төсөв өргөн барьдаг болоод төсвийнхөө дараа эдийн засгийн бодлогоо ярьж байгаа өөрчлөлт гарч байна.

О.Цогтгэрэл: Тэгвэл яаж ядуурлыг бууруулаад, дундаж давхаргаа тэлэх юм бэ? гэдэг дээр яг ямар бодлого, үзэл баримтлалыг барих ёстой вэ? Ямар ч тохиолдолд танай нам ядуурлыг халамжаар бууруулаад, халамжаар дундаж давхаргыг бий болгож чадахгүй гэдэг нь эдийн засгийн өсөлттэй, орлоготой өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд харагдлаа. Тэр 100 тэрбум ам.долларын орлого, 100 их наядын төсөв энэ бүгдийг зарцуулаад дундаж давхарга улам хавчигдлаа.

Сая 2025 оны Нобелийн шагнал авсан эдийн засгийн эрдэмтдийн бүтээлд инновац, эрх чөлөө гэдэг зүйл гарсан байна. Эдийн засгийн эрх чөлөө л тэр өсөлтийг, сайн сайхан амьдралыг авчирдаг гэдэг зүйлүүд дурдагдсан байна.

Танай Засгийн газрын зүгээс бодлогын өөрчлөлтөө яаж хийх юм бэ? Бид жижиг уриа лоозон, олон зүйл хэлэхээ больё. Эдийн засгийн бодлогын өөрчлөлт гэдгийг та нэгдүгээрт нь хэлж өгөөч.

Хоёрдугаарт нь, энэ ядуурлыг нэмэгдүүлж байгаа, дундаж давхаргаас ядуурал руу залгаж оруулж байгаа нэг асуудал байна. Энэ бол эрүүл мэндтэй холбоотой ядуурал. Айл өрх, гэр бүлийн нэг гишүүн өвдөхөд үндсэндээ тэр гэр бүлийг шууд ядууралд чирч оруулж байгаа.

Судалгаагаар ядууралд орж байгаа 20 гэр бүлийн нэг нь эрүүл мэндийн ядууралд орж байна. Үүний цаана тогтолцооны, Эрүүл мэндийн даатгалын систем, өөрчлөлт шинэчлэлтүүд өнгөрсөн хугацаанд бүгдээрээ аргацаагдаж хийгдэхгүй байсны дүнд дахиад нэг ядуурлын шалтгаан бий боллоо.

Айл гэрийн нэг гишүүн өвдөхөд... /минут дуусав/

Г.Занданшатар: Баярлалаа. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн реформ хийнэ гэдэг нь уул уурхайгаас төвлөрч байгаа өгөөжийг хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн бусад салбараа дэмжих замаар ажлын байр бий болгодог, илүү чөлөөт зах зээлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ гэсэн үг.

Дандаа төрийн өмч хэт давамгайлсан системийг илүү хувийн хэвшилд, чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж байж өрсөлдөөнийг бий болгосон шинэ эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж чадна. Үүнийгээ дэмжиж байж эдийн засгийн дундаж давхаргаа тэлж чадна.

Эрүүл мэндийн даатгалын хувьд үр нөлөөг нэмэгдүүлж цогц реформ хийхээр хөтөлбөрт тусгасан байгаа. Иргэдийг гэнэтийн санхүүгийн дарамтаас дундаж өрхөө хамгаалахад Эрүүл мэндийн даатгалын сангийн “SOLIDARITY” буюу “эв санааны нэгдлийн зарчим” оршдог.

Гэнэтийн өвчлөлийн буюу “catastrophic” зардлууд дундаж өрхийн хамгийн том санхүүгийн дарамт байна гэж судалгаагаар тогтоогдсон. Энэ нь даатгалын систем бүрэн төгс ажиллаж чадахгүй байгаагийн яруу тод илрэл. Энд захиргааны зардал санхүүжүүлээд байна. Энэ шинэчлэл Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрч байгаа нэг их наяд орчим төгрөгийн 60 хувь нь эмчилгээний бус захиргааны зардалд болон зайлшгүй шаардлагатай биш бусад өвчлөлийн зардал зарцуулагддаг байна. Иймд санхүүгийн реформ хийх ёстой.

Эрүүл мэндийн салбарын асуудал санхүүгийн реформтой уялдах ёстой. Бүтэц, зохион байгуулалтын хувьд ч гэсэн өөрчлөгдөх ёстой. Зөвхөн Эрүүл мэндийн даатгалын сан биш нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, цахим үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх замаар захиргааны зардлуудыг бууруулах ёстой. Ингэж “catastrophic” үйл явдлын өрхийн амьжиргаанд үзүүлж байгаа санхүүгийн дарамтыг бууруулах нь гол зорилт байх ёстой.

О.Цогтгэрэл: Харин тийм. Ингээд л өнгөрсөн Засгийн газрууд “ийм байх ёстой”, “тийм байх ёстой” гэдэг гоё тунхагласан зүйлүүдийг ярьж, түүнийг нь бид маш их сонслоо.

Эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын тогтолцоонд миний мэдэхээр сүүлийн 6 жилд өөрчлөлтийн цэг хатгасангүй.

Үүний үр дагавар ч гарч байна. Боловсролын салбар, оюуны дайжилд, ажлын байр, чадварлаг ажилтан, мэргэжилтэн гэх олон зүйл энэ чигээрээ

байхгүй. Ингээд бид 100 их наядаар нь, 100 тэрбумаар нь мөнгөний том, том тоо яриад байдаг. Гэвч өнгөрсөн хугацаанд цэг хатгасан, өөрчлөлт шинэчлэлийн хөтөлбөр байдаггүй.

Эрчим хүч яривал олон зүйлүүд байна. Ер нь манай улс зах зээлд шилжсэн орон биш яг л социализмаараа шахуу л байж байна шүү дээ. Эрүүл мэндийн салбар, боловсролын салбар, эрчим хүчний салбар, төмөр зам бүгд дээр нь үнэ барьсан. Нэг ийм л нөхцөл байдалтай улс орон өнөөдөр байна.

Уг нь дундаж давхарга гэдэг өөрөө бидний саяын яриад байгаа шиг зөвхөн нэг эдийн засгийн ойлголт биш юм. Энэ дундаж давхарга гэдэг нь улс орныхоо хөгжил дэвшлийг, ирээдүйг чирч явж байдаг, үр хүүхдүүдийнхээ боловсролд хамгийн их мөнгө төгрөг, санхүүгээ зарцуулж байдаг ийм хүмүүс. Тухайн улс орныхоо нийгэм, соёлын түүх бахархал бүх зүйлээ тээж явж байдаг. Улс орныхоо улс төрийн нийгмийн тогтвортой байдлыг хангаж байдаг. Энэ эдийн засгийн ойлголтын цаана ийм асар чухал нийгмийн бүлэг энд байдаг.

Уг нь ардчилалтай, ардчилсан тогтолцоо, ардчилсан сонгуультай, шударга сонгуультай хүртэл дундаж давхарга очиж холбогдож байдаг ийм л утга учиртай ойлголтыг бид зүгээр юу ч биш болгож хувиргаж, үүнийг ярьдаг, хэлдэг, хэмждэг, зорьдог ямар ч ойлголтгүй үндсэндээ... /минут дуусав/

Г.Занданшатар: Ер нь бид зөвхөн ёстой гэж яриад байгаа юм биш ээ. Энэ бол дандаа хэрэгжүүлээд эхэлсэн реформуудын талаар ярьж байгаа.

Бид ирээдүй цаг дээр биш дандаа одоо цаг дээр ярьж байгаа. Бид хийх гэж байгаа ажлынхаа тухай биш, хийж байгаа ажлынхаа үргэлжлэлийн талаар ярьж байгаа.

Бид Эрүүл мэндийн даатгалын сангийн удирдлагыг нь өөрчлөөд Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны үр ашиг, хяналтын тогтолцоог шинээр нэвтрүүлж, өөрчлөлтийг одоо Улсын Их Хуралд оруулж ирэх гээд хуулийн төсөл дээр ажиллаж байна.

Боловсролын салбарын цогц реформ дээр ажиллаж байна. Одоо Ц.Мөнхтуяа гишүүний санаачилсан хуулиас эхлээд бид хамтарч ажиллаж байна.

Тэгэхээр бид хамтарч энэ реформуудыг хийх ёстой. Ингэж байж хамтарч тарьсан 30 жилийнхээ алдаа завхралыг хамтдаа засах ёстой. Өнөөдрийн эдийн засаг, ядуурал, дундаж давхарга бид бүгдийн алдаа. Улс орны дундаж давхарга гэдэг бол ардчиллын тогтвортой байдлын гол баталгаа, тэр нь дундаж давхаргын бэхжилт байдаг. Ингэж байж санал хураалт, сонгууль шударга явагддаг.

Хэрэв нийгэмд ядуурал их байвал, зөв сонголт хийх чадавх ардчиллын баталгаа алдагдаж байдаг. Дундаж давхаргын эдийн засгийн доройтол цаад утгаараа ардчиллын доройтол байгаа юм. Ийм учраас ардчилсан нийгмийнхээ төлөвшлийн хувьд ч гэсэн тэр, эдийн засгийнхаа хөгжил төлөвшлийн хувьд ч

гэсэн хүртээмжтэй эдийн засаг гэдэг таны дурдаж байгаа Нобелийн шагналт эрдэмтдийн дурдсан чиглэл болсон. Эдийн засгийн өсөлт 10, 20 байх нь хамаа байхгүй. Дундаж давхаргатаа, нийт иргэддээ үр өгөөжтэй байх ёстой. Үүний тулд хамгийн тулгуур асуудал нь баялгийн хулгайтай тэмцэж, шударга ёсны сууриа сайжруулж байж төсөв, эдийн засаг бүх суурь сайжрах гээд байна. Үүний төлөө л бүгдээрээ нэгдэж тэмцэхгүй бол энэ бол ганц хоёр хүний хийх ажил биш.

Ийм учраас энэ нүүрсний хулгай, үндэсний баялгийн хулгайн эсрэг тэмцэл ядууралтай, тэгш бус байдалтай хийж байгаа дундаж давхаргаа өргөжүүлэх гэсэн тэмцэл юм шүү. Ер нь энэ 4 тулгуурт бодлогыг бид... /минут дуусав/

О.Цогтгэрэл: Одоо төгсгөлийн минут юм байна. Өнөөдрийн сэдэвтэй холбоотой би дүгнэлтээ хэлье.

Нэгдүгээрт, бараг бодлогоор гэмээр, санаатайгаар гэмээр ард түмнээ ядууралд байлгаж, тэр их олон тэрбум, олон их наядын мөнгөний цаана иргэдээ ядууралд байлгаад дундаж давхарга руу чирэх бодлогыг өнөөдөр хүртэл гаргаж ирдэггүй.

Хоёрдугаарт, боловсролын салбараасаа эхлээд хувь хүн рүүгээ чиглэсэн хүний хөгжил, амьдралын чанартай холбоотой бодлогыг бид томъёолж гаргахыг зорьдоггүй. Энэ байдлыг харвал XIV зууны үед Английн IV Хенри хаан Ромын ПАП-д тухайн үед нэг үгийг хэлж байсан гэдэг. Энэ хэлэлцүүлгийн дүгнэлт болгож би энэ үгийг хэлмээр байна.

IV Хенри хаан Ромын ПАП-д хэлэхдээ “Та ард түмнээ мунхаг байлгахад зорь. Би ард түмнээ ядуу байлгая. Энэ хоёр нийлэхээр та бид хоёр мөнхөд засаглаж чадна.” гэжээ. Ард түмэн ядуу, ард түмэн мунхаг байвал та бид хоёр нийлээд мөнхөд засаглаж чадна. Яг л энэ бодлого. Санаатай гэмээр бараг ийм бодлого өнгөрсөн хугацаанд үргэлжилжээ.

Тэгээд энэ бодлого дээрээ та бид тийм ийм гэсэн тунхгийн зүйлүүд биш, бодлогын эрс өөрчлөлт гаргахгүй, зорихгүй, хийхгүй бол энэ нийгэм буруу тийш явж байна шүү гэдгийг төгсгөлд нь дүгнэж хэлье.

Г.Занданшатар: О.Цогтгэрэл даргадаа. Баярлалаа.

Тунхаг биш, хэлсэн ярьсандаа байж, хэлсэн үгэндээ эзэн сууж байж бид энэ бодлогоо хэрэгжүүлэх ёстой.

Бид баялгийн хулгайтай тэмцэх, үнэн зөв нийгэм байгуулах, үгэндээ эзэн болж байж бидний үйлдэл, үйл хэрэг зөв байж ялна.

Тийм учраас бид энэ зарчмыг баримталж байгаа. Хийх ажилдаа бид тууштай байна. Яагаад гэвэл энэ ажлыг хүүхдийн мөнгөнөөс эхлээд Ардчилсан нам санаачлаад бид хамтарч ажилласан, бидний үйлийн үр, хийсэн ажил, өнөөдрийн үр дүн бол хэн нэгэн рүүгээ түлхээд байх биш, халамжийг шүтсэн

бодлого, үндэсний аж үйлдвэрээ унагаасан бодлого санаатай юм шиг явуулж ирсэн хараат байдал руу чиглэж байгаа бодлого манай эдийн засгийн аюулгүй байдлыг тун эмзэг болгосон.

Гадаад худалдааны 70 хувь нь гадаад улсаас хамааралтай, экспортын 95 хувь уул уурхайгаас хамааралтай. Нэг улсаас хамааралтай. Өр, импорт, шатахуун, эрчим хүч ямар байдалтай болгосон эдийн засаг санаатай гэмээр энэ үйлдлүүд бол бид хэлсэн үгэндээ эзэн сууж чаддаггүйгээс л болсон. Гоё гоё юм ярьдаг. Эцсийн үр дүн, үйлдэл өөр байдаг.

Тийм учраас бид та бүхнийгээ үгэндээ үнэн байж, үйлдэл үйл хэрэг эх орныхоо төлөө хамт зүтгэж, энэ өөрчлөлт реформуудыг хамтарч хэрэгжүүлье гэж эцэст нь уриалмаар байна.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Одоо Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна.

Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секунд байна. Би нэг хүн 2 минутаас хэтрэхгүй асуулт асууж, үг хэлэх хугацаатай. Нэг удаа 1 минутаас хэтрэхгүйгээр нэмж өгнө. Одоо Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууна уу.

С.Эрдэнэболд: Сая 10 дугаар сарын 19-ний өдөр Төв аймгийн Жаргалант суманд аймгийн Иргэдийн Хурлын дарга н.Энхболдын хамт, мөн Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумуудад ажиллалаа. Энэ уулзалтад Монгол Улсын Хөдөлмөрийн баатар н.Нэргүй, гавьяат агрономич н.Болдбаатар, мөн тариалан эрхлэгч н.Болормаа, н.Батнасан, н.Эрдэнэ-Од нарын иргэдтэй уулзсан.

Эдгээр уулзалтаас үүдэж танаас асуулт асууя. Ер нь дундаж орлоготой татвар төлөгч өрхүүд нийгмийн халамж, хөнгөлөлттэй гэх ипотекийн зээлд хамрагддаггүй хэр нь боловсрол, эрүүл мэнд, орон сууцын зардлын дарамтад давхар өртөөд байдаг. Энэ дотроос нэг төлөөллийг онцолж ярих гэж байгаа нь газар тариалангийн салбар. Жишээлбэл, Жаргалант сум гэхэд Монгол Улсын төмсний 60-аас доошгүй хувийг хангадаг хэр нь ган гачиг, дээрээс нь менежментийн алдаа, төрийн буруу бодлогоос болоод маш хүнд байдалтай байна.

Нэгдүгээрт, томоохон аж ахуйн нэгжүүдэд зээл чөлөөтэй олдоод байдаг хэр нь дундаж буюу бага га талбайд тариалан эрхэлж байгаа хүмүүст зээл ерөөсөө олдохгүй байна гэж байгаа юм. Тэгээд төлөөлөөд хэлэхэд, энэ нь эргээд дундаж давхарга болсон тариалан эрхлэгчдээ төрийн бодлого очихгүй байна гэдэг асуудал байгаа.

Хоёрдугаарт, иргэдийн хооронд нэг том асуудал нь тариалан эрхэлдэг газруудад тариаланч, малчид хоорондын газрын маргааны асуудал их болдог. Нэг нэгнийхээ амь насанд заналхийлдэг, адуу малыг нь бууддаг эхнээсээ шорон

оронд явдаг гээд асуудлууд байгаад байгаагийн цаад зангилаа нь төрийн бодлогын алдаа байгаа юм.

Өөрөөр хэлбэл, шударгаар бизнес хийж аж төрөх гээд, амьдрах гээд явж байгаа хүмүүст хуулийн хийдэл ч юм уу, гарц нь тодорхойгүй байдлаас иргэд өөрсдөө хохирогч болоод эдийн засгаараа ч тэр, юм юмаараа хохироод байгаа. Энэ дээр таны байр суурийг сонсмоор байна.

Ер нь сүүлийн 10 жилийн турш нэг Засгийн газарт онцолж хэлнэ гэхээсээ илүүтэйгээр Монгол төрийн сүүлийн 10 жилийн бодлогод хэрэглээний үнийн өсөлт нь дундаж орлоготой өрхийн бодит орлого хоёр гүйцэтгэж чадахгүй байгаад байгаа.

Тэгэхээр таны тэргүүлж байгаа Засгийн газар бага, дунд орлоготой өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх, инфляцын дарамтаас хамгаалах талаар яг ямар бодлого баримтлах вэ? Энэ талаар тодорхой хариулт өгөөч.

Төгсгөлд нь хэлэхэд “FOSS” буюу “The Forum of Small States”-ээс гаргасан судалгаагаар 10-аас доош сая хүн амтай улсууд хөгжихийн тулд нэгдүгээрт боловсролын салбараа л үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшил, өрсөлдөх чадварын түвшинд авч үзэх ёстой гэсэн байгаа.

Багш нарын ажил хаяад байгаа, эмч нарын ажил хаях гээд байгаа энэ асуудал бол салбарын зовлон биш Монгол Улсын ирээдүй хөгжил дэвшлийн зовлон гэдэг талаас нь дундаж давхаргаа дэмжинэ гэдэг талаас нь та нэг хариулмаар байна.

Дээрээс нь өрсөлдөх чадварын судалгааны олон улсын тайлан гаргадаг төвөөс Монголд байгаа 5 хямралын нэгдүгээрт нь засаглалын хямрал байгаа бөгөөд засаглалын хямрал нь өөрөө дундаж давхаргын бодлогоо дэмжиж чадахгүй байна гэж хэлж байгаа. Энэ дээр таны байр сууриудыг сонсьё.

Г.Занданшатар: С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээр асуулт. Төлөвлөгдөөгүй, байгаагүй асуулт ч гэсэн хариулъя. Ер нь газар тариалангийн салбарыг санаатайгаар юм шиг ерэн хэдэн оны дараа бүх сангийн аж ахуйнуудыг хувьчлал нэртэй хувьчлалаар биш дампууруулаад Монгол Улс ер нь импортоор гурил, будаа, төмсөө авах ёстой гэсэн бодлого хэрэгжиж, үүний үр дүнд газар тариалан үндсэндээ унасан байсан.

Ингээд 2022 оноос Хөдөө аж ахуйн яам энэ бодлогыг өөрчилж, одоо хөдөө аж ахуй сэргэж байгаа юм. Энэ хүрээнд “Атрын IV” аян, “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний үр дүнд хөдөө аж ахуйн салбарт нэлээн сэргэлт бий болж байгаа.

Энэ дотор таны хэлж байгаа малчид, тариаланчдын хоорондын зөрчлийг зохицуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас тариалангийн бүс нутгийг

тогтоосон. Тариалангийн бүс нутагт уламжлалт мал аж ахуй эрхлэхгүй, харин эрчимжсэн мал аж ахуй эрхэлж болно.

Эрчимжсэн мал аж ахуй болон газар тариаланг уялдаатай хөгжүүлж болох бодлогын шийдэл, чиглэлийг гаргаад хэрэгжүүлж байгаа. Үүнийг орон нутагт хэрэгжүүлэх ёстой.

Дээр нь тариалангийн талбайгаа хашаажуулах ажил, моджуулах, мод тарих ажил гэх мэтчилэн ийм цогц ажил, арга хэмжээнүүдийг нэн ялангуяа таны сонгогдсон төвийн бүс нутаг Сэлэнгэ, Дархан, Эрдэнэт, Төв аймагт тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байгаа.

Тариаланга нэмэгдүүлэхийн тулд тариалангийн бүс газраа нэмэгдүүлэх бас шаардлагатай байгаа. Энэ хүрээнд малчид, тариаланчдын хооронд хариуцлагын гэрээ байгуулах, тэжээл болон өвс тэжээлийн тусламж олгох бол сумын Засаг дарга нарын зохицуулах асуудал. Хууль тогтоомж нь хангалттай байгаа.

Тийм учраас орон нутгийн удирдлагуудтайгаа яриад малчид тариаланчдын хоорондын харилцааг зохицуулах боломжтой бөгөөд эрх зүйн үндэс бүрэн бүрдсэн байгаа. Шаардлагатай бол та тариаланчдаа төлөөлөөд хууль санаачилж зохицуулалтыг улам чангатгаж болно.

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж Г.Занданшатар Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийн 70 хувь нь нийлүүлэлтээс шалтгаалж байгаа.

Монгол Улс үйлдвэрлэгч улс биш учраас үндсэндээ импортоос хамааралтай болсон. Худалдааны 70 хувь гадаад улсаас хамааралтай болсон гэж хэлсэн.

Тэгэхдээ хэрэглээний сагсны гол нөлөөлдөг өсөлтүүд нь

- ▶ мах,
- ▶ гурил,
- ▶ цахилгааны төлбөр,
- ▶ дулааны төлбөр,
- ▶ сургалтын төлбөр

гэдэг хүчин зүйлүүд инфляцын үндсэн гол шалтгаан болж байгаа.

Ийм учраас энэ хэдэн бүтээгдэхүүнийг бид онилсон бодлого явуулж байна. Өрхийн орлого дунджаар 8 хувиар өсөж байгаа ч гэсэн инфляц нь түүнээс өндөр түвшинд байхаар иргэд ядуурч байна. Жишээлбэл, 2021 онд хоёрдугаар гурил 942 төгрөг байсан бол одоо 1500 төгрөг болсон. Нэгдүгээр гурил 1900 төгрөг байсан бол одоо 3400 төгрөг болсон гэх мэтчилэн. Зөвхөн гурил дээр

тариаланчидтай холбоотой татаасны бодлогууд байгаа боловч гурилын үнийн өсөлт инфляцын үнийн өсөлтийн нэг шалтгаан болж байгаа.

Б.Пүрэвдорж: Одоо Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Яг сарын өмнө 9 дүгээр сарын 26-ны өдөр би бас Ерөнхий сайдтай Ардчилсан намын бүлгээс мэтгэлцээнд орж бас л боловсролын салбарынхаа багш, ажилтны цалин хөлсний асуудлаар ярьж байсан. Ерөнхий сайд санаж байгаа бол би энэ хуулийн төслөө өргөн барьсан гээд өргөөд ярьж байсан. Сая Г.Занданшатар сайд энэ хуулийг бас дэмжих ёстой, явах ёстой гэж байна. Энэ дээр нь би талархал илэрхийлмээр байна.

Тэгээд та бид хоёрын мэтгэлцээнийг Монголын мянга мянган багш нар харж байгаа. Хүлээлттэй байгаа. Одоо сүүлийн 30 жил, өмнөх 9 жил танай нам, манай нам засагласан гэдгээсээ илүү цаашдаа бид яах вэ гэдгээ яримаар байна.

Ер нь бид хэдхэн хувиар аргацааж эмч, багш нарын цалинг нэмж явж ирсний үр дүнд өнөөдөр ахмадууд, эмч, багш нар жагссан, бодлогын алдааны золиос болоод сууж байгаа. Одоо хүүхдүүд золиосонд нь явж байна. Сургууль, цэцэрлэг байхгүй. Одоо эцэг, эхчүүд над руу дайрч байна. Та байнга багшийн цалин гэж нийгмийг турхирдаг. Хүүхэд сургуульгүй, цэцэрлэггүй байна. Танаас болж байна гэж над руу дайралтууд маш их ирж байна.

Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Засгийн газартайгаа нийлээд ханцуй дотроо наймаацаж тохироо хийж 5, 6 хувь нэмж ирсний харгайг ард иргэд үүрч байгаа гэдгийг би дахин давтан хэлмээр байна.

Одоо бид хоёрын хооронд 5, 10 хувь дээр наймаа тохироо хийхээ больё. Багш нарын нийгмийн асуудлыг эрх зүйн хүрээнд хамгаалъя. Хуулийн хамгаалалтуудыг би энд нэлээн сайн оруулж өгсөн. Та бас миний өргөн барьж байгаа хуультай танилцсан байх гэж би найдаж байна.

Тэгээд Боловсролын ерөнхий хуульд багш нарын ярьж байгаа, хэлж байгаа нийгмийн асуудлууд бүгдээрээ орсон байгаа.

Боловсролын салбарт дотоодын нийт бүтээгдэхүүний 7 хувь, төсвийн зардлын 20 хувь байхаар хуульд оруулсан байгаа.

Тэгээд тэтгэврийн насыг 50, 55 болгож, эрэлттэй тэргүүлэх мэргэжлээр сургана. Тасралтгүй 15 жил ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг гэсэн эдгээр заалтууд нь амьгүй байгаа юм. Үүнийг амилуулж өгөөч ээ.

Орон сууцад хамруулна л гэж байгаа. Яаж хамруулах нь ямар ч тодорхойгүй ийм нэг амьгүй үлбэгэр сулбагар баахан хууль хийсэн. Тэр нь өнөөдөр үнэхээр хэрэгжихгүй байна.

Энэ хуулийг амилуулахын тулд би ямар ч байсан 7, 8 жил гудамжинд тэмцэж багш нарынхаа дуу хоолой болж явсан хүний хувьд яг бодит хөрсөн дээр багш нарын саналуудыг энд шигтгэж оруулсан байгаа.

Энэ хуулийг Г.Занданшатар та сайн танилцаад, багш нарын нийгмийн асуудлыг даруйхан шийдэхгүй бол 5, 10 хувиар танай үйлдвэрчин, танай Засгийн газрын хийж байгаа ажил... /минут дуусав/

Г.Занданшатар: Дэлхийн аль ч улс оронд чинээлэг дундаж давхаргын гол төлөөлөл нь багш, эмч нар байдаг. Багш, эмч нараас нийгмийн хөгжил, соён гэгээрэл шалтгаалдаг.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр улсын хэмжээнд 2025 оны хоёрдугаар улирлын байдлаар улсын дундаж цалин 2 сая 728 мянган төгрөг байна.

Гэтэл шинээр төгсөөд ажилд орж байгаа багшийн цалин 1 сая 484 мянган төгрөг байгаа. Гар дээрээ сая гаруйхан төгрөг авч байгаа залуу багш яаж ажиллах вэ? Улсын хэмжээнд ажиллаж байгаа нийт багш нарын гуравны нэг нь суманд, гуравны нэг нь аймгийн төвд, гуравны нэг нь Улаанбаатар хотод ажиллаж байна. Тэгтэл нийт суралцагч 60 гаруй хувь нь Улаанбаатар хотод байна.

Улаанбаатар хотод багшийн ачаалал их байгаа бөгөөд залуу багш нарын ачаалал их, түүнтэйгээ дүйцсэн цалин бага байгаа учраас багш нарын бухимдал аргагүй байгаа юм. Энэ нэг өдөр бий болоогүй. Өнгөрсөн 3 жилд ерөөсөө цалинг нь таны хэлдгээр хуурмаг аргаар 5, 6 хувь нэмсэн төдий болоод нэг сая гаруйхан төгрөгийн цалинтай байгаа багш нарын тавьж байгаа шаардлага зүй ёсны гэж бид хүлээж авч байгаа. Багш нарын амьдралыг ядууралд түлхээд байна гэж байгаа гомдлыг бид хүлээж авч байгаа. Зөв зүйтэй зүйл юм.

Юуны түрүүнд бага цалин авч байгаа, цалингийн шатлалын доод түвшнээр цалин авч байгаа багш нарын цалинг түлхүү нэмэх бодлогыг баримтална. Жишээлбэл, 1-4 жил Улаанбаатар хотод ажиллаж байгаа багш нар нэмэгдэлгүй цалин авч байгаа. Сумд багш нар 40 хувийн нэмэгдэл авч байгаа. Энэ талаар зарчмын тохиролцоонд үйлдвэрчний эвлэлтэйгээ хүрсэн.

Мөн таны санаачлан боловсруулсан Боловсролын ерөнхий хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийн ерөнхий үзэл баримтлалтай танилцсан. Энэ дээр боловсролын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, төсвийн зардлын 20 хувь гэх мэтчилэн тодорхой хувиудыг төсвийнхөө хүрээ хязгаарыг харж үзээд хуваарилалтыг нь зарчмын хувьд дэмжиж байгаа.

Таны ярьж байгаа багшийн цалинг нэг мянган ам.долларт хүргэе. Түрүүн О.Цогтгэрэл даргын хэлээд байгаа “Brain drain” буюу багш, эмч нар гадагшлаад байгаа урсгалыг зогсоохын тулд багш, эмч нарынхаа цалинг нэг мянган долларт хүрэх бодлого бодитой хэрэгжинэ. Энэ хуультай уялдуулаад Үйлдвэрчний эвлэлүүдтэйгээ хамтраад бид энэ ажлыг хэрэгжүүлбэ.

Таны хуулийг анхааралтай судалсан. Багшийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийн тэтгэлгийг тусгасан байна. Багш ажилтнууд хүсвэл 50, 55 настай тэтгэвэрт гардаг болбол багш дутагдалтай үед жоохон эргэлзээтэй болно. Таныг энэ талаар бодож үзээсэй гэж хүсэж байна. Харин нэмэгдлийг нь олгодог зарчимд шилжье гэж бодож байна.

Орон сууцын дэмжлэг үзүүлэх асуудал орон сууцын хөтөлбөртэй болгоё гэж заасан. Хөдөө, орон нутагт тогтвортой ажилтны тэтгэмж олгох асуудал нэмэгдэл 40 хувьтайгаа уялдаж байгаа. Үүнийг хуультайгаа уялдуулаад шийдэж болох байх.

Багшаар суралцах оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт, амьжиргааны тэтгэмж зэрэг нийгмийн баталгааны асуудлыг сургалтын оноотойгоо холбох, сайн хүн багш болдог тогтолцоо... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Доржзодовын Энхтуяа асуулт асууж, үг хэлнэ.

Д.Энхтуяа: Сайн байна уу? Дэлхийн олон улсын жишгээр эмч, багш, тэтгэвэр авч байгаа иргэд тухайн нийгмийнхээ дундаж давхаргыг бүрдүүлдэг.

Өнөөдөр Монгол Улсад эмч, багш, тэтгэвэр авч байгаа иргэд цалингаараа, тэтгэврээрээ дундаж орлогыг бүрдүүлээд явах бүрэн боломжтой байсан. Одоо манай улсад энэ том давхаргыг бүтээж байгаа иргэд 700 мянга гаруй байна. Тэгэхээр Монгол Улсын хүн амын нэлээн том бүлэг гэж авч үзэж байгаа.

Энэ бүлгийн асуудал 9 дүгээр сарын 15-ны өдрөөс төсөв хэлэлцэж эхэлснээс хойш үүсээд байна. Тэгэхээр 9 дүгээр сарын 15-ны өдрөөс 2 сар төрийн хямрал болж, нэг хэрүүлийн байдалтай байснаас болоод 2026 оны төсөв дээр яг ямар шийдэл гарсан нь одоогоор тодорхой бус байна. Тэгэхээр төсөвтэй холбогдуулаад цаг үеийн асуудлаар асуулт асууя гэж бэлдсэн.

Өнөөдөр татвар төлөгчдийн цугларсан мөнгөнөөс 2026 оны төсөв дээр цалин, тэтгэврийг нэмнэ гэж ярьж байна. Нөгөө талаас салбар, салбараас 10 хувийг танана гэж байна.

Тэгэхээр ирэх жилийн хавар дахиад нөгөө бусад салбарынхан жагсахад бэлэн болно. Иймд төсвийн бүрдүүлэлт дээр анхаарах ёстой. Бид өнөөдөр бодлогоор төсвөө яаж баяжуулах вэ, яаж бүрдүүлэх вэ гэдэг дээр миний асуулт чиглэж байгаа юм.

Засгийн газар өчигдрөөс эхлээд “Оюу толгой” компанитай хэлэлцээрийн ширээнд суусан байна. 2009 онд би хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж байсан. Нэлээн том дуулиан шуугиантай “Оюу толгой”-н гэрээг үзэглэж байсан.

Засгийн газар “Оюу толгой” компанитай хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахдаа тухайн үеийн Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар татварыг тогтворжуулах ёстой байтал дэлхийд хаана ч байхгүй төлбөрийг тогтворжуулж гэрээ хийсэн.

Тэгэхээр энэ бол “Оюу толгой” компанийн талаас хийсэн... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минутаа нэмж авъя.

Д.Энхтуяа: Рояалти гэдэг бол АМНАТ. Дэлхий нийтэд байгаа энэ ойлголт эзний төлбөр. Тэгэхээр манайх АМНАТ-аа татвар гэж авч үзсэн. АМНАТ хэзээ ч татвар биш.

Тийм учраас шууд асуултаа асууя. “Оюу толгой” компанитай хэлэлцээрийн гэрээнд суусан энэ цаг үед өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн 47.5-д заасан хэмжээгээр буюу Оюу толгойн ордоос олборлож байгаа зэсийн баяжмал дахь эдийн засгийн үр ашигтай үндсэн болон дагалдах эрдсүүдийг бүрэн гүйцэд тодорхойлж өсөн нэмэгдэх АМНАТ-ыг тооцож авах талаар Ерөнхий сайд та яг энэ цаг үед буюу Засгийн газар “Оюу Толгой” компанитай гэрээ хэлцэл хийж байхад үүнийг шийдвэрлэж чадах уу? Та энэ дээр ямар шийдлийн гарц гаргалгаа олж авсан бэ?

Мэдээж хэрэг хоёр талын гэрээ бол шийдэж болдог, баяжуулж болдог, өөрчилж болдог. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болдог ийм л эрх зүйн үндэс шүү дээ.

Г.Занданшатар: Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээг Улсын Их Хурлаар хэлэлцэж батлаад, төслийн бүх хэрэгжилтийн хугацаанд татваруудыг тогтворжуулсан Улсын Их Хурлын гаргасан шийдвэр. Үүнийг Засгийн газар өөрчлөх боломжгүй. Улсын Их Хурлаар энэ хөрөнгө оруулалтын гэрээг баталсан.

Тухайн үед би хөрөнгө оруулалтын энэ гэрээг дэмжээгүй учраас санал хураалтад оролцоогүй, дэмжээгүй санал хураалт өгснийг та харж байж болно.

Тийм учраас миний байр суурь бол тодорхой. Эхнээсээ Оюу толгойн гэрээг үр ашигтай байх ёстой. Монголын ард түмэнд үр өгөөжтэй байх ёстой. Ийм зарчмаар гэрээнүүдийг дэмжиж оролцоогүй санал хураалт энд архивд байж байгаа.

Засгийн газрын байр суурь бол Оюу толгойн төслийн өгөөжийг Монголын талдаа Үндсэн хуулийн зарчимд нийцүүлж, дийлэнх өгөөж нь Монголын ард түмэнд ногдож байх зарчмыг баримталж яриа хэлэлцээг эхлүүлж байна.

Өнөөдөр “Оюу толгой” ХХК-тай зээлийн хүүгийн хэлэлцээр хийж байгаа. Зээлийн хүүгийн хэлэлцээрийг хийж болохоор тусгасан болохоос биш хөрөнгө оруулалтын гэрээг нэг тал дангаараа өөрчлөх эрх зүйн үндэсгүйгээр тухайн үед хуульчилсан байгаа.

- ▶ Зарчмын хувьд зээлийн хүүг бууруулахаар би тохиролцлоо. Үүний үр дүнд үр ашиг сайжирна.
- ▶ Зарчмын хувьд менежментийн төлбөрийг бууруулахаар тохиролцлоо.

Энэ хоёрыг өндөр байлгах замаар компанийн ашгийг бага гаргаад, ашиг бага болохоор зээлээ төлдөггүй. Монголын талд ногдох үр өгөөж бага гараад байдаг эрсдэлтэй. Миний үзэж байгаагаар зарим талаар зальтай ийм санхүүгийн асуудлуудыг зогсоох яриа хэлэлцээ одоо явж байна.

Энэ бүхний үр дүнд Монгол Улсын үр өгөөж 53 хувь болж нэмэгдүүлэх, цаашдаа бид эдийн засагт Оюу толгой төдийгүй, бүх төслүүд үр ашигтай байх, гадаад улстай байгуулж байгаа гэрээнүүд ил тод бөгөөд Монгол Улсын талдаа үр ашигтай байх зарчмыг тууштай баримталж, ард түмнээрээ хэлэлцүүлдэг, ард түмэндээ нээлттэй, ил тод хэлэлцдэг зарчмыг тунхаглан зарлаад байгаа.

Ер нь энэ асуудлууд ард иргэдээ өгөөжтэй, нээлттэй байж, зөвлөлдөж, хэлэлцэж байж л үр өгөөжтэй шийдэхгүй бол дандаа хөшигний ард шийдэгдэж байгаа шийдлүүд ард түмэндээ үр өгөөж муутай байна гэж шүүмжилж байгаатай санал нэг байна.

Ингэж бид баялгийнхаа эзэн байж, баялагтаа хийж байгаа янз бүрийн хулгай луйвруудыг таслан зогсоож байж ахмад настнуудынхаа тэтгэврийг багш, эмч нарынхаа цалинг нэмэгдүүлж, нийгмээ эрүүл, шударга, орлогын ялгаа хэт ихэссэн, баян хоосны ялгаа хэт гүнзгийрсэн нийгмийг өөрчлөх гэж, дундаж давхаргаа өргөжүүлэх гэж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж Үндэсний баялгийн сангийн үзэл санааг өөрсдөө санаачилж, Үндсэн хуулийн 6.2-т Норвегийн хуулиас эш татаж байгаад оруулж ирж хийж байсан юм.

Ийм ч учраас бидний зорилго бол зөвхөн баялгийн хулгайтай хийх гээд байгаа хоосон лоозон тэмцэл биш. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлж, Үндсэн хуулийн үзэл санаагаа хэрэгжүүлж, ард иргэдээ илүү үр өгөөжтэй... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Баясгалан: Танд өдрийн мэнд хүргэе.

Үндэсний статистикийн хорооны гаргасан мэдээнээс үзэхэд 2022 оны байдлаар насанд хүрсэн хүний дундаж хэрэглээ сард 657 мянган төгрөг гэж гарсан. 418 мянга 900 төгрөг бол ядуурлын шугам гэж тооцсон байгаа.

Өнөөдөр Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэд 397 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асран халамжилж байгаа асран халамжлагч 302 мянга 500 төгрөгийн тэтгэмж авч байгаа.

Эдгээр хүмүүс нийлээд 147 мянга орчим бөгөөд ядуурлын түвшнээс доогуур мөн амьжиргааны түвшнээс 180 мянган төгрөгөөр доор очиж байгаа. Бид хавчигдсан дундаж давхаргыг ярьж байгаа нь хамгийн зөв. Дээр нь нэмээд хаягдсан доод давхаргыг яах вэ? Энэ дээр ямар бодлого барьж байгаа вэ?

Хэрэв цалин, тэтгэмжийг 6 хувь нэмбэл ерөөсөө 17 мянган төгрөг нэмэгдэж байгаа. Өнөөдрийн 17 мянган төгрөг гэдэг бол 7 ширхэг талхны мөнгө хүрэхгүй байгаа. Тэгэхээр үүнийг 30 хувь нэмж өгөөч гэж би Танд 47 гишүүний гарын үсэг зурсан шаардлага хүргүүлсэн. Энэ шаардлагыг Улсын Их Хурлын дарга, Байнгын хороодын дарга нарт бүгдэд нь хүргүүлсэн байгаа.

Энэ асуудал ерөөсөө орж ирэхгүй байгаа болохоор Засгийн газар энэ асуудал дээр ямар бодлоготой байгаа вэ гэдгийг та тодорхой хэлж өгөөч.

Манай улс “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогынхоо 3 дугаар зүйлийн 1 дүгээр үе шатад 2021-2030 онд нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлнэ. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулна. Зорилтот эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн тусламж, дэмжлэгийг үзүүлдэг болно гэж заасан байгаа.

Тэгэхээр энэ дээр яг тодорхой хариулт авъя.

Г.Занданшатар: Монгол Улсын хэмжээнд ядуурал 27 хувьтай байгаа. Тэр дотроо хөдөө, орон нутагт 36 хувьтай. Зарим бүс нутагт өндөр байгаа.

Ядуурлын гол шалтгаан болох хавтгайрсан халамжаас татгалзаж байна гэдэг боловч үндсэн хэрэг дээр халамж яг хүртэх ёстой, шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нөгөө зорилтот бүлэгт халамжийг түлхүү боломжит түвшин хүртэл нэмэгдүүлэх бодлого оновчтой биш байна. Жишээлбэл, хоолны талоноос авхуулаад үр ашиггүй, багийн дарга нар хуваарилдаг, мянгат малчин авдаг зэрэг асуудал байна.

Энэ халамжийн бодлогод эрс шинэчлэл хийж, хавтгайрсан халамжийг оновчтой болгож зорилтот бүлэгт шилжүүлж, хөдөлмөр эрхлэлт болон зорилтот халамжийн бодлогод шилжих бодлогын эрс шинэтгэлийг хийж байж урт хугацаанд ядуурлыг тогтвортой бууруулж, хүний хөгжлийн үндэс суурийг дэмжих суурь болох юм билээ.

Монгол Улсад ядуурлын түвшин, тэгш бус байдал маш их байна.

Ийм учраас халамжийн сангийн зарцуулалтын өгөөжийг нэмэгдүүлж зорилтот хэсэгт хүргэхийн тулд Засгийн газраас хөдөлмөр эрхлэлт, чадавхжуулалтыг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг урамшуулсан бодлого хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхэлсний дараах боломжуудыг нэмэгдүүлэх, хүний хөгжил, салбар дундын уялдаа холбоог хангах зэрэг цогц бодлогуудыг хэрэгжүүлж байгаа.

Өнөөдөр улсын хэмжээнд 100 хүн тутмын 27 нь ядуу, хөдөө орон нутагт 36 хувь байгаа тул халамжийн бодлого, нийт тэтгэвэр, тэтгэмжийн бодлогоо оновчтой болгох ажлыг хэрэгжүүлж байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмж бол халамжийн бодлого биш.

Энэ хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир бид энэ төсөвт өөрчлөлт оруулж байгаа. Хувьчилж нэмэхээр бага тэтгэмжтэй улсууд, жишээлбэл нийгмийн даатгалын шимтгэл төлдөг байсан иргэд 380 мянган төгрөгөөсөө хувиар нэмэгдэхээр бага нэмэгдээд байгаа юм.

Б.Пүрэвдорж: Ж.Баясгалан гишүүнд 1 минут нэмж өгье.

Ж.Баясгалан: Та 302 мянган төгрөгөөр амьдарч чадах уу? Энэ хамгийн чухал асуулт. Яагаад гэвэл үнэхээр яг ингэж амиа зогоож байгаа 100 гаруй мянган иргэн, өрх байгаа учраас би энэ асуултыг асуугаад байгаа юм.

Энэ хүмүүсийн тэтгэмжийг 2 дахин нэмж өг, 3 сая болго гээгүй. Ядаж амьжиргааны доод түвшинд хүртэл нэмээд өгөөч гэдэг үүднээс 30 хувь нэмж өгөөч гэдэг хүсэлтийг тавьсан.

Өнөөдөр Монгол Улсад байгаа хүмүүс амьд явах эрхээ эдлэх хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хэт холыг харж биш өнөө маргаашийнхаа төлөө амьдарч байгаа хүмүүс. 10 жилийн дараа гарах үр ашиг биш, 10 өдрийн дараа гарах үр ашиг л тэд нарт хэрэгтэй. Тийм болохлоор тэтгэмжийн хэмжээг 30 хувь нэмэх бодлогыг дэмжиж байгаа юу гэдгээ хэлээд өгөөч. Энэ тэтгэмж маш бага байна.

Г.Занданшатар: Ж.Баясгалан гишүүнд хэлэхэд төсвийн бодлого хэлэлцэж байхад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төсвийг анх удаа нийт иргэдээр чөлөөтэй хэлэлцүүлсэн.

Төрийн ордонд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төсвийн хэлэлцүүлэг болоод Та бүхэнтэй би уулзсан. Тэр үед та ерөөсөө 30 хувь яриагүй. Энэ асуудлуудыг жил бүр 10 хувиар 3 жилд нэмээд явж байсан бол жигд нэмэгдэх байсан. Гэтэл одоо гэнэт бүгдээрээ 30 хувь нэмэгдэхээр инфляц, талхны үнэ, ам.долларын ханш 4 мянга давахаар нэмсэн биш иргэддээ илүү дарамт болохоор гэнэтийн өсөлтийг шахаад байгаа нь харин эрсдэлтэй болж байгаа юм.

Ийм учраас анх төсөв өргөн барьж байх үед зохион байгуулсан танай хэлэлцүүлэгт би хоёр удаа оролцож байхад энэ 30 хувиа илүү ярих ёстой байсан болов уу гэж бодож байна.

Тухайн үед бид бас Танд энэ асуудлыг хандаж хэлж байсан. Одоо 2024 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 107.9 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асууна.

О.Алтангэрэл: Манай Ерөнхий сайд баялгийн хулгайн талаар нэлээн ярьж байгаа. Ер нь энэ баялгийн хулгайтай тэмцэх, хууль бусаар хулгайлагдсан хөрөнгийг эргүүлж авчрах нь өнөөдөр гадаа жагсаж байгаа багш нар, эмч нарын цалинг дэмжих суурь нөхцөл болох байх.

Та 8 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын хуралдааны дараа хууль бус хөрөнгийг хураана гэсэн. Энэ одоо ямарваа нэг хууль, эрх зүйн орчин бүрдээгүй тохиолдолд яах юм бол гэж би анх гайхаж байсан. Анх томилогдож байхад нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах, нөхөн төлүүлэх тухай хуулийн талаар танаас асууж байсан. Монголд ийм хууль эрх зүйн орчин байгаа гэж хариулж байсан.

Харамсалтай нь өнөөдөр олон удаагийн Өршөөл үзүүлэх тухай хууль болоод, өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд өмнөх 30 жилийн хугацаанд олон төрлийн хулгай, баялгийн хулгай, төрд ойрхон байсан хүмүүсийн хийсэн хулгай, хууль бусаар хөрөнгөжсөн хүмүүсийн хөрөнгийг хураах орчин нөхцөл хязгаарлагдмал байгаа. Зөвхөн шүүхийн шийдвэр гарч явдаг, гэмт хэрэг яривал хөөн хэлэлцэх хугацаа явдаг, иргэний журмаар болон бусад арга хэрэгслээр хөрөнгө хураадаг механизм байхгүй байгаа.

Хамтарсан Засгийн газрын үед Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах тухай, Иргэний журмаар нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан. Өнөөдөр Улсын Их Хурал дээр байгаа. Өнгөрсөн долоо хоногт Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад Та бас хариулахдаа уг хуулийн төслийг Улсын Их Хурал дээр байгаа гээд хариулж байсан.

Тэгэхээр яг энэ хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр танай Засгийн газар ямар арга хэмжээ авах юм бэ?

Авлигын эсрэг багц хуульд ганцхан хууль бус хөрөнгө хураах тухай хууль багтахгүй шүү дээ. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй учраас энэ хүрээнд олон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл явж байгаа. Та энэ хуулийг дэмжих үү? Баялгийн хулгайтай тэмцэнэ гэж байгаа Таны хүсэл зориг, тэмцэл хууль эрх зүйн хувьд яаж биежих вэ?

Г.Занданшатар: О.Алтангэрэл гишүүний асуултад хариулъя.

8 дугаар сарын 17-ны өдөр би анх томилогдож байх үедээ хэлсэн зарчим бол Засгийн газар хууль тогтоох эрх мэдэл эдэлдэггүй. Таны өргөн барьсан хууль Засгийн газар дээр биш, Улсын Их Хурал дээр байгаа.

Нэгдүгээрт, Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрх мэдлийнхээ хүрээнд хууль хэлэлцэх, тогтоох явцад бид дарамт шахалт үзүүлэх, нөлөөлөх нь хуулиар хориотой. Бид байр сууриа илэрхийлээд Улсын Их Хуралд өргөн барьсан. Үүнийг хэлэлцэн батлах асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал гэж тухайн үед би хариулсан юм.

Хоёрдугаарт, 2025 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн албан даалгаврын хувийг би Танд өгч болно.

Тухайн үеийн Хууль зүй, дотоод хэргийн сайдад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, авлига, албан тушаалын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах талаар авах арга хэмжээний төсөл, төлөвлөгөө боловсруулж 7 дугаар сарын 23-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх даалгавар өгсөн.

2 дугаар заалтаар авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, үндэслэлгүй хөрөнгөжсөн, нийтийн өмчийг шамшигдуулсан, ашигласан нийтийн албан тушаалтнуудад хариуцлага тооцох, хууль бусаар олсон орлогыг хураах эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, саналыг 7 сарын 23-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг үүрэг болгосон.

Хууль бусаар олсон буюу яг энэ гэмт хэрэг үйлдээд тогтоогдсон хөрөнгүүдийг хураах ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосон. Одоо байгаа хууль, эрх зүйн орчны хүрээнд албан даалгаврын хэрэгжилтийг 7 дугаар сарын 03-ны өдөр гаргасан байгаа. Энэ хүрээнд жишээлбэл 328 нүүрсний хулгайтай холбоотой холбогдогч нарын хэрэг шийдвэрлэгдээгүй байж байна.

Б.Пүрэвдорж: Засгийн газрын гишүүн нэмж хариулах дэгтэй. 3 дугаар индрээс 1 минутад хариулна.

Б.Энхбаяр: Авлигачдын хөрөнгийг хураасаар ирсэн байдаг. Эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох асуудлыг О.Алтангэрэл сайд санаачлаад Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар огцордгийнхоо өмнөх өдөр Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцэхийг нь шийдсэн байгаа.

Үүнийг би улс төр болгож ярих асуудал биш гэж үзэж байгаа. Зарчмыг нь дэмжиж байгаа. О.Алтангэрэл сайдтай энэ хууль тогтоомжийг Улсын Их Хурал дээр Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлж батлуулахын төлөө байгаа.

Үндсэн хуулиас хальсан асуудлыг Улсын Их Хурал, хууль тогтоогч бид дэмжих ёсгүй гэж үзэж байгаа.

Монгол Улсын Дээд шүүх болон хууль хяналтын байгууллагууд зарим асуудлаар... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: О.Алтангэрэл гишүүн нэмж 1 минут тодруулъя.

О.Алтангэрэл: Хууль, эрх зүйн орчин ийм бүрхэг байгаа учраас эрэл хайгуулын үр дүнд л дэлхийн бусад орнуудын жишгийг хараад. Жишээлбэл, Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улсад яг ийм хууль байдаг.

Хууль бус хөрөнгөтэй тэмцсэн улс орнуудын жишгийг хараад боловсруулсан ийм л багц хуулийн төсөл байгаа юм. Тэгэхээр энэ багц хуулийн төслийг буцаад татаж авахгүйгээр Үндсэн хуулийн хүрээнд хэлэлцүүлэх юм байна гэж ойлголоо.

Бас нэг асуулт байна. Авлигын төсөөллийн индекс байгаа.

Монгол Улс 121 дүгээр байранд явж байгаад хамтарсан Засгийн газрын үед 114 дүгээр байранд орсон, 7 байр урагшилсан. Дэлхийн бусад улс орнууд Ковидын дараах нөхцөл байдалд авлигын нөхцөл байдал хүндэрч байхад 7 байр урагшилсан. Яг энэ урагшилсан жилийн 6 сард нь Б.Энхбаяр сайд, 6 сард нь миний бие ажиллаж байсан.

Тэгэхээр цаашид авлигын төсөөллийн индексийг бууруулна гэдэг бол зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх асуудал байдаггүй юм л даа. Энэ чиглэлээр ямар ажил хийж бодит үр дүн гаргах вэ гэсэн ийм асуулт байна.

Г.Занданшатар: Маш сайхан асуулт байна. Яг энэ чиглэлээр бид 7 сарын 03 болон 7 сарын 17-ны өдрийн захирамжуудаар Авлигатай тэмцэх цогц бодлого хэрэгжүүлэх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, улмаар үүний бодит үзүүлэлт нь авлигын индексийг бууруулах төсөл, хөтөлбөр гаргасан юм.

Авлигын индекс бууруулахад 3 цогц өөрчлөлт хэрэгтэй.

- ▶ **Нэгдүгээрт**, бодлогын өөрчлөлт. Улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, дээд шатын авлигатайгаа тэмцэж байгаагаа нотолж, Улсын Их Хурал, Засгийн газар нь хүсэл зоригоо илэрхийлж тэмцэж байх ёстой.

Энэ бол авлигын индексүүд буурах нэг дэх гол үзүүлэлтүүдийг иргэний нийгмийн байгууллагуудаас авсан судалгаагаар тодорхойлдог.

Бодлогын өөрчлөлтийн хүрээнд төрийн өмчийн ил тод байдал, хувьчлах, төрийн оролцоог багасгах, шилэн болгох цогц бодлогын өөрчлөлтийг тусгасан. Энэ бол бодлогын өөрчлөлтийн асуудал.

- ▶ **Хоёрдугаарт**, авлига, нүүрсний хулгайтай тэмцэх, шилэн болох цогц хүрээнд олон нийтэд ил тод болгох. Албан тушаалтны хяналтаас ард түмний хяналт илүү сайн учраас энэ бүх гэрээ, энэ бүх юмыг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индрийн 3 номерын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Авлигатай бүх түвшинд тэмцэх ёстой. Тэр дотроо хууль тогтоох байгууллага манлайлж үлгэрлэх ёстой.

С.Ганбаатар гишүүний санаачилсан хулгай хийчхээд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын ард нуугдаж, хуулийн хариуцлагаас бултах санаачилгыг дэмжихгүй байх ёстой. Эндээс эхлэх ёстой.

Дарга, цэрэг хамаагүй баригдах ёстой. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх ёстой. Бид Үндсэн хуульдаа тангараг өргөсөн.

Авлигачдын хөрөнгийг хураахад 2015 онд баталсан Эдийн засгийн ил тод байдлын хуулиар нийт 3 тэрбум ам.долларын хууль бус хөрөнгийг өршөөсөн хууль садаа болж байгаа. Тэр хуульд энэ өршөөгдсөн хөрөнгүүдийг эргэж эрүүгийн хэрэг үүсгэх, гүйцэтгэх ажил хийх... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: Монгол төгрөгийн ханшийн талаар асуух гэж байгаа. Бид хамгийн дээд тал нь 20 мянгатын дэвсгэр дээр монгол төгрөг хэрэглэдэг.

Сүүлийн жилүүдэд монгол төгрөгийн ханш ам.доллартой харьцахдаа ч унаж байна, нийгэмд ч бодит үнэ цэн нь унаж байна. Монголчууд өөрсдөө бид төгрөгтөө итгэхгүй, төгрөгт итгэх итгэл нь суларч байна гэж харж байгаа.

Дундаж давхарга орлогоо төгрөгөөр олдог. Тийм учраас төгрөгийн ханш тогтвортой байж, төгрөгийн ханш үнэгүйдэх нь багасаж байж дундаж давхаргын орлого баталгаатай болж, нийгмийн баталгаа нь хангагдана гэж харж байгаа. Жишээ хэлэхэд 2016 онд тэтгэвэр 208 мянган төгрөг байсан. Одоо 600 мянга болсон байгаа. 2016 онд ноолуур 100 мянга байсан. Одоо 130 мянга байгаа.

Тэтгэл бидний олж байгаа орлого өдий дайтайгаар ингэж өсөж байхад нөгөө талд нь бараа, бүтээгдэхүүний үнэ, бидний хэрэглээний зардал 3-5 дахин өссөн байна.

Тийм учраас энэ дээр бодлогын ямар арга хэмжээ авах вэ? Төгрөгийн ханшийг унагахгүй байх, харьцангуй тогтвортой байлгахад ямар арга хэрэгсэл, ямар бодлогын арга хэмжээ авах вэ гэсэн асуулт байна.

Г.Занданшатар: Мөнгөний ханшийн уналт бол зөвхөн дундаж давхаргын биш нийт ард иргэдэд нөлөөлж байгаа халаасыг нь хоосолж байгаа, үнэгүйдүүлж байгаа гол хүчин зүйл.

Төгрөгийн ханш уналт үндсэн 3 шалтгаантай.

Нэгдүгээрт, нийлүүлэлтийн шалтгаантай. Нийлүүлэлтийн шалтгаан бол Монгол Улс үйлдвэрлэгч улс биш, дотооддоо үйлдвэрлэдэг биш дандаа импортоор авдаг чөтгөрийн тойрогт орсон.

Ийм учраас экспортоосоо импорт нь их болохоор гадагшаа валютаа зараад байгаа учраас валютын ханш тогтмол өсөж байдаг. Валютын ханш тогтмол өсөхөөр цаанаас авч байгаа барааных нь үнэ өсөж байдаг.

Өөрөөр хэлбэл нийлүүлэлтийн буюу импортын... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үргэлжлүүлээд хариултыг дуусгачих.

Г.Занданшатар: Тийм учраас манай эдийн засгийн бүтэц өөрчлөгдөж, хүнсний үйлдвэрлэлээ дэмжээгүй бодлогын үр дүнд үндсэндээ

манайх импортоос хамааралтай болоод байгаа нь валютын ханш өсөхөөр бүтээгдэхүүний үнэ өсдөг, бүтээгдэхүүний үнэ өсөхөөр дагаад валютын ханш нь өсдөг, импортоос авдагтай холбоотой.

Нүүрс, алтаа зарж олсон валютаа гадагшаа хүнс, худалдаа, бүх зүйлдээ зарцуулаад дотооддоо үйлдвэрлэгч улс биш болсон нь төгрөгийн ханш унаж байгаа гол үндсэн шалтгаан болж байгаа юм.

Үүнээс болж инфляц тогтмол өсөж, 1992 оноос хойш монгол төгрөг 44 дахин үнэгүйдэж байгаа гол шалтгаан бол ерөөсөө дотоодын үйлдвэрлэл, бизнес, аж үйлдвэржилтээ дэмжээгүй, дампууруулаад, хувьчлаад, унагаад, устгаад, санаатайгаар ч юм шиг, гаднын ч юм шиг бодлогын үр дүнгүүдэд дотооддоо юмаа хийж чаддаг биш бүх юмаа импортоор авдаг болсноос импортоос, долларын ханшаас хамааралтай болсон. Энэ эдийн засаг нүүрс, алт, зэсээ экспортлоод... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Д.Жаргалсайхан гишүүн асуултаа асууна.

Д.Жаргалсайхан: Дундаж давхаргаа хэрхэн аврах вэ гэсэн сэдвийн хүрээнд өнөөдрийн мэтгэлцээн үргэлжилж байна.

Тэгээд дундаж давхарга гэдэг маань Монгол Улсын хувьд хүнд байдалд орсон. Хөгжиж байгаа улс орнуудад 50 хувиас дээш байж бололцооны гэж үздэг бол Монгол Улсын хувьд 25 хувьтай байгаа.

Тийм учраас дунд давхаргыг аврах, хамгаалах хүрээнд үндэсний үйлдвэрлэл, мөн дээрээс нь багш, ажилчид, төрийн албан хаагчдын амьжиргааг сайжруулах, өөрийнхөө хэрэглээ, дээр нь боловсрол, эрүүл мэнддээ олж байгаа орлогоороо бүрэн хангаж чаддаг байж дундаж давхаргад ордог бол өнөөдөр бидний хувьд хүнд байдалд орсон.

Гаднын компаниудыг шүтэх, гаднаас орж ирж байгаа бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр та ямар бодлого барьж байна вэ? Жишээ нь, Монгол Улсад өнөөдөр хэрэгжиж байгаа томоохон төслүүд дээр гаднынхан л ажилладаг болсон.

Монголчууд барилгаа барьж чадаж байна, замаа барьж чадаж байна. Гэтэл гаднын компаниуд ажиллаж байдаг болсон. Үүнийг яаж зогсоох вэ?

Ер нь бид үндэсний үйлдвэрлэлээ дэмжих нь нэг номерын асуудал. Үндэсний бүтээгдэхүүнийг худалдаж авах, үүнийг ард иргэддээ эх оронч худалдан авалт хийх үзэл санааг суулгах дээр та ямар ажил хийх вэ? Энэ тал дээр хариулаач.

Г.Занданшатар: Маш чухал асуулт асуулаа. Д.Жаргалсайхан гишүүнтэй санал нэг байна.

Үндсэндээ үндэсний үйлдвэрлэлээ дэмжихгүй, үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнээ худалдаж авдаггүй, импортыг шүтдэг энэ хэрэглээний байдал бол дундаж давхаргаа дэмжихгүй байх, бүрдэхгүй байх, цаашлаад үнэ ханш өндөр байх гол үндэслэл болж байгаа.

Ийм учраас бид Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн барихаар боловсруулж үндсэндээ бэлэн болсон байна. Энэ хуулийн үр дүнгээр эх оронч худалдан авалтыг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үнэ 10 хувь өндөр байсан ч дэмждэг, илүү чанартай бүтээгдэхүүнийг худалдан авдаг системд шилжүүлэх нь үндэсний үйлдвэрлэгчдээ, тэдний ажлын байрыг дэмжиж байгаа бодлого юм.

Монголд ажлын байр бий болгоод үйлдвэрлэл эрхэлж байгаа компаниудаа дэмждэг зээл, зээлийн хүү, худалдан авах ажиллагааны бодлоготой байж улс орон хөгжинө.

Одоо хөгжсөн Азийн бар улсууд Хятад, Япон, Солонгос зэрэг бүх улсуудын бодлого ийм байдаг. Импортын татвараа өндөр тавьж, дотоодын үйлдвэрлэгчдээ хамгаалдаг. Манайх өврөө дэлгэсэн юм шиг үндэсний үйлдвэрлэгчдээ дэмждэггүй бодлоготой. Жишээлбэл, ургамлын тос үйлдвэрлээд Японд чанартай тос гээд авч байхад манайх НӨАТ, гаалийн татварынхаа үнэ цэнээс болоод унагааж байдаг.

Ер нь дотооддоо үйлдвэрлэж байгаа бүх бүтээгдэхүүнийг унагаах гэж байгаа юм шиг татварын, зээлийн бодлого явж байгаа нь таны хэлж байгаа үндэсний үйлдвэрлэлийг унагааж байгаа нэг шалтгаан болж байгаа.

Энэ санаатай юм шиг бодлогыг бид өөрчлөхийн тулд 5 жилийн үндсэн чиглэлд эдийн засгийн бүтцийн реформ хийх цогц бодлогыг оруулж ирсэн. Энэ бол эрс шинэчлэлийн бодлогын нэг хэсэг нь. Дэлхийн бүх улс дотоод үйлдвэрлэлээ дэмжиж, дотооддоо мах, арьс шир, ноос ноолуур боловсруулдаг болж байж улс орон хөгжинө. Энэ зорилгоор бид эдийн засгийн чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулсан. Ирэх оноос хэрэгжүүлэхийг хүсэж байна. Улсын Их Хурал дэмжиж өгөхийг хүсье. Тэнд 350 гаруй бүтээгдэхүүн экспортолно.

Зөвхөн ноолуур гэхэд түүхийгээр нь 327.0 сая ам.доллаароор экспортолж байна. Үүнийг утас болгоод гаргахад тэрбум ам.доллар... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна. Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 15 минутаас хэтрэхгүй. Гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууна.

Отгоншарын Батнайрамдал гишүүнийг индэрт урьж байна.

О.Батнайрамдал: Өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайд.

Яг энэ цаг мөчид Оюу толгойн хэлэлцээр явж байгаа учраас хэлэлцээртэй холбоотой асуулт асуухгүй.

Улсын Их Хуралд Оюу толгойн асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулагдаад 4 сарын хугацаа өнгөрч байна. Энэ 4 сарын хугацаанд бид нотлох баримт цуглуулах хүрээнд нийт 60 мянга гаруй хуудас нотлох баримт цуглуулсан. Үүний дийлэнх нь хувь буюу 50-аас дээш хувь нь ямар нэгэн байдлаар

- ▶ байгууллагын нууц,
- ▶ төрийн нууц,
- ▶ албаны нууц,
- ▶ маш нууц гэсэн тамгатай байна.

Тэр дундаа Оюу толгойгоос ирүүлсэн 30 гаруй мянган хуудас дээр нэг бүрчлэн байгууллагын нууцад гэсэн тамгатай ирсэн байгаа. Тэгэхээр бид олон нийтэд нээлттэй сонсгол хийхэд тэр мэдээллийг ашиглах боломж нөхцөл байхгүй болоод байна.

Монгол Улсын Засгийн газраас гаргасан ажлын тайлангууд, албан тоот, бичиг баримтууд, тэр дундаа Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамнаас ирүүлсэн 10-20 гаруй мянган хуудас нотлох баримтын хүрээнд төрийн болон албаны нууц, мөн маш нууц гэсэн тамга бас дарсан байна.

Засгийн газар дээр байгаа Оюу толгойн асуудалтай холбоотой нотлох баримтыг бид Хянан шалгах түр хорооны сонсголоор ард түмэнд мэдэх эрхээр нь хангахад зөрчигдөх гээд байна.

Тэгэхээр танаас асуух асуулт бол Засгийн газраас бүрэн эрхийн хүрээнд энэ төрийн болон албаны нууцаар авсан бичиг баримтуудыг ил тод болгож нууцаас гаргах бүрэн эрх нь Танд байгаа.

Үе үеийн гаргасан, зарим хугацаа нь дууссан энэ олон бичиг баримтуудыг мөн Засгийн газраас гаргасан нууцад авсан бичгүүдийг Оюу толгой дээр ил болгох уу? Ил болгож байж буцаад бид ард түмний мэдэх эрхийг хангасан сонсгол зохион байгуулах нөхцөл боломж нь нээгдэх гээд байгаа юм.

Г.Занданшатар: Отгоншарын Батнайрамдал гишүүн таны хэлснээр одоо яриа хэлэлцээд явж байна.

Яриа хэлэлцээ амжилттай явж байгаа. Юуны өмнө Оюу толгойн төслийг Монголын ард түмэнд үр ашиггүй болгоод байсан өндөр зээлийн хүүг бууруулах тохиролцоонд хүрч чадлаа. Зарчмын хувьд бууруулах шийдэл гаргана. Хэдэн

хувиар яаж бууруулах вэ гэдэг талаар бид яриа хэлэлцэл хийгээд явж байна. Яриа хэлэлцээний тактик нарийн ширийн задалж болохгүй.

Хоёрдугаарт, үүнтэй холбоотойгоор Оюу толгойн зардлыг өндөрсгөж Монголын талд ногдох ашгийг бууруулдаг, ард түмэнд өгөх үр өгөөжийг бууруулдаг асуудал бол “менежментийн төлбөр” байгаа. Менежментийн төлбөрийг бууруулахаар зарчмын тохиролцоонд хүрээд бас ажиллаж байна. Бодит үр дүнгүүд гарч байна.

- ▶ Гэтэл энэ яриа хэлэлцээний тактикт нөлөөлж болохуйц бүх материалуудыг ил тод болгох гээд байгаа нь харин хэний эрх ашигт үүсээд байгаа юм бэ гэсэн асуултууд тавьж байгаа юм.
- ▶ Яагаад та дэд сайдаар ажиллаж байхдаа Оюу толгойн асуудлаар зоригтой дорвитой шийдвэр гаргаж ажиллаж байгаагүй юм.
- ▶ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газарт ажиллаж байхдаа зээлийн хүүг бууруулах шаардлага тавьж байсныг яагаад хэрэгжүүлээгүй юм.
- ▶ Яагаад Оюу толгойн менежментийн төлбөр, үр ашгийг сайжруулж байгаагүй юм.
- ▶ Тэр үед нууц байсан бүх материалуудтай танилцаад ил болгоод ажиллуулж байгаагүй юм.

Яг одоо арбитрын маргаан дөнгөж эхэлж байх үед, яг энэ яриа хэлэлцээ явж байх үед бүх мэдээллийг ил тод болгох асуудал Монголын эрх ашигт нийцэх юм уу.

Яриа хэлэлцээний дараа үүнийгээ хэлэлцэж болно. Харин яриа хэлэлцээнд тусалж Монголын талдаа үр ашигтайгаар шийдэхэд Та бүхэн туслах хэрэгтэй байна.

Үүн дээр хамтарч ажиллаач гээд бид тантай уулзахдаа хэлж байсан. Зээлийн хүүгийн учир шалтгаан, гадаад нөхцөл байдал, оролцоо, өмнөх яриа хэлэлцээнүүдийн талаар Танд тодорхой мэдээлэл өгч байсан. Энэ бол нийтийн эрх ашгийн төлөө хийгдэх асуудлууд байгаа.

Тэгээд нэмэлт хариултыг манай сайд өгнө.

Б.Пүрэвдорж: Б.Энхбаяр сайд 1 минутаар хариулах боломжтой.

Б.Энхбаяр: Оюу толгойтой холбоотой төрийн нууцын тамгатай асуудлууд нэмж тодорч байгаа.

Тэр дотроо манай яаман дээр миний нууцын асуудлаар шийдвэрлэсэн тоон дүнг Засгийн газрын түвшинд өөрчилж мөнгө угаасан байж болзошгүй асуудал бас гарч ирж байгаа.

О.Батнайрамдал гишүүнийг их сайн мэддэг, таньдаг хүмүүс энэ асуудлыг үйлдсэн байх боломжтой байгаа. Гарын үсэг нь байгаа.

Тэгээд энэ асуудлыг тагнуулын байгууллагаар нууцаас гаргуулахаар би материалыг нь бэлдэж дууссан байгаа. Нууцаас гаргуулсны дараа хууль хяналтын байгууллагад илээр шалгуулна.

Б.Пүрэвдорж: О.Батнайрамдал гишүүн тодруулъя. 1 минут.

О.Батнайрамдал: Тэгэхээр тухайлан нууцаас гаргамааргүй байна. Ерөнхий сайд аа. Тэр 20 сая ам.доллартой холбоотой асуудлыг бүгдийг нь нууцаас гаргах хэрэгтэй. Үүний ард Оюу толгойн 20 тэрбум ам.долларын асуудалтай баримтууд бас нууцаас гарах ёстой.

Та баялгийн хулгайтай тэмцэж байна гээд маш том ажлын хэсэг байгуулсан. Тэр дотор нүүрснээс гадна Оюу толгой багтаж байгаа юу? Түрүүчийн долоо хоногт Тагнуулын ерөнхий газар 4 хүний баривчилгаа хийсэн байна. Асуудалтай гэдгийг бүгдээрээ ард түмнээрээ ойлголоо.

Яагаад тэрийг нууцаас гаргаж болохгүй юм бэ? Хэрвээ нууцаас гаргахгүй бол сар хүрэхгүй хугацааны дараа явах гэж байгаа Оюу толгой дээрх сонсгол чөдөртэй, тушаатай, ард түмэнд мэдэх эрхийг хангаж чадахгүй, ноцтой зөрчсөн ийм л асуудал болох гээд байгаа юм.

Арбитртай холбоотой асуудлыг бид огт хөндөхгүй байгаа. Түр хорооны үйл ажиллагааны хүрээ хязгаарт байхгүй. Тэгэхээр түрүүчийн долоо хоногт Хянан шалгах түр хорооноос Танд олгосон захиа бол арбитртай холбоогүй, Хянан шалгах түр хорооны хүрээ хязгаарт багтсан Засгийн газарт авсан нууцтай материал... /минут дуусав/

Г.Занданшатар: Засгийн газар авлига хулгайтай холбоотой байж болзошгүй, нэн ялангуяа арилжааны шинж чанартай гэрээ, хэлэлцээр, контрактуудыг бүгдийг нь ил тод болгосон.

Гагцхүү хоёр улсын гэрээгээр болон олон улсын гэрээгээр нууцлах хуулийн шаардлагатай гэрээнүүд нууцад байгаа. Тухайлбал, та 4 хүнийг гэмт хэргийн тухай асуудал ярьж байна.

Гэмт хэрэг мөрдөн байцаалтын нууцад хамаардаг асуудлуудыг бид нууцаас ил гаргаж чадахгүй. Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл иргэдийн мөрдөн байцаалтын асуудал нууцад хамаардаг. Тэнд хэнтэй холбоотой нь хамаагүйгээр мөрдөн шалгах ажиллагаа тусдаа, биднээс хамааралгүйгээр явдаг. Засгийн газар, Ерөнхий сайд ч оролцох эрх байхгүй. Ил тод болгох ч эрх байхгүй. Мэдээ ч байхгүй. Мэдээлэл ч байхгүй.

Харин бид гагцхүү Монголын баялаг, түүн дотроо Тавантолгой, Оюу толгой дээрх асуудлыг хөндөж байна. Ийм учраас Оюу толгой дээр ажиллагаа явагдаж байна шүү дээ.

Ийм учраас татвар... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэбат: Өнөөдөр Ерөнхий сайдын асуулгын цаг дээр 3 асуулт асууя гэж бодсон.

- ▶ **Нэгдүгээрт нь,** бид дундаж давхарга буюу багш, эмч, нийгмийн дундаж бүлгийн хүмүүсийн цалин хөлсийг ирэх 3 жил, ер нь түүнээс цааш жил дунджаар ийм хэмжээнд хүргэнэ гэдэг тодорхой бодлогууд хэрэгтэй байна.

Тэгээд яах аргагүй ирэх жил “БОЛОВСРОЛЫН ЖИЛ” учраас цалин хөлсийг өндөр хувиар нэм гэдэг ачаалал таны Засгийн газрын хувьд ирж байгаа нь үнэн.

Тийм учраас ирэх 3 жил ер нь цалин хөлсийг нэмэх тал дээр ямар бодлого баримталъя гэж бодож байна вэ?

- ▶ **Хоёрдугаарт нь,** Хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудлыг хүмүүс тэр болгон анзаардаггүй. Хуулиараа нийт төсвийн 0.5 хувь нь байх ёстой.

Тэгэхээр ийм зүйлийг бид хаяснаас болоод алдагдалд ордог. Тухайлбал, би түрүү жилийн төсөв дээр урьдчилан сэргийлэх, хамгаалах зардал тавиач ээ гэж олон удаа хэлж байсан.

Тэгээд ёртой юм шиг III станцад осол гарахад 400,0 сая төгрөгийг хэмнэж байна гээд аюулгүй байдалд зарцуулахгүйгээсээ болоод 100,0 тэрбумын алдагдалд ордог.

Тийм учраас та хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал дээр онцгой анхаарахгүй бол олон хүний амь нас, осол аваартай холбоотойгоор хэт их улс төржүүлэх гээд байдаг. Энэ тал дээр Та хэрхэн анхаарах вэ? гэдэг асуулт байна.

- ▶ **Гуравдугаарт нь,** ахмадуудын тэтгэврийн асуудал гээд бас нэг асуудал байгаа.

Энэ тэтгэврийн нэмэлтийн асуудал яригдаж байгаа үед та өөрөө байр сууриа илэрхийлж байсан. Ахмадуудын тэтгэврийн зөрүү их байгаа үед тодорхой мөнгөн дүн, хувь гэдэг юм уу, хосолмол хэлбэрээр тавьж өгөөч ээ гэдэг асуултыг олон ахмадууд надад тавиад байгаа. Танд ч гэсэн хүрч байгаа байх.

Энэ тал дээр та ямар бодлого, шийдвэр гаргах байр суурьтай байгаа вэ гэдэг ийм гурван асуулт асууя.

Г.Занданшатар: Ирэх 3 жилд буюу 2027 он гэхэд

- ▶ багш нарын цалинг 3.5 сая төгрөгт хүргэх,
- ▶ багшийн хөгжлийн хөтөлбөр,
- ▶ орон сууцжуулалтын,
- ▶ нийгмийн хамгааллын цогц төлөвлөгөөг боловсруулахаар төлөвлөж байна.

Энэ утгаар боловсролын салбарын цогц реформ хийх, боловсролын салбарт инновац, цахим технологи, шинэ дэвшлийг ашиглах замаар боловсролын үйл ажиллагааны зардлыг бууруулах замаар багш нарынхаа цалин урамшууллыг нэмэх цогц төлөвлөгөө боловсруулах даалгавар өгөөд ажиллаж байна.

MEDLE.MN-ээс эхлээд цогц реформ хэрэгжиж байгаа. Энэ 12 цаг гээд хичээлийн 30 хувийг норматив цаг, цахим, онлайн хичээлийн цаг, улсын дэлхийн хэмжээний боловсрол эзэмшүүлдэг багш нар хичээл заалгах гээд цогц реформ хэрэгжинэ. Үүний үр дүнд багшийн ачааллыг ч бууруулна. Багшийн цалинг нэмэгдүүлэх цогц бодлого хэрэгжиж байгаа.

Ингээд ирэх 3 жилийн бодлого бол тодорхой. Үүнийг 5 жилийн үндсэн чиглэлд тусгасан байгаа.

Харин өнгөрсөн 3 жилийн хугацаанд тухайлбал, ноднин жил нүүрсний үнэ өндөр, 325.0 ам.доллар байхад та бүхэн яг ингэж адилхан тэмцээд багш нарын цалинг 10 хувиар нэмээд явж байсан бол өнөөдөр төсөв, эдийн засаг хүндэрсэн, улс төр, гадаад нөхцөл байдал, шатахуун тос бүх юм хүндэрсэн сорилт бэрхшээлийн дунд багш нарын цалинг 30 хувь нэм гэдэг асуудал үүсэхгүй байсан. Мөн гэнэт инфляцад нөлөөлөхөөр шаардлага тавихгүйгээр урьд өмнө Та хэд бас жаахан тэмцэж байхгүй яав гэж би зарим хүмүүс хэлээд байгааг уламжилмаар байна.

Тэгэхдээ бид багш нарынхаа хүндрэлтэй нөхцөл байдлыг, нэн ялангуяа шинэ залуу багш нар, Улаанбаатар хотын багш нарын нэг сая 484 мянган төгрөгийн цалинг инфляц, зардал өндөр болсон байгаа үед тодорхой түвшинд хүргэж нэмэгдүүлэх бодит шийдэлд хүрээд ажиллаж байгаа. Энэ дээр Та бүхэн хамтарч ажиллаж байгаад талархал илэрхийлье.

Ирэх 3 жилд эдийн засгийн өсөлтийг бид авлига хулгайтай тэмцэх, шинэ эдийн засаг бий болгох, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, засаглалын реформын 5 цогц реформыг хэрэгжүүлэх замаар бүтээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлт... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмэлт 1 минутын хариулт.

Г.Занданшатар: Өнөөдөр өргөн барьж байгаа 2026-2030 онд Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтын хүрээнд цалин хөлсний тогтолцооны шинэчлэл хийе гэж байгаа юм.

Гүйцэтгэл, бүтээмжид суурилсан цогц шинэчлэл хийе. Жишээлбэл, 47 мянган хүн боловсролын салбарт 954 мянган төгрөгийн цалинтай ажиллаж

байна. Яг үнэн хэрэг дээрээ 52 мянган багш ажиллаж байгаагийн суурь доод цалин залуу багш нар дээр 1-4 жил ажилласан нь нэг сая 484 мянган төгрөг байна.

Ийм учраас боловсролын салбарыг гүйцэтгэлээр санхүүжүүлэх, Эрүүл мэндийн салбарт Эрүүл мэндийн даатгалын сангийн шинэчлэл хийх, Шинжлэх ухааны байгууллагын алба хаагчдын цалинг цогцоор нь 3 жилийн хугацаанд нэмэгдүүлж, хамгийн багадаа нэг мянган ам.доллар буюу 3 сая 500 мянган төгрөгт хүргэх. Тэр хэмжээгээр бүтээмжийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлд суурилсан цалингийн тогтолцоонд шилжих цогц шинэчлэлийг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Болдын Уянга гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Уянга: Ерөнхий сайдад энэ өдрийн мэндийг хүргэе.

Сүүлийн хэдэн өдрүүдэд бид Монгол Улсын Үндсэн хуулийн хэрэгжилт яг хөрсөн дээрээ хэр сайн зөв хэрэгжиж, бууж байгаа юм бэ гэдэг талаар тал талаас нь сайхан ярилцлаа. Бас харлаа.

Тийм учраас танаас энэ асуултыг заавал асуух хэрэгтэй байгаа. Монгол хүний нэр төр бол Үндсэн хуулиараа хамгаалагдсан байгаа. Бид Үндсэн хуулийн зүйл, заалтыг харах юм бол 17 дугаар зүйлийг харж болно.

Үүнд Монгол Улсын иргэн шударга хүнлэг, ёсыг эрхэмлэн хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн ёсчлон биелүүлнэ гэж заасан.

Гэтэл хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаад бидний үр хүүхдийг, хань ижлийг, садан төрлийг, энэ танхимд сууж байгаа улс төрч болгоныг янз бүрийн нэрээр нэрлээд, хоч өгөөд зөвхөн шүүх тогтоох ёстой асуудлыг нэрлэн зааж нэр хүндэд нь маш бүдүүлгээр ханддаг байдал нэгэнт тогтжээ.

Тэгэхээр Монгол Улсын Ерөнхий сайдын хувиар, мөн улс төрчийн хувиар энэ шударга явдал уу гэдгийг хамгийн түрүүнд асуухыг хүслээ.

Хамгийн эхний асуулт маань Ерөнхий сайд аа энэ шударга явдал уу?

Хоёрдугаарт, Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.

Энэ төлөвлөгөөний 4.1.2.1-д хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт, хараат бус, бие даасан байдлыг хангах, тэдгээрийн редакцыг эздийн нөлөөллөөс гаргах, сэтгүүлчийн хэвлэн нийтлэх эрх чөлөө болон мэргэжлийн ёс зүйг баримтлан хариуцлагатай ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлнэ гээд Засгийн газар ажиллаж байх ёстой.

Энэ хүрээнд Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хоёрдугаар хөтөлбөрийг боловсруулж энэ онд оруулж ирэх ёстой байгаа. Энэ ажил хэр явцтай байгаа юм ?

Б.Пүрэвдорж: Б.Энхбаяр гишүүн хариулах юм байна.

Б.Энхбаяр: Баярлалаа. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг Хууль зүй, дотоод хэргийн яам Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтарч боловсруулаад, үүнийг Засгийн газраас санаачлах уу, Улсын Их Хурлын гишүүдээс санаачлах уу гэдэг хоёр хувилбараар ярилцаад Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг боловсронгуй болгох ажлын хэсгээс санаачилж байгаа.

Үүнийг Х.Баасанжаргал гишүүн манлайлаад Улсын Их Хуралд ойрын үед өргөн барих байх гэж бодож байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс өөрөө Засгийн газраас хараат бусаар, Улсын Их Хурлаас хараат бусаар байгуулагддаг байгууллага учраас энэ асуудлыг Засгийн газар дангаараа мэдээж хариулах хариулт биш.

Засгийн газрын бүх асуудал хүний эрхийн асуудал байдаг. Бүх оруулж байгаа хууль тогтоомжууд хүний эрхийг бас хөндөж байдаг.

Нэр төрд халдсан гэж ярих юм бол хүний нэр төрд хамгийн их халдаж байгаа хүмүүс бол улс төрийн нам, улс төрчид байдаг. Үүнийг би олонтоо хэлж байгаа. Хэвлэлийн салбарт захиалгаар улс төрийн өрсөлдөгчөө намнадаг зах зээлийн ханш 10 дахин нэмэгдсэн байна. Энэ ханш яагаад нэмэгдсэн бэ гэвэл нүүрсний хулгайчид асар их мөнгөтэй болсон байна. Зөвхөн би өөр дээрээ тулгарсан жишээг хэлж байгаа шүү. Над дээр нэг удаагийн сарын акц хийхэд тэрбум төгрөгийн зардал гаргаж санхүүжүүлсэн байгаа. Үүнийг Монгол Ардын намын... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Г.Занданшатар дарга 1 минут хариулъя.

Г.Занданшатар: 1 минутад товч хариулъя.

Тэгэхээр Үндсэн хуулийн зохицуулалт бол иргэд, монгол хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг баталгаажуулсан.

Гэсэн хэдий ч энэхүү эрхийг хэрэгжүүлэхдээ бусдын нэр хүнд, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болохгүй.

Тийм ч учраас О.Алтангэрэл сайд байхдаа шиг санаж байна. Хүн гүтгэхийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох хууль өргөн барьж байсан. Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа байх.

Гэхдээ энэ

- ▶ үг хэлэх эрх чөлөө,
- ▶ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ардчилсан нийгмийн гол үндэс.

Улс төрчид түмний хараанд байдаг учраас мэдээж дандаа шүүмжлэлд өртөж байдаг. Би есөн шидээр гүтгүүлж, доромжлуулж, зөндөө л хэлүүлж байсан боловч нэг ч удаа цагдаа, шүүхэд хандаж байсангүй.

Яагаад гэвэл хууль эрх зүйн орчин нь ийм учраас. Тэгэхдээ ил тод байдал, иргэн нь илүү мэдээлэлтэй байх нь эрүүл нийгмийн эх үндэс гэж үзнэ. Харин үнэхээр хүнийг гүтгэж доромжилж байгаа бол хууль шүүхийн байгууллагад хандаад шийдвэрлэх эрх нь одоо нээлттэй байгаа.

Б.Пүрэвдорж: Б.Уянга гишүүн 1 минут нэмж авъя.

Б.Уянга: Тэгэхээр шударга биш гэж үзэж байна гэж ойлголоо.

Тэгвэл миний дурдсан Засгийн газрын 2024-2028 он үйл ажиллагааны хөтөлбөрт дараах хуулиудыг 2025 онд Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барих ёстой байгаа.

- ▶ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- ▶ Хууль сахиулах ажиллагааны тухай;
- ▶ Таслан сэргийлэх ажиллагааны тухай;
- ▶ Шүүхийн шинжилгээний тухай. Энэ хуулиудыг яагаад 2025 онд өргөн барих ёстой вэ гэвэл хүний эрх, хүний нэр төрд бүдүүлгээр хандаж байгаа явдал газар авсан байна гэсэн байгаа юм. Энэ хариултыг Монгол Улсын Ерөнхий сайд өөрөө хариулаасай гэж хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултад хариулья.

Б.Энхбаяр: Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлах нь буруу юм байна гээд Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатараар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаад нэг жил болсон байгаа. Миний ойлголтоор энэ хуулийн төслүүдийг боловсруулж дууссан гэж ойлгосон.

Тэгэхээр Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан энэ ажлын хэсэг хийсэн юм байна.

Ер нь Улсын Их Хурлын даргаас ийм тавин хэдэн ажлын хэсэг байгуулдаг нь Засгийн газрыг ажиллах бололцоогүй болгоод байгаа шүү дээ. Хэвлэл мэдээллийн хуулийг Засгийн газар санаачил гээд ажиллаж байдаг. Энд мөн

Улсын Их Хурлын гишүүдээр нэг ажлын хэсэг ажиллуулдаг. Хэн нь өргөн барих юм. Бие бие рүүгээ жихдэг, эзэнгүйдүүлдэг ийм асуудал үүсгэсэн байгаа шүү.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо Улсын Их Хурал дахь цөөнхийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна. Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 30 минутаас хэтрэхгүй.

Одоо Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууна.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу? Эрхэм Ерөнхий сайдын энэ өдрийн амрыг айлтгая. Тэгээд өөрийнхөө асуултыг асууя.

Гурван асуулт бэлдсэн боловч бусад гишүүдтэй санал давхцаж байгаа учраас нэг асуултыг онцлон асууя гэж бодлоо. Энэ хуулийг иргэний нийгмийн байгууллагууд, иргэд нэлээн хүсэж, эрэлхийлж байгаа учраас тэдний хүслийг дэмжиж асуултаа асууж байна.

Тэгэхээр Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар нэмэлт мэдээлэл авах зорилготой асуулт юм.

Дэлхий дээр НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод нэгдсэн 140 гаруй улс байдаг. Та сайн мэдэж байгаа байх. Үүнээс 59 нь Шүгэл үлээгчийн тухай хуулийг хэрэгжүүлдэг.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцод 2005 онд нэгдэн ороод Улсын Их Хурлаар соёрхон баталсан. Тус конвенцын 33 дугаар зүйлд оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоогдсон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаарх зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн орчинд, тогтолцоонд нэвтрүүлэх, оруулах асуудлыг авч үзнэ гэж тунхагласан.

2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Засгийн газрын хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурал нэг жилийн дараа буюу 2022 оны 10 дугаар сард хэлэлцээд энэ бол чухал ач холбогдолтой хууль мөн гэж үзээд хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт шилжүүлсэн байдаг. Энэ үед Г.Занданшатар Ерөнхий сайд та даргалж байсан.

Тэгэхээр энэ хууль одоо хүртэл батлагдаагүй байна. Та энэ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг батлуулах чиглэлээр ямар ахиц гаргах амлалт өгч чадах вэ гэсэн тодорхой асуултыг асууя.

Г.Занданшатар: Баярлалаа. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг анх бид Авлигатай тэмцэх газарт санал болгож, тэндээс төслийн анхны

хувилбарыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулж, энэ чухал хуулиа гэж үзэж ажиллаж байсан.

Харамсалтай нь энэ хууль бүлгүүдийн түвшинд дэмжигдэж чадаагүй, хэлэлцэгдэж батлагдаагүй.

2025 онд энэ хуулийг бид дахин Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Ер нь Монгол Улсад авлига, хулгай, ашиг сонирхлын зерчлийг мэдээлсэн иргэдийг хамгаалах, дэмжих эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль тогтоомж одоогоор байхгүй байна.

Томоохон хэрэг явдлууд дээр, нүүрсний хулгай ч гэдэг юм уу жагсаал цуглаан болоод байдаг. Томоохон хэргүүд дээр шүгэл үлээх зориг гаргасан иргэдийг дарамт, өш хонзон, гэмт хэргийн хохирогч болох эрсдэлд оруулж байна гэж олон улсын байгууллагууд үзсэн байдаг.

Ийм учраас Шүгэл хүлээгчийн эрх зүйн байдлын анхдагч хуулийн төслийг боловсруулах үйл явц хэд хэдэн үе шаттай өрнөж байгаа. Энэ бол Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй хамт явж байгаа бөгөөд авлигын талаар мэдээлсэн этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлох, хамгаалах, урамшуулах, зохицуулах тогтолцоог бүрдүүлэх чиглэлтэй хамт явж байгаа.

Энэ төслийн гол агуулга бол аюулгүй байдлыг нь хамгаалах, эрсдэлд орохоос хамгаалах, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах эрх зүйн баталгааг бий болгоно. Хамгаалалт дэмжлэг үзүүлнэ. Төрийн болон хувийн хэвшлийн ААН, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд яллах, эрүүгийн хариуцлага татах, дарамтлахаас хариуцагчийг хамгаалах, мэдээлэгчийг хамгаалах, урамшууллын тогтолцооны асуудал байгаа. Их хэмжээний авлигын ч юм уу, мөнгө тарааж байгаа асуудлуудыг мэдээлээд, түүнд нь төлбөрийг нь тодорхой хувиар урамшуулдаг байх гэсэн зохицуулалтыг хийж байна.

Энэ хуулийг 2025 онд Улсын Их Хуралд өргөн барихаар Засгийн газрын 7 сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор үүрэг болгосон байгаа. Авлигатай тэмцэх багц хуулиудын хүрээнд. Энэ бол бодитой шинэчлэл болно. Иргэдийнхээ эрх, аюулгүй байдлыг хамгаална.

Одоо энэ Хууль зүй, дотоод хэргийн сайд... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмэлт 1 минутад хариулт өгье.

Г.Занданшатар: Одоо манай Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилогдсон Б.Энхбаяр гишүүн ч гэсэн шүгэл үлээгч.

Монгол Улсын Засгийн газар ч гэсэн өөрөө бас шүгэл үлээж байгаа. Ингэж байж бид нийтийн дунд бий болсон ард иргэдийнхээ хүсэл эрмэлзлийг илэрхийлж байж шүгэл үлээж байгаа Засгийн газар ч гэсэн шүгэл үлээгчээ хамгаалах болно. Гагцхүү энэ нь бодитой, хэн нэгний эрх, иргэний эрхийг гутаах,

доромжлоход чиглэгдсэн биш байх ёстой. Нийтийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн байх ёстой.

Ийм учраас эрх зүйн нарийн зохицуулалт, хамгаалалт шаардсан хуулийн төсөл байх ёстой гэж үзэж байгаа.

Б.Пүрэвдорж: 1 минут тодруулъя.

Б.Мөнхсоёл: Товчхон базаад хэлэхэд энэ хууль эрх зүйн орчин бүрдсэнээр хамгийн гол нь хүний эрхийн хуулийн хэрэгжилт биелэх нөхцөлийг бүрдүүлэхээс гадна ямар ч иргэн төрийн үйлчилгээг бидний хэлж заншсанаар арын хаалгагүйгээр тэгш хүртээмжтэй авах бололцоо нэмэгдэнэ.

Улмаар аль аль тал нь хариуцлагатай байснаар төрд итгэх итгэл хамгийн гол нь нэмэгдэх юм. Хамгийн макро түвшиндээ товчлоод хэлэхэд Монгол Улсын хөгжлийг л дагуулна. Нийгмийн эрүүл уур амьсгалыг бий болгоно. Бие биеэ хардах байдлыг бууруулна.

Түрүүний Б.Уянга гишүүний хэлсэнчлэн онлайнаар бие биеэ “bullying”-дэж элдэв нэр төрд нь халдах гэх мэт бүх асуудлуудад дорвитой нэмэр болохуйц хууль учраас энэ асуудлыг шийдэхэд гар бие оролцон энэ санаачилгыг хэрэгжүүлэх байх гэж найдаж байна. Итгэж байна. Хариулсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ.

Миний урилгаар Ховд аймгийн Цэцэг сумын эрх чөлөөний төлөө цогтой тэмцэгч Ард Аюушийн нэрэмжит 12 дугаар сургуулийн сурагчид ирсэн байна.

Тэгээд Та бүхэндээ сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж, ирэх жилийнхээ элсэлтийн ерөнхий шалгалтад сумаа төлөөлж Ховд аймагт хамгийн өндөр оноо авч тэргүүлээрэй гэж хүсэн ерөөе.

Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Уянгахишиг: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр миний хувьд нэг асуулт тавьсан байгаа. Хоёр хуваагаад асууя Б.Пүрэвдорж дарга аа.

Нэгдүгээрт, одоо бид нүүрсний хулгай гээд яриад байгаа. Өмнө нь чуулган дээр ч гэсэн би дурдаад өнгөрсөн. Энэ бүх нүүрсний хулгайтай холбоотой асуудал цэвэр “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компанийг тойрч байгаа асуудал.

Өөрөөр хэлбэл, “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компани дээр санхүүгийн удирдлага, хяналт муу. Нөгөө талаас тухайн компанийн ашигт ажиллагааг үл хамааран бусад ямар ч төслүүд рүү нүүрсээр төлбөр хийх, бартер хийх энэ боломжуудыг бий болгодог. Оффтек гэрээнүүд байгуулдаг. Энэ шийдвэрүүд нь

Улсын Их Хурлаар дамждаггүй, Засгийн газраас томилогдсон төлөөлөн удирдах зөвлөл, мөн тэндээс томилогдсон улс төрийн томилгоогоор очсон гүйцэтгэх удирдлагын түвшинд хийгддэгтэй шууд холбоотой гэж харагдаж байгаа.

Жишээлбэл “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2025 оны бизнес төлөвлөгөө дээр хийгдсэн свот шинжилгээний сул талд:

- улс төрийн шийдвэрээр нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний өр тавьж, байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн дарамт учруулсан, хүний нөөцийн шууд томилгоо их байдаг.
- Олборлолтыг 100 хувийн гэрээт операторуудаар хийлгэж байгаа буюу өөрсдөө оператораа хийх боломж байдаггүй.
- Нүүрс олборлолтыг нэмэгдүүлэх, борлуулалтыг өсгөх боломжтой ч Хятад талын хилийн нэвтрүүлэх хүчин чадлаас хамааран энэ нь өөрөө хязгаарлагддаг.

Үүнтэй холбоотойгоор миний асуулт бол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол байгаа. Энэ тогтоолоор Эрдэнэс Тавантолгойг байгуулсан байдаг. Тухайн үед “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны 50 хувийг Монгол Улсын иргэн, ААН-д дараах хуваарийн дагуу шилжүүлнэ. Ингэхдээ 10 хувийг нь нийт иргэнд үнэ төлбөргүйгээр хувьцааг нь шилжүүлнэ. 10 хувийг нь аж ахуйн нэгжүүдэд үнэ төлбөргүй шилжүүлнэ. 30 хүртэл хувийг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж өгье.

Г.Уянгахишиг: Гуравдугаарт, 30 хүртэл хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж хөрөнгө босгох гэсэн гурван шийдвэрийг гаргасан байдаг.

Гэтэл эхний хоёр нь биелсэн боловч 15 жилийн дараа буюу одоо 3 дахь заалт огт хэрэгжээгүй.

Тэгэхээр огт хэрэгжээгүй шалтгаан нь “нээлттэй компани” болоход гадаад, дотоодын аль ч хөрөнгийн бирж дээр гарсан төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой компанийн хувьд засаглалын болоод бүх шаардлагуудыг нь хангаж чаддаггүй.

Тэгэхээр энэ тал дээр:

- Засгийн газар ямар бодлого авч хэрэгжүүлэх вэ?
- Энэ сул талуудыг байхгүй болгох бодлогыг яаж хэрэгжүүлэх вэ буюу хэрхэн нээлттэй компани болгох вэ?
- Хэрхэн гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг оруулж ирэх вэ?
- Хувьчлалыг хэрхэн зөв явуулна гэж харж байна вэ?

Г.Занданшатар: Засгийн газраас авлига, хээл хахуультай тэмцэх, нүүрсний хулгайтай тэмцэхийн тулд цогц бодлого хэрэгжүүлж байгаа. Бодлогын орчинд нээлттэй, ил тод байдлыг бий болгож, компаниудыг хувьчлах, олон нийтийн хяналтад оруулах, олон нийтийн компани буюу “PUBLIC COMPANY” болгох зорилт тавьж ажиллаж байгаа.

Энэ хүрээнд нүүрсний хулгайтай холбоотойгоор төрийн өмчийн компаниудын үйл ажиллагааны ил тод бус байдал, менежмент, хариуцлагагүй байдлаас үүдэлтэй “governance problem” бий болсон юм билээ.

Ийм учраас “Эрдэнэс Тавантолгой” дээр бид эхний ээлжид нээлттэй хувьцаат компани болгох цогц төлөвлөгөөг боловсруулж байна.

Цагаан сараар энэ төлөвлөгөөг зарлаж боловсруулж, хэрэгжүүлэх даалгавар өгсөн. Үүний тулд Та бүхнийг төсөвтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолыг баталж өгөхийг хүсэж байна.

Энэ тогтоолын дагуу бид нээлттэй хувьцаат компани болгохын тулд олон улсын эрх бүхий компаниар аудит хийлгэсэн байх ёстой болж байгаа. Тэгээд олон улсын стандартад нийцүүлэх ёстой. ISO стандартаар “public” буюу олон нийтийн хувьцаат компанийн бүх шаардлагад нийцсэн засаглалын шинэ стандартыг бүрэн нэвтрүүлж дуусах ёстой.

Энэ тохиолдолд “Эрдэнэс Тавантолгой” олон нийтийн хувьцаат компани болох нөхцөл боломж бүрдэнэ. Үүний тулд дотоодын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа бүртгүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн орчинтой нийцүүлсэн үе шаттай төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Мөн Улсын Их Хурлаар өөрчлөлт оруулах, батлуулах асуудал гарч байна.

Саяын дурдаж байгаа тогтоол бол “Эрдэнэс Тавантолгой”-той холбоотой гарсан 10, 20 тогтоолын зөвхөн нэг нь.

Хамгийн сүүлд 2024, 2025 онд хувь хэмжээ, хувьцааг нь дахиад өөрчлөөд тогтоол баталсан. Тэгэхдээ л нээлттэй компани биш. Үнэн хэрэг дээрээ 1072 хувьцааны асуудалд бодитой оролцдоггүй. Ард иргэд хяналт тавьж чаддаггүй тийм л хиймэл хувьцаа болоод байна.

Жинхэнэ “PUBLIC COMPANY” үнэхээр 1072 хувьцааг нь эзэмшиж байгаа бол

- ▶ Монгол Улсын 3 сая 500 мянган иргэний хяналтад орох ёстой
- ▶ Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй болох ёстой.
- ▶ Үйл ажиллагаа нь шилэн болох ёстой.
- ▶ Ард иргэдийн хяналт, төлөөлөн удирдах зөвлөлд нь орж ирэх ёстой.

Ингэж байж төлөөлөн удирдах зөвлөл ард түмний компани гэсэн “public” буюу олон нийтэд нээлттэй байх ёстой. Ийм цогц... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут сунгая.

Г.Занданшатар: Тийм учраас цогц шинэчлэлийг хийж байна.

Үүн дотор олон асуудал байна. Жишээлбэл, шинээр төрсөн болон харьяат болсон иргэдэд хувьцаа эзэмшүүлэх эсэх асуудал. Хувьцаа эзэмших асуудлын хувьд тэр өдрөөр тасалбар болгоод түүнээс хойш төрсөн иргэд хувьцаа эзэмшихгүй байгаа.

Бас нэг хэсэг иргэд нь ахмад настны болон сургалтын төлбөр төлсөн гээд хувьцаанаас хассан. Ийм зөрүүтэй асуудлууд үүсээд, иргэдийн өмчлөлтэй холбоотой суурь асуудлуудыг Улсын Их Хурлын түвшинд шийдвэрлэхгүй бол Засгийн газрын түвшинд шийдвэрлэх боломжгүй. Үүний үр дагавраар хоёр дахь зах зээлд хувьцааг нь гаргах боломж хязгаарлагдаад байгаа.

Энэ компанийн засаглалыг ч гэсэн олон улсын түвшинд засаглах боловсрол, чадвартай төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагыг энэ зорилгоор бүрдүүлэхийн тулд Засгийн газраас бүрэн эрхт төлөөлөгчдийн зөвлөл томилж байгаад одоо энэ ажлыг хийх чадвартай менежментийн баг шалгаруулах сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Улс төрчид томилдог биш нээлттэй сонгон шалгаруулалтаар энэ үүргийг хэрэгжүүлж чадах удирдлагын баг “CEO” [Chief Executive Officer-Гүйцэтгэх захирал] -г томилох ажлыг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Би танаас багш нарын цалинтай холбоотой асуулт асуух гэж байна.

Яг одоо багш нарын цалинг хэдээр нэмэх юм, ямар боломжтой. Тэр тухай биш. Ер нь иймэрхүү асуудлыг яаж шийдэж байх вэ гэдэг зарчмын байр суурь, бодлогын шийдлийг яаж хийх талаар асуух гэж байна.

Манай үе үеийн Засгийн газар нам харгалзахгүйгээр дандаа алдаа хийж ирсэн нь бодлого гээд бүх хүслийнхээ жагсаалтыг баталчхаад асуудлаа эрэмбэлэхгүйгээр төсвөө тухайн үеийнхээ байдлаас хараад төлөвлөдөг.

Эцсийн дүнд яг эрэмбийн дээгүүр гэгдэж байгаа ажлууд хоцорсон байдаг. Энэ бол яг багш, эмчийн цалинтай холбоотой асуудал байна. Үүний цаана жагсахгүй байгаа ч гэсэн дараагийн ээлжид цалин нэмүүлэхийг хүлээж байгаа олонлогууд байгаа.

Тэгээд жагссан нь нэмүүлдэг, эсвэл тухайн үедээ чанга дуугарсан нь нэмүүлдэг. Энэ бол бодлого биш тухайн үеийнхээ асуудалд чирэгдэж байгаа гал унтрааж байгаа явдал болоод байна.

Тийм болохоор цаашид үүнийг жагссан үед нь биш, дуулиан болгож биш, нэлээн урт хугацаагаар зөвхөн ирэх жилийн асуудал биш, ирэх 3-5 жилийн хугацаанд асуудлаа эрэмбэлж байгаад, үнэхээр чухал гэж үзэж байгаа бол багшийн ч юм уу, эмчийн ч юм уу, төрийн албан хаагчийн ч юм уу, хэнийх нь ч байна цалинг нэмэх бодлогыг тууштайгаар баталчхаад түүнийхээ дагуу гишүүд болон иргэд, багш, эмч нар нь эсвэл цалин авах гэж байгаа иргэд нь хяналтаа тавиад явдаг бодлогыг Та яаж хийх вэ? Үүнийг хийнэ гээд хэлэхэд амархан боловч үнэндээ Монголын улс төрд, бидний шийдвэр гаргаж байгаа түвшинд жишиг болоогүй асуудал байгаа.

Тэгээд энэ асуудалд Засгийн газрын зүгээс дорвитойхон урт, дунд хугацааны, тоон дүнтэй бодлогын шийдвэр гаргах юм бол Улсын Их Хурлын зүгээс ч гэсэн хянаад явах боломж байна. Энэ дээр та ямар өөрчлөлт хийх гэж байна вэ?

Г.Занданшатар: Бид Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиа уншиж сайн ойлгомоор юм билээ.

Нэн ялангуяа төсөв, эдийн засгийн чиглэлээр ажиллаж байгаа гишүүн Та үүнийг барьдаг, хэрэгжүүлдэг байхгүй бол нэг ийм бодлогын зөрүү гараад Улсын Их Хурал дээр ч гэсэн хэлэлцүүлгийн дараалал алдагдаад байна.

Бид Үндсэн хуульд хөгжлийн бодлого тогтвортой байна гэж 2019 онд өөрчлөлт оруулаад, үүний дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийг баталсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар 5 жилийн үндсэн чиглэлээ батална.

Одоо манай Засгийн газар 2026-2030 онд хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл орж байна. Энд үр дүнд чиглэсэн цалингийн бодлого, шинэчлэлээ цогцоор нь оруулаад явж байгаа.

Энэ дээр үндэслээд Улсын Их Хурал жилийн төлөвлөгөө баталж, эрэмбээ тогтоодог байхгүй юу.

Таны яриад байгаа хөрөнгө оруулалт, урсгал зардал, багш, эмч нарын цалинг Улсын Их Хурлаар тогтоож байгаа.

Гэтэл 4, 5 сард баталсан байгаа жилийн төлөвлөгөөнд энэ асуудлууд тусаагүй. Харин гишүүд баахан хөрөнгө оруулалтууд нэмээд, тойргийн шинж чанартай зардал оруулж ирээд байхаар энэ эрэмбээ алдаад байгаа юм.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиа хаана, хаанаа зөв хэрэгжүүлбэл жилийн төлөвлөгөөнд туссан багш, эмч нарын цалингаа нэмэгдүүлье. Энэ төлөвлөгөөнд тусгаж явах ёстой. Тэгтэл харамсалтай нь

→ Засгийн газар 3 жилийн 3 талт хамтарсан хэлэлцээр үйлдвэрчний эвлэлтэй байгуулчхаад,

- 30 хувиар нэмнэ гэж тохирчхоод
- сүүлийн 3 жилийн хугацаанд төлөвлөгөөндөө ч оруулаагүй,
- 5 жилийн төлөвлөгөөндөө ч оруулаагүй,
- төсөвтөө ч оруулаагүй

явж ирсэн. Мэдээж жил болгон нэмэгдүүлж байсан нь Боловсролын хуулиар тусдаа хэрэгжүүлсэн. Боловсролын салбарт бол хуваарь бий. Ийм учраас жилийн төлөвлөгөө дээр үүнийгээ тусгаад, жилийн төлөвлөгөөний дагуу төсөв өргөн барьж эрэмбэлж орж ирж байгаа.

Тэгэхээр ерөөсөө бүх зүйлийг нь хашсан шүү дээ. Жилийн төлөвлөгөөгөөр урсгал зардал 24 хувь байна. Багш, эмч нарын цалинг нэмж болохгүй гэсэн агуулгатай 24 хувьд барьсан байхгүй юу. Яагаад... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Б.Найдалаа гишүүн 1 минут тодруулъя.

Б.Найдалаа: Тантай санал нэг байна. Гол нь яг үүнийг л асуугаад байгаа юм.

Асуудлаа эрэмбэлээгүй байж байгаад засаг нь өөрөө төсвөө өргөн барьж, бодлогоо дэвшүүлж байгаа газар нь тэрийгээ хаячхаад, эргээд сүүлд нь жагсахаар асуудалтай тулдаг байдал нь ерөөсөө болохгүй болоод байгаа юм.

Тийм болохоор Улсын Их Хурал гэхээс илүү Засгийн газрын зүгээс төлөвлөгөөгөө гаргахдаа, төсвөө боловсруулахдаа дуулиан болгохгүйгээр нэмээд байвал үнийн өсөлт, инфляц нь ч илүү зөв байгаа юм.

Тэгэхээр нэгэнт боосон, зангидсан төсөв дээр түр хугацааны гал унтраах арга хэмжээг оруулж байгаа. Тэрийг та сайн мэдэж байгаа. Тэгэхээр дараагийн удаа Засгийн газар таны саяын хэлснээр тодорхой дүнтэйгээр төлөвлөгөөндөө оруулж байгаад дуулиан болохгүйгээр батлаад, түүнийгээ хянаад явбал үр дүнтэй байна.

Зөвхөн эмч, багш нарынх биш, цаашдаа бусад салбарын алба хаагчдын цалингийн асуудал байгаа.

Г.Занданшатар: Ер нь төсвийн цаглавруудаа зөв болгохгүй бол төсвийг 9 сарын 01-нд өргөн барьдаг болсон.

Тэгтэл бидний хийж байгаа ажлын гүйцэтгэл 9 сарын эцсийн дүнгээр биет хэмжээгээрээ түүхэндээ байхгүй өндөр рекордын хэмжээ нүүрс экспортлоо. Манай улсын зээлжих зэрэглэл “Standard & Poor’s”, “BB” болгож 13 жилийн түүхэнд анх дээд хэмжээндээ хүрлээ.

Мөн “Fitch” агентлагийн үнэлгээгээр зээлжих зэрэглэл өслөө. Ингээд үр дүнгүүд гараад, төсвийн орлого нэмэгдээд цалин нэмэх боломж жоохон ч гэсэн бий болж байна.

Гэтэл 9 дүгээр сарын 01-ний өдөр өргөн барихад буюу бид дөнгөж 3 сар ажиллаж байхад нөхцөл байдал өөр байсан. Төлөвлөлт нэг талаасаа зөв боловч манайх шиг уул уурхайгаас хамааралтай, гадаад зах зээлээс хамааралтай цөөхөн хэдхэн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнээс хамааралтай. Экспортын бүтээгдэхүүн үндсэндээ нүүрс, зэс хоёрын үнээс хамааралтай тул эдийн засагт энэ хоёрын үнэ өөрчлөгдөхөд л бүх төсвүүд савлаад байна.

Бүх орлого унаад л, бүх эдийн засаг өөрчлөгдөөд л төсвийн төлөвлөлтийг ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурлын асуулгын цаг дууслаа.

Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Ерөнхий сайдад талархал илэрхийлье.

--oOo--

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ

3.1.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-ИЙН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 87 гишүүн хүрэлцэн ирж, 69 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 14 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Тусгайлан бэлтгэсэн индрээс Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Батбаярын Жаргалан, Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар нар цуварсан асуулт, хариултаар мэтгэлцэв.

Мөн тусгайлан бэлтгэсэн индрээс Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө бичгээр ирүүлсэн гишүүд болох Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Д.Батбаяр, Ж.Баярмаа, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Ө.Шижир, С.Эрдэнэболд, Улсын Их Хурал дахь олонхын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, С.Зулпхар, Г.Лувсанжамц, О.Саранчулуун, Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Б.Мөнхсоёл, Л.Энхнасан нарын тавьсан асуултад тусгайлан бэлтгэсэн индрээс Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 16 цагт хэлэлцэж дуусав.

3.2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ 2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДРИЙН “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-Т УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН ЕРӨНХИЙ САЙДААС АСУУСАН АСУУЛТУУД

№	Улсын Их Хурлын гишүүн	Асуулт
УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ		
1	Б.Жаргалан	Амьжиргааны өртөг: Сүүлийн жилүүдэд амьжиргааны өртөг тогтмол өсөж, өрхийн бодит орлого үнийн өсөлтийг гүйцэхгүй байна. Айл өрхийн санхүүгийн дарамтыг бууруулахын тулд Засгийн газрын түвшинд ямар бодит арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа вэ?
2	Ц.Баатархүү	Амьжиргааны өртөг: Амьжиргааны өртөгт нийцсэн цалингийн өсөлтийг бий болгох оновчтой стратеги юу вэ?
3	Д.Батбаяр	Амьжиргааны өртөг: 1.Монгол Улсад дундаж орлоготой өрхийн амьжиргааны өртгийн талаар; 2.Дундаж орлоготой иргэн хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулалт хийх, хадгаламжтай болох, үнэт цаас, хувьцаа худалдаж авах боломж, хугацаа;
4	Ж.Баярмаа	2021 оноос хойш инфляцын хурд иргэдийн цалин, орлогын өсөлтөөс илт давсан байгаа. Үүний үндсэн шалтгаан бол төсвийн тэлэлт, төрийн хэт их оролцоо, татварын дарамт юм. Таны өргөн мэдүүлэхээр бэлтгэж байгаа татварын багц хуулийн төсөл иргэдийн амьжиргаанд дэмжлэг болж чадахааргүй байна. Таны Засгийн газарт иргэдийн амьжиргааг бодитоор дэмжих бодлого байна уу?
5	Дав.Цогтбаатар	Инфляцыг бодитой бууруулахын тулд Засгийн газар ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ?
6	С.Цэнгүүн	1.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.3-т тусгагдсан "Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлах"-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхтэй холбоотой хүрэх зорилго, шийдэх алхмууд, цаг хугацааны дараалал, шаардагдах хөрөнгө, санхүүг тодорхойлсон эсэх; 2.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.3.9-т тусгагдсан төрийн өмчит компаниудад хийж буй менежментийн шинэчлэлийн ажлын явцын талаар; 3.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2.4-т тусгагдсан төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлж буй ажлын үр дүн, хэрэгжилт, эрчим хүчний салбар харагдаж буй эсэх;

		<p>4.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.3.1-д тусгагдсан эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэн, цаашид тогтмол индексжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, салбарын эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хэрэгжилт, үр дүн;</p> <p>5.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.3.20-т тусгагдсан Эрчим хүчний тогтворжилтыг хангах, сэргээгдэх эрчим хүчийг зөв, зохистой хөгжүүлэх үндсэн баримт бичиг болох нэгдсэн сүлжээний дүрэм, менежментийн тогтолцоог бий болгох ажлын хэрэгжилт.</p>
7	Ө.Шижир	<p>1.Амьжиргааны өртгийг тооцох аргачлалын бодит үнэн зөв байдал.</p> <p>Монгол Улсад 1998 онд "Хүн амын амьжиргааны доод түвшнийг тодорхойлох тухай" хуулийг баталсан ба уг хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт "Хүн амын амьжиргааны доод түвшнийг тодорхойлохдоо олон улсын байгууллагуудад нийтлэг мөрдөж буй аргачлалыг өөрийн орны онцлог нөхцөлтэй уялдуулан хэрэглэнэ" гэж заасны дагуу Үндэсний статистикийн хорооноос жил бүр шинэчлэн тогтоодог.</p> <p>Дээрх үзүүлэлтийг тооцож гаргахдаа бүсчилсэн байдлаар тооцож гаргадаг ба Үндэсний статистикийн хорооны даргын баталснаар 2025 онд Улаанбаатар хотод 495,400 /дөрвөн зуун ерэн таван мянга дөрвөн зуу/ төгрөг, орон нутагт дунджаар 482,900 /дөрвөн зуун наян хоёр мянга есөн зуу/ төгрөгөөс 490.000 /дөрвөн зуун ерэн мянга/ төгрөг байхаар тогтоожээ.</p> <p>Гэвч амьжиргааны доод түвшинтэйг гадна амьжиргааны өртөг гэх эдийн засгийн чухал ач холбогдолтой дата, тоон үзүүлэлтийг орхигдуулсаар ирсэн. Олон улсад мөрдөгддөг жишгийн дагуу инфляц, орон сууцны үнэ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт зэрэгтэй уялдуулан гаргадаг уг үзүүлэлтийн талаар тодорхой мэдээлэл ховор, ямар чиг үүргийн байгууллага хариуцаж гаргадаг нь тодорхойгүй байна.</p> <p>Түүнчлэн амьжиргааны өртгийн үзүүлэлтийг Засгийн газрын зүгээс олон улсын стандарт болох <i>Cost of Living Index, Household Consumption Basket</i> загварт нийцүүлэн хийж чаддаг уу? Үгүй бол нийцүүлж хийх талаар Хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан ямар төрлийн бодит арга хэмжээ авч байгаа вэ?</p> <p>2.Дундаж өрхийн амьжиргааны бодит дарамтыг бууруулах бодит механизм бий юу?</p> <p>Дундаж өрхийн амьжиргааны гол зардалд байрны үнэ, түрээс, арилжааны банкны хүү, өргөн хэрэглээний үнийн өсөлт зэрэг гол нөлөөллийг үзүүлдэг.</p> <p>Дундаж давхаргыг хамгаалах бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилтүүдийг өнгөрсөн хугацаанд Засгийн газрын зүгээс үнэлж, дүгнэлт хийсэн үү?</p>

	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Засгийн газар Монгол Улсын хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх үндсэн чиглэлийн баримт бичиг дуусгавар болохоос хоёр сарын өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ" гэж заасны дагуу Засгийн газраас 11 дүгээр сарын 09-ний өдөр "Монгол Улсыг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг танилцуулж Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан.</p> <p>Дээрх таван жилийн төлөвлөгөөнд дундаж давхаргыг 20 хувиар нэмэгдүүлэх тодорхой амлалтыг тусгаж үүний хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан нь зөвхөн цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээ байна.</p> <p>Гэвч бусад хөгжингүй орнуудын жишиг, олон улсын стандартыг харвал орлогыг нэмэгдүүлэхээс гадна дээр дурдсан амьжиргааны гол зардлыг тогтвортой байлгах, бууруулах хэрэгслийг тогтмол ашигладаг бол манай улсад энэ төрлийн бодит хэмжигдэхүйц арга хэмжээ, хөтөлбөр, бодлогын шийдлүүдийг (хүү бууруулах механизм, түрээсийн зах зээлийн зохицуулалт, өрхийн хэрэглээний татварын бууралт) хангалтгүй хэрэгжүүлж байгаа ба энэ талаар Засгийн газраас төлөвлөж буй бодит арга хэмжээ байгаа эсэх?</p> <p>3.Цалин-амьжиргааны өртгийн зөрүүг багасгах бодлого</p> <p>Дээрх асуултад дурдсанчлан "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 17 арга хэмжээг авахаар тусгасан байгаа боловч эдгээр нь бодит хүрэх үр дүнг үнэлсэн тоон үзүүлэлтээр хэмжигдэхгүй байна.</p> <p>Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаанд үндэслэн тооцоолоход манай улсад сүүлийн 5 жилд амьжиргааны өртөг 2-3 дахин өссөн байхад дундаж цалин 30-40% орчим өссөн байна.</p> <p>Дундаж давхаргыг дэмжих, ядуурлыг бууруулах бодит арга хэмжээ хэрэгжүүлж үр дүнг тодорхой үнэлэх аргачлалыг боловсруулан хариуцлагажуулах, цалин болон амьжиргааны өртгийн зөрүүг багасгахын тулд бүтээмжтэй уялдаатай цалингийн бодлого /productivity-linked wage model/, шат дараалсан татварын хөнгөлөлтийн бодлого /progressive tax relief/, жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дэмжих /MSME competitiveness support/ зэрэг системчилсэн бодлогын шийдлүүдийг хэрэгжүүлэх нь бодит өсөлт, үр дүнг үзүүлдэг нь бусад улс орны туршлагаар нотлогдсон.</p> <p>Цалин, амьжиргааны өртгийн зөрүүг багасгах чиглэлд Засгийн газрын зүгээс аливаа улс төрийн популист нэг удаагийн бус шийдэл, бүтцийн реформ бүхий ямар бодлого хэрэгжүүлэх вэ?</p>
--	--

8	С.Эрдэнэболд	<p>Хүн амын амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж буй гол хүчин зүйлийн нэг нь үнийн өсөлт билээ. Энэ талаар бодитой ямар арга хэмжээ авч байна вэ? Хавтгайрсан халамжаар иргэдийн амьжиргааг шийдэж чадах уу?</p> <p>Хүн амын нэн эмзэг хэсгийн амьжиргааны талаар ямар бодлого баримталж байна вэ?</p>
УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ МАН-ЫН БҮЛЭГ		
9	М.Ганхүлэг	<p>1.Хууль тогтоомжийн биелэлтийн талаар:</p> <ul style="list-style-type: none"> - Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт; - Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "Засгийн газарт чиглэл чиглэл өгөх тухай" 10 дугаар тогтоолын хэрэгжилт; - Монгол Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн "Засгийн газарт чиглэл чиглэл өгөх тухай" 73 дугаар тогтоолын хэрэгжилт. <p>2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар:</p> <p>Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хороог татан буулгасан. Өнгөрсөн хугацаанд хийсэн ажлын үр дүн, цаашдын бодлого.</p> <p>3.Тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлтийн талаар:</p> <p>Боловсролын салбарыг дэмжих жилийн хүрээнд Боловсролын зээлийн санг Боловсролын хөгжлийн сан болгох тухай.</p> <p>4.Улс орны эдийн засаг, нийгмийн асуудлаар:</p> <p>Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилт (Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийг зүүн бүсийн "Түүхэн аялал жуулчлалын бүс" нутаг).</p>
10	С.Зулпхар	<p>1.Хууль тогтоомжийн биелэлтийн талаар:</p> <p>Монгол Улсын газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан газрыг эзэмших хүсэлтийг засаг захиргааны нэгж болон зориулалтаа сонгож нэг удаа гаргах бөгөөд тухайн иргэний хүсэлт шийдвэрлэгдэх хүртэл өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд хадгалагдана. /Энэ хэсгийг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./, 29.9. дэх хэсэгт "Иргэний үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлтийг өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн дарааллын дагуу шийдвэрлэнэ." /Энэ хэсгийг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 2.3.Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэдэд энэ журмын 2.1-д заасан</p>

		<p>нэгж зориулалтаар эзэмшүүлэхээр тусгасан талбаруудаас эрэмбэлэгдсэн жагсаалтын дагуу иргэнд хуваарилна.” гэж тус тус заасан тул хөгжлийн бэрхшээлтэй иргэн, амьжиргааны түвшин доогуур өрхийн гишүүд, хотоос шилжин суурьшсан болон цахим соёлд бүрэн суралцаагүй иргэд цахим хүсэлт гаргаж чадахгүй байгаагаас шалтгаалж иргэдэд шинээр газар олгох үйл ажиллагаанд хүндрэл, чирэгдэл учрах боллоо.</p> <p>Тухайлбал, Баян-Өлгий аймгийн 1500 гаруй иргэн цахимаар хүсэлт гаргасан байдалтай байгаа бөгөөд нэгдсэн буюу төвлөрсөн системээр шийдвэрлэх дарааллын улмаас иргэд төрийн байгууллагын шийдвэрийг удаан хугацаанд хүлээж, хүндрэл, чирэгдэл учирч, төрийн үйлчилгээтэй уялдсан гомдол, санал байнга гарч байна. Өөрөөр хэлбэл, төрийн үйлчилгээг иргэдэд ойр, шуурхай шийдвэрлэж ирсэн урьд өмнөх нөхцөл байдал дордсон байдалтай байна.</p> <p>Иймд иргэдэд шинээр газар олгох асуудлыг сумын Засаг даргын бүрэн эрхээр шийдвэрлэж ирсэн өмнөх зохицуулалт, зохион байгуулалтыг цахим үйлчилгээний шилжилттэй уялдуулж дахин сэргээх боломж байгаа эсэхэд хариулт, тайлбар өгнө үү.</p>
11	Г.Лувсанжамц	<p>1.Хууль тогтоомжийн биелэлтийн талаар:</p> <p>2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан “Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 57 дугаар тогтоолын хэрэгжилт болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай.</p> <p>2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар:</p> <p>Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн үр дүнгийн тайлан.</p>
12	О.Саранчулуун	<p>1.Хууль тогтоомжийн биелэлтийн талаар:</p> <p>Ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх талаар хууль тогтоомжийн хэрэгжилт, биелэлтийн талаар дараах асуултыг тавьж байна. Үүнд:</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно.</p> <p>Боловсролын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх;</p>

	<p>Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2.хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх;</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно.</p> <p>Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2.ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх; гэж тус тус заасан.</p> <p>Эдгээр хууль тогтоомжийн хүрээнд ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хангах зүйл, хэсгийн хэрэгжилт ямар байгаа вэ?</p> <p>2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар:</p> <p>4.1.Хүний эрх, эрх чөлөө “4.1.1.4.Бүх нийтэд хүний эрх, Жендерийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, цахим орчин дахь ялгаварлал, хүчирхийллээс хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ.” гэсэн заалтын хүрээнд ялгаварлал, хүчирхийллээс хамгаалах тогтолцоог хэрхэн бүрдүүлж, хариу арга хэмжээ авч байгаа вэ?</p> <p>2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого</p> <p><u>Хөгжлийн бэрхшээлтэй хүн</u></p> <p>“2.1.1.23.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах эрх зүйн орчныг сайжруулна.” гэсэн заалтын хүрээнд ямар төлөвлөгөө боловсруулсан бэ?</p> <p>“2.1.1.25.Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлж, салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.” гэснийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажил төлөвлөж зохион байгуулсан уу?</p> <p>“2.1.1.26.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт байгуулна.” гэж заасан ажлын хүрээнд хэдэн төв байгуулсан, цаашид хэдийг байгуулахаар төлөвлөж байна вэ?</p>
--	---

		<p>2.1.4.Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг</p> <p>2.1.3.8.Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.</p>
ХҮН НАМЫН ЗӨВЛӨЛ		
13	П.Ганзориг	<p>Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Улсын Их Хурлаар батлахаар хэлэлцэж байна. Манай улсын гадаад худалдаа, уул уурхайн экспортын гол түнш болох БНХАУ нь Коммунист намын их хурлаар 15 дугаар таван жилийн хөгжлийн чиглэлээ өнгөрсөн 10 дугаар сард баталсан. Үүнтэй холбоотойгоор дараах асуултуудыг асууя.</p> <p>1.БНХАУ нүүрсний хэрэглээг бууруулах бодлого хэрэгжүүлж байгаа нь манай улсын нүүрсний экспортын эрэлтэд дунд хугацаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Үндсэн чиглэлийг боловсруулахдаа уг эрсдэлийг суурь болон хувилбарын тооцооллоор тусгасан уу?</p> <p>2.Ийм өөрчлөлттэй орчинд Монгол Улс экспортын бүтцээ төрөлжүүлэх, уул уурхайн хэт хамаарлыг бууруулах, түүхий бүтээгдэхүүнийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортлох талаар ямар тоон зорилт, хэмжих үзүүлэлт тавьсан бэ?</p> <p>3.БНХАУ импортын бараанд татвар–стандартын мөшгөх систем нэвтрүүлж, гарал үүсэл, чанарын баталгаажуулалт, нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдлыг шаардаж эхэлсэн. Манай Үндсэн чиглэлд энэ өөрчлөлттэй уялдуулан ямар бодлогын өөрчлөлт хийх вэ?</p> <p>4.БНХАУ-ын XV таван жилийн төлөвлөгөөнд ногоон эрчим хүч, дижитал эдийн засаг, өндөр технологи, логистикийн салбаруудтай уялдуулан Монгол Улс шинэ экспортын чиглэлүүд болох ногоон эрчим хүчийг экспортлох зэрэг шинэ төрлийн бүтээгдэхүүний экспортын сегментүүдийг хэрхэн үүсгэх вэ?</p> <p>Монгол Улсын Үндэсний баялгийн сангийн хөрөнгө 2025 онд 1.6 тэрбум, 2026 онд 2.6 тэрбум ам.долларт хүрэхээр тооцоолсон. Одоогоор уг хөрөнгийг гадаадын төв банкнууд дахь дансанд 4.4 хувийн дундаж өгөөжтэй байршуулж, Монголбанкны гадаад валютын албан нөөц (ГВАН)-д тооцож байна.</p> <p>Энэ байдал нь бодит баялгийн сангийн хөрөнгө оруулалтын жинхэнэ зорилго, урт хугацааны хөрөнгө оруулалтын зарчимд нийцэхээс илүү ГВАН-ыг нэмэгдүүлэх зорилготой богино хугацааны санхүүгийн арга хэрэгсэл мэт байна.</p> <p>Нөгөө талдаа Монгол Улс алдагдалтай төсөв баталж, үүнээс бараг 2 дахин өндөр хүүтэй гадаад зээл, бондын санхүүжилт авч байна.</p>

		Ийнхүү өндөр хүүтэй өр авч, түүнээс доогуур өгөөжтэйгөөр хуримтлал үүсгэж байгаа нь бодлогын хувьд зөв шийдэл мөн үү? Үүн дээр цаашид ямар бодлого авч хэрэгжүүлэх вэ?
14	Б.Мөнхсоёл	<p>Сонгуулийн тогтолцоо, улс төрийн намын төлөвшилтэй холбоотой асуудал хөндмөөр байна. Манай улс Улсын Их Хурлын 2024 оны сонгуульд сонгуулийн пропорциональ тогтолцооны элементийг нэвтрүүлснээр төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх, нийгмийн олон талт төлөөллийг парламентад оруулж ирэхэд ахиц, дэвшил гарсан. Гэхдээ улс төрийн нам эрх ашгийн нэгдэл болсон, төрийн алба намын алба мэт болсон зэрэг эрс шүүмжлэлийг ард иргэд байнга хэлж байна.</p> <p>Сонгуулийн тогтолцоог улам төгөлдөржүүлэх, улс төрийн намын төлөвшлийг бэхжүүлэх чиглэлээр бодит үр дүн гаргах ямар арга хэмжээнүүдийг танай Засгийн газар авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?</p>
15	Л.Энхнасан	<p>Монгол Улс залуучуудын орон гэж тодорхойлж, сурталчилдаг атлаа залуучуудын дэмжих бодлого дутмаг байна. Залуучуудыг ажлын байр, орон сууц зэрэг нийгмийн баталгааг хангах асуудал хэтэрхий салангид шийдэгдэж байна.</p> <p>Өрийн дарамт, сэтгэц, сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудлууд бүр орхигдож байна.</p> <p>Засгийн газар эдгээрийг нэг цогц бодлого болгон уялдуулах бодит төлөвлөгөө байгаа юу?</p>

-оОо-

3.3. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ 2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДРИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-ИЙН ТЭМДЭГЛЭЛ



Н.Учрал: Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 28-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэллээ. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын асуулгын цаг эхэлж байна.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдаас урьдчилан хүргүүлсэн асуултын дагуу асуулт асууж, хариулт авах Улсын Их Хурлын асуулгын цаг эхэллээ.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан, Монгол Улсын Ерөнхий сайд

Гомбожавын Занданшатар нарыг тусгайлан бэлтгэсэн индэрт урьж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан Монгол Улсын Ерөнхий сайдад урьдчилан хүргүүлсэн асуултыг тавина. Бүлгийн цуварсан асуултын тоог 9-өөс хэтрүүлэхгүй асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй байна. Асуулт асуух зөвшөөрөл өгч мэтгэлцүүлэх дэгийн хуулийг баримтална. Асуулгын цагийг эхлүүлье.

Батбаярын Жаргалан гишүүн мэтгэлцээнээ эхлүүлье.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу? Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал асуулгын цагтай болсноос хойш 3 дахь удаагийн мэтгэлцээн эхэлж байна. Энэ удаа гишүүдэд Ерөнхий сайдаас асуух маш их зүйл байгаа. Учир нь намрын чуулган нээлтээ хийснээс хойш эрх баригч Монгол Ардын намынхан нам дотроо зодолдсон болохоос биш, улс орны өмнө тулгамдсан асуудалд төдийлөн анхаарал хандуулсангүй. Энэ намар багш нар ажил хаялаа, эмч нар ажил хаялаа, хүүхдүүд цоожтой хаалганы цаана үлдлээ, бензин тасарлаа. Харин одоо утааны улирал эхэлсэн, томуу өвчин дэгдсэн. Хүүхдүүд эмнэлгийн коридорт хэвтэцгээж байна. Улаанбаатарын утаа байдгаараа л байна. Хятадаас 1 тонн нүүрсийг нэг сая орчим төгрөгөөр авч байгаа. Тэглээ гээд утаа буурахгүй л байна. Харин Монгол Ардын намын дарга нар нам доторх өрсөлдөөнд ялахын тулд бүхнээ зориуллаа. Улмаар Засгийн газрын бодлогын үндсэн хэрэгсэл болох улсын нэгдсэн төсвийг хүртэл улс төрийн наймааны хэрэгсэл болгов. Эцэст нь Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар та Улсын Их Хурлын 71 гишүүний саналаар огцорсон атлаа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр суудалдаа үлдсэн

анхны Ерөнхий сайд гэгдэх өвөрмөц амжилтын эзэн боллоо. Мөн Монгол Ардын намын даргаар сонгогдсон Ням-Осорын Учрал та 5 намын төлөөлөл бүхий Улсын Их Хурлын индэр дээр гараад суучихлаа. Одоо та нөхөд минь сандал суудлаа хуваарилж дууссан бол үндсэн ажилдаа орцгооно уу гэж хичээнгүйлэн хүсье.

Тэгвэл улс орон ямар нөхцөл байдалд байна вэ? Улсын Их Хурлын чуулганы танхимд яригдаж буй улсын төсвийн хөрөнгө оруулалт, элдэв мега төслийн өртөг их наядаар хэмжигддэг болсон. Хамгийн багадаа л хэдэн тэрбум төгрөг гэж ярьдаг. Улаанбаатар хотын захирагч 1км авто замыг 70 тэрбум төгрөгөөр барина гэж ярьж байна. Сүүлдээ эрх баригчид их наядаар хулгайлаад байна гэж бодохоор эдийн засаг үнэхээр сайн байгаа ч юм шиг.

Гэвч бодит байдал ямар байна вэ? Иргэдийн амьдрал ямар байна вэ? Тэгээд жаахан амьдралтай зүйл ярьж гэж бодож байна. Өнөөдөр дэлгүүрт “атар” талх 2600 төгрөгөөр зарагдаж байгаа. Тэгвэл ердөө 4-хөн жилийн өмнө “атар” талхны үнэ 1300 төгрөг байжээ. 4 жилийн дотор талхны үнэ 2 дахин нэмэгдсэн байна. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ ийнхүү нэмэгдэж байгаа. Иргэдийн орлогын өсөлт, үнийн өсөлтийг гүйцэхээ байлаа. Тэгвэл Засгийн газраас богино хугацаанд айл өрхийн өдөр тутмын зардал, амьжиргааны өртөг санхүүгийн дарамтыг бууруулахын тулд ямар бодит арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар тодорхой шийдэл нэрлэнэ үү? гэж Ерөнхий сайд танаас эхний асуултаа асуух байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Б.Жаргалан гишүүний зөв өө. Засгийн газар хүнд нөхцөлд ажилласан. Одоо гадаад зах зээл дээр манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ бараг 2 дахин унаж, төсвийн орлого тасарч, дотооддоо улс төрийн тэмцэлтэй, парламент, улс төржилт, шатахуун, нефть зэрэг биднээс шалтгаалахгүй олон сорилтуудыг Засгийн газар давж амжилттай ажиллаж байгаа. Ийм учраас Засгийн газар гадаад зах зээл, төсөвт учирч байгаа хүндрэлийг даван туулахын тулд байгуулагдсан өдрөө ажилдаа шамдан орж ард түмнийхээ нуруун дээр ачаа, дарамтыг үүрүүлэхгүйн тулд төсвийн тодотголыг хийсэн. Энэ бодитой ажил. Монгол Улсын түүхэнд анх удаа улсын төсвийн зардлыг 2.2 их наядаар танаж, үрэлгэн зардлуудыг танаснаар та бүхний баталсан хэт хөөсрүүлсэн төсвийг зөв голдиролд нь оруулж чадсан.

Ингэснээр ам.долларын ханш 4000-д хүрэх тооцооллыг бид бууруулж, ам.долларын ханш 50, 60 төгрөгөөр буураад байна. Өнөөдөр ам.долларын ханш 3559 төгрөг байгаа. Тухайн үед ам.долларын ханш 3600 төгрөг гарсан байсан. Энэ нь импортоос хамааралтай манай бүтээгдэхүүний инфляцыг хөөрөгдөөд ард түмний амьдрал, карманд шууд хүндээр тусах байсан. Төсвийн алдагдал 2.2 их наядаар хөөргөж байгаа энэ зардал инфляцыг 14, 15 хувьд хүргэх байсан. Бид улс төржөөгүй, ард иргэдийн амьдралыг хамгаалахын тулд, ард түмнийхээ халааснаас хулгайлаад байдаг инфляц, үнийн өсөлтийг хязгаарлахын тулд төрийн данхайсан бүтцийг танаж төсвийн зардлыг нэмсэн. Та бүхний хамтарсан Засгийн газрын данхайлгасан төсвийг бид танаж авлигатай тэмцэх ажлыг зохион байгуулсан. Авлига, хулгайтай тэмцэх ажлын үр дүнд өнөөдөр 300 гаруй хэрэг

шүүхэд шилжээд байна. Энэ бүхний үр дүнд төсвийн үр ашиг, дотоод үр ашгийг сайжруулсан.

Манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 1 жилийн өмнө та бүхэн Засгийн газар байгуулж байхад 250 ам.доллар байсан. Өнөөдөр 70 ам.доллар болж унаад байгаа. Ийм хүнд эдийн засгийн нөхцөл байдлыг давахын тулд бид ард иргэдийн нуруун дээрээс ачааллыг авч, үүний үр дүнд 8, 9 дүгээр сард анх удаа төсвийн тэнцэл дараалан 70 сая ам.доллар, 240 сая ам.долларын ашигтай гарч, Монголын түүхэнд анх удаа гадаад валютын ханш тогтворжиж, валютын нөөц бараг 6 тэрбум ам.долларт хүрлээ. Үүний үр дүнд ханш тогтворжиж байна. Инфляц буурч байна. Мөн иргэдийн амьдрал, түүнийг доройтуулж байсан үнийн өсөлт, орлогын дутагдлыг хязгаарлаж бодит төсөв анх удаа 4 хувьд хүрсэн. Хамгийн гол нь иргэдэд орлого хүрэлцэхгүй байсан.

Энэ бүхэн бол иргэддээ чиглэсэн бодлого, авлига, хулгайтай тэмцэж байгаагийн үр дүн юм. Хамтарсан Засгийн газрын үед данхайлгасан, тэлчихсэн төсвийг.../минут дуусав./

Н.Учрал: Уучлаарай, мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд, Далайн Батбаярын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11-ийн “б” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд, Далайн Батбаярын халуун дотно мэндчилгээг өргөн дэвшүүлье. Та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсье.

Батбаярын Жаргалан гишүүн асуултаа үргэлжлүүлэн асууя.

Б.Жаргалан: Ерөнхий сайд, та гадаад шокийн талаар ярьж байна. Дэлхийн бүх улс орнууд гадаад шоктой адилхан нүүр тулж байгаа. Тэр утгаараа Ерөнхий сайд Засгийн газрын үйл ажиллагаа энэ гадаад шокуудыг хэрхэн яаж амжилттайгаар даван туулах вэ? яаж зөв бодлого баримтлах вэ? гэсэн үндсэн даалгавартай байдаг.

2 дугаарт нь, та танай Засгийн газар гэж маш ихээр ярилаа. Танд сануулахад 2016 оноос хойш Монгол Ардын нам үнэмлэхүй олонхоор парламентад засаг бариад 10 дахь жилдээ очиж байна. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд ажилласан хамтарсан Засгийн газар бол Монгол Ардын намын Засгийн газар байсан. Тэрхүү хамтарсан Засгийн газарт Ардчилсан намын 8 сайд урилгаар оролцож тодорхой ажлуудын ард гарахыг зорьсон. Дор бүрнээ тодорхой амжилт, ололтыг хийсэн гэж бодож байна. Гэхдээ улс төрийн бодлогын манлайлал, санаачилга зөвхөн Монгол Ардын нам дээр сүүлийн 10 жилд явж байгаа шүү гэдгийг Танд сануулахыг хүсэж байна.

Өнөөдөр бид амьжиргааны өртгийн талаар ярихыг зорьсон. Амьжиргааны өртөгт хамгийн гол нөлөөлж байгаа зүйлүүдээс төлөөлүүлж “атар” талхны

үнийг би ярилаа. Та Засгийн газрын тэргүүний хувьд манай орон импортлогч улс биш, үйлдвэрлэгч улс орон болно дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ гэж маш ихээр ярьдаг. Тэгээд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжиж байгаа гэж танай Засгийн газар ярьдаг. Энэ салбарыг толгойлж байсан хүн одоо Эдийн засгийн хөгжлийн сайдаар ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд хөдөө аж ахуйн салбарт “Атрын аян”, “Хүнсний хувьсгал”, “Шинэ хоршоо”, “Цагаан алт” гээд маш олон хөтөлбөрүүд хэрэгжсэн. Гэсэн хэдий ч иргэдэд бодитой мэдэгдсэн зүйл харахан алга байна. Үүн дээр нэмж хэлэхэд олон татаастай зээлүүд төсөв дээр явж байгаа. Татаастай зээлийн хэмжээ 2.3 их наяд төгрөг болсон байна. Банк санхүүгийн салбарт давхар зах зээлийг үүсгээд, сөрөг нөлөөлөл бий болгож байна.

Ямар нэг улс төрийн хамааралгүй, бор зүрхээрээ ажиллаж байгаа жинхэнэ ЖДҮ-чид 30 хувийн зээл арайхийж авч байхад тодорхой улс төрийн хамааралтай, мэдээлэлд ойрхон, сонгуулийн санал өгч болзошгүй хүмүүс 3 хувийн зээл аваад ажиллаж байна. Энэ бол банк, санхүүгийн салбарт давхар зах зээл үүсгэж, зах зээл болон нөөцийн хуваарилалтыг буруу тийшээ авч явж байна. Тэгэхээр та банкны салбарт ажиллаж байсан хүний хувьд санхүүгийн салбарт байгаа зах зээлийн бус өрсөлдөөнт бус орчинтой цаашид яаж тэмцье гэсэн бодолтой байна вэ? Бодитоор яаж үндэсний үйлдвэрлэлээ дэмжих вэ?

Г.Занданшатар: Аливаа үйлдвэрлэл, бүтээн байгуулалтыг нураахад нэгхэн жил, бүтээн байгуулах, түүнийг сэргээн босгоход их олон жил шаардагддаг юм байна. Манай өмч хувьчлалын алдаатай бодлого мөн Дэлхийн худалдааны байгууллагад элсэхдээ дотоодын зах зээлээ хамгаалаагүйгээс шалтгаалаад манай улсын дотоодын үйлдвэрлэл дампуурч, 4382 аж ахуйн үйлдвэрийн газрууд хувьчлал нэрийн доор алга болоод, тоног төхөөрөмж нь урагшаа, хойшоо ачигдаад үндсэндээ бид үйлдвэрлэгч улс биш болсон.

Таны нэр дурдаад байгаа “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” зэрэг хөтөлбөрүүдийн үр дүнд өнөөдөр манай ноолуурын салбар гэхэд 247 сая ам.долларын самнасан ноолуур үйлдвэрлэж, тэр хэмжээгээр ажлын байр нэмэгдэж байгаа. Үйлдвэрлэлийн технологийн хөгжилд 1 шат ахиж байгаа. Дахиад 1 шат ахихад утас үйлдвэрлэдэг улмаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болох юм бол бид ухдаг шар алтнаас ургадаг цагаан алт, ноос, ноолуураа дэлхийн валют болгож гаргах бололцоотой. Үүний тулд шинэ зах зээлийг нээж Евро Азийн эдийн засгийн чөлөөт худалдааны хэлэлцээрт нэгдэхэд бид 1 тэрбум ам.доллар хүртэл ноолуураа эргэлтэд оруулах бололцоотой. Ноолуур бол ургаад жил болгон төлжиж байдаг. Одоо ноолуурын салбар сэргэж байна. Манай дотоодын самнах хүчин чадал 100 хувьд хүрлээ. Энэ салбарт 247 сая ам.доллар бүхий үр дүн, өндөр өртөгтэй, 30-40 хувийн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл бий болж байгаа.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 56 шинэ үйлдвэр байгуулагдсан. Одоо бид хүнсний хангамжийг бүрдүүлэхэд үйлдвэрлэлийн хувь хэмжээг 100 хувьд хүргэж дотоодынхоо хүнсний хэрэгцээг өөрсдөө хангадаг болчихвол иргэдийн амьжиргаанд тустай байх болно. Амьжиргааны хэрэглээний

сагсны багцад байдаг гол бүтээгдэхүүн бол хүнсний бүтээгдэхүүнүүд юм. Ийм учраас импортын хамааралтай байсан тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн жишээлбэл өндөг, тахиа зэрэг дотоодын үйлдвэрлэл нэмэгдээд 100 хувь болж эдийн засгаа дэмжих бодлого бодитой хэрэгжиж байна.

Б.Жаргалан: Бид бараг 30 гаран жилийн туршид ийм тусгайлсан төрөөс дэмжиж байгаа гэсэн нэрийн дор тодорхой салбарыг онилоод тухайлбал, ЖДҮ сан ч гэдэг юм уу, саяын нэрлэдэг хөтөлбөрүүд ч гэдэг юм уу ийм тусдаа зах зээл бий болгоод улс төрд ойрхон хүмүүст илүү давуу тал болж очсон байдлаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж ирлээ. Ноос, ноолуурын салбарыг 30 жил дэмжсэн байдаг. Би Танд бодлогын арай өөр шийдэл хэлээд байгаа юм. Тэр нь юу вэ гэвэл ийм давхар зах зээл үүсгэж зарим аж ахуйн нэгжүүдэд илүү маш хямд зээлийг олгоод, зарим аж ахуйн нэгжүүдэд маш өндөр зээлтэй нөхцөлийг олгож байгааг бүрмөсөн болиод, нийтээр нь санхүүгийн салбарын хүүг буулгах нөхцөлийг бүрдүүлэх нь зөв арга хэлбэр гэж тодорхой бодлогын шийдлийг Танд санал болгож байна. Тэгэхээр энэ дээр та Засгийн газрын тэргүүний хувьд бодолцож үзмээр байна.

Үнийн өсөлтөд нөлөөлж буй бас нэгэн хүчин зүйл бол суурь дэд бүтцийн үнэ өртөг юм. Өнгөрсөн жил цахилгааны үнийг нэмэгдүүлэх шийдвэр гарсан нь инфляцад маш их нөлөө үзүүлж байгаа. Өнөөдөр инфляц 9.2 хувьтай байгаагийн 2 орчим хувь нь цахилгааны үнэ бүрдүүлж байна. Тэгээд би Танд нэг хүний сэтгэгдлийг уншиж өгье. Энэ тог цахилгааны үнэ гэж улаан мөлжлөг боллоо. Стандартын шаардлага хангасан тог цахилгаанаар хангаж чадахгүй байна. Ямар ч бэлтгэлгүй дүн өвлийн хүйтнээр ухаалаг тоолуурт шилжүүллээ. 19 цагаас 23 цаг хүртэл цахилгаан халаалтаа салгаж байж хоол ундаа хийж байна гэжээ. Өрхийн орлого, зарлагын судалгааг харвал Монгол Улсын дундаж айл өрхийн цахилгааны зардал өмнөх оны мөн үеийнхээс 30 хувиар өссөн байна. Бид цагийн сайханд эрчим хүч экспортлогч улс болно гэж ярьж байсан. Зөвхөн нүүрс гэлтгүй сэргээгдэх эрчим хүчний их арвин баялаг нөөцтэй манай улс ингэж тог цахилгаанаа хязгаарлах түвшинд хүрч байгаа нь үнэхээр эмгэнэлтэй санагдаж байна. Тэгэхээр эрчим хүчний эх үүсвэрээ эрс нэмэгдүүлж, импортын хамаарлаас гарах цаг болсон гэж харж байгаа.

Энэ асуудлаар Танд тодорхой санал хэлэхийг хүсэж байна. Энэ мэтгэлцээнээр та бодлогын шийдэл ярья гэсэн. Цахилгаан станц барих тусгай зөвшөөрлийг бүрэн халж, хувийн хэвшилд хүссэн станц барих боломж, бололцоо олгох нь чухал гэж үзэж байна. Эрчим хүчний тухай хууль орж ирнэ гээд орж ирэхгүй байгаа. Энэ дээр танай Засгийн газар яг ямар бодит бодлого барьж байна вэ? гэдгийг Ерөнхий сайдынх нь амнаас сонсмоор байна. Ингэж чадвал бид Улаанбаатарын гэр хорооллыг цахилгаан халаагуурт шилжүүлэх замаар богино хугацаанд утаанаасаа бүрэн салах боломжтой гэж харж байна.

Эрчим хүчний салбарын либералчлах гэж яриад байгаа үед тусгай зөвшөөрлийг халахаас эхэлье. Цаашлаад цахилгааны үнийг биржээр тогтоодог, эх үүсвэрүүд нь хоорондоо бирж дээр өрсөлддөг тогтолцоо бүрдүүлэх боломж байна уу? Цаашлаад эрчим хүч экспортлогч улс болохыг та зорьж байна уу?

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр, Сүхбаатарын Эрдэнэболдын урилгаар Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын ЗДТГ-ын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхний ажилд өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Далайн Батбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүнийхээ халуун дотно мэндийг дэвшүүлье.

Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Б.Жаргалан гишүүнтэй санал нэг байна. Парламентын мэтгэлцээн бол шийдэл ярьдаг, түүнийг нотолдог няцаагчдын мэтгэлцээн. Засгийн газар шийдлээ оруулж ирээд түүнийгээ мэтгэлцдэг байх зарчимд яваандаа парламентын мэтгэлцээн чиглэх учиртай. Тийм ч дэг агуулгатай байсан.

Нэгдүгээрт, эрчим хүчний либералчлалыг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай. Тэгэхдээ шат шатанд байгаа үр ашиггүй байдал, авлига, хээл хахуулийг дээрээсээ эхэлж залруулахгүйгээр шууд нийлүүлэлтийн циклээсээ либералчлах нь бас оновчтой биш байгаа юм. Яагаад гэвэл эхлээд хямд нүүрс үйлдвэрлэхэд уурхай дээр байгаа үр ашиггүй байдлыг халах ёстой. Тэгээд үйлдвэрлэлийн шатанд өнөөдөр тодорхой авлига, хээл хахууль худалдан авалтын ажиллагааны асуудлаас шалтгаалаад IV цахилгаан станцын захирлыг халж байна. Тэнд бас асуудлууд байна. Үр ашиггүй зардлуудыг нэмэгдүүлээд байхаар эцсийн дүнд цахилгааны үнэ өртөг иргэдийн нуруун дээр ирдэг учраас тусгай зөвшөөрлийг либералчиллаа гээд суурь үнэ өндөр байвал үр дүнтэй хэрэгжихгүй.

Дээр нь хэдэн центээр сүлжээ нийлүүлэх тухай эрчим хүчний гэрээ заавал байгуулагдах ёстой.

Зах зээлийн хүүгийн зарчмын хувьд Улсын Их Хурлаас хууль батлагдаад улс төрийн өндөр албан тушаалтнууд, түүнтэй хамаарал бүхий этгээдүүд хөнгөлөлттэй зээл авч болохгүй гээд хууль баталсан. Бүр тодорхой санхүүцэж, агуулгатай хууль батлагдсан байдаг. Ер нь энэ хүүгийн зардал та сайн мэдэж байгаа. Макро эдийн засгийн тэнцвэр алдагдсан, төлбөрийн баланс алдагдалтай, үйлдвэрлэгч улс биш болсон учраас импортын үнэ дандаа инфляц өртөөлөгдөөд. Импорт нь үнийн өсөлтийг, үнийн өсөлт нь зээлийн хүү, инфляц өндөр болгоод байна. Зээлийн хүүгийн хэсэг нь инфляц байгаа шүү дээ. Инфляцын ханшаасаа өндөр болгож бодлогын хүү гэж гарч ирээд байгаа юм. Энийгээ давсан өндөр хүүтэй үндэсний үйлдвэрлэл сэргэх бололцоогүй. Үндэсний үйлдвэрлэл сэргэж дотоодын зах зээлээ хангахгүй болохоор импортод гарч байгаа валют хэвээрээ байна. Ийм чөтгөрийн тойрогт ороод байгааг таслан зогсоохын тулд стандартын бус чиглэлтэй олон улсад нэн ялангуяа Азийн орнуудын төрийн зохицуулалтад түлхүү ашиглагддаг хөнгөлөлттэй зээлийн механизмаар энэ нураагаад унагасан үйлдвэрлэлийн салбараа, үүн дотор эхний ээлжид хүнс, хөнгөн үйлдвэрийн салбараа дээш нь татах бодлого явуулж байгаа.

1991 онд манай экспортын 80 хувь нь хүнс, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн байсан байна. Одоо бол уул уурхайн 2, 3-хан бүтээгдэхүүнээс 90 хувийн хамааралтай. Энэ хоёр бүтээгдэхүүний үнэ нь дэлхийн зах зээл дээр хэлбэлзэхээр дагаад бүх төсөв, инфляц, иргэдийн амьжиргаа бүгд доройтдог. Ийм чөтгөрийн тойрогт ороод байгааг л эрс шинэчилж засах ёстой учраас бид ирэх таван жилийн үндсэн чиглэлд иргэдийн амьжиргааг татах, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх цогц төлөвлөгөөнд эрс шинэчлэл хийж оруулья гэж байгаа. Ингэж байж бид энийг.../минут дуусав./

Б.Жаргалан: Тэгэхээр таны ярианаас ойлгохдоо хөнгөлөлттэй зээлийн тогтолцоо явсаар байх юм байна. Тэгээд эрчим хүчний салбарыг хөгжүүлэхдээ нийлүүлэлтээс эхлэхгүй эрэлтээс нь эхэлнэ гэж ойлголоо. Макро эдийн засгийн бодлогын хувьд Ардчилсан нам бол төсөв мөнгөний бодлогын хүрээнд нийлүүлэлт талд илүү түлхүү дэмжих бодлогыг ямагт барьж ирсэн. Та бүхэн эрэлтийг дэмжих буюу эдийн засагт мөнгө нийлүүлэх, олон төрлийн халамж, хөнгөлөлттэй зээл олгох маягаар эдийн засагт мөнгө шахах бодлогыг дэмжсэний гай, үр нөлөөгөөр өнөөдрийн нөхцөл байдалд хүрээд байна гэж харж байгаа. Тэгэхээр үүнийг эргэж харна уу гэж хүсэх байна.

Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ яаж ч нэмэгдсэн гэсэн Монголчууд бид яаж ийж байгаад хоол хүнсээ болгодог. Гэтэл урт хугацааны хөрөнгө оруулалтууд байна. Ялангуяа залуу гэр бүлүүдийн хувьд орон сууц худалдан авах нь хамгийн том хөрөнгө оруулалт байдаг. Гэтэл 3 жилийн өмнө 1м² шинэ орон сууцын үнэ 3 сая төгрөг байсан бол өнөөдөр 5 сая төгрөг болоод өссөн байна. Ердийн нэг залуу гэр бүл 60м² орон сууц худалдаж авахад 300 сая төгрөг шаардагджээ. Гэтэл 6 хувийн ипотекийн зээлийн дээд хэмжээ 150 сая төгрөг хэвээр байгаа, 30 хувийн урьдчилгаа төлөөд 6 хувийн зээлд хамрагдлаа гэхэд 1 сарын эргэн төлөлтийн хэмжээ 2.7 сая төгрөг болж байна. 1 өрхийн дундаж орлого 3 сая төгрөг хүргэх үгүйтэй байгаа. Та тоо ярьдаг хүн учраас би тоо хэлээд байна л даа. Тэгэхээр дундаж залуу гэр бүл орон сууц худалдаж авах нөхцөл бололцоогүй боллоо. Тийм ч учраас залуучууд маань гадагшаа гарахыг илүүд үзэж байна. Тэгж байж ядаж орон байрныхаа асуудлыг шийдье гэж байна. Өнгөрсөн хугацаанд Ардчилсан намын Засгийн газар ипотекийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлсэн, барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн. Одоо таны Засгийн газрын хувьд ямар бодлого барих вэ?

Г.Занданшатар: Б.Жаргалан гишүүнтэй агуулга нь адилхан боловч таны яриа яг 2 зөрчилтэй болоод байгаа юм. Би нийлүүлэлтээ дэмжье гээд байгаа байхгүй юу. Эрчим хүчний ч тэр. Одоо сэргээгдэх эрчим хүч гэхэд дангаараа 5, 6 цент, батарейтайгаа 10 цент хүрээд байна. Сэргээгдэх эрчим хүчийг 3, 4 центэд хямдруулах, ногоон эрчим хүчний шинэ технологи нэвтрүүлэхээр тодорхой төслүүд ирэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан байгаа. Үүнтэй адилхнаар жишээлбэл, барилгын салбарт нийлүүлэлтийг дэмжих бодлогыг түрүүлж бодож байна. Ингэж байж барилгын үнийг бууруулахгүй бол ипотекийн зээл эрэлтийг нь дэмжээд байна. Та бүхний хэрэгжүүлж эхэлсэн ипотекийн зээл бол манай улс өөрөө барилгын материал үйлдвэрлэдэггүй байхад эрэлтийг дэмжихээр импортоо дэмжинэ. Манайх барилгын материал, ган, төмөр, цемент

бүгдийг импортоор аваад байхаар валютын ханшийг өсгөөд, валютын ханш нь эргээд инфляцыг өсгөөд иргэдийн амьжиргаанд хүндрэл учруулаад байгаа юм.

Ийм учраас эрэлт, нийлүүлэлт 2-ыг аль алийг нь дэмжихгүй бол дан эрэлтийг дэмжээд байхаар орон сууцын үнэ тасралтгүй өсөөд таны хэлснээр 3 сая төгрөг байсан бол одоо 2 дахин өсөж 6 сая төгрөг болсон. Зөвхөн өнгөрсөн 2 жилийн хугацаанд гэхэд 24 хувиар өслөө. Тийм учраас бид орон сууцжуулалтын банк байгуулж эрэлт, нийлүүлэлт хоёуланг нь дэмждэг “affordable housing” буюу орлогод нийцсэн орон сууцыг хот, хөдөөд барьдаг болохоор төлөвлөж байна. Улаанбаатар хотод гэхэд 83 мянган өрх айл 3-5 сая төгрөгийн орлоготой байна. Тэгвэл энэ орлогод нь нийцсэн орон сууцыг барьж байгуулдаг байх хэрэгтэй. Зөвхөн эрэлтийг дэмжээд байхаар худалдан авах чадвартай өрх айлууд Туулын голоос урагшаа Хан-Уул дүүрэгт хороолол бий болгоод, өндөр өртөгтэй орон сууц үнийг өсгөөд байдаг. Яг бага орлоготой иргэдийн орлогод нь нийцсэн орон сууцын бүтээмж байхгүй байна.

Ийм учраас эрчим хүч, орон сууц дээр нийлүүлэлт талын бодлогыг дэмжиж байж, нийлүүлэлт дотроо орцуудынхаа бодлогыг дэмжиж байж өөрөөр хэлбэл цементийн үйлдвэр, арматурын үйлдвэр, гангийн үйлдвэрээ дэмжиж байж хямд өртөгтэй орон сууц баригдах, тэр хэмжээгээр иргэдээ орон сууцжуулах, Улаанбаатар утаагүй болох зөвхөн халаагуураар биш орон сууцад орж байж XXI дүгээр зуунд хүн шиг амьдрах.../минут дуусав./

Б.Жаргалан: Ардчилсан нам засаг барьж байх үед, шинэчлэлийн Засгийн газрын үед барилгын материал үйлдвэрлэлийн чиглэл дээр олон ахиц дэвшил гарсныг та хүлээн зөвшөөрч байгаа юм байна. Ардчилсан намын хувьд эдийн засаг дахь төрийн оролцоо нэмэгдэж буй явдалд ямагт шүүмжлэлтэй хандаж ирсэн. Аливаа эдийн засгийн харилцаа зах зээлийн зарчмаар хөгжиж, эрүүл өрсөлдөөн явагдах учиртай. Тиймээс шинээр төрийн өмчит аж ахуйн нэгж байгуулахгүй байх, одоо байгаа төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээ аль болох хувьчлах бодлого баримтлахыг танай Засгийн газраас бас шаардсаар ирсэн байгаа.

Гэтэл та орон сууцжуулалтын банк байгуулна гэж яриад байгаа. Монгол Улсын банк, санхүүгийн салбарт одоогоор 10 гаруй банк үйл ажиллагаа явуулж байна. Тэр дунд Төрийн банк гэж ашигт ажиллагааны хувьд учир дутагдалтай, ямагт хоцордог төрийн өмчийн банк байгаа. Энэ банкиг ч гэсэн хувьчлах нь зүйтэй гэсэн байр суурьтай байдаг. Түүнээс гадна ипотекийн санхүүжилтийн тогтолцоог олон улсын жишгийн дагуу тогтолцооных нь арга хэлбэрээр хөгжүүлж ирсэн 10 гаруй жилийн туршлага байгаа. Орон сууцжуулалтын банк гэдэг бол энэ тогтолцоог эвдээд тэгээд хувийн арилжааны банкнууд сүүлийн жилүүдэд олон улсын зах зээлээс бас ногоон эх үүсвэрийн зээлүүдийг татах замаар ипотекийн зээлийг өөрийн санхүүжилтээр олгодог болоод байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ бүх зүйлээ эвдэх ийм санаачилга орж ирж байна гэж харж байгаа. Бид цаашид хоёрдогч зах зээлээ улам хөгжүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт татах замаар барилгын салбарыг, ипотекийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж байна гэж харж байгаа. Цаашдаа Орон

сууцжуулалтын банк гэдэг дээр эсрэг байр суурьтай байгаа гэдгээ хэлье. Энэ тогтолцоог яаж илүү эвтэйхэн одоо байгаа зүйлээ илүү төгөлдөржүүлэх замаар авч явах вэ? гэдэг дээр анхаарал хандуулаач гэж бас хүсэх байна.

Г.Занданшатар: Ер нь өмч хувьчлал гэдгийг оновчгүй буруу зохион байгуулснаас шалтгаалаад нийгэмд хувьчлалын талаар сөрөг ойлголттой болсон юм билээ. Зуны хугацаанд зохион байгуулсан хэлэлцүүлгүүдийн үеэр явж үзэхэд Төрийн банкиг хувьчилна, хэн хувааж авах гэж байна гэдэг ийм ойлголттой байна.

Тийм учраас бид “IPO” гаргах буюу 22 компанийг судлаад Төрийн банкиг оролцуулаад нийт 9 төрийн өмчийн компанийг олон нийтийн болох чиглэл барьж байна. Илүү олон нийтийн хяналтад, олон нийтийн “public” компани болох чиглэлийг барьж байна.

Тэр шаардлагыг хангахын тулд 3 жил ашигтай ажилласан байх ёстой, Олон улсын аудит хийгдсэн байх ёстой. Ийм тодорхой шалгууруудыг хангасан бол энэ төрийн өмчийн компаниудын үр ашгийг сайжруулна. Харамсалтай нь ярьснаасаа эсрэг юм хийдэг их зүйл байна. Тухайн үед хэт их төрийн оролцоог дэмжсэн зүйл болсон. Жишээлбэл 2012-2016 онд Төрийн банкиг хувьчлахгүй яасан юм? Үр ашгийг нь сайжруулахгүй яасан юм?

Ер нь “Эрдэнэс Монгол” ХХК, “Тавантолгой” ХК дээр энэ бүх бололцоо нь байсаар байсан. Харин энэ хэрэгжээгүй. Одоо бид үүнийг илүү “public” компани болгож үр ашгийг нь дээшлүүлэх чиглэл, хандлага барьж байна. Орон сууцжуулалтын банк бол дэлхий нийтийн хандлага. Манайх шиг эсгий гэртэй хот дэлхийд байхгүй. Эсгий гэртээ хот биш Солонгос, Германы орон сууцжуулалтын банк, орон сууцжуулалтын хөтөлбөр, санхүүжилтийн хэлбэрүүд бол нийлүүлэлт, эрэлтийг бас дэмжсэн хосолмол дэмжүүлэлтийн бодлогоор иргэдээ орон сууцтай болгодог, хямд өртөгтэй орлогод нийцсэн орон сууцаар хангадаг бодлогыг Америкт, Сингапурт хэрэгжүүлсэн. Дэлхийн бүх улсад Фредди Мак, Фанни Мэй-гийн жишээгээр орон сууцжуулалтын санхүүжилтийн тусдаа механизм үйлчилж байгаа. Яагаад гэвэл энэ бол хүний суурь, үндсэн хэрэгцээ байхгүй учраас, хүний эрхийн орох.../минут дуусав./

Б.Жаргалан: Яг сая таны дурдсан Америкийн Фанни Мэй болон Фредди Макийн жишээгээр Монголын Ипотекийн Корпорац гэж байгуулаад хоёрдогч зах зээлийн хөгжүүлэлтүүд эхлээд явж байсан. Хамгийн гол нь бид нар танайх ингэсэн манайх тэгсэн гэж яримааргүй байна. Урагшаа гарч ярья гэсэн бодол байгаа. Барилгын салбар дээр Танд бас нэг санаа хэлэхэд өнгөрсөн 10 жилийн хугацаанд ямар хандлага давамгайлж байна вэ? гэвэл улсын төсвөөс янз бүрийн гадаад, дотоодын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр барилга барьж байгаа явдал маш ихээр ихсэж байгаа. Ялангуяа бүр орон сууцын барилгууд.

Гэтэл манай дотоодын барилгын компаниуд барилга барих бүрэн чадавхтай болсон. Тэгэхээр төсвийн хөрөнгө оруулалтаар эсвэл төр дээр байгаа зээлийн эх үүсвэрээр барилга барих явдлыг зогсоох нь зөв гэсэн байр суурьтай байгаа.

Дараачийн асуудалдаа оръё. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн, цахилгааны үнэ өссөн талаар ярьж байгаа. Бас нэг хамгийн эмзэг хэрэглээний үнэ өдөр ирэх тусам өсөж байгаа. Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээ гэсэн ангиллын зардлын хэмжээ өнгөрсөн 1 жилийн хугацаанд 18 хувиар өсжээ. 1 өрх дунджаар 1 сард 113 мянган төгрөгийн эм худалдан авдаг гэжээ. Утааны улирал эхэлсэн. Энэ зардал улам бүр нэмэгдэж байгаа.

Нөгөө талаас тогтмол эм авах хэрэгцээ шаардлагатай хүмүүс бол хамгийн эмзэг бөгөөд хамгийн орлого багатай хүмүүс байдаг. Тухайлбал, манай ахмадууд байна. Тэтгэврийн хөгшчүүд үнийн өсөлтөд хамгийн ихээр нэрвэгдэж байна. 689 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа хөгшид эм тангаа авна, хоол хүнсээ авна, орон сууцны төлбөрөө төлнө, цахилгаан, дулаанаа төлнө гэвэл яаж амьдрах вэ? Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч бас энэ ангилалд багтаж байна. Тэгэхээр Засгийн газраас ахмадуудын нийгмийн асуудалд хэрхэн яаж анхаарч байгаа, цаашид тэтгэврийн реформ хийх бодол байна уу?

Н.Учрал: Нийслэлийн ерөнхий боловсролын 48 дугаар сургуулийн 9-ийн “а” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагч нартаа сурлага хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе.

Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Тэтгэврийн реформ хийх шаардлагатай. Манай реформуудын үндсэн шаардлага бол авлига, хулгайтай л нөхцөлдөж байгаа. Яагаад тэтгэврийн реформ хийх шаардлагатай вэ гэвэл Тэтгэврийн сан алдагдалтай болсон. 2030 он гэхэд Тэтгэврийн нийгмийн даатгалын сангийн алдагдал бараг Оюу толгойн хэмжээнд хүрэх тооцоотой. Яагаад тэтгэврийн зөрүү их, Нийгмийн даатгалын санд төлж байгаа тэтгэврийн хэмжээ өсөөд байхад инфляцаас шалтгаалаад энэ сан хөгжөөгүй.

Нийгмийн даатгалын санд үеийн үед хулгай нүүрлэсэн. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хямд хүүтэй байршуулдаг. Үржүүлж байх ёстой газар нь үрэн таран хийгээд хаясан учраас Нийгмийн даатгалын сан өрөө даахаа больсон. Монгол хүний насжилт уртсаад байгаа сайн үзүүлэлт байдаг. Ахмадуудын нас уртсаад байдаг, Тэрийг дагаад тэтгэврээ инфляцын хэмжээтэй уялдуулж нэмэгдүүлээд зардал тал нь өсөөд байдаг. Гэтэл дагаж өсөж байх ёстой Нийгмийн даатгалын сан хулгайд идэгдсэн байдлаас үүдэн Тэтгэврийн санд зайлшгүй реформ хийх шаардлагатай болоод байна. Одоо энэ дутсан санг яаж нөхөх вэ гэдэг хамгийн том асуудал байна. Энэ банкин дээр ч байгаа, үе үед газар болгон хулгайд нэрвэгдсэнээс болж энэ бүх сангууд алдагдлын уурхай болоод байна. Жишээлбэл, Нийгмийн даатгалын сан байна. Үүнийг хаахын тулд заавал дээрээс нь шүүрдэж сахилга хариуцлага, авлигагүй дэг журамтай системийг бий болгож байж, бүх савны цоорхой ёроолуудыг хааж бөглөж байж энэ системүүд бүгд ажиллаж эхэлнэ. Тэгэхээр 1 дүгээр зорилт бол авлига, хээл хахуулгүй байх системээ төгс төгөлдөржүүлэх асуудал байгаа. Ингэж байж Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Чөлөөт эдийн засгаа дэмжих багц хуулиудыг

ойрын хугацаанд өргөн барихаар төлөвлөж байна. Эдийн засгийн эрх чөлөөний хуультай хамт Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, татварын багц хууль, татварын реформ, нийгмийн даатгалын реформын.../минут дуусав./

Б.Жаргалан: Ахмадуудын тэтгэвэр нэмэгдэхгүй байгаа шалтгаан нь эрх баригчдын авлига, хээл хахууль, хулгай гэж хэлэх шиг боллоо. Тэгээд авлига, хээл хахууль, хулгайтайгаа хэдүүлээ тэмцмээр байна. Тэгээд энэ бол зөвхөн хоосон та бүхний “PR” үг баймааргүй байна. Тодорхой бодит үр дүн баймаар байна. Тэгэхийн тулд бодитой үр дүнгээ та нар богино хугацаанд харуулаач гэж хүсэх байна.

2 дугаарт, бодлогын шийдлүүдээ цогц байдлаар Засгийн газраас яаралтай өргөн баримаар байна. Бас хангалттай хугацаа өнгөрч байна. Аливаа Засгийн газрын бодлогын манлайлал, бодлогын шийдлүүд оруулж ирэх цаг хугацаа эхний 100 хоногтоо хийгддэг шүү дээ. Би Танд 100 хоног болох үед тэрийг ярьж байсан. Тэгэхээр Нийгмийн даатгалын сангийн нийгмийн даатгалын тогтолцооны реформ, татварын реформ үгүйлэгдэж байна. Татварын багц хуулийн шинэчлэлийг Засгийн газар өргөн барих бүрэн эрхтэй. Энийг бид 2024 оны 7 сарын 02-ны өдрөөс хойш шаардаж байгаа. Харамсалтай нь орж ирэхгүй байгаад байгаа. Иргэдээс санал авч байна гээд л яваад байгаа. Өнгөрсөн долоо хоногт Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг дээр Татварын ерөнхий газрын тодорхой мэдээллүүдийг сонссон. Татварын байгууллага дээр төвлөрч байгаа өр төлбөртэй аж ахуйн нэгжүүдийн тоо өнгөрсөн жил 50 мянга байсан бол энэ жил 70 мянга болжээ. Татварын өр төлбөрийн үлдэгдэлтэй, үлдэгдлийн хэмжээ өнгөрсөн жил 3 гаруй их наяд төгрөг байсан бол энэ жил 6.5 их наяд төгрөг болжээ.

Аж ахуйн нэгжүүд татварын дарамт дор сөхөрч байна. Түүрүүн бид зээлийн хүү өндөр байна, татварын дарамт өндөр байна гэж ярилаа. Яаж энэ нөхцөлд бид иргэдийнхээ амьжиргааг тэтгэх юм бэ? Яаж орлогыг нь нэмэгдүүлэх юм бэ? Энэ татварын асуудал дээр та яг ямар тодорхой бодлого, шийдвэрийг богино хугацаанд яаж оруулж ирэх вэ? Энэ дээр яг тодорхой шийдлүүд нэрлэнэ үү.

Г.Занданшатар: Ер нь бид тасралтгүй ажиллаад л байна. Тэгэхдээ ажил хийлгэхгүй байна, амар заяа үзүүлэхгүй байна. Нэг бол огцруулна гэх юм, нэг бол л улс төржөөд байх юм, Нэг бол ажил хаяад байх юм. Бензин шатахуун биднээс хамааралгүй өөрсдөө үйлдвэрлэдэггүй учраас дайн байлдаанаас болоод тасраад байх юм. Тэгэхдээ тэр бүх асуудлуудыг бид зохицуулаад, эрэмбэлээд, шийдээд явж байна.

Бид татварын реформыг энэ төсвийн хуультай хамт эхлэлийг нь бид тавьсан. НӨАТ бол татварын орлогоос гадна бүртгэлийн зорилготой учраас бүртгэлийг ил тод болгох зорилгоор НӨАТ-ыг 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгож нэмэгдүүлэх, тодорхой түвшинд 70-80 хувьд хүрэх хуулийн төслийг өргөн барьсан. Парламентын хэлэлцүүлгийн явцад энэ 10 дугаар сарын 01-ний өдөр болж хойшилсон. Үүнтэй уялдаад бид

татварын реформын багц хуулийн төслийг шинэчлээд ойрын хугацаанд өргөн барина. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг ирэх долоо хоногт өргөн барихаар төлөвлөж байна. Энэ дотор багц хуулиуд өргөн баригдана. Тэгэхээр ипотекийн зээл ч бай, орон сууцжуулалтын банк ч бай цогцоор нь ирэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан. Хэрвээ өнөөдөр батлагдвал энэ бүх идеологи нь ирэх жилүүдэд хэрэгжүүлэх бодлогын суурь баримт бичиг батлагдана.

Үүнтэй уялдуулаад бид төрийн өмчийн компаниудын үр ашгийг сайжруулах асуудлыг 3 удаа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд түрүүчээсээ хариуцлагыг нь тооцохыг нь тооцоод, хувьчлах, татан буулгах, эрэмбэлээд тэгээд ирэх долоо хоногт Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөн ажиллаж байна.

Дээр нь Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуультай хамт татварын реформ, нийгмийн даатгалын цогц реформын хуулиудаа өргөн барина. Татварын дарамтыг ерөнхийдөө бидний тооцож байгаагаар 3-4 их наяд төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн. Энэ маань жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг илүү чөлөөлөх зорилготой байгаа.

Харамсалтай нь сүүлийн үед татвар төлөлтийг сааруулах зорилготой юм шиг татварын өршөөл үзүүлж байгаа. Татварын реформ хийж байж дараа нь татварын өршөөл үзүүлж байсан циклтэй байгаа. Өмнөх Монгол Улсын татварын 4:10-ны тогтолцоо дээр ч гэсэн би ажиллаж байсан. Тэгтэл одоо.../минут дуусав./

Б.Жаргалан: Тэгэхээр Г.Занданшатар сайдаа та ажил хийлгэхгүй байна, улс төржүүлээд байна, янз бүрийн зүйл парламент руу оруулж ирээд байна гэж ярьж байна, гадаад шок ч бас ярьж байна. Мэдээж дэлхийн аль ч улс оронд бүх улс төрч нар, бүх Засгийн газрууд иймэрхүү бэрхшээлүүдтэй байгаа. Тэгэхээр хүн ер нь улс төрд яах гэж орж ирдэг вэ? Энэ бэрхшээлүүдийг даван туулаад, тодорхой бодит шийдлүүдээ өөрийнхөө легисийг үлдээх гэж орж ирдэг. Тийм ээ. Тэгэхээр элдэв янзын шалтаг, шалтгаан тоочихоо болиод бодит ажил руугаа зоригтой орохыг бид шаардаад байгаа шүү дээ. Тийм л зүйл өнөөдөр бас яригдаж байгаа.

Өнөөдөр Танд би 1 нэр томьёо хэлэхийг хүсэж байна. Бид өнөөдрийн хэлэлцүүлгийг “Амьжиргааны өртөг” гэсэн сэдвийн хүрээнд хийе гэж нам дээрээ ярьсан. Тэгээд амьжиргааны өртгийн хямралд Монгол Улс нэрвэгдэж байна уу? Энэ бол Ковидоос хойш бий болсон амьжиргааны өртгийн хямрал буюу Англиар “cost of living crisis” гээд байгаа. Тэгэхээр бид яг ийм бодитой хямралтай нүүр тулаад байна гэдэг өнцгөөс та дараа дараачийн Засгийн газраас хэрэгжүүлэх бодлого, шийдвэрийн арга хэмжээнд хандаач гэдэг байдлаар асууж байгаа.

Яагаад гэвэл иргэдийн амьдрал үнэхээр хүнд байна. Амьжиргааны өртөг нь дийлдэхээ байлаа. Тэгэхээр бид бодитой зүйлүүдийг хийхгүй бол өнгөрсөн удаагийн хэлэлцүүлэг дээр ярьсан дундаж давхарга улам бүүр багасна. Тэгээд Монгол Улс хэзээ тэгж чинээлэг Швейцар лугаа хөгжихгүй улам бүүр алсраад байна. Тэгэхээр бид өөрсдийнхөө цаг хугацаан дээр өөрчлөлт хийх ёстой.

Тэгээд төгсгөлийн асуулт асууя. Та элдэв янзаар гуйвуулж дайвуулахгүйгээр яг 1 асуултад хариулт өгнө үү? Та өрхийнхөө амьжиргааны зардалд сард хэдэн төгрөг зарцуулдаг вэ? Улсын Их Хурлын даргаас Ерөнхий сайдын цалин илүү бага байгаа гэж бодож байгаа. Ерөнхий сайдын хувьд энэ мэдээлэл нээлттэй байх боломжтой гэж харж байгаа. Тэгэхээр энэ амьжиргааны ертгийн хямрал танай өрхөд ямар арга хэлбэрээр нөлөөлж байна вэ?

Г.Занданшатар: Ер нь бараг сүүлийн 30 жилд өрхийн зардал бол үндсэндээ бодит орлогын дүнгээс өндөр байсан. Цар тахлын үед хувь хүний хэрэглээ хумигдсантай холбоотойгоор зардал нэлээн буурсан, орлого үл ялиг давсан тооцоолол гардаг. Өөрөөр хэлбэл орлого давж байж хүн хуримтлалтай байна. Хуримтлалтай байж дундаж давхарга амьдралын нөхцөлөө сайжруулах бололцоо бүрдэнэ. Тийм учраас амьдрах зардал бол орлогоосоо их байхыг хэлж байгаа. “Cost of living” хот хотоороо тухайлбал тэр хот илүү өндөр өртөгтэй хот гэдэг ч гэдэг юм уу.../минут дуусав./

Н.Учрал: 37 минут 30 секунд хэтэрсэн байна. Ерөнхий сайд хариулж чадаагүй асуултад сөрөг хүчний бүлгийн гишүүд асуухад бас нэмээд хариулах нь зөв байх. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар хугацаа тогтоосон. Батбаярын Жаргалан гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна. Асуулт асууж хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй байна. Гишүүдэд ирцээ бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асуух зөвшөөрөл олгоё.

Одоо Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр би нэг дор 3 асуулт асууна. Гэхдээ мэтгэлцээн гэдэг нэртэй мөртөө урьдчилж асуултаа өгөхөөр мэтгэлцээн биш болоод байгаа юм. Цаашдаа бас үүнийг анхаармаар юм байна. Зарчмын зүйл хэллээ.

1. Амьжиргааны зардлын өсөлт ба иргэдийн бодит орлогын бууралтын талаар.

Өрхийн бодит орлого бодит инфляцын өсөлтийг гүйцэхгүй байгаа. Хүнсний болон өргөн хэрэглээний барааны үнэ сүүлийн жилүүдэд тасралтгүй хаданд гарч байгаа. Энэ нь иргэдийн амьжиргааны маш том дарамтын шалтгаан болж байгаа. Засгийн газар ойрын хугацаанд буюу дараагийн 6 сарын хугацаанд иргэдийн амьжиргааны зардлыг бууруулах, орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр яг ямар бодитой алхмууд хийх вэ? Энэ төлөвлөгөөгөө та товч тодорхой хэлнэ үү?

Энэ хавтгайрсан үр дүн муутай бодлогын талаар.

Төрийн халамжийн хэмжээ жил ирэх тусам өсөж байгаа. Гэхдээ энэ иргэдийн амьжиргаанд сайжрах түлхэц авчирч чадахгүй байгаа. Хавтгайрсан халамжийн бодлого иргэдийн ажил хөдөлмөрт уриалах биш, урам зоригийг нь

бадраах биш өөрөөр хэлбэл, ач холбогдол муу байгаа гэдэг нь маш тодорхой харагдаж байгаа. Залуу үе ялангуяа Солонгос руу явдаг ч гэдэг юм уу, ер нь дүрвэх, дайжих тал руугаа боллоо. Тэгэхээр Засгийн газар энэ халамжийг хавтгайруулах биш зорилтот бүлэгт нь хүргээд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар бодитойгоор яг ямар бодлого, шинэчлэлийг хийх вэ?

Малчин, тариаланчдын амьжиргааны асуудлаар олон аймагт ган, зудын эрсдэл байна. Энэ өвөл тухайлбал, малчид, тариаланчдын орлого буурч өрхийн амьжиргаа хүндрээд байгаа. Энэ малчид, тариаланчдын өрийн ачаалал өсөж залуу малчдын ирээдүй маш хүнд байгаа. Ер нь л орон нутгаас залуучууд дайжих хандлагатай болж, гэр бүл төлөвлөлтийн бодлого алдагдсан гээд маш олон асуудал цаана нь байгаа.

Нөгөө талаас уур амьсгалын эрсдэлийг даван туулах чиглэлээр Засгийн газар яг ямар яаралтай бодлогуудыг хэрэгжүүлж байгаа вэ? Эдгээр 3 асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: С.Эрдэнэболд гишүүнтэй санал нэг байна. Энэ парламентын мэтгэлцээн бол Засгийн газраас оруулж ирсэн тодорхой шийдэл дээр мэтгэлцээн хийж байвал илүү оновчтой, ажил хэрэгч, үр дүнтэй болно. Одоо бол асуултууд өгсөн нэртэй боловч асуултаасаа өөр асуултууд ирээд асуулт, хариултын танин мэдэхүйн шинж чанартай хариулт давамгайлаад байгаа.

Тийм учраас илүү парламентын шийдэл гарахад чиглэсэн, ажил хэрэгч шийдэл тойрч маргалдаж, мэтгэлцэж байвал парламентын мэтгэлцээн илүү үр дүнтэй болох болов уу гэж бодож байна. Өнөөдрийн сэдэв бол “Амьжиргааны өртөг” гэж байгаа. Тэгэхээр нэгдүгээрт энэ хавтгайрсан халамжаар иргэдийн амьжиргааг шийдэж чадахгүй. Бага орлоготой иргэдийн орлогын 78 хувийг нь тэтгэвэр, тэтгэмж бүрдүүлж байгаа. Тэгэхээр зорилтот бүлэгт илүү чиглэсэн халамжийн бодлого илүү оновчтой. Нийт иргэдийн бараг 90 хувь нь ямар нэгэн байдлаар тэтгэвэр, тэтгэмж авдаг гэсэн судалгаа байна. Ийм учраас халамжийг оновчтой болгох, халамжийн реформ хийх чиглэлээр Т.Аубакир сайд ажиллаж байгаа. Энэ талаар дэлгэрүүлж хариулж болно. Ер нь амьжиргааны өртгийн өөрчлөлт нь инфляц, үнийн өсөлтөөр л хэмжигдэж байгаа. Бид эрэлт, нийлүүлэлт хоёуланг нь анхаарахгүй бол дандаа нийлүүлэлтийн шинж чанартай инфляц биш, эрэлтийн ч шинж чанартай инфляц бий болоод байгаа.

Нийлүүлэлт талаас гэхэд энэ жилийн хувьд шатахуун, эрчим хүчний үнийн өсөлтүүд нөлөөлсөн бол Улсын Их Хурлаас батлагдсан улаан буудайн импортыг тэглэсэн ч байдаг юм уу, гурилын импортыг тэглэсэнтэй холбогдоод тариалалт багасаж, манай ургац тариалалттайгаа 34.7 хувиар буурсан. Үүнээс болоод энэ жил улаан буудайг импортоор авахаас өөр аргагүй болж байгаа. Төмс 54.8 хувь, хүнсний ногоо 15 хувиар тус тус буурсан. Энэ нийлүүлэлт буурч байгаа учраас импортыг өдөөж байгаа.

Н.Учрал: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя. Гишүүд 2 минутад асуултаа товч тодорхой асууна. Ерөнхий сайд 2 минутад хариулна.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Монголчууд өнөөдөр зээлээс зээлийн хооронд, өрнөөс өрний хооронд амьдарч байгаа. Барьцаалж болох бүх юмаа барьцаанд тавиад, тавьж болох бүх зүйлээ барьцаанд тавьж амьдарч байгаа. Нэг үгээр хэлбэл “Өртэй хүн өөдөлдөггүй, өттэй мал таргалдаггүй” гэж Монгол ардын зүйр үг байдаг. Монголчууд маш энгийн зүйл хүсэж байгаа. Олсон орлого нь амьжиргааны өртөгт нь, амьдрах зардал нь хүрдэг байх ийм л зүйлийг хүсэж байгаа. Засгийн газраас, танаас тансаг амьдралыг хүсээгүй. Өнөөдөр 1.4 сая хүн хөдөлмөр эрхэлж байгаа хэдий ч улсын дундаж цалин 2.6 сая төгрөг гэж байгаа. Нийт уул уурхайн салбарт 5 сая төгрөгөөс дээш төгрөгийн цалинтай ажиллаж байгаа 73,100 хүнийг хасаад тооцвол энэ тоо арай гэж 1.9 сая төгрөгт хүрнэ. 1.9 сая төгрөгөөр хүн өнөөдөр ахуй амьдралаа залгуулж байна гэсэн үг. Нийт хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн 57 хувь нь улсын дунджаас бага цалинтай ажиллаж байна. Амьжиргааны доод түвшин 2016 оноос хойш 10 жилийн хугацаанд 318,700 төгрөгөөр өссөн бол 1 өрхийн сарын хэрэглээний зардал 2 сая төгрөгөөр нэмэгдсэн. Нэг үгээр хэлбэл өрөөр амьдарч байна.

Тийм учраас би Танд нэг иргэний жишээг хэлье. 36 настай, 3 хүүхэдтэй, өөрөө төрийн албан хаагч хийдэг, эхнэр нь хувийн хэвшилд ажилладаг 2.6 сая төгрөгийн цалин дээр нэмэх нь эхнэр нь 2 сая төгрөг. Ингээд нийтдээ 4.6 сая төгрөгийн цалингийн орлоготой өрхөөр жишээ авч танаас асуулт асууя. Энэ өрх ипотекийн зээлд сард 700 мянган төгрөг, цалингийн зээлд сард 950 мянган төгрөг, аппликэйшний зээлд 150 мянган төгрөг төлөөд үлдсэн багахан мөнгөөрөө хоол хүнс буюу саяын 2 сая төгрөгөөр амьдарч байгаа. Ингээд өрхийн орлого нь зөвхөн анхдагч хэрэгцээгээ хангадаг хоёрдогч, гуравдагч хэрэгцээг хангаж чаддаггүй. Том хүүхдийнхээ хувцсыг багадааар дунд хүүхдэдээ, дундхад нь багавал дахиад багавал нь өгдөг ийм л амьдрал байна.

Өнөөдөр залуучууд ипотекийн зээлтэй, цалингийн зээлтэй, автомашины зээлтэй, сургалтын зээлтэй, хэрэглээний зээлтэй, гар утасны зээлтэй, банк бусын зээлтэй, аппликэйшний зээлтэй, нэмээд ломбардын зээлтэй. Ахмад малчид нь малчны зээлтэй, тэтгэврийн зээлтэй. Ёстой л нээрээ цалинтай тулдаа амьдарч байна л гэдэг нөхцөл байдалд амьдарч байна. Надад танаас ганцхан асуулт байна. Та ямар нэгэн зээлтэй юу?

Г.Занданшатар: Судалгаанаас үзэхэд нийт өрх айлуудын 63.8 хувь нь зээлтэй байгаа. Энэ бол өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал цалингийн зээл, хэрэглээний зээл багассан үзүүлэлт боловч иргэд орлого нь хүрэлцэхгүй байгаа учраас голдуу хэрэглээний зээл авч байгаа. Цалингийн зээл, тэтгэврийн зээл, саяын хэлсэн малчдын зээл ихэвчлэн бизнес хөгжилдөө гэхээс илүү амьжиргаагаа нөхөхдөө авч байгаа зээл харагдана. Үүний 15 хувьд нь автомашины зээл, лизингийн зээл, санхүүгийн лизингийн зээл, автомашины зээл авч байгаа. Тэгэхээр нийт агуулгаар нь харгалзан авч үзвэл, амьжиргааны ертгийн үзүүлэлтийг олон улсын стандартын дагуу тооцсон ч гэсэн, статистик үзүүлэлтээр дундаж орлого 2 сая 970 мянган төгрөг гэж байгаа. Зардал нь 3 сая 90 мянган төгрөг гэвэл 120 мянган төгрөгөөр дунджаар зарлага орлогоосоо илүү байгаа гэж үзэж болох юм.

Зарлага илүү байна гэдэг бол хүмүүс дунджаар зээл рүү чиглэж байна гэсэн үг. Таны хэлж байгаа 56 хувь нь энэ дунджаас доогуур цалинтай байгаа.

1 дэх бодитой хийж байгаа шийдлүүд юу байна гэвэл эмч, багш нарын цалинг нэмэгдүүлсэн. Тэгэхдээ хавтгайруулж нэмэгдүүлээгүй. Цалинг хавтгайруулж нэмэгдүүлсэн гэж яриад байна. Бид суурь доод цалинг нэмж байгаа. Улаанбаатар хотын багш нарын ачаалал их, нийт сурагчдын 2/3 буюу 60 гаруй хувь нь Улаанбаатарт сурч байна. Тэгтэл нийт багш нарын 1/3 нь Улаанбаатарт байна. Залуу багш нар 1,200,000-1,484,000 төгрөгийн цалингаас гар дээрээ 1,200,000 төгрөг аваад Улаанбаатар хотод амьдрахад хэцүү байна.

Хөдөө орон нутгийн багш нар 40 хувийн нэмэгдэлтэй байдаг учраас зардал харьцангуй бага байна. Гэхдээ хөдөөд багш нарыг дэмжих бодлого гэж тайлбарлана. Тийм учраас бид сая суурь бага цалинг дээшээ 2,200,000 төгрөг хүртэл нэмэгдүүлэх бодлого, чиглэл барьсан. Эмч, нар багш нарын цалин нэмэгдэхэд гол дундаж давхарга болох.../минут дуусав./

Н.Учрал: Ө.Шижир гишүүн нэмэлт 1 минут тодруулна.

Ө.Шижир: Та миний ганц асуултад хариулсангүй. Гэхдээ 2016 оноос хойш хэрэглээний үнийн индексийн өсөлтийг дунджаар 8.66 хувь гэж тооцсон байна. Гэтэл бодит байдал дээр 8.66 хувь бус зөвхөн хонины мах гэхэд 2016 оноос хойш жилийн дунджаар 204 хувь, өмнөх оныхоос 14 хувь, үхрийн мах өмнөх оныхоос 14.7 хувь, адууны мах 13 хувь, төмс 16.2 хувь, манжин 14.6 хувь, элсэн чихэр 9.5 хувь, ургамлын тос 13.6 хувь гэх мэт өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнүүд Үндэсний статистикийн хорооноос гаргаж байгаа жилийн дундаж хэрэглээний үнийн индексийн 8.6 хувиас өөр байгаа шүү гэдгийг би Танд хэлэх гэсэн юм. Бодит амьдралд статистикийн гаргаж байгаа цаас, амьдрал 2 зөрж байгаа гэдгийг Монголчууд бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд та миний ганц асуусан асуултад хариулсангүй. Баярлалаа.

Н.Учрал: Ерөнхий сайд 1 нэмэлт минутаар хариулна.

Г.Занданшатар: Асуултад гүйцээж хариулж амжсангүй. Би өөрөө хувь хүний нэр дээр зээлгүй байна. Миний зарлага харьцангуй бага. Би ажил, гэр хоёрын хооронд явдаг учраас өөр бусад газраар ордоггүй. Өдрийн хоолны зардлаас бусад зардал гаргадаггүй учраас одоогоор зээлгүй амьдарч байна. Өглөө гараад л орой ирдэг өөр газраар явдаггүй, ажил гэр хоёрын хооронд хүргэж өгөөд хүргээд, авчихдаг учраас миний зардал харьцангуй гайгүй. Ордонд ордны хямд хоол идчихэж байна. Ингээд үндсэндээ миний зардал өдрийн хоолны зардал гарч байгаа.

Түрүүн Б.Жаргалан гишүүний асуултад хариулж амжаагүй. Нийлүүлээд хариулахад эдийн засагч хүн учраас зардлаа хэмнэж энэ хүндрэлтэй эрин үед ингэж амьдарч байна. Зээл алга байна. Тэгээд зээлгүй 32 хувьд хамаарч байгаа. Бусад асуудлаар амьжиргааны өртөг, амьжиргаа шийдэл гарцууд багш, эмч нарын цалинг нэмэгдүүл.../минут дуусав./

Н.Учрал: Ерөнхий сайдаас асуулт асуух, үг хэлэх хугацаа 2 минутаас хэтрэхгүй. 1 удаа 1 минутаас хэтрэхгүй хугацаагаар тодруулж болно.

Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Өнгөрсөн 10 жилийн Монгол Улсын өнөөгийн байдлын үр дүнг илэрхийлэх хүнтэй хамт мэтгэлцэх гэж байна. Өнөөдөр Улаанбаатар хотын агаар орчны бохирдол, амьжиргааны энэ өртөг, ажил хийсэн ч ядуурдаг, ажил хийгээгүй ч ядуурдаг энэ Монгол Улсын сүүлийн 10 жилийн бодлого, шийдвэртэй салшгүй холбоотой хүн бол Монгол төрд байдаг бүхий л өндөр албан тушаалыг ээлжлэн сэлгэн хашсан хүн бол та гэж би хувьдаа бодож явдаг.

Та дандаа ирээдүй цаг дээр ярьж байна. Ер нь Монгол хөгжихгүй байгаа шалтгаан дандаа ирээдүй цаг дээр ярьдагт байгаа. Одоогоо оношилж, өнгөрснөө зөв дүгнэж, алдаагаа засахгүйгээр бид цаашаа явах боломжгүй. Үнэхээр өнөөдөр 2 талд улс төржих биш Монгол Улсыг улс шиг улс болгоё, 3.5 сая хүнийг цалингаараа амьдардаг улс болгохын төлөө бид бодлогоо уралдуулъя гэж бодож байна. Монголын өнөөгийн байдал цоорхой хувинтай адилхан. Ямар ч зүйл хийгээд тэр хувин дүүрэхгүй байна. Тэр бидний алдаа. Монгол Улсын Ерөнхий сайд хариуцлагатай хүн. Нэг зүйлийг онцолж хэлж байна. Монголын сүүлийн 10 жил шат шатад хулгай гарсан юм байна. Хулгайгаар дүүрсэн юм байна, хулгай цэцэглэн хөгжсөн юм байна. Энэ хулгайн өртгийг иргэд нуруун дээрээ төлж байгаа юм байна. Өнөөдрийн амьжиргааны өртөг, инфляц, үнийн өсөлт бол энэ хулгайн шалтгаан, үр дагавар гэж хэллээ. Тэгэхээр бид цалинг шат дараатай нэмье гэж яриад байдаг. Инфляцыг үйлдвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг нэмэгдүүлж байгаа үндсэн шалтгаан нь хулгай юм гэж бодож байна. Тийм учраас яг энэ цаг үед та .../минут дуусав./

Н.Учрал: Нэмэлт 1 минут Баатархүү гишүүнд өгье.

Ц.Баатархүү: Тодруулахдаа асууя.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ер нь би ирээдүй цаг дээр зөвхөн яриагүй өнгөрсөн, одоо, ирээдүй 3 цаг дээр ярьж байгаа гэж бодож байна. Яагаад гэвэл би төсвийн тодотгол хийсэн. Үнийн өсөлтийг бууруулахын тулд 2025 оны төсвийн тодотгол хийж, 2026 оны төсвийг илүү бодитой мөчлөг сөрсөн бодлого болгож, энэ талаасаа эдийн засагт үнэ өсөх дарамтыг бууруулж, цалинг нэмэгдүүлж, суурь орчныг арилгаж засахад чиглэгдсэн өөрчлөлтүүдийг хийж ирснээ, ирээдүйд хийх энэ таван жилийн үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар батлагдаж байгаа учраас ийм 3 цаг дээр ярьж байна. Тийм учраас өнгөрсөн, ирээдүй, одоо цаг гэсэн энэ гурван цагаа холбож, аливаа 3 үе дээрээ тогтож байх ёстой гэж би ойлгож байгаа.

Тийм учраас зөвхөн 10 жилд эдийн засаг ингээд болохоо байчихсан биш, энэ бол 30 жилийн алдаа. Өмч хувьчлалаас эхлээд хүнсний үйлдвэрлэл дампуурсан, Дэлхийн худалдааны байгууллагад элссэн эдийн засгийн алдаатай бодлогуудын үр дүнд үнэ өссөн. Өөрсдөө үйлдвэрлэгч улс биш болсон, хараат болсон, хамааралтай болсон энэ бүх тоо, эдийн засгийн баримтууд 30 жилийн

алдаа. Зөвхөн 10 жилд бий болсон юм шиг ярьж болохгүй. Энэ авлига, хулгай өмч хувьчлалаас эхлээд л өнөөг хүртэл үргэлжилж байгаа. Ардчилалтай хамт үр хөврөл нь гараад ирчихсэн учраас танай, манай гэж бие бие рүүгээ чихэх биш хамтраад энэ болж бүтэхгүй асуудлуудаа шийдээд, засаад, тэр цоорхойгоо бөглөөд, хамтраад урагшлах нь илүү эрүүл шийдэл гарц юм. Тийм учраас бид бие биеийгээ буруутгахаас илүү зөв шийдэл гаргахын төлөө явах ёстой гэж бодож байна.

Бид эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих гэж байна. Хувийн хэвшлийг дэмжих татварын таатай орчныг бүрдүүлэх, ТӨК-уудыг нээлттэй ХК болгож, олон нийтийн хяналтад шилжүүлэх, дэд бүтэц, орчин, хүчний төслүүдэд түлхүү анхаарах зэрэг арга хэмжээг нэмэгдүүлж үүний үр дүнд бүтээмж нэмэгдэж, энэ хэрээр Монгол хүний үнэлэмж өсөж, цалин орлого нэмэгдэнэ. Бүтээмж сайтай бол цалин, орлого нэмэгдэнэ.

Н.Учрал: Цэндийн Баатархүү гишүүн тодруулна.

Ц.Баатархүү: Бидний өнгөрсөн зам алдаатай байсан гэдэгтэй санал нийлж байна. Гэхдээ өнгөрсөн 10 жил алдааг засах чиглэлээр ажиллаагүй, алдааг улам цэцэглэн хөгжүүлсэн байна гэдгийг бид бүхэн бүгдээрээ хүлээн зөвшөөрч байна. Одоо танай Засгийн газрын хувьд алдааг засах 100 хоног өнгөрч байна.

Төрийн өмчит компанийг нээлттэй болгоё гэж ярьж байна. Одоо яаралтай энэ реформоо хийгээсэй гэж би хүсэж байна. Үнэхээр энэ амьжиргааны өртгийг нэмэгдүүлж, үнийн өсөлтийг бий болгож байгаа жишээлбэл Улаанбаатар хотод орон сууц барихаар барилгын компани газрын зөвшөөрөл авахын тулд хүнд суртлын төлбөр төлдөг. Дулааны эх үүсвэр авахын тулд хүнд суртлын төлбөр төлдөг. Цэвэр усны эрх авахын тулд хүнд суртлын төлбөр төлдөг, эргүүлээд Улсын комисст хүлээлгэж өгөхийн тулд авлигын хүнд суртлын төлбөрийг төлдөг. Энэ тогтолцооны авлигын өртгийг Улаанбаатарчууд, Монголчууд нуруун дээрээ үүрч байна. Тийм учраас таны ярьж байгаа хулгайтай тэмцэх энэ .../минут дуусав./

Н.Учрал: Нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургуулийн 11-ийн “а” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагч нартаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье.

Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Нэлээн хэдэн сэдэв бэлдэж ирсэн. Цаг маш бага учраас товчилъё. Төсөв болон хувьчлалтай холбоотой асуудлуудаар санал хэлэх, зарчмын хувьд асуух юм байгаа.

Төсөв дээр Засгийн газар 120 их наяд төгрөгийн хөрөнгө буюу актив хөрөнгийг хөдөлгөж байгаа. Гэтэл бид 33 их наяд төгрөгийг улсын төсвөөс

татвар нэрээр баталж өгөөд Засгийн газрыг ажилд нь оруулдаг, 90 их наядын цаана нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүд дээр эргэлдээд байна. Энэ эргэлдээд байгаа мөнгөнөөс буцаагаад улсын төсөвт нэмэр болж байгаа орлого бол маш муу байгаа. Энийг сайжруулж ажиллах шаардлагатай. Энэ дээр таны саналыг сонсьё.

Дараа нь урсгал зардлаа цаашид ер нь хөдөлгөхгүйгээр яг энэ чигт нь царцаагаад, одоо байгаа энэ урсгал зардлынхаа хүрээнд цаашид Засгийн газар оруулж ирэх төсвөө баримталж ажиллавал их зүгээр байна.

Тэгээд гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл, хөтөлбөр дээрээ Монгол Улсынхаа эрх ашгийг сайн тавьж өгөхгүй бол Монгол Улс өөрөө алдагдалд орохуйц ийм гэрээ, контрактуудыг маш их хийж ирсэн алдаа дутагдлууд байна. Түүнчлэн төр өмчүүдээсээ хувьчлах замаар цаг алдахгүйгээр салах ёстой болоод байна. Хамгийн тод жишээ Монгол Ардын намын Цагаан байрны даргынх нь үеэл нь Төрийн банкны захирал хийж байгаа. Бид ийм нөхцөлд шударга ёс, авлига, хулгайгаас салах гэдэг асуудлуудыг ярих боломж байхгүй. Яг шударгаар нээлттэй сонгон шалгаруулалт зарлаад захирлуудыг нь сайхан томилоод нээлттэйгээр компаниудаа хувьчлаад явбал банкнуудаас бид хэдэн тэрбумаар нь орлого олж улсын төсөвтөө нэмэр болох боломжтой атал өнөөдөр энэ маш муу түвшинд явж байгааг та өөрөө харж байгаа. Энэ дээр та саналаа хэлээрэй.

2 дугаар асуудал малчидтай холбоотой. Өнөөдөр сүү, мах 2 үнэтэй байна. Тэрнээс бусад дайвар бүтээгдэхүүн, арьс шир ерөөсөө үнэ хүрэхгүй байна. Монголчууд, малчид тэр дундаа энийг сүүлийн хэдэн жил ярьж байгаа. Энэ тал дээр ямар бодлого баримталж ажиллаж, ойрын хугацаанд энэ явал үнэд хүрэх вэ гэдгийг та малчдад бас хэлж өгөөч? Яг малчнаас ирсэн асуулт нь Малчны тухай хуулийн 4.2.9 дээр заасан өндөр настны тэтгэмжийн асуудлыг тодруулж өгөөрэй гэсэн.

Сүүлийн асуулт бол нийгмийн асуудал буюу Улаанбаатар хотод Туулын хурдны зам гээд 2.5 их наяд төгрөгөөр зам барих гээд байна. Энэ мөнгөөр жишээлбэл, баруун аймаг буюу Баянхонгор, Өвөрхангай руу гардаг Лүнгийн замыг өргөтгөх боломжтой. Энэ Улаанбаатар хотоор явж байгаа төмөр замыг судлаад өгч байхад яагаад Нийслэлийн Засаг дарга ийм буруу шийдвэр гаргаад ажиллаад байгаа юм бэ? Энэ дээр таны байр суурь?

Г.Занданшатар: Ц.Баатархүү гишүүний асуулттай нийлүүлээд хариулахад хамгийн гол нь үр ашгийг сайжруулах ёстой салбар бол ТӨК-уудын асуудал байгаа. Тэгэхээр төрийн өмчийн компаниудыг хувьчлах тэр дотроо "IPO" гаргаж олон нийтийн компани болгоход тодорхой шалгууртай байдаг. Өөрөөр хэлбэл, олон улсын аудитаар аудитлагдсан байх ёстой. Тэрэнд хугацаа орж байна. Дээр нь 3 жил ашигтай байх ёстой. Тэгж байж олон нийтэд хувьцаа нь гарч арилжаалагдаж, хөрөнгийн бирж амилна. Ингээд үнэт цаасны зах зээлд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, хүүг бууруулахын тулд хувьцааны өгөөжийг нэмэгдүүлж санхүүгийн зах зээлээ хөгжүүлэх шаардлагатай

байгаа. Энэ талаар Б.Жаргалан гишүүн асуугаад байсан. Ингэж байж санхүүгийн бүтээгдэхүүний өртөг хямдарч, санхүүгийн зах зээл ч гэсэн хөгжих ёстой. Гэтэл 30 жилийн алдааг 100 хоногийн дотор засаж болохгүй. Жишээлбэл томоохон компаниуд дээр аудит хийхэд зарим тохиолдолд 6 сарын хугацаа шаардагдаж байна. Аудитын процесс эхэлж байна. Ингээд үр ашгийг сайжруулна.

2 дугаарт сүү, махнаас гадна арьс шир, ноос, ноолуур, дайвар бүтээгдэхүүнийг гаргах нь манай улсын туйлын зорилго байгаа. Энэ нь “ухдаг шар алтнаас ургадаг цагаан алт” гэж нөхөн төлждөг баялгаа экспортын бүтээгдэхүүн болгох нь манай эдийн засгийн таван жилийн үндсэн чиглэл юм. Ийм учраас 183 сая хүнтэй 2 триллион ам.долларын зах зээл Евро Азийн холбооны 6 улстай эдийн засгийн чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг оруулж ирнэ. Үүний гол зорилго бол 3 төрлийн 347 нэр төрлийн бүтээгдэхүүнийг татваргүй, хөнгөлөлттэй, тарифын болон тарифын бус барьергүйгээр экспортлоход чиглэгдэж байгаа. Үр дүнд бидний хийсэн тооцооллоор дайвар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд 160 хувиар өсөх тооцоотой.

Мах, махан бүтээгдэхүүн болох нухаш, зайдас, хиам, каз зэрэг бүтээгдэхүүнийг боловсруулаад махныхаа экспортыг 140 хувиар нэмэгдүүлэх, арьс ширний үйлдвэрлэлийг шинэ шатанд гаргах бололцоотой. Энэ зах зээл гэхэд 12 тэрбум ам.долларын арьс шир, ноос, ноолуур, мах, махан бүтээгдэхүүн импортолдог зах зээл. Үүний 10 хувьд нь бид нэвтрэхэд 1.2 тэрбум ам.долларын экспорт хийх бололцоо бүрдэнэ гэж байгаа.

Малчны тухай хуулийн 4.2.9-д малчны нийгмийн даатгалыг 1 удаа нөхөн төлөх тухай хууль батлагдсан. Жил бүр 1 удаа нөхөн төлдөг хууль батлагдаад байвал энэ байнгын хуультай ялгаагүй болно. Тухайн хугацаанд л нөхөн төлөх давуу эрхийг олгосон. Зах зээл дээрх оролцогчид, татвар төлөгчид жигд, тэгш, шударга байх зарчмыг мөрдлөг болгохгүй бол цэргийн тэтгэвэр, малчдын тэтгэвэр гээд тус тусад нь ялгаад л хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлээд байх тусмаа Нийгмийн даатгалын сан улам дампуураад, алдагдалд ороод нийтийнх нь эрх ашиг хохироод байгаа гэдгийг бодох ёстой.

Н.Учрал: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуултаа асууя.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд Ерөнхий сайдаа. Энэ инфляцын 2 хувийг үүсгэж байгаа эрчим хүчний салбарын талаар ярилцъя гэж би асуултаа Танд өгсөн байгаа. Дулаантай холбоотой сонин юм яваад байгаа. Та мэдэж байгаа байх. “Эрдэнэс Тавантолгой”-оос 300 тэрбум төгрөгийг гаргаад 1.1 сая төгрөгийн өртөгтэй шахмал түлшийг БНХАУ-аас бид авч байгаа. Эрээнд оруулж ирэх дүн нь 700 мянган төгрөг, хот руу оруулж ирэхэд 1.1 сая төгрөг болдог, иргэдэд 200 мянган төгрөгөөр бид зарж байгаа. Өмнө нь 750 цэгээр борлуулж байснаа одоо болохоор 350 цэг болгосон. Иргэд түлшээ авах гэж очирлоод хүнд байдалтай байгаа. Ер нь энэ шийдвэрийг хэн шийдсэн юм бэ?

Г.Занданшатар: Манай Засгийн газрыг томилогдоод бүрдэх үед энэ тендер нь зарлагдаад шалгарчихсан зогсоох боломжгүй гэж байсан. Өмнө нь ч

гэсэн Орчны бохирдлын хорооноос Бортээгтэй холбоотой шалгагдаад, яригдаад байгаа асуудал бас яг ийм хагас коксожсон нүүрс баахныг оруулж ирээд хадгалсан. Тэр нь бас үүнээс илүү үнэтэй байж байдаг юм байна. Маргааш би явж газар дээр нь үзэж үүний хоруу чанар, үр ашиг, бусад зүйлийг газар дээр нь үзэж танилцъя гэж төлөвлөж байна. Тендер нь шалгагдаад, зарлагдаад компани шалгарчихсан нөхцөлд буцааж болдоггүй олон улсын гэрээ, контрактууд ихэвчлэн хийгдсэн байна. Олон гэрээнүүд тэгж хийгдсэн байна.

Үүний үр ашгийг бид газар дээр нь үзэхэд тухайн үед Улаанбаатар хот утаагүй болно, агаарын бохирдол 50 хувь буурна, энэ бол сүүлийн үеийн хамгийн шилдэг технологи гэсэн.

Харин бид бол цахилгаан халаагуураа нэмэгдүүлье. Хамгийн их утаатай газруудад байгаа 5 мянган айлыг яаралтай цахилгаан халаагуурт шилжүүлье. Цаашлаад дунд хугацаанд цахилгаан халаагуур, газар утааг бууруулах 5 цогц бодлогын шийдлийг гаргаад түүнийг хэрэгжүүлье. Тэр шахмал түлшээ ч гэсэн, хагас коксоо ч гэсэн Монгол Улсад үйлдвэрлэдэг больё. Дараа жилийн хувьд Багануур болон Улаанбаатар хотод үүнийг хэрэгжүүлэх чиглэл гаргаад ажиллаж байгаа. Энэ жилийн хувьд зун өнгөрч байхад бид томилогдоод энэ асуудлыг аль болох үр бүтээлтэй байхыг л шахаж шаардаж байна. Цахилгаан халаагуурын асуудал бол эрчим хүчний хангамжтай холбогдох асуудал болно.

Н.Учрал: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр асуулт, хариулт нь 2 минут тэгээд 1 минутаар тодруулж болно. Тэгэхээр С.Цэнгүүн гишүүнд 2 минутыг бүтэн өгчихье. Тэгээд Ерөнхий сайд 1 минутаар хариулна.

С.Цэнгүүн: Энэ их сонирхолтой байгаад байгаа юм. Монгол Улс өөрөө ямар нүүрсний баялагтай улс билээ. Тийм байж ийм шийдвэрийг яг хэн нь гаргаад явчихсан юм бэ? Та Засгийн газрын тэргүүн хэр нь нийслэл шийдсэн гэж байна. Нийслэлийн Х.Нямбаатар дарга шийдсэн юм уу? Би энийг Б.Чойжилсүрэн сайд шийдсэн юм болов уу? гэж асуух гээд байна л даа. Яагаад энийг асууж байна гэвэл, сүүлийн 15 жил 5 их наяд төгрөгийг бид утаатай тэмцэхэд зарцуулсан байгаа. Тэгээд энэ 5 их наяд төгрөг өөрөө зүгээр салхинд хийсээд алга болсон. Хэн ч энэ дээр хариуцлага үүрч байгаагүй. Үндсэндээ утааны тухай асуудлаа бид шийднэ гэвэл орон сууц барина гээд бодит байдлаа байхгүй болгоод явдаг. Төрийн өмчит компаниуд дээр ажиллаж байхад төрийн өмчит компанийн менежментээ сайжруулна гэдэг.

Та санаж байгаа бол анх томилогдохдоо ТӨК-уудыг хувьчилна гэж байсан. Тэгээд би танаас асууж байсан. Эрчим хүчний 47 компанийг хувьчилж болж байна. Та хувьчлах уу? гээд асуусан. Та эхний 100 хоногтоо 20 компанийг хувьчилчихна гэсэн. 8 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар та 1 компанийг татан буулгаад, 1 компани дээр 1-ийг нь нийлүүлсэн ийм үр дүнтэй байж байна.

Хэзээнээс та ажлаа хийх гэж байгаа юм бэ? Эрчим хүчний компаниуд дээр асар их менежментийн шинэчлэл дутагдаад тэнд бид удирдлагуудыг нь солих шаардлага гарсан.

6 дугаар сарын 02-ны өдөр ТЭЦ-III дээр гарсан дэлбэрэлтийг ярьж байгаа хүн алга байна. ТЭЦ-III дээр та БЭТ томилсон. Та яагаад ТЭЦ-III дээр БЭТ томилох шийдвэр гаргасан юм бэ? ТЭЦ-III бол өөрөө 100 хувь төрийн өмчит компани. Тэгэхээр төрийн өмчит компани Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө дамжуулаад гүйцэтгэх захирлаа солиод шийдвэрүүдээ гаргаад явах чадамжтай байх ёстой. Төр өөрөө тийм чадамжтай байх ёстой. Гэтэл гэнэт БЭТ томилоод энэ асуудлыг шийдсэн юм шиг болгочоод байгаа юм бэ? Тэгээд таны удирдаж байгаа Засгийн газар ажиллаж чадахгүй байгаа юм биш үү? Таны кабинет таны үгэнд орохгүй байгаа юм биш үү? Би танаас 15 асуулттайгаар эрчим хүчний салбарт болж байгаа бүх бодлогуудыг асуусан.

Г.Занданшатар: Нэгдүгээрт, эрчим хүчний 2 компани татан буулгасан. Цаашдаа эрчим хүчний компаниудын дамжуулахыг хувьчилж болохгүй. Түгээх болон цахилгаан станцуудад олон нийтийн хяналттай болох “public” компани болох ажил хийгдэж байгаа. Миний хэлж байгаа шалтгаанаар аудитлагдсан байх, “IPO” гаргахад шаардах шаардлагуудын процесс нь зуун задгай байгаа учраас хэрэгжихэд хугацаа авч байна.

БЭТ томилохын хувьд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу явагдана. Энд хууль хэрэгжсэн байх практикийг хэрэгжүүлэхгүй бол дэлбэрэлтээс шалтгаалаад эрчим хүчний салбарт онцгой дэглэм тогтоохгүй бол өвлийг өнөтэй давах уу үгүй юу, Улаанбаатар хот хөлдөх үү, үгүй юу гэдэг асуултын тэмдэг тавигдсан байсан. Ингэж онцгой дэглэм тогтоож ТЭЦ-III болон бусад эрчим хүчний салбарууд дээр өндөржүүлсэн бэлэн байдлаар ажилласны.../минут дуусав./

Н.Учрал: Баярлалаа. Жудгийн Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Ерөнхий сайд танаас амьжиргааны өртөгтэй холбоотой дараах асуултыг асууя. Мэдээж Монгол Улсын амьжиргааны өртөг хэдийгээр өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулбал бага боловч бодит орлого нь хэзээ ч түүнтэйгээ нийцдэггүй учраас амьжиргааны өртөг асар өндөртэй гэж тооцогдохоос өөр замгүй болж байгаа. Мэдээж ядуурлын түвшин 418 мянган төгрөг гэж байгаа. Тэгээд 418 мянган төгрөгөөс доош орлоготой өрхийн тоо маш өндөр, иргэдийн тоо бас маш өндөр, ядуурлын түвшин 27 хувьтай байна. Өөрөөр хэлбэл, 913 мянган хүн ядуурлаас доогуур түвшинд амьдарч байна. Сүүлийн 10 жилд ядуурлын түвшин огт буурсангүй. Гэтэл Вьетнам улс 1990 онд ядуурлын түвшин 70 хувьтай байхад тухайн үед манай улс 33 хувь байсан байна.

Гэтэл өнөөдөр Вьетнам улс ядуурлын түвшин 4 хувьтай болсон байхад Монгол Улс нөгөө л 28-27 хувь огт буурахгүй байна. Та эдийн засагч хүн Энгелийн коэффициент гээд мэдэж байгаа. Нийт айл өрхүүд, иргэдийн зардалд эзлэх хүнсний зардал ер нь хэд байгаа юм бэ? Үүнийг гаргадаг юм уу? Эндээс маш их зүйл хамаарах юм байна. Монголд энэ хүнсний зардал асар өндөр байгаа гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл энэ зардал өндөр байна гэдэг бол айл өрх хоол хүнснээс өөр зардал гаргах ямар ч боломжгүй. Юун театрт очиж кино үзэх, юун тэр зугаа цэнгэл байхгүй. Аргагүй шүү дээ. Бараг нэг сая орчим хүн нь 418 мянган төгрөгөөс доош орлоготой амьдарч байхад ямар соёлын зардал гаргах юм бэ?

Тэгэхээр Монгол Улсын Засгийн газарт энэ коэффициентыг зөв болгоход эсвэл энийг ер нь хэмждэг зүйл байна уу? Яаж Монгол Улсыг.../минут дуусав./

Г.Занданшатар: Монгол Улсад амьжиргааны өртгийн өөрчлөлтийг хэрэглээний үнийн индекс буюу инфляцаар тооцдог. Үүнийг санамсаргүй түүврийн аргаар сонгосон нийгмийг төлөөлж чадахуйц 10 мянган өрхийн хэрэглээний багцыг судалж үзээд, тэндээс Монгол айл өрхүүдийн гол хэрэглэдэг 430 бараа, үйлчилгээний үнийг Олон улсын валютын сангийн аргачлал болон олон улсын стандартын дагуу 430 барааны үнийг 1 сагсанд хийж үүгээр инфляцыг тооцдог.

Энэ дотор хүнсний бүтээгдэхүүнээс эхлээд эм, эмийн хэрэгсэл, бусад бараа, үйлчилгээний бүгдийнх нь үнэ орж байгаа. Нэн ялангуяа 2019 оноос хойш, Ковидоос буюу хүнсний бүтээгдэхүүний үнэ 2 дахин нэмэгдсэн. Сая Б.Жаргалан гишүүн хэлээд байсан “атар” талх 2700 төгрөг болсон. Бусад талхнууд тэр үед 400 төгрөг байсан бол 2700 төгрөг болох жишээтэй. Гурилын үнэ бараг 2 дахин өссөн. Дэлхий дахины энэ хямралаас шалтгаалаад тэвээр логистикийн шинжтэй асуудал үүссэн. Үүнээс үүдэн дэлхийн улсуудад инфляц өндөр болсон. Туркийн инфляц 33 хувь, Аргентины инфляц 38 хувьтай байх жишээтэй. Манай улсын хувьд 2 оронтой тоонд барьж байна. Дэлхий нийтээр үнэ өссөн. Монгол хүний хувьд мах, гурил 2-ын үнэ бол хамгийн суурь үнэ байгаа. Өнөөдөр үхрийн мах ястай мах 20 мянга, ясгүй мах 23 мянга орчим төгрөг байгаа. Бид 4 цэгт захыг нээснээр ченжгүйгээр малчид махаа шууд борлуулж эхэлсэн тул үнэ 1 мянга орчим төгрөгөөр буурч байгаа. Махны үнэ бол байнга өсөж ирсэн юм байна. Бараг л 2 дахин өссөн. Тэгэхээр бид 6 сарын 30-нд ажил авснаас хойших хугацааны хооронд үнэ тогтвортой байгаа. Валютын.../минут дуусав./

Ж.Баярмаа: Мэдээж бодит орлого нь амьжиргааны өртгөө яагаад ч гүйцэхээ больсон гэдэг нь тодорхой байгаа. Үндэсний статистикийн хорооноос инфляцыг 8-12 хувийн хооронд хэлбэлзэж байна гэж байгаа. Гэтэл хүнсний инфляц дангаараа 15-20 хувьтай гэж байгаа. Бодит байдал дээр иргэдийн 70-80 хувь нь ядуу амьдарч байна гэж үзэж байгаа. Тэгэхээр таны өргөн барих гэж байгаа Татварын багц хуульд иргэдийн бодит орлогыг дэмжсэн ямар ч зүйл, заалт байхгүй байгаа. Хувь хүний орлогын албан татварыг 1 хувь болгох гэсэн 100 мянган иргэдийн санаачилга, мөн гишүүдийн санаачлаад өргөн барихад бэлдчихсэн байгаа хуулийн төслийг та дэмжих үү? Ингэж байж бодит орлого бага ч гэсэн нэмэгдэж улмаар тэр өртгөө нөхөж чадахгүй байгаа зардал бага ч атугай тэр хамрах хүрээнд нь очих тал дээр та яг ямар бодолтой байгаа юм бэ? Ялангуяа иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд энэ татвар дээр та ямар бодолтой байгаа вэ?

Г.Занданшатар: Иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх зорилгоор НӨАТ-ын буцаан олголтыг 2 дахин нэмэгдүүлж 5 хувьд хүргэх төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Одоогоор 10 дугаар сарын 1-ний өдөр болоод хойшилсон байна. Бодит байдал дээр 5 хувь гэдэг нь үндсэндээ 50 хувиар буцаан олголтыг нэмэгдүүлж байгаа. Инфляцад НӨАТ өөрөө үнэд шингээд явдаг учраас нэг талаас тодорхой хэмжээгээр инфляцад, нөгөө талаас иргэдийн орлогод бодитой нэмэр болно гэж тооцож байгаа. Дундаж орлого 3 сая төгрөг гэж байгаа бол жилдээ 4 ам бүлтэй өрх худалдан авалтын хэмжээгээр 3-4 сая төгрөг

буцаагаад, НӨАТ-ын буцаан олголтоор аваад байх болно. Энэ бол хамгийн бодитой жишээ юм. Бусад хүн амын орлогын албан татвар 1 хувь, бага орлоготой иргэдээ илүү дэмжсэн татварын реформын 3-4 их наяд төгрөгөөр татварын дарамтыг бууруулахад чиглэсэн татварын багц хуулийн төслийг D-parliament дээр тавиад манай Сангийн яам, холбогдох газрууд.../минут дуусав./

Н.Учрал: Далайн Батбаяр гишүүн асуултаа асууя.

Д.Батбаяр: Ерөнхий сайдад энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ илүү мэтгэлцэх гэхээсээ илүү иргэдэд тодорхой мэдээлэл хүргэх зорилготой байгаа учраас би асуултаа тодорхой тоо баримт асуух маягаар тавья. Та бас тодорхой хариулахыг бодоорой.

Амьжиргааны өртөг гэдэг маш өргөн ойлголт. Нутаг дэвсгэрээс авхуулаад хот тосгон гээд байгаа газраас хамаараад амьжиргааны өртгүүд янз бүр байдаг. Тийм учраас би амьжиргааны өртгийг зөвхөн дундаж орлоготой өрхийн хэмжээнд байгаагаар нь асуултуудаа тавья. Нэг ёсондоо дундаж орлоготой өрхийн амьжиргааны өртөг гэсэн үг.

Тэгэхээр 1 дүгээр асуулт нь дундаж орлоготой өрхийн амьжиргааны өртөг яг хэдэн төгрөг байгаа вэ? Өөрөөр хэлбэл хэдэн төгрөгийг 1 сарын хэрэгцээндээ зарцуулбал өнөөдөр Монгол Улсад дундаж орлоготой өрх гэж тооцох вэ? гэсэн асуулт байна. Үүнтэй зэрэгцүүлээд хэрэглээний үнийн индекс гээд 430 барааны талаар та бас түрүүн ярьсан байгаа. Тэгэхээр хэрэглээний үнийн индекс 8.6 хувь өмнөх оны мөн үеэс өссөн гэж бид түрүүн дурдаад өнгөрсөн. Доторх бүтцийг нь харвал эрчим хүчний бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд хамгийн их өссөн байгаад байгаа.

2 дахь анхаарах ёстой асуулт нь үйлчилгээний салбарын зардал маш их өссөн байгаа. Нөгөө талд нь харахаар үйлчилгээний салбарт ажиллаж байгаа ажилчдын цалин нэмэгдээгүй байгаа. Тэгэхээр энэ зардал хаанаас гарч ирээд байгаа юм бэ? Яагаад хэрэглээний үнэд багтаж байгаа үйлчилгээний салбарын зардал өсөж байгаа вэ? гэдэг дээр та хариулт өгнө үү.

Г.Занданшатар: Д.Батбаяр гишүүний асуултад хариулъя. Ер нь амьжиргааны доод түвшин 488-495 мянган төгрөг орчим байхад Үндэсний статистикийн хороо өрхийн дундаж орлогыг 2 сая 970 мянган төгрөг гэж тооцсон. Зарлага нь 3 сая 90 мянган төгрөг гэж байгаа. Өөрөөр хэлбэл дунджаар 120 мянган төгрөгөөр зарлага нь орлогоосоо даваад байгаа чиг хандлагатай байна. Ийм учраас өнөөдөр дундаж өрх сар бүр зээл авах шаардлагатай болж байна гэсэн үг. Үүнийг орлогын бүлгээр нь авч үзвэл нийт өрхийн 60 орчим хувь нь орлогоосоо давсан зарлагатай, 63.8 хувь нь зээлтэй байна. Ирэх жилүүдэд эдийн засгийн өсөлттэй макро түвшинд 6 хувь байж байж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлснээр дундаж давхаргаа өргөжүүлэх, хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулалт хийх, хадгаламжтай болох, үнэт цаас, хувьцаа худалдаж авах боломжтой болох, хуримтлалтай болох, орлого нь зарлагаасаа илүү давж байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн зорилтыг ирэх таван жилийн үндсэн чиглэлд тавьсан байгаа. Өнгөрсөн хугацааны бодлогууд зардал болон инфляцыг

бууруулахад чиглэсэн бол бид эрэлтийн болон нийлүүлэлтийн шинж чанартай инфляцыг хязгаарлахад чиглэгдэж байна.

Үйлчилгээний салбар бүтээмж багатай байдаг салбар. Жишээлбэл, үсчний бүтээмж өдөрт хэдэн хүний үс засна түүгээр хэмжигддэг, нэмэгдэх бололцоогүй. Бусад салбар технологийн дэвшлээр.../минут дуусав./

Н.Учрал: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулиар 37 минут 30 секунд хариулах цаг дууссан байна. Далайн Батбаяр гишүүнд 1 минут нэмж өгье.

Д.Батбаяр: Уян хатан хурлыг удирдаж байгаа Н.Учрал даргадаа их баярлалаа. Тэгэхээр би залгуулаад асууя Ерөнхий сайдаа. Та сая нэг өрх 3 сая 90 мянган төгрөгийн дундаж зардалтай байгаа гэж хэлж байна. Тэгвэл дундаж орлоготой өрхөд энэ зарлагаа даагаад цаана нь өртөг, орлого нь илүү гарч байгаа хуримтлалтай үлдэж байгаа дундаж орлоготой өрх хэдэн хувь байгаа вэ? Энэ дээр Танд тоо байгаа юу?

2 дугаарт нь хэрэв ингээд үлдэгдэлтэй, цаанаа хуримтлалтай үлдэж чадаж байгаа бол үүнийг зөвхөн банканд хадгалуулахаас илүүтэйгээр хөрөнгө оруулалт хийх боломжууд нь юу байгаад байгаа вэ? Таны ойлголтоор энэ “passive income” гэдэг ойлголт ер нь зөв үү буруу юу? Энийг дэмжих ёстой юу үгүй юу? Энэ дээр та тодорхой хариулаад өгөх үү?

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ер нь Монгол Улсын нийт хадгаламжийн хэмжээ 24.3 их наяд төгрөг болсон. Инфляцыг тооцоод бодит хүү 3.8 хувь байгаа. Тэгэхээр бусад үед дандаа буурч байсан бодит орлого энэ жилийн хувьд бодит өсөлт 4 хувь гэж тооцож байгаа. Өөрөөр хэлбэл, инфляцаа орлого нь гүйцэхгүй байгаа. Тийм учраас “passive income” буюу хөрөнгө оруулалт хийх, хадгаламж, хүү, үнэт цаас олох гэх мэт нэмэлт орлого олох боломж нь илүү орлоготой, бодит орлоготой болж байж энэ нөхцөл бүрдэнэ. Ийм учраас үнийн өсөлтийг макро түвшиндээ хязгаарлаж байх нь Засгийн газрын гол зорилго байна. Ингэж байж иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх нөхцөл болно. Үүний тулд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мөн ажлын байр бий болгох, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого ирэх таван жилийн гол бодлого байгаа. Саяын хугацаанд ч гэсэн энэ чиглэлүүдийг барьж байна. Хамгийн гол нь ажил эрхлэлтэд шилжих ёстой. Энэ бэлэн мөнгөний нийлүүлэлтийг дэмжээд энэ.../минут дуусав./

Н.Учрал: Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна. Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 15 минутаас хэтрэхгүй байна. Гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууна. Сархадын Зулпхар гишүүнийг индэрт урья.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Хөвсгөл, Завхан, Увс, Баян-Өлгий аймгийн иргэдээс ирүүлсэн хүсэлт байгаа. Монгол Улсын Газрын тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хуульд нэгдүгээрт, газар олгохтой холбоотой харилцааг цахим хэлбэрт шилжүүлээд, хялбарчлах, хоёрдугаарт, иргэд хүсэлтээ цахимаар гаргах зохицуулалтыг хийж өгсөн.

Нөгөө талаар цахим хэлбэрээр гаргах боломжийг олгосон мөртөө зөвшөөрлийг олгох эрхийг орон нутагт байсныг нь төвлөрүүлсэн байдал үүссэн байна. Өнөөдөр үүнтэй холбоотойгоор иргэд хэдийгээр хүсэлтээ гаргасан боловч дараалалд орсон байдлаар газрынхаа зөвшөөрлийг авч чаддаггүй, эзэмших эрхийн гэрчилгээгээ авч чаддаггүй ийм хүнд суртал үүссэн гэж байна. Иргэдийн хувьд ахуй болон амьдралтайгаа холбоотой газар эзэмших харилцаа нь хүндэрсэн, зарим иргэдийн хувьд бизнесийн харилцаанд орсон байдлаар үүнийг ашиглах зорилготой байдаг. Энэ асуудал дээр үнэхээрийн хүндрэл учирлаа. Цахим шилжилт нэг талдаа сайн юм шиг мөртөө нөгөө талд эрх мэдлийг төвлөрүүлснээс болоод захиргааны хүнд суртал үүсэж байна гэсэн санал, гомдол ирүүллээ. Энийг Ерөнхий сайд, таны Засгийн газар хэдийд яаж шийдэх вэ? гэсэн ийм асуулт байна.

Г.Занданшатар: С.Зулпхар гишүүний санал маш чухал санал, асуудал байгаа юм. Газар бол амьдралын үндэс, улсын ч үндэс. Тийм учраас газрын харилцаа их тодорхой зохицуулах шаардлагатай. Хэт төвлөрүүлснээс болоод нэн ялангуяа аймаг, орон нутаг, сум орон нутгийн газар олголт иргэдийн газар эзэмших эрхэд хүндрэлүүд учирч байгаа.

Ийм учраас бид 7 дугаар сарын 18-ны өдрөөс Засгийн газрын хуралдаанаар Газрын тухай хуульд өөрчлөлт оруулж нэгдүгээрт, хэт төвлөрлийг багасгах, иргэдэд арай хүндрэл чирэгдэл багатай хөдөө, орон нутагт нэн ялангуяа газар олголтыг илүү хялбарчлах, оновчтой болгох, харин газар тариалан, уул уурхай, мал аж ахуй бэлчээрийн газрын нэгдсэн бодлогыг Засгийн газар дээр барьдаг болох асуудлыг хэлэлцсэн. Түүнээс одоо бол газар олголтыг Засгийн газрын хуралдаанаар шийдээд яваад байгаа. Барилга, хот байгуулалтын яамны харьяа байсан Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар Ерөнхий сайдын харьяанд ирсэн. Үүнийг эргээд төвлөрлийг сааруулах үүрэг чиглэл өгсөн. Өнгөрсөн долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар энэ асуудлаар би тодорхой үүрэг чиглэл өгч, газар олголтыг Засгийн газрын түвшинд шийддэг биш аймаг, орон нутгийн түвшинд, тэгэхдээ хяналттай, нээлттэй, ил тод байдлаар шийддэг. Зөвхөн цахимаас гадна бодитоор санал, өргөдлийг авч шийддэг нэн ялангуяа хөдөө, орон нутгийн хүндрэлтэй байдлыг харгалзаж үзэж шийдэх тодорхой зохицуулалт хийх үүрэг даалгавар өгсөн. Энэ чиглэлээр манай Э.Бат-Амгалан сайд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай нар ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа. Үүн дээр С.Зулпхар гишүүний хэлсэн саналуудыг тодорхой тусгаад хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж болно.

Н.Учрал: С.Зулпхар гишүүн тодруулна.

С.Зулпхар: Ерөнхий сайд болон Засгийн газар үүн дээр их шуурхай ажиллаж байгаад талархалтай байна. Бид цахим шилжилтийг хийх ёстой. Нөгөө талдаа цахим шилжилт бол төрийн үйлчилгээг заримдаа авч байгаа иргэдийн хувьд бэрхшээл учруулдаг. Энэ нь цахим соёл, цахим хэрэглээтэй холбоотой. Тодорхой бүлгүүдийн хувьд хүндрэл учруулдаг. Энийг цаашид анхаарна гэж ойлголоо.

2 дугаарт, бүх юм төвлөрч байгаа нь нэг талдаа мэдээллийн системийн хувьд зөв боловч яг шийдвэр гаргах түвшинд анхан шатын нэгжид шийдвэр гаргах эрхийг нь олгож байх нь зөв байна гэсэн сургамж болж байна. Энэ дээр та тууштай ажиллах юм байна гэж ойлголоо. Зөв үү?

Г.Занданшатар: Ер нь цахимжилтыг огт үгүйсгэж болохгүй. Цахим хүсэлт нэвтрүүлснээр иргэдээс шаарддаг 18 төрлийн цаасан баримт бичиг, материал цуглуулах хүндрэл арилж, улсын хэмжээнд 18169 иргэн цахимаар газар авах хүсэлтээ тавьж шийдвэрлүүлсэн байгаа. Одоогийн хуульд ч гэсэн Засаг дарга газар олголтын ерөнхий дарааллыг хөндөх эрхгүй ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй, амьжиргааны түвшин доогуур зэрэг тусгай хэрэгцээт иргэдийг дэмжих, цахим үйлчилгээний хүртээмжийг хангах хууль, эрх зүйн болон зохицуулалтын 3 боломж байгаа.

1 дүгээрт, цахим хүсэлт гаргах боломж. 2 дугаарт нь Засаг даргын түвшинд тусгайлан газар олгох эрх хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, улс, нийслэлийн хөрөнгө оруулалт болон олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд газар эзэмших эрх олгоход дарааллын зохицуулалт хамаарахгүй гэж заасан. Үүнд Засаг даргын эрх байгаа. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нар нэгдсэн бодлого, шийдвэрийн хүрээнд уг заалтыг үндэслээд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, амьжиргааны түвшин доогуур хүрэхийн гишүүдэд нэн тэр... /минут дуусав./

Н.Учрал: Тодруулж дууссан. Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Өдрийн амгаланг айлтгая. Юуны өмнө 9 сард цаг гаргаж уулзсанд баярлалаа. Тухайн үед Танд утааг шийдэх боломж болон шийдэл тэгээд хэдий хэмжээний санхүүжилт хэрэгтэй, жил болгон байшин гэрийг дулаалах арга хэмжээг хэрэгжүүлснээр цаашдаа 2028 он гэхэд нийслэлийн агаарын бохирдол 50-аас дээш хувиар буурах боломжтой байна гэсэн шийдлийг танилцуулсан. Тэгээд энэ хүрээнд Танд өнөөдөр 2 зүйл дээр асуулга явуулсан. Эхнийх нь 2017 онд батлагдсан Засгийн газрын 98 дугаар тогтоолоор агаарын бохирдлыг шийднэ гээд 8 жилийн хөтөлбөр боловсруулсан.

2 дугаарт хаврын чуулганаар миний бие ажлын хэсгийг ахалж, Улсын Их Хурлын 2025 оны 57 дугаар тогтоолыг батлуулсан. Энэ 2 тогтоолын хэрэгжилтийн талаар танаас асууя гэж бодож байна.

Засгийн газрын 98 дугаар тогтоолын 4.1.2-т нийслэлийн гэр хорооллын тэлэлтийг зогсоож, яндангийн тоог нэмэгдүүлэхгүй.

4.1.6.Цахилгаан халаагуур ашиглах техникийн боломжийг бүрдүүлэх гэж тусгасан боловч гэж тусгасан боловч өнөөдөр цахилгаан халаагуурт шилжээд утааг бууруулж байгаа өрхүүдийн цахилгаан нь хангалтгүй байна, чанар нь хүрэлцэхгүй байна гэсэн асуудлууд их байна.

4.2.6.Гэр, байшингийн дулаалгыг сайжруулж дулааны алдагдлыг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ гэсэн Засгийн газрын зүгээс бодитой төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй гэж ойлгож байна. Миний хувьд сүүлийн 3 сарын хугацаанд Улаанбаатар хотын төвийн 6 дүүргүүдээр тойроод явж байна. Маргаашаас Сонгинохайрхан дүүргээр явж дулаалах зөв мэдлэг, мэдээллийг мэргэжлийн байгууллагууд олон улсын холбооны байгууллагуудаас хүргүүлье гэсэн байдлаар та бүхний ажлыг дэмжээд явж байна.

“Эрчим хүч хэмнэх” үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, дээрээс нь Хот байгуулалтын яамнаас агаарын бохирдлыг бууруулах дотоодын үйлдвэрлэлд татварын хөнгөлөлт үзүүлэх талаар Сангийн сайдад бичиг хүргүүлсэн байгаа гэж ойлгосон. Энэ шийдэл хэзээ гарахаар байгаа бол?

4.5.5.Агаар орчны бохирдлын улмаас үүсэх өвчлөлийг бууруулна гэсэн зорилтыг тавьсан.

5.1.Агаарын бохирдлыг 80-аас дээш хувиар бууруулна гэсэн 8 жилийн хөтөлбөр дээр зорилгын шалгуур үзүүлэлтийг тавьсан байгаа. Өнөөдөр.../минут дуусав./

Г.Занданшатар: Ногоон санхүүжилтийг дэмжих, ногоон шилжилтийг дэмжих, нэн ялангуяа манайх шиг агаарын бохирдол ихтэй улс, ялангуяа Улаанбаатар хотын хувьд цогц бодлого хэрэгтэй. Зөвхөн санхүүжилтийн эрх зүйн орчноос гадна бид урт хугацааны орон сууцжуулах, дунд хугацааны түлш болон дулаалгын цогц шийдэл хийх, ойрын хугацаанд агаарын бохирдлыг бууруулах шилжилт шинэчлэлүүд шаардлагатай байгаа. Тэгэхээр Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи баримт бичгийг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, бусад байгууллагуудыг оролцуулан байгуулан ажиллаж байгаа. Одоогийн ангилал шалгуурыг Зүүн өмнөд Ази болон Европын холбооны таксономитой харьцуулсан судалгаа хийж байна.

Энэ талаар бид Сингапуртай карбон кредитийн гэрээ байгуулан ажиллаж байгаа. Энэ бол ногоон шилжилтэд ногоон санхүүжилтийг олж авахад дулаалга ч тэр, ногоон орон сууц мөн адил, товчхондоо Улаанбаатарын агаарын бохирдлыг бууруулах, утааг бууруулах карбон гаралтыг бууруулах, яндангийн тоог бууруулах цогц шийдэл хэрэгтэй байна. Энэ чиглэлээр банк бус санхүүгийн байгууллагууд байгуулагдаад карбон кредитийн ажил хийж байгаа. Үүнийг орон сууцжуулалтын банктай холбож шийдэхээр төлөвлөж ажиллаж байна.

Үүнд татварын хөнгөлөлт бол ногоон барилга, дулаалгыг дэмжсэн өрх айлуудад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэг хуулийн зохицуулалтыг

Хувь хүний орлогын албан татварын хуулийн төсөлд оруулсан. Ер нь ногоон барилгын стандартад нийцсэн орон сууц худалдан авах, барих үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт үзүүлэх асуудал манай татварын реформын ажлын хэсэгт байгаа. Гэр хорооллын айл өрх дулааны алдагдлыг бууруулах.../минут дуусав./

Н.Учрал: Нэмэлт тодруулга 1 минут Г.Лувсанжамц гишүүнд өгье.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Ажлын хэсэг ажиллаж байгаа юм байна гэж ойлголоо. Карбон кредитээ хэрэгжүүлнэ гэдгийг дэмжиж байна. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэхийн тулд бид хэмжих, тайлагнах, баталгаажуулах буюу “MRB” тогтолцоо нь байх ёстой. Засгийн газрын 57 дугаар тогтоолд үүнийг хэрэгжүүл гээд үүрэг өгсөн байгаа. Сингапур дээр бид хэдийгээр хэлэлцээр хийж байгаа боловч үндэсний “MRB” байхгүй байвал карбон кредитийг хэрэгжүүлэх боломжгүй байх. Тэгэхлээр үүн дээр хэрхэн ажиллаж байгаа вэ? Сангийн яаманд гаргалгаа байгаа юм болов уу? Байхгүй бол үүн дээр дэмжиж ажиллахад бэлэн байна. Татварын хууль дээр байшин, гэрээ дулаалсан өрхүүдэд татварын буцаан олголтыг олгоно гэсэн заалт туссан байгаад баяртай байна. Тэгээд энэ чуулганы хугацаанд багтаад үүнийг батлах боломжтой байгаа болов уу?

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Г.Лувсанжамц гишүүнтэй санал нэг байна. Маш зөв. Гэхдээ энэ уур амьсгалын өөрчлөлт болон карбон зах зээлийн дэлхий нийтийн чиг хандлагатай уялдуулаад явбал санхүүжилтийн болон ногоон шилжилтийн бодлого цогцоороо шийдэгдэх, дэмжлэг туслалцаа авах, ирэх жил болох дэлхийн цөлжилтийн эсрэг “COP-17” зохион байгуулахад нэг хэсэг нь болгож ажиллах зорилгоор ажлууд явж байгаа.

Тэгэхдээ Сангийн яам биш Эдийн засаг, хөгжлийн яам дээр уур амьсгалын өөрчлөлт ба карбон зах зээлийн хүрээнд Монгол Улсад агаарын чанарыг сайжруулах мастер төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлсэн. Ялангуяа гэр хорооллын дулаалгын асуудал ч гэсэн тэргүүлэх ач холбогдолтой орж байгаа. БНСУ-тай, Сингапуртай, Швейцартай Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулж, хэрэгжилтийг хангах хамтарсан хороо байгуулахаар төлөвлөсөн. Энэ нь карбон зах зээлийн бүртгэлийн механизмыг бий болгох суурь болно. Энэ бүртгэлийн механизм нь хэмжинэ, тайлагнана гэдэг бол смарт буюу бүх төлөвлөлтийн суурь зарчмууд байгаа. Мэжурибл майнинг.../минут дуусав./

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байна уу? Манай улс ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх талаар хууль тогтоомжтой. Үүн дээр Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлд олон хувилбарыг тусгасан байгаа. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал гээд хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхлыг хориглоно гэж заасан байгаа. Гэсэн хэдий ч хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй

нийт хүмүүсийн дөнгөж 10 хувь нь өнөөдөр хөдөлмөр эрхэлж байгаа. Засгийн газрын төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ гэсэн төлөвлөгөө оруулсан байгаа. Энэ дээр ямар арга хэмжээг авахаар төлөвлөж байна вэ? гэдэг нэгдүгээр асуулт байгаа.

2 дугаарт нь Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.1-д гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого дотор хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангана гэсэн заалт байгаа. Яг энэ заалтын хүрээнд одоо манай Засгийн газарт ямар төлөвлөгөөг боловсруулсан бэ? Яагаад гэвэл 2026 оны төлөвлөгөөнөөс энэ асуудалтай холбоотой арга хэмжээг олж хараагүй. Мөн 2024 оны ажлын тайлан дээр тухайлсан ажлуудыг олж хараагүй.

3 дугаар асуулт нь Ерөнхий сайд та хөгжлийн бэрхшээлтэй хүнийг, тэргэнцэртэй нэг хүнийг дагуулаад хотын хамгийн ээлтэй ямар төрийн үйлчилгээгээр орох вэ? Мөн ямар хувийн хэвшлийн үйлчилгээгээр дагуулж орж өдрийн хоолонд орж юм ярьж суух вэ?

Г.Занданшатар: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 48 холбооноос хамтраад надад хүсэлт тавьсан. 12 дугаар сарын 03-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр гэдгийг та мэдэж байгаа байх. Тэрний өмнө бид энэ талаар яриа хэлэлцүүлгүүд өрнүүлж холбогдох асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа. Гол нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар төвлөрч байгаа. Энэ талаар манай Т.Аубакир сайд бид 2 ярилцаад Засгийн газартай шууд хамтарч ажиллая гэсэн санал тавьсан байгаа.

Боловсролын ерөнхий хуульд жишээлбэл боловсрол дээр ялгаварлахгүй, тэгш, хүртээмжтэй, гадуурхгүй, нээлттэй байх зарчмыг баримталж, бүх иргэнд боловсрол эзэмших эрхийг тэгш хүртээмжтэй болгоно гэж заасан. Энэ дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт 86 хувьд хүрсэн. Санхүүжилт бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, малчин өрхийн хүүхэд зэрэг ялгаатай хэрэгцээтэй сурагчид ногдох хувьсах зардлыг 3 дахин нэмэгдүүлж санхүүжүүлж байна. Ганцаарчилсан сургалт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамран сургах тойрог харгалзахгүйгээр боловсролын үйлчилгээ үзүүлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Энэ дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийт хүүхдүүдэд тэгш боломж олгож байгаа зүйл Засгийн газраас medlee.mn цахим сургуулийг байгуулсан. Энэ цахим сургууль бол ахлах ангийн сонгон сурах, судлах хичээлийн багшийн хүрэлцээгүй байдлыг арилгах, хөдөө орон нутагт болон хилийн чанад дахь Монгол хүүхдүүд, тэр дотроо бас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хэл заслын сургалт зэрэгт хамрагдах тэгш боломжийг олгож байгаа.

Боловсрол нөхөн олгох сургалтад 4241 сурагч хамрагдаж байна гэсэн тоо баримт байна. Үүний 392 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна. Цаашдын төлөвлөгөө бол.../минут дуусав./

Н.Учрал: Нийт хугацаа дууссан байна. 15 минутаас хэтрэхгүй байна гэсэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуультай. О.Саранчулуун гишүүнд баярлалаа.

Гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо үргэлжлээд Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүд асуулт асууж, хариулт авна. Нийт хугацаа 30 минутаас хэтрэхгүй байна. Ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууна. Пүрэвжавын Ганзориг гишүүн асуултаа асууна уу.

П.Ганзориг: Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, нийт гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөлөөс тодорхой 2 асуудлаар урьдчилсан хүргүүлсний дагуу би өнөөдөр тодорхой асуултуудыг асууя гээд бэлдсэн байгаа.

1 дүгээрт, Монгол Улсын 2026-2030 оны хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болох хөгжлийн чухал баримт бичгийг Улсын Их Хурлаар батлахаар хэлэлцээд явж байна. Энэ нь Монгол Улсын хамгийн том гадаад худалдааны эргэлт уул уурхайн бүтээгдэхүүний экспортын гол түнш болсон БНХАУ-ын өнгөрсөн 10 сард батлагдсан XV таван жилийн төлөвлөгөөтэй тодорхой асуудлууд нь, экспортын чиглэл дээр уялдсан болов уу? гэсэн эхнийхээ асуултуудаа асууя.

2 дугаарт, Хятадын энэ таван жилийн төлөвлөгөөнд БНХАУ нүүрсний хэрэглээг бууруулах бодлого хэрэгжүүлэхээр тусгасан. Тэгэхээр Монгол Улс нүүрсний экспортын эрэлтэд дунд, урт хугацаанд сөргөөр нөлөөлөхөөр байна гэж харагдаж байгаа. Тэгэхээр уг нөлөөллийг энэ таван жилийн төлөвлөгөөнд ер нь яаж тусгасан бэ? Ер нь Засгийн газар энэ дээр бас ямархуу бодлого, чиглэл барьж ажиллаж байгаа вэ? гэдэг эхний асуултаа асууя.

Н.Учрал: П.Ганзориг гишүүнээ, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар асуулт хариулт 30 минутаас хэтрэхгүй байна гээд цөөнхийн гишүүдэд хуваарилсан байна. Тэгээд 2-хон гишүүний нэр ирсэн учраас асуултаа асуугаад, тодруулах нэмэлт 1 минут асууж болох юм байна. Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: П.Ганзориг гишүүний асуултад хариулъя. Ер нь бид энэ үндсэн чиглэлийг боловсруулахдаа Монгол Улсын нүүрсний экспортын гол зах зээл болох БНХАУ-ын зах зээлийн нөхцөл байдал, таамаглалыг суурь тооцоонд тусгасан. Манай холбогдох яам, судлаачдын дунд хугацааны эрэлтийн таамаглалаар БНХАУ-ын нүүрсний хэрэглээ 2030 он хүртэл одоогийнхоо есөлтийг хадгална. Түүнээс хойш аажмаар буурах хандлагатай байгаа. Иймд Монгол Улсын 2026-2030 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд гадаад эрэлтийг үүн дээр тооцоод хангалттай гэж үнэлсэн. Үүнийг практик алхам болгож бид БНХАУ-ын Ерөнхий сайд Ли Чянтай сая уулзахдаа 2 улсын төрийн

тэргүүн нарын түвшинд хүрсэн гадаад худалдааг 20 тэрбум ам.долларт хүргэх зорилгоор нүүрсний экспортыг 100 сая тоннд хүргэж хадгалах гэсэн энэ зорилтоо ярилцаж, зарчмын хувьд тохиролцож ажиллаж байна.

Сүүлийн 10 жилд Хятад Улсын нүүрсний импорт 147 хувиар өсөж, 48 сая тонноос 122.3 сая тонн болж нэмэгдсэн. Хятад улсад уул уурхайд тавигдаж байгаа дотоод хяналт шалгалт чангарсан тул олборлолт буурсан байдаг.

Хятад Улсын XV таван жилийн төлөвлөгөө нь ирэх 3 сард батлагдана. Үүнийг бүс нутгийн интегралчлал, эдийн засгийн интегралчлалтай уялдуулъя, хил боомт, хамтын ажиллагааны хүрээнд уялдуулъя гэдэг саналыг бид БНХАУ-ын Засгийн газарт тавьж ажиллаж байна. Мэдээж бүс нутгийн интегралчлал, дэд бүтэц, бүх хөгжил бол бүс нутгийн интегралчлалд нэгдэж, харилцан уялдаж байж үр дүнтэй, бодитой хэрэгжинэ. Ийм зорилгоор үүнийг уялдуулах саналыг тавьж манай Шинэ итгэл, эрс шинэчлэл гэдэг таван жилийн үндсэн чиглэлийг нэр дурдаж байгаад уялдуулах талаар бас.../минут дуусав./

П.Ганзориг: Үүнтэй холбоотойгоор Монгол Улс экспортынхоо бүтцээ төрөлжүүлэх ялангуяа уул уурхайгаас хэт хамаарлыг бууруулах чиглэлээр хөдөө аж ахуйн салбарт жишээлбэл нэлээдгүй хэмжээний хөнгөлөлттэй зээл, татаас, дэмжлэг өгч ажиллаж байгаа. Энэ нь яг бодитой үр дүнгээ өгч байна уу үгүй юу гэдэг нь ялангуяа ажлын байрыг нэмэгдүүлж байна уу, экспортын орлогыг өсгөж байна уу гэдэг нь тодорхойгүй байгаа тул маш нарийн үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай байгаа. Тэгэхээр түүхийн бүтээгдэхүүнийг боловсруулаад нэмүү өртөг шингээгээд экспортлох талаар ямар чиглэлийн үйлдвэрүүдийг тухайлбал хэзээ оруулаад ямар хэмжээний бүтээгдэхүүнийг экспортолно гэж тооцож байгаа вэ? Энэ дээр тодорхой хариулт өгөөч гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Манайх уламжлалт экспортын бүтээгдэхүүнүүдээ сэргээж хөгжүүлэх зорилтын хүрээнд ноос, ноолуур, арьс шир, мах, махан бүтээгдэхүүн бас дэлхийд өрсөлдөх чадвартай, органик шинэ төрлийн зах зээл болгож хөгжүүлэх зорилт тавьж байгаа. Яг энэ 3 бүтээгдэхүүнийг экспортолъя гэдэг зорилгоор хамаарал бүхий 347 нэр төрлийн бүтээгдэхүүнийг Евро Азийн 183 сая хүнтэй 2 триллион ам.долларын зах зээлд экспортлох зорилгоор энэ гэрээг манай талын хүсэлтээр тавьж шийдвэрлэсэн. Зарчмын хувьд шийдэл нь гараад явж байна.

Энэ гэрээ хүчин төгөлдөр болоод мөрдөгдөөд ирэхэд манай дайвар бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос, ноолуурын үйлдвэрлэл 100-аас дээш хувиар өснө гэсэн симуляц таамаглалтай. Өөрөөр хэлбэл зах зээлийн тодорхой хэсэгт манайх өрсөлдөх чадвар, органик чанар, стандартад нийцсэн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх замаар Евро Азийн эдийн засгийн холбооны худалдааны төрөл зээлээр уул уурхайн.../минут дуусав./

Н.Учрал: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар хуралдаанд нэрсээ ирүүлсэн гишүүд 2 минут асуугаад 1 минут тодруулна. Өмнө нь болохоор бүлгийн даргаа цөөнхийн бүлгийн даргыг төлөөлж Б.Жаргалан гишүүн 75 минут мэтгэлцсэн байна.

Д.Ганзориг гишүүн асуулт асууя.

П.Ганзориг: Экспортын төрөлжилттэй холбоотой манай Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний асар их нөөцтэй. Тэгээд Хятадын XV таван жилийн төлөвлөгөөний хувьд коммунист намынхаа хурлаар ерөнхийдөө үндсэн чиглэлээ баталсан. Энэ дээр ногоон эрчим хүч, дижитал эдийн засаг, өндөр технологи, логистикийн салбарууд гээд салбарууддаа нэлээд хэмжээний хөрөнгө оруулалтууд хийж бодлого чиглэлээ түүнд чиглүүлж ажиллана гэж заасан. Тэгэхээр манай Монгол Улсын хувьд эрчим хүчээр дотоодынхоо хэрэгцээг хангаад, цаашлаад эрчим хүчнийхээ, ялангуяа сэргээгдэх эрчим хүчнийхээ нөөцийг ашиглаж, экспортын шинэ бүтэц салбар үүсгэж ажиллах бодлого, чиглэлд Засгийн газар ямар бодлоготой байгаа вэ? Хэзээнээс энэ ногоон эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчний экспортыг ямар байдлаар хийнэ гэж бодож байгаа вэ?

Г.Занданшатар: Монгол Улс БНХАУ-ын ногоон дижитал шилжилт хөгжлийн бодлогын хүрээнд уялдуулаад уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр 3 салбарт онцгой ач холбогдол өгч ажиллаж байна.

1 дүгээрт, ногоон эрчим хүч. Бид Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд эрчим хүчний экспортын хэмжээг 10 гигабайтад хүргэхээр төлөвлөсөн. Санхүүжилтийг нь нүүрстөрөгчийн кредит, карбон кредит сая Сингапуртай гэрээ байгуулсан. Одоо Швейцартай байгуулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд ногоон эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэх замаар Шадар сайд бас нэлээн идэвхтэй ажиллаж байгаа.

Дижитал эдийн засаг, логистикийн хүрээнд бид хиймэл оюун ухаан, дата төв, дижитал эдийн засгийн чиглэлээр хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Монголын давуу талыг ашиглаж эрчим хүчний үйлдвэрлэл сайжирвал түүнтэй нийцсэн дата төв, дата центрүүдийг барьж байгуулах чиглэлээр хамтран ажиллах бололцоо гарах юм байна.

2 дахь үндсэн чиглэл нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын баталгаажуулалтыг хийж хэрэгжүүлснээр энэ чиглэлийн экспортоо нэмэгдүүлэхэд анхаарч байна. Одоо махны экспорт гэхэд эрс нэмэгдэж 170 сая ам.долларт хүрээд байна. Энэ жил 280 сая ам.доллар хүргэхээр төлөвлөөд махны экспортыг хийж байна. Ноос, ноолууран бүтээгдэхүүн, нэмүү өртөг шингээгээд самнасан ноолуурын экспорт 247 сая ам.долларт хүрсэн. Энэ нь уул уурхайн бүтээгдэхүүнтэй хамт экспортоо төрөлжүүлэх эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг бид ирэх таван жилд эрчим хүч экспортлогч, хүнс экспортлогч улс болгох зорилгод нийцэх юм.

Н.Учрал: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиа баримтална. Улсын Их Хурлын асуулгын нийт хугацаа 2 цагаас хэтрэхгүй. Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах хугацаа цөөнхийн бүлэгт 75, олонхын бүлэгт 15, цөөнхийн гишүүд 30 минут гэж заасан. Цөөнхийн бүлэгт ногдсон хугацааны 2-ны 1 хүртэлх хугацааг бүлгийн дарга, бусдыг нь гишүүд, дээрээс нь 112.2 буюу бүлгийн цуварсан асуултын тоог 9-өөс хэтрүүлэхгүй гээд

Б.Жаргалан гишүүн сая 8 асуулт асуулаа. Үлдсэн цөөн бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс нэрсээ ирүүлсэн байдлаараа 30 минутад багтаагаад гишүүд нь асуух ёстой. Д.Ганзориг гишүүн л нэрээ ирүүлсэн байгаа юм. Хуульдаа ингээд заачихсан учраас би сая Танд бас нэмээд өгчихлөө. Тэгэхээр нэмэлт асуултуудаа та Ерөнхий сайдаас тухайлан асуугаад тодруулаад явахыг хүсье. П.Ганзориг гишүүн хуулийг ойлгож байгаа байх гэж бодож байна. Тэгээд Ерөнхий сайдыг дагаад П.Ганзориг гишүүн өөрөө үлдсэн 8 асуултаа асууна. Зарим асуултуудаа өрөөнд нь ороод асууж болж байна, утсаар холбогдон асууж болж байна. Ийм олон хэлбэрүүд байна.

Ингээд гишүүдэд ирцэд бүртгэгдсэн дарааллын дагуу гишүүд асуултаа Ерөнхий сайдаас авсан. Улсын Их Хурлын асуулгын цаг дууслаа. Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Танд талархаж байгаагаа илэрхийлье. Амжилт хүсье.

--oOo--

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ

4.1. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 12 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-ИЙН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 75 гишүүн хүрэлцэн ирж, 59.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 15 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Тусгайлан бэлтгэсэн индрээс Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар нар цуварсан асуулт, хариултаар мэтгэлцэв.

Мөн тусгайлан бэлтгэсэн индрээс Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө бичгээр ирүүлсэн гишүүд болох Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, С.Цэнгүүн, Л.Мөнхбаясгалан, Да.Цогтбаатар, Ч.Лодойсамбуу, Б.Жаргалан, Ж.Баясгалан, Улсын Их Хурал дахь олонхын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа нарын тавьсан асуултад тусгайлан бэлтгэсэн индрээс Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир нар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 15 цаг 36 минутад хэлэлцэж дуусаав.

4.2.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДРИЙН “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-Т УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН ЕРӨНХИЙ САЙДААС АСУУСАН АСУУЛТУУД

№	Улсын Их Хурлын гишүүн	Асуулт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ		
1	О.Цогтгэрэл	2025: Унасан эдийн засаг, уруудсан итгэл: Та Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд 2025 оныг дүгнэж хэлээч?
2	Ж.Баясгалан	1.Эм ханган нийлүүлэх байгууллагуудаас эмнэлгүүдэд нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн үнээ авч чадахгүй байгаагаас үүдэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ доголдох нөхцөл байдал үүсээд нэлээд хэдэн сар боллоо. Энэ талаар Засгийн газраас ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа вэ, хэзээ хэвийн байдалд орох вэ? 2.Шатахуун, түлшний хомсдол хот, хөдөөгүй үүсэж, иргэдийг бухимдуулаад удаж байна. Энэ байдал хэзээ цэгцрэх вэ?
3	Б.Жаргалан	Монгол Улсын төсвийн орлого уул уурхайн бүтээгдэхүүн тэр дундаа нүүрснээс хамааралтай. Дэлхийн зах зээл, ялангуяа нүүрсний үнэ, эрэлт өөрчлөгдвөл манай улсын төсвийн орлого, төгрөгийн ханш, инфляц зэрэг бүгд савлах эрсдэлтэй. 2025-2026 онд уул уурхайгаас хамаарах хамаарлаа бууруулах бодит шийдэл тань юу вэ?
4	Ч.Лодойсамбуу	Манай улсын инфляц удаан хугацаанд өндөр түвшинд үргэлжилж буй шалтгааныг хэрхэн дүгнэж байна вэ? Цаашид инфляцыг бууруулахад чиглэсэн ямар бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна вэ?
5	Л.Мөнхбаясгалан	2025: Унасан эдийн засаг, уруудсан итгэл: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах вэ?
6	Д.Цогтбаатар	16 дэд сайд нарыг томилсноор эдийн засгийн үзүүлэлт сайжрах уу?
7	С.Цэнгүүн	1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.1.1-д Эдийн засгийн өсөлтийг жил бүр 6 ба түүнээс дээш хувьд тогтвортой байлгах, инфляцыг 5 хувиас бага түвшинд хадгалах бодлогыг баримталж, гадаад валютын нөөцийг 10 тэрбум ам.доллар хүртэл нэмэгдүүлнэ гэж тусгагдсан. Үүний хэрэгжилтийн талаар: 2.Уг хөтөлбөрийн 3.1.2.3-т Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлнэ гэж тусгагдсан. Үүний хэрэгжилт, нэг хүнд ногдох Засгийн газрын гадаад өрийн хэмжээ, өрийн өсөлтийн талаар; 3.Хөтөлбөрийн 3.1.2.4-т Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын

	<p>менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ гэж тусгагдсан. Үүний хэрэгжилтийн талаар дараах асуултауд:</p> <p>3.1.Засгийн газраас Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн. Үүний хүрээнд бүхэлд нь худалдах 8 компанийг ямар шалтгаан нөхцөл, баримтад үндэслэж хэрхэн сонгосон бэ? Энэ худалдан авах ажиллагаанд оролцогчдод ямар нэгэн шалгуур, хязгаарлалт байгаа юу? Худалдах ТӨК-уудын үнэлгээг хэрхэн тогтоох вэ? Энэ үнэлгээг тогтооход хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, хараат бус шинжээч оролцуулах боломжтой юу? Худалдах компаниудын хөрөнгийг үнэгүйдүүлэх, төрд ирэх ашгийг бууруулахгүй байхад чиглэсэн ямар арга хэмжээ авч ажиллах вэ? Дээрх компаниудыг худалдсан орлогыг хаана төвлөрүүлэх вэ? Үүнээс олсон орлогыг юунд зарцуулах вэ? Уг компаниудын худалдан авагчид цаашид тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, тухайн чиглэлээр ажиллуулахгүй байх боломжтой юу? Тухайн компани үндсэн чиглэлээрээ үйл ажиллагаа явуулахаа болиход иргэд, олон нийт тухайн үйлчилгээг авч чадахгүй болох, тэр чиглэлээр аж ахуй нэгжүүд үйл ажиллагаа явуулахад эдийн засгийн үр ашиггүй байх нөхцөл үүсэх үү?</p> <p>3.2.Долоон төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, нийлүүлэх, бүтцийн өөрчлөлт хийхээр төлөвлөсөн байна. Ямар компаниудыг хэрхэн нэгтгэж, ямар бүтцийн өөрчлөлт хийх вэ? Эдгээр компаниудыг нэгтгэх үндэслэл юу вэ? Яагаад худалдах, хувьцааг нээлттэй худалдахаар төлөвлөөгүй вэ? Эдгээр компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хэрхэн томилох эсвэл сонгон шалгаруулах вэ? Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавих шалгуур, шаардлага ямар байх вэ? Цаашлаад гүйцэтгэх захирлыг хэрхэн сонгон шалгаруулах, ямар шаардлага тавих вэ? Гүйцэтгэх захирлын бие даасан байдлыг хэрхэн баталгаажуулах вэ? Бүтцийн өөрчлөлтөөр хэдэн ажилтныг цомхотгох вэ? Үүнд ямар түвшний ажилчид түлхүү хамрагдах вэ? Бүтцийн өөрчлөлт оновчтой чиг үүргийн давхардалгүй, үр ашигт суурилсан байхад хэрхэн анхаарч, ямар аргачлалаар хэрэгжүүлэх вэ? Үүнд улс төрийн нөлөөллийг хэрхэн хязгаарлах вэ?</p> <p>3.3. Арван найман төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын төрийн мэдлийн 10-66 хүртэлх хувийн хувьцааг олон нийтэд хөрөнгийн биржээр дамжуулан санал болгон худалдахаар төлөвлөсөн байна. Иргэн, аж ахуй нэгжийн худалдан авах хувьцааны хэмжээнд нэг хувьцаа эзэмшигч 5 хүртэлх хувийн хувьцааг худалдан авч болно гэх мэт хязгаарлалт тавих уу? гаднын улсын иргэд, гадаад улсад бүртгэлтэй аж ахуй нэгж энэхүү ТӨК-уудын хувьцааг худалдан авах боломжтой байх уу?</p>
--	---

	<p>34 хүртэлх буюу хяналтын багцад хүрэхгүй жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрхэн хамгаалах вэ? 50 хүртэлх хувийн хувьцааг нь олон нийтэд худалдсан компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирлыг хэрхэн сонгон шалгаруулах вэ? Энэ компаниудын хувьцаа эзэмшигчдийн хяналтын эрх, хяналтын чиг үүргийг хэрхэн баталгаажуулах вэ? 51-ээс дээш хувийн хувьцааг нь олон нийтэд худалдсан компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хэрхэн сонгон шалгаруулах вэ? Төрийн өмчийн хувьцааг төлөөлөх төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хэрхэн сонгон шалгаруулах вэ? Сонгон шалгаруулалтын хараат бус, бие даасан байдлыг хэрхэн хангах вэ? Төрийн өмчийн хувьцааг үнэгүйдүүлэхгүй байх, тогтмол ашиг хүртдэг байх, төрийн өмчийн хувьцааг төлөөлж буй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн төрийн өмчийн эрх ашгийг бодитой хамгаалах, ашиг сонирхлын зөрчил, нөлөөнд автахгүй байх талаар ямар зохицуулалт, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ? Дулааны цахилгаан станц зэрэг үнийг нь төрөөс зохицуулдаг компаниудын хувьцааг худалдан авах зах зээлийн эрэлт ямар байгаа вэ? Үүнийг хэрхэн тооцсон бэ? Үнийг нь төрөөс зохицуулж байгаатай холбоотойгоор эдгээр компаниуд ашигтай ажиллах, хувьцаа эзэмшигчид ашиг хүртэх боломжтой юу? Ямар тооцоолол хийсэн бэ? Нээлттэй хувьцаат компаниудад гаднын менежментийн баг сонгон шалгаруулах талаар ямар байр суурьтай байна вэ?</p> <p>3.4.Дээрх шинэчлэлийг хийснээр төрийн өмчит компанийн ажилчдын тоо хэдэн хувиар буюу хэдээр буурах вэ? Төрийн өмчит компанийн дунд, дундаас дээш удирдах түвшний ажилчдын тоо хэдэн хувиар буурч нийт ажилчдад эзлэх хувь одоо хэд байгаагаас хэд болж өөрчлөгдөх вэ? Ингэснээр хэдэн төгрөгийн төсөв хэмнэх бэ? Цомхотголд орсон ажилчдад нөхөн олговор олгох уу? Ямар хэмжээний нөхөн олговор олгохоор төлөвлөж байгаа болон тэр нь тухайн компанийн санхүүд хүндрэл үүсгэх үү?</p> <p>3.5.Бусад компаниудыг бүхэлд нь худалдаагүй, тодорхой хувийн хувьцааг нээлттэй худалдаагүй, нэгтгээгүй шалтгаан юу вэ? Өөрчлөлт оруулаагүй үлдсэн болон нийт ТӨК-уудын менежментийн шинэчлэл, бие даасан байдлыг хэрхэн хангах вэ? Компанийн удирдлагын бие даасан байдлыг хангах, шаардлагагүй үрэлгэн зардал, орон тоог бууруулах, үр ашигтай ажиллах чиглэлээр ямар бодлого баримталж, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ? Төрийн өмчит компанийн төрийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь ямар байгууллага эсхүл албан тушаалтан байх вэ?</p> <p>3.6.Аймаг, нийслэл, сум дүүргүүд орон нутгийн өмчит компани байгуулж улс төр, хувийн эрх ашгийг хангах чиглэлд ажиллаж байгаатай санал нийлэх үү? Орон нутгийн ТӨК-уудын талаар ямар бодлого баримталж байна вэ? Цаашид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ?</p>
--	---

8	С.Эрдэнэболд	<p>1.Сүүлийн хоёр жилд иргэдийн бодит орлого буурч, инфляц өндөр хэвээр, жижиг дунд бизнесүүд хаалгаа барьж байна. Хэрэв бодлогын алдаа гэж үзвэл аль салбарт, ямар шийдвэр дээр алдаа гарсан гэж үзэж байна вэ?</p> <p>2.Өнөөдөр иргэд төрд итгэх итгэлээ алдаж, төр нь түмний төлөө байгаа эсэхэд иргэд маань эргэлзэх асуудал газар авч байна. Уруудсан итгэлийг Засгийн газрын зүгээс сэргээх талаар тодорхой, хэмжигдэхүйц ямар бодит арга хэмжээг хэзээнээс авч хэрэгжүүлэх вэ?</p> <p>3.Ойрын 6-12 сарын хугацаанд иргэдийн амьжиргаанд шууд, эерэг нөлөө үзүүлэх, тодорхой тоо, хугацаатай 2-3 бодит ямар арга хэмжээг Засгийн газар хэрэгжүүлэх вэ?</p>
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ МОНГОЛ АРДЫН НАМЫН БҮЛЭГ		
9	Д.Ганмаа	<p>1.2016 онд батлагдсан Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн явц байдал ямар түвшинд байна вэ? Тус хуулийн ямар зүйл заалтууд бодитоор хэрэгжихгүй байгаа вэ? Хэрэгжихгүй байгаа гол шалтгааныг юу гэж харж байна вэ?</p> <p>2.ЭТҮТХ бол салбарын чухал хууль, эрүүл мэндтэй холбоотой маш олон харилцааг зохицуулах чадвартай, хэрэгжилт нь иргэндээ ээлтэй орчныг бүрдүүлж байх хууль атал хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа гол шалтгаан нь юу вэ? Цаашид хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ямар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй вэ?</p> <p>3.Баяжуулсан хүнсний тухай хуулийн 6.2.2-т Засгийн газар баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан. Энэ хүрээнд Засгийн газар ямар бодлого хөтөлбөрийг бодитоор хэрэгжүүлж ажилласан бэ? Мөн Баяжуулсан хүнсний тухай хуулийн 6.2.1-д заасны дагуу тус хууль тогтоомжийн биелэлтийг хэрхэн зохион байгуулж, хэрэгжилтэд ямар шалгуур үзүүлэлтээр хяналт тавьж ажилладаг вэ?</p>
ХҮН НАМЫН ЗӨВЛӨЛ		
10	Л.Энхнасан	<p>1.2026 оны Монгол Улсын төсвийн ойролцоогоор 35 хувь нь автозам болон тээвэр, инфраструктурын төсөлд зарцуулахаар тусгасан бөгөөд энэ нь бусад нийгмийн салбаруудтай харьцуулахад замын бүтээн байгуулалтад харьцангуй өндөр зардал төсөвлөгдсөн гэж үзэхээр байгаа. Гэхдээ бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдаатай талаас нь авч үзвэл аймаг, сум, хязгаарлагдмал газруудын инфраструктурыг сайжруулснаар өнөөгийн төвлөрлийг сааруулах, аймаг, сум хоорондын тээврийн холболтыг сайжруулах тал дээр илүү чиглэсэн байна. Бид өнөөдөр бүс нутгуудаа хөгжүүлэхийн тулд аймаг, сум, хөдөө орон нутгуудад ажлын байр бий болгох, бүс нутгийн хүн амын орлогыг нэмэгдүүлэх тал дээр илүү анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Одоогоор бүс бүрд үйлдвэр барихаар албан ёсоор төлөвлөсөн дорвитой төсөл газрын тосны үйлдвэрээс өөр бараг байхгүй байгаа.</p>

	<p>Цаашид Засгийн газраас бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд хүн амын орлого, ажлын байр нэмэгдүүлэх тал дээр ямар арга хэмжээ авч ажиллах вэ? Энэ талаар тодорхой төслүүд төлөвлөж байгаа юу?</p> <p>2.Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг хэлэлцэж Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэхдээ Хүн төвтэй хөгжлийн үзэл санаанд нийцсэн бодлогыг түлхүү хэрэгжүүлэхээр баталсан. Бид нэг сайхан төлөвлөгөө баталж, зарлахаас илүүтэй бодит ажлуудыг хийж хэрэгжүүлэх цаг ирээд байна.</p> <p>Учир нь Монгол Улсад хүн амын төрөлт 2025 онд сүүлийн 5 жилд байгаагүй тоо хэмжээгээр буурлаа, удахгүй Япон, БНСУ-ын хэмжээнд хүртэл буурахыг үгүйсгэхгүй. Мөн сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн тоо жилээс жилд нэмэгдэж байна. Ялангуяа нийт нас баралтад эзлэх амиа хорлогчдын насны бүлэгт эзлэх хувь 15-24 насны залуучууд гэхэд 50.8 хувийг нь эзэлж байгаа нь үнэхээр сэтгэл түгшээсэн статистик гараад байна.</p> <p>Тэгэхээр Засгийн газар хүн амын тоог өсгөх, төрөлтийг дэмжих асуудлаар цаашид ямар дорвитой арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа вэ?</p> <p>Хүн амд сэтгэл зүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах механизмыг хэрхэн боловсруулан ажиллаж байна вэ? Засгийн газарт энэ асуудлаар тодорхой авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил байгаа бол түүнийгээ танилцуулна уу?</p>
--	--

4.3. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДРИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ”-ИЙН ТЭМДЭГЛЭЛ



Н.Учрал: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан эхэлж байна. Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдаас урьдчилан хүргүүлсэн асуултын дагуу асуулт асууж, хариулт авах Улсын Их Хурлын асуулгын цаг эхэллээ. Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар нарыг тусгайлан бэлтгэсэн индэрт урьж байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл Монгол Улсын Ерөнхий сайдад урьдчилан хүргүүлсэн асуултыг тавьж мэтгэлцэнэ. Бүлгийн цуварсан асуултын тоог 9-өөс хэтрүүлэхгүй асуулт

асууж хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй байна гэсэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийг баримтална.

Ингээд асуулгын цаг эхэллээ. О.Цогтгэрэл даргын микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Гишүүддээ үдээс хойшийн мэндийг хүргэе. Ээлжит Улсын Их Хурлын асуулгын цаг эхэлж байна. Энэ удаагийн Улсын Их Хурлын асуулгын цагаар дээр АН-ын бүлгээс “Унасан эдийн засаг, уруудсан итгэл” гэдэг сэдвийг өгсөн. Яагаад бид ингэж ярих болов? Өмнөх асуулга, мэтгэлцээнүүд дээр шинэ Засгийн газар бүрэлдээд 100 хоногт ажил хийх хугацаа болоогүй гэдэг зүйл ярьдаг байсан. Одоо ажлын эхний үр дүнгүүдийн тухай ярих боломжит буюу хагас жил өнгөрч байна. Энэ бол бага биш хугацаа. Тэгэхээр өнгөрсөн цаг хугацаанд дүгнэх боломжтой олон зүйлийг бид ярьж болно. Шинэ Ерөнхий сайд, шинэ Засгийн газар бүрдэхдээ олон нийтэд баялгийн хулгайтай тэмцэнэ. Унаж байгаа, уруудаж байгаа эдийн засгийг өсгөнө, босгоно гэж олон зүйлд итгэл найдвар төрүүлсэн.

Гэтэл энэ бүхэн улам алсарч одож байна. Өнөөдөр тал талаас дэд сайдын хэрүүл хийж байна. Энэ бол зөвхөн дэд сайдын асуудал биш. Эдийн засаг, иргэдийн итгэл уруудаад байна. Үүний мөсөн уулын орой нь зөвхөн энэ жижигхэн зүйл байгаа. Үүний цаана улс төрийн том асуудал болж байгаа гэдгийг ойлгож байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр эхний асуулт бол, яагаад ард иргэдийн итгэл унаад байна вэ? Та хууль хэрэгжүүлэх ёстой, хууль сахиулах ёстой субъектийг төлөөлж байгаа хүний хувьд өнгөрсөн хугацаанд баялгийн хулгайтай тэмцэх чиглэлээр хэчнээн албан тушаалтны авлига, албан тушаалын хэргийг шийдвэрлэж шүүхэд шилжүүлсэн бэ? Энэ хагас жилийн хугацаанд эхний үр дүн гарах ёстой.

Г.Занданшатар: Унасан эдийн засаг, уруудсан итгэл гэж үнэн. Үнэхээр хамтарсан Засгийн газар ажилласан 2025 оны 6 дугаар сар хүртэл эдийн засаг унаж, эдийн засгийн өсөлт 2.4 хувь болж унасан байсан. Валютын ханш өсөөд 4000 хүрэх эрсдэлтэй болсон байсан. Төсвийн орлого дутагдаад ам.долларын ханш 4000 давах, инфляц 15 хувь хүрэх тооцоололтой байсан. Тэгвэл улсын эдийн засаг сэргэсэн. Мэдээж инерцээрээ яваад одоо бид хүндрэлтэй нь нүүр тулж байна. Өнгөрсөн жил хүнд жил байсан, хөөс хагарч үнэнтэй тулсан жил байсан. Ирэх жил ч гэсэн хүндрэлтэй жил байна. Дэлхийн эдийн засаг сорилттой тулгарна. Нүүрсний үнэ 2-3 жилийн өмнөхөөс 4 дахин шахуу унасан байна.

Тийм учраас үнэнтэй тулсан жилд эрс шийдэмгий бодлогуудыг хэрэгжүүлсний үр дүнд, авлигатай тэмцэсний үр дүнд, хэдэн хэрэг хаашаа шилжсэнээс илүүтэй энэ бодит үр дүнд эдийн засгийн өсөлт өнөөдрийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 6.5 хувь болж өсөх дүнтэй байна. 11 дүгээр сард 5.9 хувь байсан. Цаашид 6.4-6.5 хувьд хүрнэ. Ам.долларын ханш 3600 давсан байсан бол одоо 3550 төгрөг болж буурсан. Төгрөгийн ханш чангарлаа. 15 хувь хүртэл өсөж байсан инфляц өнөөдөр 8.2 хувь болж буурлаа. Тоо худлаа хэлдэггүй тул авсан арга хэмжээнүүдийн үр дүнд эдийн засаг сайжирч байгаа статистикийн бодит тоонууд байна.

Дэлхийн нэр хүндтэй зээлжих зэрэглэлийг тогтоогч “Moody’s corporation” Мүүдиз агентлаг, “Standard and poor’s rating agency” Стандарт энд пүэрс агентлагууд Монгол Улсыг үнэллээ. Мүүдиз агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг В2 ангиллаас В1 тогтвортой ангилал руу шилжүүлээ. Стандарт энд пүэрс агентлаг 10 дугаар сарын 25-ны өдөр манай улсын зээлжих зэрэглэлийг “В+” болголоо.

Н.Учрал: О.Цогтгэрэл даргын микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Унасан эдийн засгийн тухай асуултуудыг үргэлжлүүлээд би асууна. Бид яагаад иргэдийн итгэлийг уруудуулаад байна вэ? гэдэг тодорхой асуултыг би эхэлж асуусан. Өнгөрсөн 6 сарын хугацаанд авлига, албан тушаал, баялгийн хулгайтай холбоотой хэдэн хэргийг танай Засгийн газар хууль сахиулах байгууллага, шүүхэд шилжүүлсэн бэ? гэдэг асуудлыг ярьсан. Ард иргэдийн итгэл унаад байна гэдэгтэй холбоотойгоор өнгөрсөн 7 хоногт танай Засгийн газрын Хууль зүйн сайд хэлж байна. Том хулгайд холбогдсон зарим хүмүүсийг хилээр гараад явсан эсэхийг асууж байна. Үүнийг та нар хэн нэгэн хүнээс асуух биш Засгийн газрын харьяа Хил хамгаалах байгууллагаас тодруулах хэрэгтэй. Та нар ард иргэдийн итгэл хүлээлт дээр гарч ирээд одоо битгий ингэж хоорондоо жүжиг тавьж бай. Хэн хилээр гарсан, орсныг Монгол Улсад хэн нэгэн биш та нар мэдэж байх ёстой. Тэр тусмаа би Танд баримттай нь харуулъя.

2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы хуралдаанд та “Би хулгайтай эвлэрэх гэж тэмцээгүй. Би хулгайтай хамт унах гэж тэмцээгүй. Би хулгайтай эвлэрэхгүй” гэж хэлж байсан байна. Гэтэл яг одоо нөхцөл байдалд саяын бүх асуудлууд хэвээрээ, та бүхэн олон нийтийн өмнө жүжиглэлтийн байдалд орсон. Яг саяын хэлсэн баялгийн хулгайчид дээр яг ямар бодлого барьж

байгаа вэ? гэсэн асуултаа дахиад асууя. Хэдэн хэрэг шүүхэд шилжсэн бэ? Тэр хулгайчидтай хариуцлага тооцож чадах юм уу, чадахгүй юм уу? Үргэлжлүүлэн жүжиг тавих юм уу?

Г.Занданшатар: Авлигатай, хулгайтай тэмцэх ажил үргэлжилж байгаа. Өргөс авчихсан юм шиг нэг өдөр ингээд тоогоор хэмждэг үзүүлэлт биш. Харин тэднийг өмгөөлөөд хамгаалаад байдаг л газрууд нь асуудал байна гэж хариулъя.

Тухайлбал, өнгөрсөн жилүүд 58 хэргийг шүүхэд шилжүүлж, авлига, албан тушаал, баялгийн хулгайтай гэмт хэрэг илрүүлнэ. Саяхан хүртэл АМХЭГ-ын даргаар ажиллаж байсан хүн Олон овоотын гэдэг 16 мянган кг алттай Монгол Улсын чухал алтны нөөцтэй ордыг хулгай хийгээд хүнд өгсөн байсныг илрүүлээд шалгаж байна. Ийм олон жишээг би дурдаж болно. Тэгэхдээ энэ шүүх хурлын танхим биш. Парламентын мэтгэлцээний танхим. Тийм учраас хэрэг явдал ярихаас илүү бид унасан эдийн засаг, уруудсан итгэл юунаас болоод байна, авлига хулгай хаанаас гараад байгаа юм. Үүнийг язгуураар нь устгахын төлөө хийж байгаа тэмцэл, ажлууд тууштай үргэлжилж байгаа. Хууль хяналтын байгууллагууд шүүх засаглалын эрх мэдлийг парламент шүүж аль эсвэл гүйцэтгэх засаглал шүүдэггүй. Гэхдээ улс төрийн хүсэл эрмэлзэл, манлайлал, авлигатай тэмцэх, тухайлбал баялгийн хулгайтай тэмцэх ажлууд тууштай үргэлжилж байгаа.

Олон арван хэргүүд шалгагдаж байна. Энэ талаар тусад нь ярилцвал хууль хяналтын байгууллагуудтай хаалттай хэлэлцээд тодорхой мэдээллүүдийг өгч болно. Ер нь авлига хээл хахууль, баялгийн хулгай нэг өдөр бий болсон. Тэрийг нэг өдөр өргөс авчихсан юм шиг засаж залруулдаг зүйл биш юм байна. Бүх шатад байна. Ийм учраас үүнийг язгуураар нь арилгахын тулд бид одоогийн байдлаар 2 их наяд төгрөгтэй холбоотой үл хөдлөх хөрөнгө, лицензтэй холбоотой асуудлаар битүүмжлэх, шалгах ажиллагаа явуулж байгаа. Энэ талаар нэхэмжлэл гаргаж байгаа. Тухайлбал, сая үүсмэл ордууд болон стратегийн ордуудыг Засгийн газар, ард түмний мэдэлд шилжүүлэх тодорхой ажлууд хэрэгжээд явж байхад одоо ингээд... (минут дуусав)

О.Цогтгэрэл: Энд ямарваа нэгэн хаалттай мэдээлэл элдэв зүйл хэрэггүй. Энд та нар уриа лоозон биш, жүжиг тавих биш, жинхэнээсээ авлига, ашиг сонирхлын хэрэгтэй, баялгийн хулгайтай тэмцэх шаардлагатай байгаа учраас ард иргэдийн итгэл унаад байна.

Хоёрдугаарт нь би эдийн засагтай холбоотой ганц 2 асуултыг унасан эдийн засагтай холбон асууна. Манай ДНБ-д эзлэх татварын ачааллыг 35 орчим хувь гэж тооцдог. Яг энэ харьцаа коммунист Хятад улсад 22 хувь байдаг юм байна. Харин бид Хятад Улсаас бараг 60-70 хувиар илүү татварыг ард иргэдээсээ, бизнес эрхлэгчдээсээ авч байна л гэсэн үг. Бодит нөхцөл байдалд өнөөдөр гучаад мянган ААН дансаа хаалгасан, 6-7 их наяд төгрөгийн өрөнд орсон эдийн засаг байна. Тэгэхээр эндээс асуулт байна. ААН-үүд ашигтай ажиллаад, ашигтай ажилласан мөртөө татвараа өгөхгүй байгаа учраас хааж байгаад, дарамталж байгаад татвар авах ёстой гэж үзэж байна уу? Аль

эсвэл эдийн засгийн тогтолцоо нь болохгүй байна гэж үзэж байна уу? Аль нь юм бэ? Ашигтай ажиллаад тэд татвараа өгөхгүй байгаад байгаа юм уу? Аль эсвэл тогтолцоонд нь байна уу? Та эхлээд үүнийг хариулаад өгөөч.

Г.Занданшатар: Татварын тогтолцооны шинэчлэл, реформыг хийхээр Татварын багц хуулийг Улсын Их Хуралд өргөн барьсан. Аль алинд нь байгаа гэж үзээд үүнийг засаж залруулахаар өгсөн. Гучин хэдэн мянган ААН биш л дээ. Сүүлийн статистик тоогоор 23 мянга орчим ААН-ийн данс хаагдсан байсныг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, чиглэл өгөөд Татварын багц хууль өргөн барьсантай холбогдуулаад бүгдийг нь нээсэн. Өнөөдрийн байдлаар 4368 ААН-ийн дансыг нээгээд байна. Эрсдэлтэй холбоотойгоор ААН-үүдийн татварын данс хаагдсан байсныг зогсоож байгаа. Одоо Улсын Их Хуралд өргөн барьж байгаа Татварын багц хуулиар татварыг албадлагын шинж чанартай дарамталдаг, данс хаадаг тогтолцооноос илүү зөвлөн туслах хэлбэрт шилжүүлж байгаа. Үзэл санааны философийн хувьд бизнес эрхлэхэд нь, зөвшөөрөл авахад нь ААН-үүдээ дэмждэг, тайлан баланс гаргахад нь дэмждэг, асуудлыг нь шийдэхэд тусалдаг, зөвлөдөг хэлбэрт шилжүүлж зөвлөн туслах хэлбэрээр татварыг барагдуулдаг, бизнесийнх нь үйл ажиллагааг дэмждэг тогтолцоонд шилжүүлэх өөрчлөлтийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлж байна.

Ийм учраас манай эдийн засаг, татварын тогтолцооны өнгөрсөн 30 жилийн гажуудлыг ч энэ хуулиудаар засаж, ололт, амжилттай сайн талуудыг нь тодотгож чангатгах хэрэгтэй.

Тэгэхдээ таны хэлсэн статистик тоонууд алдаатай байна. Миний санаж байгаагаар Хятадын нийт бизнес ДНБ-тэй татварын ачаалал 20 хувь биш, Европын улсуудад бүр 40 хувь хүрдэг улсууд ч байна. Скандиновын орнуудад ч байна. Тийм учраас татварын ДНБ-д оногдуулдаг, төсвийн зарлагад эзэлдэг хувь хэмжээгээрээ ялгаатай. Улс орон болгон эдийн засгийн бүтцээрээ ялгаатай. Ийм учраас татварыг зөвхөн макро эдийн засгийн тогтолцооных нь хувьд биш микро эдийн засгийн түвшинд цогцоор нь харах шаардлагатай.

О.Цогтгэрэл: Баярлалаа. Тэгэхээр ААН-үүдэд хүндрээд байгаа нь тогтолцооны асуудал гэж та хэлж байна. Тогтолцооны, татварын иж бүрэн шинэчлэл шаардлагатай гэж та хэлж байна. Үнэхээр таны энэ хариулттай би санал нийлж байна. Ийм учраас АН-ын бүлэг дээр бид ярилцаад нэг тодорхой байр суурийг илэрхийлж байсан. Яагаад ААН-үүдийн 60-70 хувь нь өрөнд ороод байгаа юм бэ? Энэ бол хувь ААН-ийн гэхээс илүүтэй тогтолцооны асуудал байна. Тогтолцооны асуудал байгаа учраас 1 дүгээрт нь эдийн засгийн реформ хийх ёстой. Энэ реформыг дагаад тодорхой хэмжээний өршөөлийн асуудал яригдах нь зүйтэй гэдэг санал гарсныг Сангийн яамнаас мэдэгдэл гаргаад АН-ын бүлэг О.Цогтгэрэл хэлснээс болоод татвар тасарлаа гээд өөр тийшээ мушгисан.

Бидний байр суурь бол магадгүй 75 мянган ААН-ийн 70 мянгад нь хамаарч байгаа ЖДҮ-үүдэд хамаарах ёстой. Энэ бүхнийг судалж байна гэдэг байр суурь гаргасан. Тэгэхээр эндээс гарч байгаа гол дүгнэлтэд асуудлын уг

шалтгаан нь ашигтай ажиллаад татвараа өгөхгүй байгаа ААН-үүд ер нь биш. Энэ бол тогтолцооны том шинэчлэлийг Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал бизнесийн орчин шаардаад байна. Иж бүрэн шинэчлэлийг шаардаад байна. Тэр иж бүрэн шинэчлэлийн санал хаана байна вэ? Та бүхэн үндсэндээ хэдэн жилээр нөгөө нийгмийн даатгал, эрүүл мэндийн шинэчлэл, татварын тогтолцоо, төрөл бүрийн сангуудын талаар ярьсан, зөвхөн таны Засгийн газар ч биш. Яг үнэндээ бид ярьсан болохоос биш, аль нь ч бодлогын түвшинд өнөөдрийг хүртэл юу ч хийж ирээгүй. Магадгүй та нар одоо өнөө маргааш Улсын Их Хуралд өргөн барина гэж хэлнэ. Энэ зүгээр л олон нийтийн нэг хий гаргах гэж л хийж байгаа ажлууд юм шиг л сүүлийн үед санагддаг болсон.

Та бүхэн зүгээр л асуудлыг яаж намжаах вэ? гээд байгаа. Гэтэл яг суурь асуудал болох системийн өөрчлөлтийг та биднээс шаардаад байна.

Г.Занданшатар: Тогтолцооны хувьд тантай санал нэг байна. Бид аль болох бүтээлч шийдэл гаргасан парламентын мэтгэлцээн өрнүүлж татварын цогц реформ, тогтолцооны шинэчлэлийг хийх учиртай. Энэ дээр та нартай санал нэг байна. Гэхдээ өршөөл эхэлж явдаггүй. Татварын реформоо хийгээд, түүнийгээ тууштай хэрэгжүүлэх явцад татварын өршөөл хэрэгждэг. Татварын өмнөх 4:10-ын тогтолцооны реформыг хийх ажлын хэсэгт нь би ажиллаж энэ 4:10-ын реформын үзэл санааг анх хэрэгжүүлэх ажилд оролцож байсан. Тэр үед бидний төсөөлөл өөр байсан. Үл хөдлөх хөрөнгийн татвар бусад татваруудыг хамтад нь цогцоор хийгдэх ёстой байсан боловч шийдэгдээгүй юм.

Тэгэхээр 2015 оны Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулиар 35 их наядын хөрөнгө орлогыг ил болгож шийдсэн боловч энэ нь манай улсыг хар жагсаалтад орох нэг үндэслэл болсон. Саарал жагсаалтад орсноос зээлийн хүү нэмэгдэж, таны яриад байгаа тогтолцооны гажуудал үүсэж, ААН-ийн зээлийн хүү, санхүүжилтийн зардал өсөж эдийн засагт ямар сүүдэр ужгирсныг та бид сайн мэдэж байгаа.

Тийм учраас тогтолцооны реформ бол цогц хэлбэрээр эхэлж ярихгүй бол өршөөнө гээд түрүүлээд зарлачихаар ямар ч татвар төлөгч намайг өршөөх гэж байгаа юм бол би яах гэж төлөх юм бэ гэсэн сэдэл үүснэ. Адам Смитийн номд байдаг зах зээлийн үндсэн зарчим гажуудуулсан мэдэгдлүүд зах зээлд ямар дохио сигнал өгөх вэ гэдгээ Засгийн газар, парламент хамтарч хэлэлцээд зөв мессеж сигнал өгч байж татварын төсвийн реформуудаа хэрэгжүүлж байхгүй бол эхлээд дандаа популист чиглэлтэй эсвэл халамжийн чиглэлтэй бодлогууд нь бидний тогтолцоонд гараад байгаа улс төрийн шалтгаанууд болоод байгаа. Энийг харин бид хамтдаа шийдээд зөв голдирлоор нь... (минут дуусав)

О.Цогтгэрэл: Тэр агуулгатай бол санал нийлж байна. Миний хувьд яг энэ агуулгаар асуудалд хандаж байгаа. Судлаад үзэхэд 2008 оны 4, 10-ын бодлого, түүнийг залгаад гарсан татварын өршөөл бол маш зөв зүйтэй бодлого байсан байна. 2015 оных татварынх биш, энэ бол тоо дүнгүй байсан. Татварын өршөөл гэдэг бол 100 сая төгрөгийн өртэй бол тодорхой тоо бүхий зүйл юм.

2015 оны эдийн засгийн өршөөлийн асуудал бол маш алдаатай бодлого гэж би боддог. Татварын өршөөл, эдийн засгийн өршөөл тусдаа ил тод байдал тусдаа. 2015 оных бол Монголчуудын хувьд сургамж авах ёстой буруу зүйл гэж боддог.

Тэгэхээр иж бүрэн реформ шинэчлэлийг залгаад өршөөлийн асуудал байдаг. Өршөөл гэдэг нь 100 хувь хөнгөлөх чөлөөлөх тухай асуудал биш гэдгийг би бас давтаад хэлье.

Дахиад, та 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр намынхаа Их Хурал дээр хэлсэн үгийг манайхан бэлтгэсэн байна. Манай Засгийн газар эдийн засгийн хүнд сорилтыг даван туулахдаа ачааны хүндийг ард түмэн ААН-д үүрүүлэх бус төр өөрөө бүсээ чангалж даван гарна гэж албан ёсоор үг хэлээд яг ийм постоор гарч байсан байна. Гэтэл яг одоо шинэчлэл өөрчлөлтийн олон бодлогууд таны саяын хэлснээр биш, таны хэлсний эсрэг явж байгаа зүйлүүд харагдаж байна гэдгийг хэлье.

Өнөөдрийн нөхцөл байдлыг харахад НДШ байна. Монголчуудын хувьд НДШ татварын шинж чанартай болоод хувирсан. Энэ бүгдийг оруулаад тооцвол 40 гаран хувийн татвартай далайгаас хол, тээврийн зардал өрсөлдөх чадварт нь нөлөөлсөн. Энэ бүхэн Монголчуудын бизнесийн орчны хувьд, өрсөлдөх чадварын хувьд дахиад л та биднээс суурь дүгнэлтүүдийг онцгойлон шаардаж байна.

Г.Занданшатар: Тантай санал нэг байна. Татварын ерөнхий ачааллын хүрээнд бидний анхаарах ёстой асуудал бол НДШ мөн. Тэгэхдээ нийгмийн даатгалын санг хоосолсон сангийн менежментийг хэрэгжүүлж чадаагүй, хулгайлсны улмаас нийгмийн даатгал дээр иргэдэд учруулж байгаа энэ өндөр дарамтыг бууруулах ямар ч боломжгүй. 2030 он гэхэд бараг Оюу толгойтой адилхан хэмжээний нийгмийн даатгалын сангийн зарлага, алдагдал үүснэ. Энэ бүхэн маань нөгөө нийгмийн даатгал дээр байгаа ачааллыг бууруулах боломжийг хүндрүүлээд байгаа юм. Түүнээс биш энэ одоо нийт татварын нийгмийн даатгалын цогц реформын хүрээнд бид аль болох ААН-үүдэд дарамт багатай, илүү чөлөөтэй эдийн засгийн эрх чөлөө олгосон хуулиудыг хэлэлцэж байна. Энэ зорилгоор Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байгаа. Энийг Баялаг бүтээгчдийг дэмжих багц хууль гэж нэрлэж байгаа. Энд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Төрийн өмчийн компаниудын үндсэн чиглэлүүд мөн Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль зэрэг багц хуулиудыг хэлэлцээд явж байна. Энэ бүхэн үндсэндээ эдийн засгийн либералчлах, чөлөөтэй байдлыг дэмжих, үүний үр дүнд хувийн хэвшлээ дэмжих, улмаар хувийн хэвшил давамгайлсан эдийн засаг, зах зээлийн тогтолцоог бэхжүүлэхэд чиглэгдсэн өөрчлөлтүүдийг Засгийн газраас хэрэгжүүлж эхлээд явж байна. Гэвч саяын таны хэлсэн, “ард түмэндээ ачааг нь үүрүүлэхгүй” гэдэг бол инфляцаар ард түмний халааснаас хулгайлж байдаг инфляцыг бууруулахын тулд төсвийн тодотголыг хийсэн. 2.2 их наядаар танахад нийт төрийн албан хаагчдын тоог 9 хувиар цомхотгосон. Энэ маш том тоо гээд та ч гэсэн хэлж байсан. Энд 147

дарга, цэргийн орон тоог цомхотгож 28 Үндэсний хороодыг татан буулгасан. Энэ бүхэн тодорхой хэмжээний өвдөлт өгч байгаа, тэр хэмжээгээр эсэргүүцлийг бий болгож байгаа.

О.Цогтгэрэл: Өнөөдөр 12 дугаар сарын 26-ны өдөр. 2025 оны төгсгөлийн өдөр. 12 дугаар төгсгөлийн асуулга мэтгэлцээний өдөр болж байна. Ийм учраас энэ сэдэв өөрөө энэ оныг дүгнэж хэлэх боломжтой гэж бид бүхэн асуултынхаа сэдэв дээр ярилцсан. Тэгэхээр манай гишүүд өргөн сэдвээр танаас асуух боломжтой байх гэж бодож байна. Энд эрүүл мэнд, боловсрол гээд бүхий л салбарын асуудлууд хамаарна. Зөвхөн эрүүл мэндийн салбарын жишээг аваад үзэхэд яг өнөөдөр ЭМД-ын сангийн дампуурлаас болж үндсэндээ дампуурлаас гээд хатуухан хэлчихье, эм тариа гээд олон зүйлүүд бүгд байхгүй болсон. Сая та нэг эмнэлэг дээр очсон талаарх мэдээллээр нэг эмнэлгийн асуудлыг шийдлээ гээд гарч байсныг бид харж байсан.

Гэтэл үүний цаана тогтолцооны асуудал дахиад та биднээс том хариулт нэхсээр байна. Яг одоо эрүүл мэндийн салбарын хувьд гэхэд бараг жилдээ зуугаад мянган Монгол Улсын иргэн гадагшаа гарч эмчилгээнд явж байна. Энэ дотор дотооддоо эмчлүүлэх боломжтой, аль эсвэл техник технологийн асар өндөр нөхцөл байдлыг шаардаагүй мөртөө өнөөдөр бид иргэдээ гадагшаа явуулж байгаа. Эдийн засаг талаас нь яривал валютын асуудлууд, эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч ажилтнууд гадагшаа гарч асрагч, сувилагч бүүр бусад биеийн хүчний ажлыг хийдэг. Энэ салбар нь ийм урвалт уналтын байдалд орсон. Салбаруудыг дүгнээд яривал олон зүйлийг та бид ярьж болж байна.

Мөн боловсролын салбар. Монгол Улсын ирээдүйн төлөө ирээдүй цагийн иргэнийг бэлдэж байгаа боловсролын салбарын багш нар гадагшаа гарч виз нь олдвол бүгд гарч ажиллахад бэлэн байна. Тэгэхээр энэ бүгдэд бид өнөөдөр ямар дүгнэлт хийж, ямар хариу арга хэмжээг авах юм бэ? Та бид нар ингээд бие биедээ үг хаяж, бие биеэ гайхаад явах юм уу? Одоо яг яах ёстой юм бэ?

Г.Занданшатар: Бид бүх зүйл сайхан болж байна гэж бие биеэ хуурахгүй. Бүх юм болохоо болиод унаж байна гэж оны төгсгөлд муу амлахгүй. Монгол хүн амныхаа бэлгээр байх ёстой, үнэн бодит тоог хэлэх ёстой. Тоо худлаа хэлдэггүй. 2.5-аас доош унаж байсан эдийн засаг өнөөдөр 6.4-6.5 хувь болж өсөж байна. Энэ өсөлт биш гэж үү? Энийг би унасан биш, сэргэж байгаа эдийн засаг гэж хэлнэ. Валютын нөөц 2 тэрбум ам.доллароор уруудаж байсан бол өнөөдөр түүхэндээ анх удаа 6 тэрбум ам.долларыг даваад 6.5 тэрбум ам.доллар болсон. Энэ бол Монголын хувьд түүхэн рекорд хэмжээнд хүрнэ. Энэ төгрөг чангарч байгаа сайн үзүүлэлт биш гэж үү? Ингээд эдийн засгийн өсөлт 6 хувь гараад явна. Валютын нөөц 6.5 тэрбум ам.долларыг давна, валютын ханш төгрөг тогтворжоод унаж байсан бол өсөж байна. Инфляц тогтворжиж байна, зээлжих зэрэглэл сайжирлаа. Энэ бүхэн бол сайн үр дүнгүүд. Оны эцсээр эерэг үр дүнгүүд гарч байна. Мэдээж ард иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байсан, инерцээрээ ард түмний амьдралд, төсөвт хүндрэл учруулж байгаа нь бодит үнэн. Тэгэхдээ энэ эдийн засгийн тогтолцоо, нүүрснээс хамааралтай эдийн засаг нэг өдөр бий болоогүй. Бид аж үйлдвэржилт, хүнс, татварын бодлого, үндэсний үйлдвэрлэлээ

дэмждэггүй, алдаатай бодлогуудын үр дүнд үүссэн өнөөдрийн энэ тогтолцоог засаад зөв голдиролд оруулж байна.

Ийм учраас Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг сэргээх идэвхжүүлэх 300 хоногийн төлөвлөгөөг өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж батлаад одоо Худалдаа аж үйлдвэрийн танхим бизнес эрхлэгчдээрээ хэлэлцүүлээд явж байна. 300 хоног буюу 10 сарын дотор өдөр бүрийн төлөвлөгөөгөөр эдийн засгаа сэргээх, эдийн засгийн эрх чөлөөг бий болгох, зөвшөөрлийг багасгах, эрчимтэй хувийн хэвшлээ дэмжсэн, ард иргэдийнхээ орлогыг дэмжсэн ард иргэддээ амьдралд наалдацтай бодитой бодлогуудыг хэрэгжүүлнэ.

Ойрын хугацаанд том мега төслүүд хэрэгжиж эхэлж байна. Тэгээд олон ажлууд үр дүнтэй хэрэгжсэнээр ирэх он итгэл найдварын жил болох юм.

О.Цогтгэрэл: Би сая таны үгэнд гарсан нэг тоотой холбоотой тодотгоод асууя. Та валютын нөөц 6 тэрбум ам.доллар хүрч түүхэн дээд хэмжээнд хүрлээ гэж байна. Яг энэ тоотой холбоотойгоор өнгөрсөн жил валютын нөөц 4.5 орчим тэрбум ам.доллар байсан. 2025 оны туршид Монгол Улсын урсгал дансны алдагдал 1 тэрбум гаран ам.долларын алдагдалтай. Экспорт, импорт, гадаад худалдаа биш урсгал дансны алдагдал. Тэгэхээр 4.5-аас 1 тэрбум ам.доллар хасах гарахаар Монгол Улсын цэвэр бодит нүүрс 4.5-аас 1-ийг хасаад бараг үүнээс ч их хасагдаад 3 руу орсон байх ёстой. Гэтэл та нар 6 гэж хэлээд байна. Энэ мөнгө хаанаас гарч ирсэн, ямар мөнгөний тухай ярьж байна вэ?

Энэ бол Монгол банк, Хөгжлийн банкнаас бонд авсан, өр зээл тавьсан дээр нь арилжааны банкнуудаас авсан зээлийг Монгол Улсын нэг жилийн ажлын эдийн засгийн үр дүн гэж та нар зүгээр хууран мэхлэлт хэлж байгаа шүү дээ. 4.5 тэрбум ам.доллараас 1 тэрбумын ам.долларын урсгал дансны алдагдалтай гарахаар 4-өөс нэг хасагддаг юм байгаа биз дээ. Өөр нэмэгдэх зүйл байхгүй. Хөгжлийн банкны 500 саяыг аваад ирчихсэн. Худалдаа хөгжил, Голомт банкнуудын авч ирсэн бүх бондыг та нар нэмээд 6 гээд бичсэн байна. Та мэлзэх арга байхгүй. Би бас наад тоог гадарлана. Та хариулаарай.

Г.Занданшатар: О.Цогтгэрэл гишүүний хэлж байгаа санхүүгийн дансны ашиг илүү байгаа нь үнэн. Урсгал дансны тэнцэл эхний хагас жилийн байдлаар буурч байсан нь үнэн. Гэхдээ экспортыг нэмэгдүүлж байгаа урсгал дансны тэнцэл бол одоо баланс бариад, дээр нь санхүүгийн дансны ашгууд нэмэгдээд гарна. Санхүүгийн дансны ашиг гэдэг нь таны хэлж байгаа санхүүжилтийн төлбөрийн тэнцлийг анги зүйлээр нь ялгаж үзвэл манай экспортын бүтцийн доголдол, импортын хамаарал бүгд тодорхой болно. Энэ импортоос хамаарсан эдийн засаг валютын ханшийг хөөргөж байгаа хүчин зүйл болж байгаа нь үнэн. Гэхдээ одоо 6.5 тэрбум ам.доллар хүрэхэд санхүүгийн дансны ашиг ч нөлөөлсөн зүйл бий. Илүү их экспорт унаад нүүрсний үнэ унаснаас шалтгаалсан илүү урсгал данс, илүү алдагдалтай болчихсон байсныг эхний хагас жилийн байдлаар валютын цэвэр нөөц хасах руугаа орох эрсдэлтэй болчихсон байсныг өнөөдөр нэмэх болгоод урсгал дансны тэнцлийг эерэг болгоод явж байгаа.

Өөрөөр хэлбэл, бид 4 сая тонн нүүрс экспортолж, бодит хэмжээгээр нэмэгдүүлээ. Энэ бүхэн валютын тэнцэл, төлбөрийн тэнцлээ ашигтай болгох нөхцөлийг бүрдүүлж байгаа. Сангийн сайдын хэлж байгаа бол Засгийн газрын бондуудыг хэлээд байх шиг байна. Хөгжлийн банкны бонд, арилжааны банкнуудын авч байгаа бонд төлбөрийн тэнцэлд санхүүгийн дансны ашиг болж тусдаг учраас эерэг үзүүлэлтүүд гарахад нөлөөлсөн зүйлүүд байгаа.

О.Цогтгэрэл: Тэгээд эдийн засгийн асуудал, амлалтууд дээр бас нэг жижигхэн тоо байна. Жишээ нь төсвийн зардлыг нэмэхгүй, орон тоог нэмэхгүй гээд. Сүүлийн хэдэн өдрийн улс төрд дэд сайдын асуудал яригдаж байгаа. Зарим нь дэд сайдын асуудлыг ярихаар АН цөөхөн хүний буюу арван зургаахан хүний асуудал ярилаа. Энэ нь 900-аад сая төгрөгийн асуудал гэдэг. Үүнийг дагаад бусад үржигдэж гарах олон зардлыг нь больё. Энэ 900 сая төгрөг бол 9 тэрбум төгрөг биш, маш бага мөнгө. Би маш бага мөнгөний тухай нэг тооцоо хийж харуулья.

900 сая төгрөгөөр цалинжуулахын тулд өнөөдөр Монгол Улсын нэг дундаж 2.7 сая төгрөгийн цалинтай иргэн нь 228 мянган төгрөгийн татвар төлж байна. 900 сая төгрөгөөр 16 дэд сайдыг цалинжуулахын тулд өнөөдөр 3789 Монгол Улсын дундаж цалинтай иргэний татвараар нөгөө 16 дэд сайдыг цалинжуулах юм байна. Тэгэхээр Монгол Улсын дундаж 3789 иргэний татварыг хурааж аваад 16-хан дэд сайдыг цалинжуулна, тийм ээ?

Тэгэхээр та нарын хэлээд байгаа энэ мөнгө бага мөнгө үү? Нөгөө талаас Монгол Улсын 3700 иргэний ажил амьдралаас нь татварыг нь хурааж аваад цалинжуулж байгаа буюу үүний цаана байгаа мөсөн уулын оройны тухай яриа юм. Өнөөдөр ярьж байгаа энэ унасан эдийн засгийн тухай, том эдийн засгийн тухай яриа гэдэг. Энэнд АН-ын зүгээс ач холбогдол өгч ингэж ярьж байгаа.

Г.Занданшатар: Монгол Улсад 220 мянга гаруй төрийн албан хаагч ажиллаж байгаа. Эдгээр төрийн албан хаагчдаас 20 мянган төрийн албан хаагчаас гадна төрийн өмчийн компаниудын түвшинд ажиллаж байгаа 228 хүний зардал, төсвийг хэмнээд, энэ зардал төсөв нь үүнээс 10 дахин их мөнгийг хэмнээд жишээлбэл, 10 дахин зардалтай бензин машиныг цахилгаан машинаар солиод ажиллуулахад илүү үр дүнтэй бол 900 сая төгрөгийн зардал гаргаад бид 24 тэрбум төгрөгийн зардал хэмнэж байна. 24 тэрбум төгрөгийн зардал хэмнээд 900 сая төгрөг зарцуулах 2-ыг харьцуулахгүйгээр энэ зардлыг их, бага мөнгө гэж ярих тухайд биш, харин үр ашгийг нь тооцвол дэлхийн бүх улсуудад дэд орлогч сайдгүй ажил байхгүй. Амьдрал дээр ажлаа хөөцөлдөөд явахад сумын дарга хүртэл орлогчгүй бол ажил нь явдаггүй юм. Одоо хойд, урд хөршөөс харахад хэдэн 10 дэд сайдтай. Дэд сайдын түвшний 3 талт механизмын ажил, том ажлууд, нүүрс, бензиний асуудал дэд сайдгүйгээс болоод 3 талт механизм ажиллахаа больсон. Гадаад яамны дэд сайд нарын уулзалтууд зохион байгуулагддаг байсан. Олон улсын түвшинд дэд сайдын олон механизмууд бий. Салбар хоорондын уялдаа холбоо гээд олон 100 тэрбумын асуудлыг хянаж шалгалтын үүрэг гүйцэтгэж байгаа. Нэг сайд дураараа авирлахгүйн тулд Дэд сайд хяналтын үүрэг гүйцэтгэж байгаа.

Аливаа төрийн байгууллагад байдаг систем бол 2 орлогч заавал 2 гарын үсэг зурдаг шиг давхар гарын үсгийн хяналтын тогтолцоо байдаг нь Засгийн газрын хяналтыг бий болгож байгаа. Яамдад нэг сайдын компани шиг ажилладаг соёл тогтоож болохгүй. Ийм учраас дэлхийн бүх улсуудад байдаг зарчим бол дэд сайд хяналтын үүрэг гүйцэтгэдэг. Нөгөө талаас салбар хоорондын уялдаа холбоог хангах үүргийг гүйцэтгэдэг. Үр ашиг нь 100 хүн ажилласнаас илүү үр дүнтэй байдаг. Эцсийн үр дүнд бүтээмж, үр ашиг, хяналтын тогтолцоо өнөөдөр төрийн чиг үүргийг дахин инженерчлэхэд туйлын чухал байна. Ийм учраас гишүүд санал гаргаад төрийн чиг үүргийн...(минут дуусав)

О.Цогтгэрэл: Дахиад тодотгоод хэлье. 16-хан дэд сайдыг ажиллуулахын тулд 3789 иргэний татвараар амьдардаг юм байна гэдгийг үүний цаана төрийн албаны бүтэц ямар их үр дагавартай вэ гэдгийг хэлье. Ингээд ярихаар нөгөө талд нь АН-ын хэдэн хяналтын менежер, бүтээмжийн менежерээс болоод тэрийг цомхотгосноор тэрийг ингэснээр гэдэг. АН-ын хувьд та бүхэнтэй, танай Засгийн газартай, танай намтай хамтарч ажиллаад нийт 25 хүн л томилсон байна. Та нарын мэдээллээс харахад 25 менежер томилсон гэж бид ойлгож байгаа. Гэтэл үүний цаана ямар том асуудал 200 мянга, үүний цаана жил жилд хэдэн 10 мянгаар нэмэгдэж байгаа төрийн алба гэдэг ямар үр дагавартай вэ гэдгийг нэг талаар харуулж байна.

Мөн АН-ын хувьд олон нийтэд PR явуулахдаа АН хэдэн менежерээ хамгаалж байна гэж ямарваа нэгэн яриа байхгүй. Жишээ нь миний зүгээс аль нэг сайдад, Ерөнхий сайдад АН-ын менежерийг үлдээж өгөөч, ингэвэл тэгье, үүнээс болж ингэж байна гэдэг өчүүхэн төдий яриа байхгүй. Бид бүгдийн зүгээс нэг зарчмын шаардлагын хажууд нэг хувь хувьсгалын жижиг зүйл үүний цаана ярьж байсан тохиолдол байхгүй гэдгийг би улаан нүүрээрээ хэлж чадна. Энд ямарваа нэгэн жижиг сажиг асуудал байхгүй гэдгийг олон нийтэд хэлэх хэрэгтэй байх. Мэдээллийн хэрэгслээр буруу зөрүү ойлголтуудыг түгээдэг. АН жижиг зүйлээр шантааж хийж байна гэдэг бол зарчмын шаардлагууд байсан гэдгийг хэлье.

Энэ төгсгөлийн асуулт дуусаж байгаа юм байна. Тэгэхээр Ерөнхий сайдаа, 2026 онд яг юу өөрчлөгдөх вэ? Бид нар ингээд ард иргэдийн итгэлийг алдаад эдийн засгаа унагаад...(минут дуусав)

Г.Занданшатар: Би зөвхөн хяналтын болон бүтээмжийн менежерийн тухай асуудал огт яриагүй. Төрийн чиг үүргийг дахин инженерчлэл ард иргэддээ ээлтэй, олон түмэнд тустай, хяналттай, авлигагүй, ил тод төрийн тогтолцооны бүтцийг дахин том утгаар нь засаж залруулах асуудал юм. Энэ 16 дэд сайдын ч асуудал биш, 220 мянган төрд ажиллаж байгаа хүмүүсийг үр дүн бүтээмжид нь уялдуулж цалинжуулдаг, үр дүнг нь хянадаг тогтолцооны тухай ярьж байна. Тэр 16 дэд сайд үр дүнтэй, бүтээмжтэй, өгөөжтэй ажиллаж байвал ард иргэддээ хэрэгтэй асуудал шийдэж байвал тэр хүмүүс ажиллах ёстой. Аль эсвэл тэр бүтээмжийн ч, хяналтын ч байна уу менежерүүд үр дүнгүй зардал гаргаж байгаа, ямар ч ажил хийж бүтээгдэхгүй байгаа тэр орон тоонуудыг цомхотгох ёстой. Энэ бол орчин үеийн төрийн чиг хандлага. Үүнтэй нийцүүлсэн цогц өөрчлөлт хуулийн төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барихаар төлөвлөж байна. Нийт

төрийн албаны бүтцийн дахин инженерчлэлийн асуудал ярьж байгаа. Ингэж байж ард иргэддээ ойрхон, ээлтэй, хүнд суртал, чирэгдэлгүй, авлигагүй ээлтэй төрийн алба үйлчилгээг бий болгох ёстой.

Түүнээс биш зөвхөн 16 дэд сайдын асуудал биш. Төр үндсэндээ шуурхай, ард иргэдтэй ойрхон байх нь ардчилсан төрийн хамгийн гол эрхэм зорилго байх ёстой.

Зөвхөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр үнэлгээг олон улсын аргачлалаар хийж үзэхэд, 114 огт шаардлагагүй чиг үүрэг байна. Байгаль орчны яаман дээр орон нутаг болон улсын хэмжээнд 1900-аад давхардсан чиг үүргүүд байна. Чиг үүргүүдийг оновчтой хуваарилж, процессыг дахин инженерчилж байж хэн юуг хариуцах гэдэг асуудлууд тодорхой болохгүй бол салбар бүр хяналтгүй болсон. Хяналт гэдэг бол авлигагүй тогтолцооны суурь юм. Бас ард иргэддээ ойрхон үйлчилгээний тогтолцоо юм.

Н.Учрал: Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн дарга 37 минут 30 секунд асуулт асууж дууслаа. Цөөнхийн бүлгийн гишүүд асуулт асууна. Цөөнхийн бүлгийн гишүүдийн нэрс гарсан байна.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Ер нь дэд сайдуудаа татвал зүгээр байсан юм гэдэг үгээр асуултаа эхэлье.

Нэгдүгээрт, амьжиргаа, бодит үр дүнтэй холбоотой асуулт байгаа. Засгийн газар 5 жилийн хөтөлбөрөө дэвшүүлээд явж байгаа. Тэгэхээр Ерөнхий сайд аа, нэг талаас засаг нь тоо баримт яриад байдаг, нөгөө талаас сөрөг хүчин нь асуулт асуугаад байдаг. Бодит амьдрал дээр хүмүүсийн хүртээмжтэй эдийн засаг буюу англиар хэлбэл “inclusive economy” гэж яг нэг иргэний бодит амьдралд амьжиргаа болж орж байна уу, үгүй юу? гэдэг л асуулт байгаа.

Тэгэхээр та 2026 оны наадам гэхэд, 2026 оны шинэ жил гэхэд ч юм уу 6-12 сарын үечлэлтэй ямар хэмжигдэхүйц үр дүнд эдийн засгаа өсгөсөн байна гэж тооцож байгаа вэ? гэдгийг сонсмоор байна.

Хоёрдугаарт нь Хүний эрхийн дэд хороонд ирсэн нэг гомдол ирсэн учраас энэ нь эргээд амьжиргаатай шууд холбоотой учраас асууя гэж бодож байна. Хөдөлмөрийн хуулийн 101 дүгээр зүйлд цалин хөлстэй холбоотой, цалин хөлсний үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдэнэ гэж заасан байгаа. Төрийн албаны хуулийн 9.2-т төрийн албаны зардлыг бууруулах талаар төрөөс авах арга хэмжээ гээд тодорхой зохицуулалтыг оруулсан байгаа. Гэтэл Засгийн газар шийдвэр гаргаад урамшууллыг хассан гэж ойлгож байгаа зөв үү? Энэ шийдвэрийн дараа ийм төрлийн гомдол ирээд байгаа. Дээр үед Засгийн газрын 20 дугаар тогтоол гарахыг мэдээд дотор нь байсан хүн гарч яваад 2 диктафон худалдаж аваад хэрэгт орлоо гэдэгтэй адилхан зүйл байгаа. Сангийн яам урамшууллаа өөрсдөө

авсан байна, бусад хүмүүсийн урамшууллыг хаслаа гэдэг гомдол ирээд байгаа. Хүний эрхийн дэд хороон дээр ирж байгаа энэ гомдлыг би уламжилж байна. Ерөнхий сайдаас энэ дээр хариулт авъя. Тэгээд асуулт асуух олон хүмүүс байгаа учраас асуултаа ингээд товчхон дуусгачихъя.

Г.Занданшатар: Би таны 3 асуултад хариулъя. Та бүхэн төрийн хуулийг дагана гэж Улсын Их Хуралд тангараг өргөдөг тийм үү? Бид хууль дагах ёстой юу? Хууль дагаж мөрдөх ёстой.

Засгийн газрын тухай хуулийн 18⁴-д сайдынхаа өмнө тодорхой үүрэг чиглэл хариуцах дэд сайд байна гэсэн байгаа. Төрийн дахин инженерчлэл хийсэн олон улсын байгууллагуудын дүгнэлтээр дэд сайд буюу хяналтын механизм байхгүйгээс яамдад хууль зөрчигдөх нөхцөл байдлууд үүсэж байна гэж гарсан байгаа. Тэгэхээр би хууль биелүүлэх үүрэгтэй.

Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхий сайд хууль биелүүлэх ажлыг хариуцах ёстой. Хуульд нь дэд сайд байна гээд заасан. Би хууль биелүүлэх үүрэгтэй. Хууль биелүүлээгүйгээс гарсан үр дагаврыг сүүлд нь хууль хүлээлгээгүй Засгийн газар хариуцна.

Тийм учраас би хуулиа л хэрэгжүүлж байна гэдгийг хэлээд байна. Энэ зөвхөн хуульд биш дэлхий нийтэд байгаа жишиг байна. Гүйцэтгэх засаглал, дэд сайдыг ажиллуулдаг жишиг дэлхийн бүх улсад байна. Дэд сайдын ажлыг олон салбар нэгжтэй бүх системд авч явж байгаа. Бүх улсад түүнтэй төстэй ямар нэгэн байдлаар, парламент хариуцсан ТНБД, хэдэн арваараа дэд сайдууд ажиллаж тухайн яам салбарын ажлууд явж байна. Нэршил нь янз бүр боловч эрх үүрэг нь дэд сайдын статусаар салбарын бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагуудын уялдаа холбоо парламенттай харилцах харилцааг зохицуулахад чухал үүрэгтэй байна. Ингээд дэлхийн бүх улсуудад байгаа систем манайд хэрэгжээгүй нь асуудалтай байна гэдгийг би хэлмээр байна. Таны сүүлд асуусан асуултуудтай зарчмын хувьд санал нэг байна. Энэ дээр урамшуулал хасаагүй. Эхний 3 улирлын урамшуулал олгосон.

Дөрөвдүгээр улирлын урамшууллыг даргын үзэмжээр олгоод байгааг больж бүтээмж, үр дүнд суурилсан ажлын үнэлгээний үндсэн дээр урамшуулал олгодог тогтолцоог...(минут дуусав)

Н.Учрал: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуултаа асууя.

С.Цэнгүүн: Бүтцээ томруулах болохоор та Үндсэн хууль, бусад хуулиа биелүүл гээд яриад байх юм. Хэрвээ Монгол Улсад хуулиа биелүүлдэг байсан бол бид нарт хуулиа биелүүлэх ёстой маш олон зүйлүүд байгаа. Хариуцлагаа хүлээдэг байсан бол маш олон сайд нар өнөөдөр сайдын ажлаа хийхгүй байх ёстой байсан. Дэд сайд томилох болохоор л бид нар хуулиа барьж байна гээд яриад байгаа нь шалтаг юм шиг санагдаж байна. Та хэд дэд сайд гэдэг зүйлээ анхнаасаа оруулж ирэх ёсгүй ч байсан. Одоо ч гэсэн татаад авах ёстой гэдэг дээр хатуу байр суурьтай байна.

Тэгэхээр миний асуулт бол олон улсын түвшинд эрчим хүчний салбарыг либералчлахдаа түгээх, хангах салбараас нь эхэлдэг туршлагатай. Олон улсын байгууллагууд ч тэр, манай эрчим хүчний салбарын мэргэжилтнүүд бүгдээрээ хэлж байгаа нь түгээх, хангах салбараас бид хувьчлалыг хийх ёстой гэж байхад эсэргүүцэж байгаа юм шиг ТЭЦ-3, ТЭЦ-4 гэсэн хуучны цахилгаан станцуудаас эхэлж байгаа нь 2.3 жилийн дараа энэ салбарын үнийг чөлөөлөөгүйгээс болж эдгээр станцуудын үйл ажиллагаа доголдож эхэлнэ. Тэр үед нь энэ хувьчлал буруу байсан юм байна. Эрчим хүчний реформ ерөөсөө хэрэггүй байсан юм байна гэдэг зүйл рүү явуулах алдаа давтагдах гээд байна.

Тийм учраас эрчим хүчний реформыг явуулах ёстой, либералчлах хийх ёстой. Гэхдээ бодлогоо маш зөвөөр тодорхойлж хийх ёстой. Энэ үнэ тарифыг төрөөс бариад байдаг. Дулааны үнэ, цахилгааны үнэ тарифыг нэмэхгүй гээд та чуулган дээр хэлж байсан. Гэхдээ өнөөдөр Ерөнхий сайдад тэгэх эрх нь хуульд байхгүй. Улсын Их Хурлын гишүүнд ч энэ дулаан цахилгааны үнийг нэмэх эрх нь хуулиар байхгүй. Эрчим хүчний зохицуулах хороо л үнэ тарифын асуудлуудыг хуулиар зохицуулах үүрэгтэй. Сүүлийн 10 гаран жилийн хугацаанд улс төржилтөөс болж үнэ тарифыг өөрчлөхгүй явж байгаад гэнэт 10, 20 дахин нэмээд явдаг. Улс оронд иргэд, ААН-үүд төлөвлөх боломжгүйгээр гэнэт өндөр дүнгээр үнийн нэмэгдлүүдийг хийдэг. Өмнөх онд Б.Чойжилсүрэн сайдад бид энэ үнийг шууд хэд дахин нэмж өөрчилж болохгүй гэж хэлж байсан. Бага багаар, жил болгонд нь, ард иргэдэд...(минут дуусав)

Г.Занданшатар: 1 дүгээрт хууль тогтоох байгууллага хууль сахиж мөрдөх ёсгүй гэж хэлж болохгүй. Хууль дээдлэх тангараг өргөдөг. Би бүх хуулийг мөрдөж байгаа. Бид жишээлбэл төрийн албаны тоог 9 хувиар цомхотгож, хууль биш тогтоомжийг хэрэгжүүлсэн. 9 хувь гэдэг асар том тоо шүү. Хэдэн мянган хүнийг ажлаас чөлөөлөөд ажил үүргийн хийдэл, зөрчил, давхцал гаргахгүйн тулд, төрийн хяналт механизмыг ажиллуулахын тулд хуульд заасан чиг үүргээ л хэрэгжүүлж байна гэдгийг хэлж байна. Хэрвээ энийг шаардлагагүй гэвэл та хууль санаачлаад түүнийг хэрэгжүүлж болно. Эрчим хүчний либералчлах ч гэсэн тэр. Та бүхний хандлага буруу байна. Ард иргэдэд үүрүүлэх ачааллаас нь эхлэх гээд байна. Та нар цахилгаан дулааны үнийг нэм гэж шаардаад байгаа юм.

Энэ бол суурь үнэ байдаг учраас инфляцад шууд нөлөөлдөг ард иргэдийн халаасанд шууд орно. Цахилгаан эрчим хүчний үнэ шингээгүй нэг ч бүтээгдэхүүн байхгүй. Энэ суурь үнэ. Энэ суурь үнийг сууриас эхлэх ёстой.

Яагаад гэвэл нүүрс үйлдвэрлэж байгаа өртөг авлига, үр ашиггүй системээс болоод өндөр үнэтэй болоод байна. Түүн дээр хувь иргэдийн тодорхой хяналт бий болгох хэрэгтэй байна. Цахилгаан станцуудыг хувьчлах гээд байгаа юм биш. Хувийн цахилгаан станцууд аль хэдийн гэрээ байгуулаад эхэлсэн байна. 9 центээр худалдаж авч байна. Гэтэл иргэдэд нийлүүлж байгаа үнэ өөр байна. Тэгэхээр чөлөөл гэсэн үг биз дээ. Чөлөөл гэдэг бол нэм гэсэн үг. Тэгэхээр бие биеийгээ хуураад яах вэ? Жишээлбэл, хувийн цахилгаан станц 9 центээр нийлүүлээд эхэлсэн.

Тэгтэл Монгол шуудан компанийн 34 хувийг олон нийтийн болгож биржээр арилжаалснаар ашигт ажиллагаа, үр ашиг нь 1,6 дахин сайжирсан байна. Иргэдийн хяналт бий болгож байгаа. Түүнээс биш стратегийн ач холбогдолтой салбаруудыг хувьчлах гээд байгаа зүйл огт байхгүй. Уурхайнууд дээр ард иргэдийн хяналтыг болгоё, тэр станцууд мөн ард иргэдийн хяналтыг дээр бий болгоё. Ингээд түгээх дамжуулах...(минут дуусав)

Н.Учрал: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаясгалан: Та хуулийн дагуу дэд сайдуудыг тавьж байгаа юм байна. Тэгэхээр дэд сайд гэдэг шагнал юм уу, ял юм уу? МИАТ компанийг 10 тэрбум төгрөгний өрөнд оруулсан хүн өнөөдөр дэд сайд болсон. Энэ шагнал уу? ял уу?

Дээрээс нь Ерөнхий сайдаа Монгол Улсад тогтвортой үйл ажиллагаа явуулдаг 99 мянган ААН байдаг юм байна. Үүнээс 70 гаруй мянган ААН нь татварын өртэй. Татварын хүлээгдэж байгаа өр 6,2 их наяд төгрөг байна.

9 мянга гаруй ААН дансаа хаалгасан. Та түрүүн 4 мянга гаруй гэж хэллээ. Буулгасан бол сайн байна. Тэгэхээр одоо би нэг бодит жишээ асуух гээд байна. Иргэн “А”-ын компани төрөөс тендер аваад 400 сая төгрөгний ажил хийж гүйцэтгэсэн. Мөнгөө авч чадаагүй. НӨАТ-ын өр нь 40 сая төгрөг. Гэтэл өнөөдөр татварын байгууллагаас 40 сая төгрөгийг авахын тулд дансыг нь хааж байгаа. Тэгэхээр нөгөө хүн 40 сая төгрөгөө төлөхийн тулд Банк бус санхүүгийн байгууллагаас 3 хувийн хүүтэй зээл авч байна. Төр өөрөө өглөгтэй мөртөө, өгөх ёстой хэр нь 40 сая төгрөгний төлөө ААН-д ийм дарамт учруулж байгаа нь маш дээрэлхүү бодлоготой байна. Тэгэхээр үүнийг яагаад уян хатан болгож тохиролцоонд хүрч болдоггүй юм бэ? НДШ-ийг тохиролцоод, графикаар төлөөд явдаг. Татвар дээр бас ийм байж болох талтай.

Г.Занданшатар: Татварын байгууллагууд дээр татварын реформын талаар хэлэлцүүлэг хийгээд данс хаахгүй, зөвлөн туслахыг илүү түлхүү баримтлах чиглэл өгсөн. Гэхдээ буруу хандлага хүлээлтийн улмаас санаатайгаар татвар төлөхөөс зайлсхийгээд байгаа уул уурхайн болон өөр бусад компаниуд дээр тодорхой хэмжээний шаардлага тавих хууль эрх зүйн орчин нь татварын байцаагчид байгаа. Ийм учраас үүнийг хуулиар зохицуулахаар Татварын багц хуульд тусгасан. Би 4398 ААН-ийн дансыг хаасан байсныг нээсэн гэж хэлсэн. Одоо бусад ААН-үүдийн дансууд үе шаттайгаар нээгдэнэ. Таны хэлж байгаа шийдэлтэй холбоотой асуудал голдуу он дамнасан хөрөнгө оруулалтууд байгаа. Үүнийг он гараад шийдэж болно. Он дамжаад тэдний хөрөнгө оруулалтын зардлыг шийдэж болно. Он дотроо дуусаж байгааг аль болох гүйцээж өгөх чиглэл барьж байгаа. Өртэй, татвартай асуудлыг нь яриад зөвлөн туслах маягаар шийд гэсэн чиглэл өгөөд явж байгаа.

Асуудлын гол нь Улсын Их Хурлаас Төсвийн хуульд бид 1 их наяд 300 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталсан. Тэгэхээр зардлаа санхүүжүүлэхээр тэрийг давах гээд байгаа учраас асуудал үүсэж байгаа. Төрийн

сангийн данс мөнгөтэй байгаа, энэ асуудлыг шийднэ. Гагцхүү он дамнасан хөрөнгө оруулалтуудыг он гаргаад өгнө. Харин Төсвийн хуульд захирагдсан зарим зохицуулалтыг Сангийн яамнаас хийж байна. Урамшууллын хувьд эхний 3 дугаар улирлыг олгосон, 4 дүгээр улирлын урамшууллыг он гаргаад эхний улиралд шийдэж явдаг. Ажлын гүйцэтгэл үр дүнгээр нь шийдээд явна.

Татварын тодорхой кэйсүүд дээр санал гомдлууд байвал үүнийг татварын маргаан таслах зөвлөлд өгч болно. Тус зөвлөлд татварын гомдол маргааныг илүү хялбарчлан шийдвэрлэх чиглэл өгчихсөн байгаа. Одоо хуулиа л өөрчлөхгүй бол татварын байцаагчийн эрхийг Ерөнхий сайд ч өөрчлөх эрхгүй. Тийм учраас Татварын багц хууль дээр та бас...(минут дуусав)

Н.Учрал: Нэмэлт нэг минутыг Л.Мөнхбаясгалан гишүүнд өгье.

Л.Мөнхбаясгалан: Та хуулиа биелүүлж дэд сайдуудыг тавьж байгаа. Тэгэхээр дэд сайд гэдэг шагнал юм уу? эсвэл ял үүрүүлж байгаа юм уу? МИАТ компанийг 10 тэрбум төгрөгний өрөнд оруулсан хүн өнөөдөр дэд сайд болж байна. Энэ хүн шийтгүүлээд байгаа юм уу? Шагнуулаад байгаа юм уу? Уг нь бол хариуцлага тооцох ёстой гэж би бодоод байна. Хуулиараа ямар байдаг юм бэ?

Г.Занданшатар: Ер нь орчин үед төрийн аливаа ажил, албан тушаал нэг талаас хариуцлага болсон. Тэрийг та ял гэж хэлж байх шиг байна. Гэхдээ бид тэр хүнийг шалгаж үзсэн. Хүн шийтгэхэд хүндэтгэн үзэх шалтгаан хэрэгтэй. Тэр 10 тэрбумын алдагдалтай гээд чөлөөлсний дараа нь нарийвчилсан шалгалт хийхэд энэ нь авиа бензиний үнийн өсөлт, өөрөөр хэлбэл авиа бензиний гэрээ хэлэлцээр Улсын Их Хурлаар батлаагүйгээс шалтгаалаад үнэ нь өндөр болоод, зах зээлийн үнээс 30-40 хувиар өндөр шатахууны нийлүүлэлт хийснээс шалтгаалсан алдагдал үүссэн учраас хувь хүний буруу биш харин тодорхой ахиц дэвшил гаргасан, борлуулалт нэмэгдүүлсэн, үр дүнтэй байсан байна. Тийм учраас тэр алдагдлын шалтгааныг бид нарийвчилж судалж үзээд үүнийг аялал жуулчлалаар нөхөх чиглэл, үүрэг даалгавар ногдуулсан гэж үзвэл зохино. Үүрэг даалгавар өгч байгаа.

Н.Учрал: Даваагийн Цогтбаатар асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Энэ өдрийн мэнд хүргэе. Та тоо худлаа ярихгүй гэж ярьдаг. 16 дэд сайд томилсон. 1 дүгээр асуулт, хэзээ ямар үр дүн гаргах вэ?

2 дугаарт нь, Монголчууд “Долоо хэмжиж нэг огтол” гэдэг. Та алдаатай шийдвэр гаргаж болохгүй, хамгийн хариуцлагатай албан тушаалтан. Та дэд сайд нараа сайн судалсан уу? Энэ 16 дэд сайдын ХАСХОМ-той маш сайн танилцсан. Иргэдээс ирүүлж санал хүсэлт дотор бол 3 дэд сайдын боловсролын сангийн зээлээр авсан 7-10 жил болж байгаа төлөгдөөгүй зээлийн өрийн үлдэгдэл байна. Энэ бол зээл. Зээл бол төлөгдөх ёстой, тэглэгдэх ёсгүй. Энийг та ч мэдэж байгаа, би ч мэдэж байгаа. Эдийн засаг ойлгодог бүх хүн мэдэж байгаа. Тэгээд энэ дээр та ёс зүйн хариуцлага хүлээлгэж чадах уу?

Гуравдугаарт, Булган аймгийн Засаг даргын асуудал байна. Иргэдийн хурал нь та ажлаа зохион байгуулж чадахгүй байна, болохгүй байна гэдэг дүгнэлт гаргаад Танд хүргүүлсэн. Гэтэл Булган аймгийн Засаг дарга өнөөдрийг хүртэл ажлаа хийгээд яваад байгаа. Яг энэ нөхцөл байдал 4 дүгээр асуудалтай холбоотой Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг даргын асуудал байна. Энэ асуултад хариулт өгөөч.

Г.Занданшатар: Манай Улсын Их Хурлын энэ мэтгэлцээний цаг, парламентын мэтгэлцээний цаг гэж бид ойлгож байгаа. Урьдчилан асуулт асуух нь дүүрч. Гэхдээ ингээд бүх талын асуултауд асуудаг “УВ” комедиагийн дайралцаа шиг байж болохгүй гэж бодож байна. Дайралцаа нь ч гэсэн логиктой байх ёстой. Тэгэхдээ дэд сайд нарын асуудлуудыг хянадаг, шалгадаг газар тусдаа, хариуцлага тооцуулаад явах ч гэсэн хуулийн дагуу шийдэгдэнэ.

Хамгийн гол нь үр дүн нь бүтээмжтэй ажиллах ёстой. Ер нь 2015 онд Ардчилсан нам засаглаж байх үед боловсролын зээлийн санг анх тухайн үеийн Ерөнхийлөгчийн санаачилгаар эхлэхдээ төрд ажиллаж, энэ хүмүүс мэдлэг, ур чадвараараа зээлийн өрөө төлөх ёстой гэсэн агуулгаар баталсан юм байна. Одоо энэ хүмүүс энд ажиллаж үр ашгаа өгч, сурсан мэдсэн мэдлэг чадвараа Монголдоо зориулж тухайн гадаад улсад үлдчихгүй, гадаадад явчихгүй, тархи оюунаа гадагш нь алдахгүй улс орондоо ажиллаад улс орныхоо төлөө шинэ бүтээл, санаачилга гаргаад, олон тэрбум төгрөгийн үр ашигтай бодлого хөтөлбөр хэрэгжүүлээд ажиллаж чадвал харин үр дүнгээ өгнө гэсэн үг.

Түүнээс гадаадад сурсан болгоноо гадагшаа тавьж явуулаад байвал хайран улсын мөнгө болно. Тийм учраас одоо энэ хүмүүсээс хариуцлага, үр бүтээмж, үр дүн л нэхэж шаардаж ажиллах ёстой. Энд 30 хоногийн хугацаатай, 300 хоногийн хугацаатай даалгавар өгөөд байгаа. Салбар болгонд тодорхой ахиц дэвшил, үр дүн, хариуцлага тооцож ажиллах чиглэл өгөөд ажиллаж байгаа. Үүнийг тухайн үед нь хараад дүгнээд та асууж, жич уулзаад явж болно.

Булган аймгийн Засаг даргын асуудал бол Үндсэн хуулийн цэц дээр маргаан үүсээд явж байгаа гэж ойлгосон. Тэгэхдээ Цэц дээр маргаан үүсгэсэн асуудлаар цэцийн шийдвэр маргаан гарсны дараа таслан шийдвэрлэх хуультай. Тэр сумын Засаг даргын асуудлыг та надаас илүү өөрөө мэдэж байгаа учраас улс төрийнх нь хувьд өөрөө очоод зохицуулаад шийдээд явах нь зөв байх. Орон нутгийн иргэдийн хуралд...(минут дуусав)

Н.Учрал: Нэмэлт нэг минутыг Да.Цогтбаатар гишүүнд өгье.

Да.Цогтбаатар: Би Танд баримтыг нь харуулья. Ганболдын Уянга 2018-2020 онд 317 сая төгрөгийн зээл авч сурсан. Одоо болтол төлөөгүй. Д.Гантулга 1997-1999 онд 92 сая төгрөг авч сурсан. Тэглүүлсэн төлөөгүй. Энэ Г.Уянга бол Гантулгын эхнэр юм байна.

Г.Занданшатар: Г.Уянга гэж дэд сайд байхгүй.

Да.Цогтбаатар: Ганболдын Уянга. Улсын Их Хурлын гишүүн байсан Ганболд сайдын охин. Улс төрд, мэдээлэлд нөлөөтэй байсан хүмүүс давуу байдлаа ашиглаж танай Зам, тээврийн дэд сайд Ганболдын Уянга гэдэг хүнийг би яриад байна. Тэгээд би таныг энэ хүмүүсээ бүрэн сайн судалж байж томилсон уу? Та 7 хонож байж нэг огтлох ёстой. Хамгийн хариуцлагатай шийдвэрийг гаргах ёстой хүн гэж асуугаад байна.

Г.Занданшатар: Миний мэдэж байгаагаар Ганболд дэд сайдын охин Улсын Их Хурлын гишүүн байхад нь Ерөнхийлөгчийн тэтгэлэгт шалгараад, тэгээд өөрөө татгалзсан. Өндөр албан тушаал хашдаг учраас охин нь онц сайн сурдаг өндөр чадвартай хүүхэд байсан боловч татгалзсан. Энэ бол бие даасан субъектүүд. Үндсэн хуулийн дагуу таны ахын ч, тэр хүний хүүхдийн асуудлыг, гэмт хэргийг бусдад нь нялзаадаггүй. Гэхдээ тэр тусдаа асуудал. Зээл авах бол гэмт хэрэг биш. Зээлээ төлөх л ёстой.

Н.Учрал: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуултаа асууя.

Ч.Лодойсамбуу: Манай Ерөнхий сайд логик нэхээд байна. Би логик ярьж өгье. Миний минутыг 3 минутаар нь бүтэн өгөөрэй. Монгол Улс Ерөнхий сайдаа хайгаад байна л даа. Монголчууд Монгол Улсын Ерөнхий сайдыг олж харахгүй байна. АНУ-д сургууль төгссөн боловсролтой, тогтуун. Сүүлд Улсын Их Хуралд олон удаа суусан. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг гардан зохион байгуулсан эрдэм мэдлэгтэй Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга байсан. Шатар тоглодог, ном уншдаг ухаантай хүнийг харж байна, сайхан ухаантай Монгол ахыг харж байна.

Гэхдээ энэ хүнээс Ерөнхий сайдыг олж харахгүй байна. Яагаад ингэж байна вэ гэвэл Монголчууд үе үед Ерөнхий сайд шиг Ерөнхий сайд нарыг харж байсан. Тусгаар тогтнолынхоо төлөө амь биеэ үл хайхран зүтгэж байсан Ерөнхий сайд нарыг харж байсан. Өмч хувьчлалыг хийж чадсан Ерөнхий сайдыг харж байсан.

“Таван төгөлдөршил” гэж нэрлээд “Атрын 3 дугаар аян” гэж хэрэгжүүлээд эхний 200 хоногтоо үр дүнгээ танилцуулж байсан Ерөнхий сайдыг харж байсан. Шинэчлэл бол сэтгэл хийж гаргаж хийх ажил юм гээд шинэчлэлийн бодлогоо 100 хоногтоо танилцуулаад 200 дахь хоног дээрээ үр дүнгээ танилцуулж байсан Ерөнхий сайд нарыг харж байсан учраас Монголчууд өнөөдөр Ерөнхий сайдаа хайгаад байгаа. Өнөөдөр яагаад Ерөнхий сайдыг хайж байна гэж хэлж байна гэвэл Монголчууд өнөөдөр өрх бүр, өрхийн гишүүн болгон амьдралд нь наалдахгүй тоо яриад байдаг, амьдрал нь дордоод доройтоод байгааг анзаарахгүй байгаа тэр төрийг хараад гомдоод байгаа. Хамгийн сүүлийн нэгхэн тоог хэлье.

11 дүгээр сараас өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэгхэн сарын дотор 6.7 хувиар өссөн статистик харагдаж байгаа. Эдийн засгийн өсөлт нь өрхийн хаалгаар орохгүй байгааг энэ тоог жишээ болгож харуулж байгаа. Бид өрхийн амьжиргааг ярихгүйгээр баахан тоо яриад байгаад л Монголчууд гомдоод байгаа.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Би бас “Улаан бал” нэвтрүүлэг хөтөлж байсан, шударга үнэний дуу болж байсан Ч.Лодойсамбуу гишүүнийг хайж олж харахыг хүсэж байна.

Энэ инфляц жилд 14 хувиар өсөж байхад, Ковидын шалтгааны улмаас бараа бүтээгдэхүүний үнэ 2.3 дахин өсөж байхад, тэгээд өнөөдөр энийг нь сааруулаад бид өөрчлөлт гаргаж байхад яагаад олж харахгүй байгаа юм бол? Мэдээж инерцээрээ хүний амьдрал нэг өдөр сайн сайхан болчихгүй, 6 сарын дотор сайн сайхан болчихгүй. Өнөөдөр харин 53 хүнсний үйлдвэр шинээр нээгдсэнийг яагаад олж харахгүй байгаа юм бол? Яагаад хүнсний хангамж, бүтээгдэхүүн сайжирч байгааг яагаад олж харахгүй байгаа юм бол? Яагаад инфляц саараад 8.2 хувь болж байгааг дандаа тоо гэж үзэж байгаа юм бол? Өнөөдөр валютын ханш нүдэн дээр 3605-аас 4000-д хүрэх гэж байхад энийг бид 3550 болгож бууруулж байгааг яагаад харахгүй байгаа юм бол? Энэ хүний амьдралд наалдацгүй гэж үү? Ийм бодит үнэнийг олж харахгүй яагаад заавал юмыг үгүйсгэж хараад байгаа юм бол? Яагаад дандаа үгүйсгэхийн тулд биш болж бүтэж байгаа юмыг нь хараад ажиллаж болдоггүй юм бол? Яагаад энэ дээр хамтраад хууль санаачлаад, жишээлбэл үнийн өсөлтийг шийдвэрлэх ард иргэдэд амьжиргаанд шийддэг асуудлыг Улсын Их Хурлын гишүүний хувьд хамтраад ажиллаж болдоггүй юм бол? гэх мэтчилэн ингээд тайлбарлаад байвал болно. Тэгэхдээ инфляцыг өдөөж байгаа хамгийн гол хүчин зүйл болох нийлүүлэлтийн инфляц, эрэлтийн инфляцыг бид хязгаарлалаа. 2.3 их наяд төгрөгөөр төсөв таналаа. Энэ төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулж, 9 хувь гэдэг асар том тоо, олон мянган хүний асуудал байгаа. Төсвийн 5.2 их наядаар унах байсан. Ингээд унаж байгаа бүх юмыг тоормослоод, зогсоогоод хошууг нь дээш нь өргөж байгаа энэ бүхнийг үгүйсгээд байгаа юм бол?

Н.Учрал: Ч.Лодойсамбуу гишүүнд нэг минут өгье.

Ч.Лодойсамбуу: Таныг энэ өрхийн амьжиргаатай холбоотой өрхийн санхүү муудаж байгааг олж харахгүй байгааг харин бүгд гайхаад байгаа учраас асуугаад байгаа юм. Хамгийн сүүлийн жишээ. Та хэмнэлтийн горимд шилжиж, тэтгэврийг нэмэгдүүлэхийн тулд хэмнэх албан даалгавар гаргасан байна. Жишээлбэл та шинэ жилээр тэтгэвэр нэмэх гэж байна гэж мэндчилгээ дэвшүүлэх гэж байгаа юм шиг байна. Гэтэл тэнд цалин урамшууллаа хасуулсан төрийн албан хаагчдын нэг халааснаас нь аваад нөгөөд шилжүүлэх нь нэг өрхөөс мөнгийг нь аваад нөгөө өрх рүү шилжүүлэх гэж байгаа улс төрийн PR болгож ярих гэж байгаа.

Өнөөдөр Монгол Улс яагаад ийм сэтгэгдэлтэй байна вэ гэвэл өнөөдөр баярын уур амьсгалтай байгаа нэг ч айл өрх алга. Өнөөдөр Ерөнхий сайд 12 дугаар сарын 31-ний өдрийн орой ямар мэндчилгээ дэвшүүлэх юм, юу хэлэх юм бэ? Ямар ерөөл хэлэх вэ? Ямар итгэл найдвар бид нарт байгаа юм бэ?

Г.Занданшатар: Ч.Лодойсамбуу гишүүн ээ, би шинэ жилээр сэтгүүлч хүн шиг гоё мэндчилгээ дэвшүүлэхдээ гол биш, яг бодитой, наалдацтай үр дүнгүүдийг гаргахыг л эрхэмлэж байгаа. Таны нэг карманаас аваад нөгөө карманд өгч байгаа зүйл байхгүй. Таны баталсан, та бидний баталсан улсын төсөвт багш нарын цалинг 70 хувиар, бүх тэтгэвэр тэтгэмжийг 8.6 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан байгаа. Ийм хууль батлаад л үүнийг бид хэрэгжүүлээд явж байгаа. Тэр урамшууллын талаар би түрүүнд хэлсэн. Эхний 3 улирлын урамшуулал олгогдсон. 4 дүгээр улирлын урамшууллыг оны эцэст бүтээмж, үр дүнд нь суурилж, даргын үзэмжээр хуваарилдаг тогтолцоог халж хэн ажлаа сайн хийж байгаа нь, хариуцлагатай хийж байгаад нь урамшууллыг нь олгодог шинэ тогтолцоонд шилжүүлж байна.

Н.Учрал: Батбаярын Жаргалан гишүүний микрофоныг нээе.

Б.Жаргалан: Өнөөдөр Улсын Их Хурлаас Оюу толгой төслөөс Монголын талд ногдох өгөөжийг 53 хувиас доошгүй байлгах асуудлыг баталгаажуулах чиг үүргийг Засгийн газарт өгсөн тогтоол батлагдсан. Тэгээд бид хэд сая хэвлэлийн хурал хийхэд сэтгүүлч өмнө нь Улсын Их Хурлаас удаа дараалан хэд хэдэн тогтоол баталсан ч тэдгээрийн хэрэгжилт маш муу байгаа нь сая сонсгол дээр ч гэсэн яригдсан. Энэ тогтоол хэрэгжих үү? гэж асууж байна. Ноднин бид Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар агаарын бохирдолтой холбоотой нээлттэй Хяналтын ерөнхий сонсгол хийсэн. Үүний дараа Улсын Их Хурлаас утаатай тэмцэх асуудлаар нэг тогтоол баталсан. Тэр тогтоолын хэрэгжилтийн талаар би Танд удаа дараалан албан бичиг явуулсан. Харамсалтай нь энэ тогтоол хэрэгжихгүй байгаад байна.

Тэгэхээр өнөөдөр бид итгэл ярьж байна. Төрд итгэх итгэл үнэхээр алга. Улсын Их Хуралд тодорхой шийдвэр гаргаад байж болж байна. Тэрийг нь хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй Засгийн газар тэр хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргээ огт биелүүлэхгүй байна. Гэтэл та өнөөдөр дэд сайд томилсноороо хууль биелүүлж байна гээд яриад зогсож байдаг. Та нөхөд намаржингаа сандал суудал албан тушаалын хэрүүл маргаан хийлээ. Тэгээд хүмүүс яагаад энэ дэд сайд нар дээр бухимдаад байна вэ гэвэл энэ томилгоо ерөөсөө дуусахгүй байгаад байна. Тэгээд одоо “Би хууль биелүүлж байна” гээд баатар шиг зогсоод байж болохгүй Ерөнхий сайд аа.

Тэгээд та энэ дэд сайд томилж байгаа явдал, ер нь танай Засгийн газарт байгаа сайд нарт ямар ч итгэл төрөхгүй байгаад байна. Энд бодлогын манлайлал харагдахгүй байгаа нь өнгөрсөн цаг хугацаанд Л.Оюун-Эрдэнийн Засгийн газарт ажиллаж байсан сайд нар бүгдээрээ улираад, сандал суудлаа сэлгээд ажиллаж байгаа. Б.Чойжилсүрэн сайд эрчим хүчний салбарт үр дүн гаргана гэдэгт энэ улсад итгэж байгаа хүн алга. Б.Жавхлан сайд яаж ч хичээгээд үр дүн гаргана гэдэгт итгэх хүн алга.

Тэгэхээр таны баг бүрэлдэхүүнд итгэх хүмүүсийн итгэл хүрэхгүй байгаад байна. Тийм л асуудал яригдаад байна. Тэгээд Засгийн газар зөвхөн гарчиг тавих маягаар, гоё аформизмтай, гоё зурагтай постер хийх маягаар ажил хийгээд

байна. Энэ гарчгаар битгий ажил хийгээч. Бид нарт цаг хугацаа маш бага байна. Энэ цаг хугацаа бол та, бидний л адилхан цаг хугацаа. Монголчуудын бүгдийнх нь цаг хугацаа. Тэгээд энэ цаг хугацааг битгий үрээч л гэж байна. Та 2025 оны 6 дугаар сарын 12-нд томилогдсон. Анхны хэлэлцүүлэг, мэтгэлцээн бол таны, танай Засгийн газрын 100 хоног дээр явагдсан. Өнөөдөр та албан тушаалаа аваад 197 дахь хоногтоо ажиллаж байна. Тэгээд надад ганцхан асуулт байна. Танд Ерөнхий сайдын албан тушаалд дахиад 100 хоног, бүүр больё, дахиад 3 хоног ажиллах, үр дүн гаргах итгэл өөрт тань байна уу?

Г.Занданшатар: Энэ таны хэлсэн 187 хоногт уруудаад байгаа эдийн засгийг сэргээсэн байна. Бодит тоо баримт. Та өөрөө эдийн засагч хүн сайн мэдэж байгаа. Эдийн засгийн өсөлт оны эцэст 6.4 хувьд хүрнэ. Хоосон итгэл биш бодит итгэл ярих ёстой. Хоосон шүүмжлэл биш бодит тоо ярих ёстой. Тоо худлаа хэлдэггүй гэж би хэлээд байна. Эдийн засгийн өсөлт 6.4 хувь болгосон байна. Энэ өөрөө болоогүй, валютын нөөц 6.5 тэрбум ам.доллар болно. Валютын ханш 3600-д аваад 4000 хүрэх байсныг өнөөдөр 3545 болгож буулгалаа. Энэ бол тоо баримт өөдрөгөөр харвал, энэ бүхэн сэргэлтийг бодитой харж байгаа. Дандаа хар талаас нь хараад байвал амьдралд нэг ч болж бүтэж байгаа юм байхгүй байж болно. Харин гэрэл гэгээтэй өдрийг бид бас харж урагшаа алхаж байна. Хүнд жил байсан, сорилттой жил байсан. Бүх юмыг сайн сайхан болж байна гэж бид хэлэхгүй. Гэхдээ хүндийг даваад, шийдээд өөдрөг жилийг өгч байна. Ирэх жил хүнд болно. Олон улсын нөхцөл байдал, эдийн засгийн прогноз хүнд байгаа. Гэхдээ бид илүү сайн болгох эдийн засгийг сэргээх 300 хоногийн төлөвлөгөө батлаад ажиллаж байна. Өдөр өдрөөр нь шахаад, хийх функцээр нь шахаад, сайд, дэд сайдтай нь шахаад ажиллаж байна.

Тэгтэл АН-ын бүлэг энэ 300 хоногт улс орныхоо эдийн засгийг сэргээх асуудлын талаар биш 16 дэд сайдын асуудлыг бүгдээрээ асуусаар байгаад өнөөдрийн цагийг барж байгаад харамсаж байна. Бид илүү бүтээлч юм яримаар байна. Монгол Улсад 220 мянган төрийн албан хаагч ажиллаж байна. Энэ 220 мянган төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, үр дүнг сайжруулах, эдийн засаг, үр өгөөжийг сайжруулах асуудлыг бүгдээрээ хамтдаа шийдмээр байна. 53 шинэ үйлдвэр баригдаж байгаа бол үүнийг 100 болгомоор байна. Ингэж байж бид эдийн засгаа сэргээж, татварын реформоо хийнэ. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг батлаад өгөх хэрэгтэй байна. Татварын багц хуулийг хэлэлцмээр байна.

Н.Учрал: Жадамбын Баясгалан гишүүн асуултаа асууя.

Ж.Баясгалан: Энэ өдрийн мэнд хүргэе. Сая 21 аймаг тойроод, нийт 10,012 км замыг 236 цагийн туршид машиндаа явлаа. Ажлын 21 хоногт 21 аймгийн нийт 5600 орчим иргэдтэй уулзаж 3 мянга гаран саналтай ирлээ. Тэгээд эдгээр хүмүүсийн үгийг хэлчихье. Сайдаа нэмэхээр шатахуунаа нэмээч гэж байна. Сонгууль болгоноор Зоригийн хэрэг шиг ярьдаг бас нэг дэд сайд гээд хэрэг гараад ирлээ. Энэ хэргийг нэг мөсөн Хууль зүйн яаманд нь өгөөч гэсэн саналыг ард түмэн хэлж байна. Тэгээд ард түмэн бол уг нь дан дээлтэй сайд нартай больё гэсэн бүүр нэмэгдээд дан дээл байтугай дэд сайдтай боллоо шүү гэдэг саналыг дамжуулж байна.

Гол асуудал гэвэл 1 дүгээрт Дундговь аймгийн хэмжээнд бөөрний аппаратад 23 хүн орж байна. Энэ бөөрний аппаратад орж байгаа 23 хүнээс ЭМД-ын сан хоосорсонтой холбоотой А, Б уусмалаа авч чадахгүйгээс болоод үйлчилгээгээ авч чадахаа байсан. Нэг диализын аппарат нь эвдэрсэн. Үүнээс болоод 23 хүний амь насны асуудал тэнсэж байна. Энэ дээр яах ёстой вэ? ЭМД-ын сангийн асуудал дээр ямар арга хэмжээ авах вэ? Энэ дээр нэг яаралтай арга хэмжээ авч өгөөч. Он дуусах гэж байгаа учраас 21 аймагт ЭМД-ын сантай холбоотой гомдлууд маш их ирлээ. Энэ саналыг Дундговь аймгийн 6 дугаар багийн иргэн Эрдэнэчулуу гэж хүн тавьсан байна. Энэ 1 дүгээр асуулт байгаа.

Г.Занданшатар: ЭМД-ын санг шинэчлэн өөрчлөх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна. Үнэхээр ЭМД-ын санд сахилга батгүй замбараагүй байдал ноёлсон байснаас болоод энэ сан өр үйлдвэрлэдэг сан болсон байсныг өөрчилж, яг ард иргэддээ хүрдэг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ үйлчилдэг асуудлыг нь шийддэг болгож өөрчилж байна. Тус санд 279.6 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн байсныг 200 гаруй тэрбум төгрөг болгож бууруулаад байна. Ер нь ЭМД, нийгмийн даатгалын сангуудын менежментийн шинэчлэлүүд хийгдэж байгаа.

Шатахууны хувьд бол мэдээж ОХУ-ын дотоод нөхцөл байдал, дотооддоо шатахуунаа хязгаарлаж байгаа дайны нөхцөл байдал, довтолгоог та бүхэн сайн мэдэж байгаа. Гэсэн хэдий ч бидний яриа дипломат хэлэлцээний үр дүнд Монгол Улсын шатахуун таслахгүй “нөхрийн хэрэг бүтвэл өөрийн бүтнээ” гээд өөрсдөө хязгаарлаад манайд нийлүүлж байгаа. Сая ч гэсэн 2 дахин шатахуун нэмэгдүүлэх яриа хэлэлцээрийг ярьж шийдээд өнөөдрөөс улам нэмэгдэж байна. Өнөөдрөөс бол ШТС-ууд, хөдөө орон нутгийн хангамжийг сайжруулна. Ирэх 1 дүгээр сард бид нөөцтэй болох бодлого баримталж байна. Үндсэндээ бид мега төслүүд яриад байгаа гэсэн мөртөө шатахууны нэг ч сав бариагүй юм байна. Орос нөхдүүд бидэнд танай улс шатахууны савтай болооч, дүүргээд өгье тэгвэл танай шатахуун тасалдахгүй болно гэж хэлээд байна.

Манай Улаанбаатар хотод гэхэд 100 мянган машин нэмэгдсэн. Бензин шатахууны хэрэглээний хэрэглээ 1 сая тонн байсан бол одоо 2 сая тонн болоод 2 дахин нэмэгдсэн. Гэвч манай ШТС-уудын тоо хэвээрээ, захиалга нь ч хэвээрээ байсан зохицуулалтын алдаануудыг засаж залруулж байна. Ингээд нийлүүлэлтээ ирэх 1 дүгээр сараас тогтворжуулахаар ажиллаж байна. Тэгэхдээ энэ давагдашгүй хүчин зүйл гэж асуудлууд байна.

Н.Учрал: Г.Баясгалан гишүүнд нэг минут нэмж өгье.

Г.Баясгалан: Ирээдүйд авах арга хэмжээг ойлголоо. ЭМД-ын сан хоосорсонтой холбоотой он гартал доголдоод байгаа өвчтэй хүмүүсийн асуудлыг яах вэ? Тэдний амь нас эрсэдвэл энэ асуудлыг хэн хариуцах вэ? Энэ дээр яг тодорхой хариулт авчихъя.

Хоёрдугаарт гэвэл Улсын Их Хурлаас батлагдсан тогтоол хэрэгжих юм уу? Энийг иргэд их асууж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр,

тэтгэмжийг 20 хувь, асран хамгаалагчдын тэтгэвэр тэтгэмжийг 8.6 хувь нэмнэ гэсэн заалт байгаа. Гэтэл 12 дугаар сарын 31-ний өдөр яригдах болоод байна. Энэ дээр яг тодорхой мэдээлэл өгөөч. Та энд нэмэгдсэн гээд яриад байна гэтэл энэ нэмэхгүй болж байгаа юм биш үү? гэдэг айдас иргэдийн дунд маш их байна.

Ахмадуудын хувьд ялгаа алга байна. Тэтгэвэр тэтгэмжийг нь нэмэхээ болих шиг боллоо. Энд яг ямар асуудал байна вэ? Энийг Ерөнхий сайдаас шууд асуугаач гэсэн даалгавар өгсөн.

Н.Учрал: Баярлалаа. Юуны өмнө ард иргэдтэйгээ уулзаж бүх аймгаа тойрсонд нь Г.Баясгалан гишүүнд баяр хүргэе. Ингэж суусан цэцнээс явж ажиллаж байгаа нь сайн байна. Ард иргэдийнхээ асууж байгаа зүйлийг бидэнд хүргэж байгаад талархал илэрхийлье.

Г.Занданшатар: Энэ гэнэтийн асуулт байна. Тэгэхдээ би хариулъя. 36.8 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг түүнээс 16.1 мянган хүүхэд бий. Нийлээд 51 орчим мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмжийг 20 хувиар нэмэгдүүлэхээр Улсын Их Хурал тогтоол баталсан. Үүний дагуу 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдээд явна. Хэрвээ би андуураагүй бол 327,500 төгрөгийн тэтгэмж авдаг хөгжлийн бэрхшээлтэй нэг иргэний тэтгэмж нь 477,500 төгрөг болж нэмэгдэнэ. Түүнээс гадна ойролцоогоор 75 мянган төгрөгийн тэтгэмж авдаг хүмүүс байдаг. Энэ тэтгэмж бас 8.6 хувиар нэмэгдэнэ. Нийт тэтгэвэр, тэтгэмж буюу өндөр насны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж бүгдээрээ жигд 8.6 хувиар нэмэгдэнэ.

Н.Учрал: Минут дууссан байна. Т.Аубакир сайд нэмэлт нэг минутад тодруулж хэлье.

Т.Аубакир: Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд төрийн халамж шаардлагатай иргэдийн орлого амьжиргааг нэмэгдүүлэх хүрээнд нийт 93.3 тэрбум төгрөг зарцуулахаар баталсан. Энэ төсөвт багтаан 2026 онд хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэвэр тэтгэмжийг 20 хувиар, бусад халамжийн тэтгэвэр тэтгэмжийг 8.6 хувиар нэмэгдүүлэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын салбарын төсөвт тусгасан. Тийм учраас Засгийн газрын ирэх Лхагва гарагийн хурлаар шийдэгдээд үндсэндээ 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 8.6 хувь буюу 20 орчим хувиар бүх асаргааны халамжийн тэтгэвэр, шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмжүүд хуульд заасны дагуу нэмэгдээд явна гэсэн залруулгыг хэлье.

Н.Учрал: Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууна. Нэг л гишүүн нэрээ ирүүлсэн байгаа. Даваасамбуугийн Ганмаа гишүүнийг индэрт урья.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Миний асуулт ойлгомжтой. Ерөнхий сайд ойлгож байгаа байх. Эрүүл мэндтэй холбоотой асуулт асууна. 2016 онд батлагдсан Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль гэж байгаа. Энэ хуулийн хэрэгжилтийн түвшин ямар байгаа вэ? Тус хуулийн ямар зүйл заалтууд нь бодитоор хэрэгжихгүй байгаа вэ? Хэрэгжихгүй байгаа гол шалтгааныг та юу гэж үзэж байна вэ?

Энд би нэг товчхон хэдэн үг уншаад өгье. Энэ хуулийг 2016 онд батлахад ард иргэд тэгээд Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн ахлагч, ер нь бүгдээрээ их хүч чадал гаргаж ажилласан байна. Тэгээд их гоё сэтгэгдлүүд бичиж байсныг нь би бүгдийг нь нэгд нэгэнгүй уншсан. Жишээлбэл энэ хуулиар эмнэлгийн засаглалын асуудал төрөөс хараат бус байна.

Хоёрдугаарт, эмнэлгүүд санхүүгийн эрх мэдлээ өөрсдөө авна.

Гуравдугаарт, сонгуулийн үр дүнгээр ялсан намын томилгоо биш. Эмнэлгийн дарга нарыг томилдог хүмүүс нь өөрсдөө, мэргэжилтнүүд, ажилчид нь байна. Туршлагатай, мэргэжлийн, мэдлэгтэй хүмүүс эмнэлгээ удирдана. Төрийн болон орон нутгийн өмчит эмнэлэг нэгдсэн эмнэлгийн захирал нь батлагдсан төсвийг үр ашиггүй ажиллуулахгүй, даатгалын тэнцэтгэл хасахдаа орохгүй. Харин ч цалингаа нэмэх, эмч эмнэлгийн ажилчдаа урамшуулах, цаашилбал гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай ажиллах гэх мэтийн бүх эрх мэдэл нь нээгдэнэ гэх мэтчилэн их сайхан хүлээж авсан байна. Гэтэл энэ хууль батлагдаад 9 жилийн хугацаанд нөхцөл байдал яг тийм биш байгаа. Эдгээр асуултад хариулж өгнө үү?

Г.Занданшатар: 2016 онд батлагдсан Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хуулийн хэрэгжилт хангалттай бус байна. Эрүүл мэндийн салбар 2021 оноос хойших нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж, эрүүл мэндийн багц хуулиар зохицуулж ирсэн. Хуульд зааснаар хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэжлийн нэгдсэн эмнэлэг, клиник түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж үйлчилгээний жагсаалт сонгон шалгаруулалт болон гэрээ байгуулах, хэрэгжилтийг нөхөх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг ЭМД-ын Үндэсний Зөвлөлийн тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Тэгэхээр хуулийн хэрэгжилтэд хуульд заасан журам заавруудыг цэгцлэх ажлыг Засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэн. Одоо мянга гаруй журмыг хүчингүй болгохоор ажиллаж байна. Манай хуульд нийцээгүй энэ мэт журмаар хүний эрхийг хязгаарлаж байгаа, аль эсвэл хуулийн үзэл санааг дордуулж байгаа. Нийт мөрдөгдөж байгаа журам дотроос мянган журмыг хүчингүй болгохоор манай ХЗДХЯ ажиллаж байна. Энэ дотроо төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ болон санхүүжилтийг зарцуулах журмыг Эрүүл мэндийн болон Сангийн сайдын 2022 оны хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байгаа. Энэ бол инфляц, үнийн өсөлттэй уялдуулаад Ковидоос хойших буюу 2022 оноос хойш гарсан эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн өсөлт бусад асуудалтай холбогдуулж шинэчлэхээр 2 яам хамтран ажиллаж байна.

Хуульд заасан энэ бусад дүрэм журмуудыг нийцүүлж хуулийн хэрэгжилтийг хангаж тодорхой болгох ёстой. Ер нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах цогц шинэчлэл хийх зорилгоор ажлын хэсэг байгуулж ажиллаж байгаа. Тухайлбал лабораторийн үзлэгийн стандарт тогтоохоос эхлээд...(минут дуусав)

Н.Учрал: Д.Ганмаа гишүүнд нэмэлт нэг минут өгье.

Д.Ганмаа: Баярлалаа. Хуулиа давсан журам, стандартуудыг шинэчилнэ өөрчлөхөөр ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа гэж товчхондоо хариуллаа. Мэдээж 2016 оны хуулиас хойш Ковид цар тахал гарсан. Тэрнээс хойш зөвхөн Монгол Улс ч биш бусад хөгжингүй орнууд эдийн засгийн хүч чадалтай орнууд ч гэсэн эрүүл мэндийнхээ бодлогыг цогцоор нь өөр нүдээр харж анхан шатны тусламж үйлчилгээ буюу өрхийн эмнэлэг дээрээ бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг хүргэх нь зайлшгүй шаардлагатай юм байна гээд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага бусад улс орнуудын төлөөллүүдтэй хамтраад нийтлээд яригдсан. Төлөвлөсөн, шийдсэн ажлууд байгаа. Монгол Улс ч гэсэн үүнээс мэдээж гажих аргагүй. Олон улсын стандартыг цар тахалд тааруулсан байдлаар эрүүл мэнд тусламж үйлчилгээг шинэчлэх хэрэгтэй.

Үүнтэй та санал нэг байна уу? Хэрвээ санал нэг байгаа бол та анхан шатын эмнэлэг тусламж үйлчилгээ дээр ямар асуудлууд энэ хуульд тусгавал зүгээр гэж үзэж байгаа вэ?

Г.Занданшатар: Товчхондоо санал нэг байна. Ер нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахын тулд лабораторийн үзлэг анхан шатын эмнэлгүүдийн үзлэг, хүртээмж чанар үйлчилгээг сайжруулах ёстой. Үүнийг шинээр стандартлах шаардлагатай. Бусад улстай харьцуулбал Монгол Улсын суурь дэд бүтцүүд бүх сумд, аймгийн төвүүдэд эмнэлгүүдтэй. Тогтолцооны хувьд бол хатуу бүтэц харьцангуй сайжирсан боловч зөөлөн дэд бүтэц буюу үйлчилгээний стандартыг шинэчилж шинэ дэг соёлыг нэвтрүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа.

Ийм учраас гадаад зогсоол, сувилагчийн пост, дотор байх сандлаас эхлээд түүнд тавигдах стандартыг бүрэн шинэчлэх ёстой. Тэгэхгүй бол орыг санхүүжүүлдэг биш урьдчилан сэргийлэх оношилгоо, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах нь 1 дүгээрт эрхэмлэх зорилго байх ёстой. Мэдээж ирэх жил шат шатны эмнэлгүүдийн чанар хүртээмжийг сайжруулах ёстой.

Н.Учрал: Баярлалаа. Д.Ганмаа гишүүний эрүүл мэндийн салбарт тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ахлан ажиллаж байгаа. Тэгээд 59 ажлын хэсгийг татан буулгаад 12 ажлын хэсэгтэй болгосон. Үүний 1 ажлын хэсэг нь эрүүл мэндийн салбар. Тэгэхээр Д.Ганмаа гишүүн ахалж ажиллана гэдгийг хэлье.

Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо Улсын Их Хурал дахь цөөнхийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууна. Нэрсээ ирүүлсэн Л.Энхнасан гишүүн байхгүй байна. Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиа барина.

Улсын Их Хурлын асуулгын цаг дууслаа.

Улсын Их Хурлын гишүүдийн асуултад хариулж нээлттэй ярилцсан Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Танд талархал илэрхийлье.

--oOo--

УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГЫН ЦАГ

№62

Эмхэтгэсэн:	Д.Энхмаа
Хянасан:	Ч.Онончимэг
	Д.Энхбат
Эх бэлтгэсэн:	Б.Төгсзаяа

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хяналт шалгалтын газраас эрхлэн гаргав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх, олшруулах цехэд бэлтгэв.